



# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199 I оны II дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 8

Улаанбаатар  
хот

Ардын Их Хурлын II хуралдааны 8 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9.00 цагт Ардын Их Хурлын Танхимд эхлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хуралдаанд ирвэл зохих 427 депутатаас 403 нь хүрэлцэн ирсэн, ирц 94 хувьтай байгааг мэдэгдээд хуралдааны ажиллагааг эхлүүлэв. Ардын Их Хурлын орлогч дарга Г.Жагай хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон, иргэдээс ирүүлсэн бичиг, захидал, цахилгаан, санал, хүсэлтийн тоймыг танилцуулав.

Ж.Уртнасан хэлмэгдэгсдийн дурсгалыг суудлаасаа босч хүндэтгэхийг уриалсан ардчилсан эвслийн нэр бүхий 102 гишүүний өргөх бичиг Ардын Их Хурлын нэр дээр иржээ. Бид өнгөрсөн жил анхдугаар хуралдааны үед хэлмэгдэгсдийн дурсгалд хүндэтгэл илэрхийлсэн. Архивт материал нь байгаа юм. Жил болгон ийм ёслол үйлдэх шаардлага байгаа юм уу гэв.

399 дүгээр тойргийн депутат Д.Чилхаажав өргөх бичгийн утгыг тодруулж саналаа хэлэв.

283 дугаар тойргийн депутат Ш.Шагдарсүрэн Д.Чилхаажавын саналыг дэмжиж үг хэлэв. 36 дугаар тойргийн депутат Р.Ёндондөмбөрэл ерөнхий санал, шүүмжлэлтэй холбогдуулан үг хэлснээр хурлын уур амьсгал хурцдаж, депутатууд маргах шинжтэй болов.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх талаар гарсан санал дээр санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн	147 -45%
Татгалзсан	115 -35%
Түдгэлзсэн	65 -20%
Бүгд	327 -77%

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэе гэсэн 147 депутатад хүндэтгэл илэрхийлэх бололцоо олгохыг Ардын Их Хурлын даргаас шаардав. 167 дугаар тойргийн депутат Ш.Гүрбазар эмгэнэл илэрхийлэх асуудлыг өөрөөр ойлгож байгаа тухай үг хэлэв.

396 дугаар тойргийн депутат Б.Чимид "Монгол Улсын Үндсэн хууль" гэсэн хамтатгасан нэрийг зөвшөөрч байгаа эсэх талаар санал хураалгахыг хүсэв. 85 дугаар тойргийн депутат К.Сайраан хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан эмгэнэлийн төсөл уншив.

Нийт депутатууд нэг минут суудлаасаа босч хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэв.

294 дүгээр тойргийн депутат И.Бадарч горимын, 210 дугаар тойргийн депутат П.Хаадгар Халх голын дайнд амь үрэгдэгсэд, Налайхын уурхайн осол, цаг агаарын бэрхшээлд өртөж жил бүр үрэгдэж байсан малчдын дурсгалыг хүндэтгэе гэсэн санал хэлэв. 406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш, 243 дугаар тойргийн депутат Я.Жалбаа, 335 дугаар тойргийн депутат Ж.Мөнхбат, 323 дугаар тойргийн депутат Ч.Дашдэмбэрэл, 39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав нар үг хэлж хуралдааныг дэгийн дагуу явуулахыг нийт депутатуудад уриалав.

Үүний дараагаар цөөнхийн саналыг таслах санал хураалт явуулав.

зөвшөөрсөн	210 -88%
татгалзсан	18 -7%
түдгэлзсэн	12 -5%
Бүгд	240 -56%

Олон депутат санал хураалтад оролцоогүй учир санал дахин хураав.

зөвшөөрсөн	382 -96%
татгалзсан	13 -3%
түдгэлзсэн	3 -1%
Бүгд	398 -93%

396 дугаар тойргийн депутат Б.Чимид өөрийн гаргасан "Монгол Улсын Үндсэн хууль" гэсэн томбёоллыг давтан хэлэв.

Энэ хувилбар дээр санал хураалт явуулах уу? Үгүй юу? гэдэг дээр санал хурааа гэж Ж.Уртнасанг хэлэхэд олонхи депутатууд зөвшөөрсөнгүй. 284 дүгээр тойргийн депутат Ш.Бадам олонхи депутатуудыг төлөөлж санал хэлэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан өчигдөр шийдвэрлээгүй, задга орхисон 2 асуудал дээр санал хураалгав.

Хуулийн нэр Их засаг

зөвшөөрсөн	175	44%
татгалзсан	190	47%
түдгэлзсэн	36	9%
Бүгд	401	94%

Хуулийн нэр "Үндсэн хууль"

зөвшөөрсөн	252	68%
татгалзсан	123	31%
түдгэлзсэн	23	6%
Бүгд	398	93%

Нэгдсэн тохиролцоонд хүрээгүй учир хуулийн нэрийг дахин нээлттэй орхиод хэлэлцүүлгээ үргэлжлүүлэх болов.

39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав, 31 дүгээр тойргийн депутат Д.Дожоодорж, 238 дугаар тойргийн депутат Г.Төмөрбаатар, 71 дүгээр тойргийн депутат Т.Ядамсүрэн, 33 дугаар тойргийн депутат Д.Мөнхөө, 413 дугаар тойргийн депутат Н.Насан-Очир, 85 дугаар тойргийн депутат К.Сайраан, Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам, 314 дүгээр тойргийн депутат М.Гантөмөр, 288 дугаар тойргийн депутат С.Баярцогт, 72 дугаар тойргийн депутат А.Болат, 168 дугаар тойргийн депутат Г.Вандандагва нар цөөнхийн санал хэлж, 7 дугаар тойргийн депутат Ц.Балдорж Ардын Их Хурлыг тараах, Үндсэн хууль батлах эрхийг Улсын Бага Хуралд буюу шинээр сонгогдох Ардын Их Хуралд үлдээх, 145 дугаар тойргийн депутат Л.Лантуу улсын нэр, далбааг урьдчилан өөрчилбөл бусад асуудлыг тохирч болно гэсэн санал, 178 дугаар тойргийн депутат Д.Энхбаатар Ардын Их Хурлыг

тараах, 245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат "Их цааз", "Үндсэн хууль" хоёроор урьдчилан санал хураалгах, 185 дугаар тойргийн депутат Д.Жанцан тэвчээртэй сууж, асуудлаа шийдвэрлэх, улс төрийн бүлгүүд урьдчилан ярилцах, 316 дугаар тойргийн депутат Г.Сосорбарам хуралдаан даргалагчдад хандсан, 167 дугаар тойргийн депутат Ш.Гүрбазар өлсгөлөн зарласан хүмүүсийн шаардлагын талаар 186 дугаар тойргийн депутат Р.Чойжинням хэлэлцэж байгаа асуудлаар 8-9 хоногт багтаан хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэг явуулах, 154 дүгээр тойргийн депутат Ё.Моголцог Б.Чимидийн төслөөр санал хураах, бие биедээ болгоомжгүй үг хэлэхгүй байх, 18 дугаар тойргийн депутат Г.Ганболд төрийн удирдах хүмүүс хэлэлцэж байгаа асуудалд ажил хэрэгчээр оролцож санаачилга гаргах, 14.00 цаг хүртэл Ардын Их Хурлын хуралдааныг завсарлуулах талаар саналыг тус тус гаргав.

Ардын Их Хурлын хуралдаан дэгийнхээ дагуу 11.00-11.26 цагт завсарлав.

БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат Ардын Их Хурлын хуралдаанаа 15.00 цаг хүртэл завсарлуулаад улс төрийн бүлэг, орон нутгийн депутатуудын группийн ахлагч нарын зөвлөлгөөн, ярилцлагыг хийх санал хэлэв. Ерөнхийлөгчийн гаргасан санал дээр депутатуудын санал хураалт явуулав.

эвшөөрсөн	380	-97%
татгалзсан	6	-2%
түдгэлэсэн	4	-1%
Бүгд	390	-91%

Ардын Их Хурлын хуралдааныг 11.30 цагаас 15.00 цагт завсарлахаар шийдвэрлэв.

Үдээс хойшхи хуралдаан 15.05 цагт эхлэв.

Ж.Уртнасан депутатуудын нам, орон нутгийн бүлгийн ахлагч нарын уулзалт, зөвлөлгөөний дүнгийн тухай товч танилцуулаад санал хураалтад оров. Ирц 94 /403/ хувь байв.

"Монгол улсын Үндсэн хууль" гэсэн томъёоллоор 15.10 цагт санал хураав.

зөвшөөрсөн	273	-69%
татгалзсан	83	-21%
түдгэлзсэн	42	-10%
Бүгд	398	-93%

Цөөнх болж 69 дүгээр тойргийн депутат Ж.Ядамсүрэн, 293 дугаар тойргийн депутат И.Бадарч, 358-р тойргийн депутат Б.Жанцансамбуу, 394-р тойргийн депутат С.Лувсандаш, 165-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 235-р тойргийн депутат Ц.Өөлд нар үг хэлэв. Депутат Ж.Ядамсүрэнгийн асуултанд 4-р тойргийн депутат К.Зардыхан хариулав.

Цөөнхийг сонссоны дараа дахин санал хураалт явуулах болов. Гэвч маргалдан шуугилдаж 10-р тойргийн депутат О.Дашбалбар 15.44 цагт хуралдаанд оролцохгүй гэдгээ мэдэгдэн танхимыг орхин гарч явав. Хурлын дарга Дэгээ баримталж, санал хураалтанд орохыг депутатуудаас шаардав. 15.55 цагт намуудын бүлгийн хүсэлтээр 30 минутын завсарлагыг хурлын дарга зарлав.

Хуралдаан 17.11 цагаас үргэлжлэв.

Депутат О.Дашбалбар суудлаа эзэлсэн байв.

Ж.Уртнасан намуудын бүлгийн ахлагч нар ямар тохиролцоонд хүрснээ депутатуудад товч танилцуулахыг хүсэв. МАХН-ын бүлгийн ахлагч, 42-р тойргийн депутат Б.Даш-Ёндон, "Ардчилсан эвсэл" бүлгийн ахлагч, 3-р тойргийн депутат Р.Барсболд, 39-р тойргийн депутат Д.Ламжав, МоАН-ын бүлгийн ахлагч О.Очиржав, МҮДН-ын бүлгийн ахлагч, 22-р тойргийн депутат Л.Дашням нар товч үг хэлж намынхаа байр суурийг илэрхийлэв. Дараа нь Ж.Уртнасан улсын нэртэй холбогдуулан тайлбар хэлээд 17.23 цагт "Монгол улсын Үндсэн хууль" гэдгээр санал хураалгав.

зөвшөөрсөн	123	32%
татгалзсан	230	59%
түдгэлзсэн	37	9%
Бүгд	390	91%

МАХН-ын бүлгийн ахлагч Б.Даш-Ёндонгийн саналын дагуу "Улсын нэрийг хэлэлцэнэ, хуралдааныг хаалттай явуулна" гэдгээр санал хураав.

зөвшөөрсөн	336	86%
татгалзсан	49	13%
түдгэлзсэн	7	1%
Бүгд	392	92%

Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэх болов.

Цөөнх болж хуралдааныг нээлттэй явуулахын төлөө 39-р тойргийн депутат Д.Ламжав, 7-р тойргийн депутат Ц.Балдорж, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, Улсын Бага Хурлын гишүүн Б.Галсандорж, Улсын Бага Хурлын гишүүн П.Улаанхүү, 288-р тойргийн депутат С.Баярцогт, Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам, 85-р тойргийн депутат К.Сайраан нар үг хэлж хуралдааныг нээлттэй явуулах, нэрээр санал хураах, танхимд видео бичлэг хийх саналуудыг гаргав.

17.40 цагт хурлын даргын хүссэнээр Б.Даш-Ёндон хуралдааныг хаалттай хийх саналынхаа тухай товч тайлбар хийсний дараа "Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ" гэдгээр 2 дахь санал хураав.

зөвшөөрсөн	227	59%
татгалзсан	116	30%
түдгэлзсэн	39	11%
бүгд	382	89%

Хуралдааныг хаалттай хийх болов.

Цөөнх болж 9-р тойргийн депутат С.Зориг, 84-р тойргийн депутат Н.Самат, 170-р тойргийн депутат Ж.Лхагважав, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, Улсын Бага Хурлын гишүүн П.Улаанхүү, 399-р тойргийн депутат Д.Чилхаажав, 6-р тойргийн депутат Б.Нямбуу нар үг хэлсний дараа "Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ" гэдгээр 3 дахь санал хураав.

зөвшөөрсөн	165	42%
татгалзсан	170	44%
түдгэлзсэн	54	14%
бүгд	389	91%

Цөөнх болж 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, 143-р тойргийн депутат Г.Зуунай, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 340-р тойргийн депутат Б.Сумъяа нар үг хэлсний дараа "Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ" гэж 4 дахь удаа санал хураалгав.

зөвшөөрсөн	165	43%
татгалзсан	162	42%
түдгэлзсэн	60	15%
бүгд	387	91%

"Хуралдааныг ердийн байдлаар явуулна, депутат хүсвэл үгийг нь хэвлэл мэдээллээр үл дамжуулна" гэдгээр

зөвшөөрсөн	260	82%
татгалзсан	30	9%
түдгэлзсэн	29	9%
бүгд	319	75%

Энэ хувилбарыг зөвшөөрөв.

18.14 цагт хуулийн нэрээр санал хурааж эхлэв.

#### 1. Их засаг хууль

зөвшөөрсөн	273	68%
татгалзсан	99	25%
түдгэлзсэн	28	7%
бүгд	400	94%

Дийлэнх олонхийн саналаар "Их засаг хууль" гэх болж өөр хувилбар дээр санал хураахыг болив.

18.16 цагт улсын нэрээр санал хураалт эхлэв.

Эхлээд "Улсын нэрийг хэлэлцэе" гэдгээр:

зөвшөөрсөн	346	94%
татгалзсан	21	6%
түдгэлзсэн	3	0%
бүгд	370	87%

## I. Бүгд Найрамдах Монгол Улс гэдгээр:

зөвшөөрсөн	156	40%
татгалзсан	204	52%
түдгэлзсэн	32	8%
бүгд	392	92%

## II. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдгээр:

зөвшөөрсөн	217	55%
татгалзсан	148	37%
түдгэлзсэн	33	8%
бүгд	398	93%

## Цөөнхийн саналыг сонсох болгов.

156-р тойргийн депутат Ж.Гантөмөр, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан /хэвлэл, мэдээлэлд үл тавих/, 335-р тойргийн депутат Ж.Мөнхбат, 10-р тойргийн депутат О.Дашбалбар /хэвлэл, мэдээлэлээр үл гаргах/, 251-р тойргийн депутат М.Адъяатулгат, 164-р тойргийн депутат Ц.Дамцагдорж, 72-р тойргийн депутат А.Болат /зарим зүйлийг хэвлэл, мэдээлэлд үл тавих/, 160-р тойргийн депутат Д.Содном, 114-р тойргийн депутат С.Ёндонжамц, 111-р тойргийн депутат Г.Бадарч нар үг хэлсний дараа хуралдааныг үргэлжлүүлэх талаар санал хураав.

## I.I цаг үргэлжлүүлэх:

зөвшөөрсөн	266	70%
татгалзсан	101	27%
түдгэлзсэн	14	3%
бүгд	381	89%

39-р тойргийн депутат Б.Ламжав, 9-р тойргийн депутат С.Зориг нар улс, хуулийн нэрээ тогтоохос нааш тарахгүй хуралдахыг санал болгов.

234-р тойргийн депутат Д.Дэмбэрэл, 64-р тойргийн депутат Ч.Молом, 284-р тойргийн депутат Ш.Бадам, 349-р тойргийн депутат У.Баянбилэг, 104-р тойргийн депутат Д.Жагварал, 105-р тойргийн депутат Б.Чойжилсүрэн, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж, 145-р



тойргийн депутат Л.Лантуу, 240-р тойргийн депутат С.Пүрэв, 413-р тойргийн депутат Н.Насан-Очир, 374-р тойргийн депутат Т.Санжаа, 410-р тойргийн депутат Л.Баатарсүрэн, 388-р тойргийн депутат Б.Энхтуяа нарыг үг хэлсний дараа цөөнхийн саналыг таслая гэсэн томъёоллоор санал хураав.

зөвшөөрсөн	340	91%
татгалзсан	29	8%
түдгэлзсэн	5	1%
бүгд	374	88%

Улсын нэрийн талаар: БНМАУ, БНМУ, Монгол Улс гэсэн 3 янзын томъёоллоор шалгаруулах санал хураалт явуулах талаар санал хураахад:

зөвшөөрсөн	333	85%	
татгалзсан	56	14%	
түдгэлзсэн	3	1%	
бүгд	392	92%	болов.

Хуралдааны цагийг асуудал шийдтэл сунгая гэж санал хураахад:

зөвшөөрсөн	223	63%
татгалзсан	115	32%
түдгэлзсэн	17	5%
бүгд	355	83%

Шалгаруулах санал хураалтыг зөвшөөрөөгүй цөөнхийг төлөөлж 148-р тойргийн депутат Д.Баттулга нар үг хэлж, 85-р тойргийн депутат К.Сайраан, 1427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, Улсын Бага Хурлын гишүүн С.Товуусүрэн, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 186-р тойргийн депутат Р.Чойжинням,

113-р тойргийн депутат Ж.Гүррагчаа 85-р тойргийн депутат К.Сайраан, 148-р тойргийн депутат Д.Баттулга, 17-р тойргийн депутат Т.Очирхүү, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 25-р тойргийн депутат Л.Энзбиш, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 1-р тойргийн депутат С.Баяр, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 14-р тойргийн депутат С.Лхагва-сүрэн, 257-р тойргийн депутат Ч.Цэрэндагва, 4-р тойргийн депутат К.Зардыхан, 390-р тойргийн депутат Ү.Аварзэд, 303-р тойр-

гийн депутат Ж.Норовсамбуу, 267-р тойргийн депутат Р.Таванжин, 187-р тойргийн депутат О.Очиржав, 396-р тойргийн депутат Б.Чимид 144-р тойргийн депутат Ц.Лоохууз нар улсын нэр, горимын талаар үг хэлсний дараа улсын нэрийг,

"БНМАУ" гэдгээр санал хураав.

Зөвшөөрсөн	280	71%
татгалзсан	100	25%
түдгэлзсэн	16	4%
бүгд	396	93%

"БНМУ" гэсэн санал дээр

зөвшөөрсөн	52	14%
татгалзсан	305	80%
түдгэлзсэн	25	6%
бүгд	382	89% болов.

Үүгээр хуралдаан 21.22 цагт дуусав.

Депутатуудын ирц, хуралдааны явцын соронзон бичлэгийг хавсаргав.

АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА *М. Уртнасан* Ж.УРТНАСАН  
ОРЛОГЧ ДАРГА *Н. Батбаяр* Н.БАТБАЯР

*Т. Жагай* Т.ЖАГАЙ  
*Ц. Лоохууз* Ц.ЛООХУУЗ  
*Д. Моондой* Д.МООНДОЙ

ТЭМДЭГЛЭСЭН: *А. Юундэндорж* А.ЮУНДЭНДОРЖ  
*Г. Хүрэлбаатар* Г.ХҮРЭЛБААТАР

АРДЫН ИХ ХУРЛЫН 1991 ОНЫ II ДҮГЭЭР  
САРЫН 19-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ИРЦИЙН  
Б А И Д А Л

Ирвэл зохих: 427

Хуралдаанд ирээгүй/шалтгааныг дурдана/: Депутат  
Г.Чингэл /339/, Г.Батмөнх/376/, Ц.Охинтогтох /254/, Н.Сампил-  
норов/199/, Г.Дамдиндорж / 250/, Н.Дэлгэрмөрөн/306/, Н.Пүрэвдорж  
/41/, нар өвчтэй.

Хуралдаанд хоцорч ирсэн:

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

1991-II-19

Кассет III-57

9.02-9.22

Ж. Уртнасан → Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая. Найм, ес дэх өдрийнхээ хуралдааныг бид үргэлжлүүлэх гэж байна. Юуны өмнө уламжлал ёсоор ирцээ бүртгээ. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү. Ирцийг бүртгэж эхэллээ.

Ирвэл зохих 427 депутатаас 403 депутат буюу 94 хувийн ирцтэй байна. Тийм учраас хурлын ирцийг хүчин төгөлдөр гэж чуулганаа үргэлжлүүлье.

Өчигдөр орой үдээс хойш болон өнөөдөр өглөөг хүртэл гэсэн хөдөлмөрдөөс ирсэн санал, хүсэлт, мэдээллийг орлогч дарга Жагай хэлж сонсгоно.

Мэдээ уншихын өмнө зарлалын чанартай зүйл хэлье. Энэ хуралд оролцож байгаа аймаг, аж ахуй, нэгдлийн дарга нарт дараах зүйлийг зарлаж өгнө үү. Үүнд: Увс аймгийн ихэнх нутаг, Завхан аймгийн хойт хэсгээр цас их орж, хүйтний эрч улам нэмэгдэж, Увсад зарим бог малын суурь бэлчээрт гарахад бэрхшээл учирч байна. Мөн баруун аймгуудад нэлээд хүйтэрч байна. Өвс тэжээлийн хэмжээ, түүнийг тээх шатахуун зэргээс хамаарч дотоод нөөцөө дайчлан ашиглах шаардлага улам нэмэгдэж байна. Энэ байдлыг анхааран үзэж, аймаг, аж ахуй, нэгдлийнхээ хэрэгцээнээс илүү байгаа өвс, тэжээлийг улсын аюулаас хамгаалах тэжээлийн нөөцөд нийлүүлэхийг хүсье. Өвс нийлүүлэх энэ тухай саналаа Хөдөө аж ахуйн дэд сайд Хаадгарт өгнө үү. Засгийн газрын хурал, захиргааны хэлтэс, Хөдөө аж ахуйн яам, 1991 оны II-р сарын 18 гэсэн зарлалыг танилцуулъя.

Өчигдөр оройны байдлаар Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон хувь хүнээс бичгээр 42, цахилгаанаар 23, утсаар 2, хүлээн авах байраар 1 хүн ирж санал тавьсныг тоймлон уншиж сонордуулъя.

Сүхбаатарын районы ОСТ-ны 33-р хорооны өндөр настан Сэрээтэр хүлээн авах байраар:

Зарим депутатууд ард түмэнд хэрэгтэй, сургамжтай сайхан үг хэлж байна. Иймээс тэдний хэлсэн үг, хурлын шийдвэр, баримт

бичгийг ном болгож худалдахыг хүсье.

Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний газрын инженер Цэрэнбадамаас:

Та бүхэнд Монголд өрнөсөн ардчиллын баталгаа, Монголын ард түмний эрх чөлөөний баталгаа болсон Их цаазыг хэлэлцэн батлах эрх бүхий түүхэн хариуцлагатай, хувь тавилан заяагдсан хүмүүс юм. Шинэ Үндсэн хууль нь далан жилийн харанхуйг гийгүүлсэн, анхны гэгээ болох тул та бүхэнд үг үсэг, зүйл бүр дээр нь хэлэлцэж, маргалдаж, оюун ухаанаа уралдуулах нэн чухал цаг мөчтэй тулгарлаа. Иймд Монгол улсын түүхэн түлхүүр үндэс нь хөрст газар, хөх тэнгэр шүтэж, начин шонхорын зоригоор хэнд ч дийлдэж яваагүй Монгол түмний уламжлалаа бодолцох нь зүйтэй.

Дорноговь аймгийн МОАХ-МАН. В.Саарал /бичгээр/

Түмний итгэл, төрийн түшээ та бүхнээс өнөөдрийг өнгөрөөж, ирээдүйг харсан холч мэргэв ухаан, монгол уужуу тайван сэтгэлээр асуудлыг шийдвэрлэхийг хүсье гэжээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хөдөлмөрчдөөс /цахилгаанаар/

Улс орны эдийн засаг ээдрээтэй үед төр, улсынхаа тулгуур хуулийг хэлэлцэж, бидний хүсэн хүлээсэн ард түмнийхээ сэтгэл зүрхэнд хонотгосон баримт бичиг гаргана гэдэгт Их Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье гэжээ.

Зохиолч С.Эрдэнэ/бичгээр/

Эрхэм депутатуудад мэхийн ёслоё. Үзэл суртлын хүлээсээ сулруулж, төрийн ухаан сууж байгаад чин сэтгэлийн угаас талархаж, хоосон хийрхэл, мэдэмхийрэх, үймэрлээс ангижрахын үлгэр жишээг зон олондоо үзүүлж, Монгол улсаа төвхнүүлэн даян

## 3.

дэлхийн өмнө нэр төрийг нь өргөмжлөх, хүнд ачааг үүрсэн та бүхний мэргэн ухаанд өчүүхэн бичгүнээ иргэж байна гэжээ.

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын иргэн Жамбазаваас:

Денутатууд ард түмний нэрийг барьж, бүхнийг хуучнаар байлгахыг эрмэлзэж байна. Энэ нь Монгол улсын хөгжилд сайнаар нөлөөлөхгүй. Их цааз, Монгол улс гэж нэрлэх нь зүйтэй гэжээ.

Дундговь аймгийн Хотол чуулган сонины эрхлэгч С.Пүрэвсүрэн бичгээр:

Хуралдааны үед өдөр жагсаал цуглаан зохион байгуулж, нээгдсэн өдөр нь улс төрийн суулт зарлах вэргээр тогтворгүй байдлыг үүсгэж байгаа эвсэл, холбоодын туйлын зорилго, тэдний цаана байгаа улс төрийн хүчний тухайд ухаалаг байр, суурь баримталж, мэргэн оюундаа тунгаана уу гэжээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын I-р хорооны иргэн Эрдэнэдалай, Ганболд /цахилгаанаар/:

Хуулинд газрыг өмчлөх, хошуу байлгах заалтыг дэмжиж байна.

Өвөрхангай аймгийн иргэн Жаргал, Даваа, Цогзолмаа, Сарангэрэл нарын 9 хүн цахилгаанаар:

Их хурлын үйл ажиллагаанд амжилт хүсчээ.

Сүхбаатарын дүүргийн 26-р хорооны иргэн Содномдаржаагаас:

Ерөнхийлөгч тэргүүтэй комиссын боловсруулсан Их цаазын төслийг ард түмэн өндөр үнэлэж байна. Монгол улсаа Монгол улс гэж уламжлалт нэрээр нэрлэх, хуулийнхаа нэрийг олон хуулиудаас онцлон зааж, Их цааз гэсэн нэрээр батлах нь зүйтэй гэжээ.

4.

Баруун-урт хотын 7-р <sup>тойргийн</sup> депутат Сааралаас:

Их цаазын төсөл маш сайн болсон гэж ард түмэн үзэж байна. Энэ төслийг батлаж өгөхийг хүсье гэжээ.

Сэлэнгэ аймгийн Түнхэл хорооны хөдөлмөрчдийг төлөөлж Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга Базар, Доржсүрэн, Дашдондог, Батсүх нар/цахилгаанаар/:

Үндсэн хуулийн нэр, улсын нэр, сүлд, төрийн дууллыг хэвээр нь үлдээх гэжээ.

Үндсэн хуулийг батлах талаар олон хүмүүсээс бичиг, цахилгаан ирсэн байна:

Октябрийн районы 24-р хорооны өндөр настан Гомбожав утсаар:

Улсын тусгаар тогтнол, газар нутгийн тухай хэлэлцэж байгуу учир улсын хил хязгаарыг баталгаатай болгох талаар анхаарах нь зүйтэй. 34 онд батлагдсан Үндсэн хуулиар тогтоосон хил одоо хэвээр байна уу?

Газрыг улсын мэдэлд байлгана гэхээр улс дуртай цагтаа комисс томилоод, Давст уул шиг хэсэг газар өгчих вий дээ гэж эмзэглэсэн байна.

Октябрийн районы ОСГ-ны 35-р хорооны өндөр настан Хандааваас: /хүлээн авах байраар/

БНМАУ гэж Их цаазад тусгах нь буруу юм. Найрамдал гэснээс ЗХУ, БНХАУ-д газар нутгаасаа өгсөн Давст уул, урьд Байдаг болд уулын өмнөх хэсгийг өгсөн. Иймд Монгол улс гэх нь зөв гэжээ.

## 5.

Октябрийн дүүргийн ОСГ-ны 37-р хорооны өндөр настан Банзрагч /хүлээн авах байраар/:

Их цаазыг олноор хэлэлцүүлэн санал авсан тул одоо хэлэлцэж батлах нь зүйтэй. Үндсэн хуулийн нэрийг өөрчлөн Их цааз, Их засаг, Их журам гэхийн оронд оновчтойгоор оноосон оноосон нэр өгье, сумдыг хошуу болгодог нь зөв гэжээ.

Октябрь дүүргийн өндөр настан С.Доржпалам /бичгээр/:

Манайд бэлэвсэн эх 20 мянга, бүтэн өнчин хүүхэд 15 мянга, хагас өнчин 50 шахам мянга байна. Одоогийн зах зээлд орж байгаа нөхцөлд эмэгтэйчүүд, ялангуяа бэлэвсэн эхчүүд нэрвэгдэж байна.

Их цаазын 2-р бүлгийн хүний эрх, чөлөө гэсэн 17-р зүйлийг II-р хэсэгт эдийн засаг, ёс суртахууны хувьд боломжтой хүмүүс их, бага гэр бүл зохиох эрхтэй гэж нэмж оруулах гэсэн санал ирүүлжээ.

Өнөөдрийн мэдээ Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон, хувь хүнээс бичгээр 4, цахилгаанаар 2, утсаар 38, хүлээн авах байраар 21 хүн ирж, санал, хүсэлтгээ тавьсныг тоймлон дурдъя.

Сүхбаатар дүүргийн <sup>хорооны</sup> 33-р иргэн Ш.Асрал, Октябрийн дүүргийн 33-р хорооны иргэн Бямбадорж, Сүхбаатарын районы 9-р хорооны иргэн Жамсран, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын сумангийн дарга Очирбат, салааны ахлах Мягмарсүрэн, Монголын хэрэглээний хоршоодогч Хүдэр хоршооны дарга Нямдаваа, Сүхбаатар районы 10-р хорооны иргэн Авирмэд, Баатар, Хөвсгөл аймгийн Их уул сумын дарга Нянтайсүрэн, Октябрийн районы 5-р хорооны иргэн Давгадорж, Найрамдлын районы 15-р хорооны иргэн Лхамсүрэн, Сүхбаатарын районы ОСГ-ны 4-р хорооны өндөр настан Цэнд, мөн Дорждамба, Өвөрхангай аймгийн



Улаан загалмайн хорооны дарга Авирмэд, Октябрийн районы 35-р хорооны Доржготов 6 хүнийг төлөөлж, Октябрийн районы сургууль, цэцэрлэгийн нэгдсэн төвийн захирал Гэндэншарав, Сүхбаатарын районы 3-р хорооны иргэн Чулуун /утсаар/

Олон хүн Их Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч, ажил, хэрэгт зөв мэргэн шийдвэр гаргана гэдэгт та бүхэнд итгэж байна гэжээ.

Сүхбаатарын районы 10-р хорооны иргэн Базар/хүлээн авах байраар/:

Депутатууд минь маргалгүй, бухимдалгүй, ухаантай хандаж, санал хураалтаар шийдэх нь хэрэгтэй байна. Иргэдээс өгсөн саналыг уншихад, депутатууд нэр хийтэл инээж байгаа нь дуулах нь доромжилсон хэрэг шиг эвгүй сэтгэгдэл төрүүлж байна гэж анхааруулжээ.

Ховд аймгийн Үенч сумын цэргийн ангийн ахмад Лхагвасүрэн /утсаар/:

Депутатууд зөвхөн тойргийнхоо сонгогчдын эрх ашгийг хамгаалж яриад, улсын эрх ашгийн үүднээс хаядаж ярихгүй байна. Иймд Монгол улсын цаашдын хувь заяаны асуудлыг хэлэлцэж байгаа гэдгээ ухаарч, асуудалдаа хэлэлцэхдээ арагшаа харж, ярах хэрэггүй. Ар талын ажлыг зохицуулж, гүйцэтгэж байгаа хүмүүс бий шүү дээ. Улсын нэр, сүлд, далбааны асуудлыг хэлэлцэхдээ үндэслэлийг сайн гаргаж, зөв шийдэх хэрэгтэй. Зөвхөн хэсэг хүмүүсийн санаачар шийдэх асуудал биш гэдгийг анхаарах.

Депутатууд та бүхнээс хурлынхаа үйл ажиллагаанд идэвхтэй ажил хэрэгчээр хандаж, цаг хугацаанд хавчигдах, хөрөнгө мөнгө зарцуулах гэж бодолгүйгээр улсынхаа ирээдүйн хувь заяаг бодож, олон жилийн настайхууль гаргахад оюун ухаанаа дайчлан ажиллахыг хүсье гэжээ.

7.

Сүхбаатарын районы өндөр настан Цэнд /угсаар/:

Одоо манайд гадаадын хамтарсан үйлдэрүүд байна.Тийм учраас газрыг түрээслэх нь зүйтэй. Тэр ч байтугай хувь нийлүүлсэн төмөр зам байгуулахад газрыг зөвлөлтийн талд худалдсан гэж би ойлгодог. Үүнийг хоёр улсын байгуулсан гэрээг тодруулж үзэж болно гэжээ.

Октябрийн районы 15-р хорооны иргэн Лхамсүрэн:

БНМАУ-ын нэр, сүлд зэргийг өөрчлөх нь гэж ятгалаг хийгээд байгаа хүнийг боллуулах,зөвхөн телевизээр Сталин Монголын сүлдийг хийж өгсөн гэж дэмий ярьж байна. Иймэрхүү дэмий ярианд ард түмэн дургүйцэж байгааг та бүхэн соргог мэдэрч байгаа байх аа. Үүнийг депутатуудад уншиж, сонордуулж өгөөрэй гэж Уртнасан даргаас хүссэн байна.

Цэргийн нэгдсэн эмнэлгийн их эмч Даваасамбуугаас:

Сүлдэнд мал, малчингүйгээр Монгол орныг дүрслэж сэтгэхийн аргагүй. Иймээс Монгол морьт хүн хоёр заавал байх ёстой гэж бичжээ.

Дэвшлийн

Монголын Үндэсний намын жижүүр Өлзийхутаг /хүлээн авах байраар/:

Гэмт хэрэг анх удаа хийсэн этгээдийг нэг удаа өршөөл үзүүлж, хоёр ба түүнээс дээш удаа хэрэг хийсэн хүнийг хэзээ ч өршөөл үзүүлэхгүй байх тухай Их цаазад тусгах.

Тэнгисболдын зурсан төрийн их, хөх тамганы бариул нь шонхор шувуу байгааг өөрчлөж, армаг хөлөг болгох гэсэн саналыг ирүүлжээ.

Захидал мэдээнээс тоймлон сонордууллаа.

Ж. Уртнасан -Саяхан манай хуралд оролцож байгаа ардчилсан эвсэл бүлгийн 102 депутат Их Хурлын даргад хуралдааны эхэнд нийтэд толилуулна уу гэсэн эмгэнэлийн бичиг ирүүлснийг уншиж сонсоё.

Монголчуудын эртний уламжлалт төрт ёс, Монгол түмний сэргээн мандалыг бататгах, тулгар их хуульдаа нэр хайрлахын өмнө Монгол улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөө, сайн сайхны төлөө адд биеэ алдруулан зүтгэж яваад большевизмийн гар хөл болсон гадаад, дотоодын харгис хүчний аймаглан устгах балмац үйл ажиллагаанд өртөж, амь үрэгдсэн гэм зэмгүй олон мянган хөвгүүд, охидынхоо гэгээн дурсгалыг хүндэтгэн хун эмгэнэл илэрхийлье.

Ардын Их Хурлын II чуулганд оролцогчид, хүндэт депутат та бүхнийг энэхүү саналыг хүлээн авна гэдэгт итгэж байна гэсэн бичиг, эмгэнэл ирүүлжээ.

Тэхээр та бүхний сонорд сануулахыг хүсч байна. Өнгөрсөн жилийн анхдугаар чуулганаар та бид нар энэ танхимд хэлмэгдэгсдийн дурсгалыг босч хүндэтгэсэн, тэр материалыг бид архивын материалаас авчруулахаар сая хүн томиллоо. Бид өнгөрсөн жил хэлмэгдэгсдийнхээ дурсгалыг хүндэтгэсэн шүү. Жил бүр босоод байх хэрэгтэй юу, үгүй юу гэдэг нь бас бодуштай асуудал юм. Энэ эмгэнэлийг бид нийтлээ.

Бас нэг санал байна. Зөвшилд хүрэх нь гол зорилт болж байна. Иймээс та Их цагаг /Үндсэн хууль/ гэсэн миний саналыг санал хураалгаж өгнө үү. Энэ саналыг нэлээд депутат, Ерөнхийлөгч хүртэл дэмжсэнийг бодолцоно уу гэсэн Ардын Их Хурлын депутат Жагваралын хүсэлт ирсэн байна.

Д. Чиджаажав/399-р тойргийн депутат/ -Саяны уншсан текст нь арай өөр юм нэгдүгээрт. Хоёрдугаарт цөөнхийн хувьд үгээ хэлчихье гэж бодож байна. Эчигдөр уг хэлсэн депутатуудын зарим,

Ерөнхийлөгч мөн буруу хэлчихсэн гэж бодож байна.

1924 оны Үндсэн хууль бол Монголын шилдэг олон мянган хүмүүсийг хэлмэгдүүлэх, өнөөдрийн хямралыг бий болгох үр хөврөлийг тавих үндсэн хууль гэдэгт хүн бүрийн санаа нэг байна байх гэж бодож байна.

Яагаад гэвэл 1924 оны Үндсэн хуулиар хөрөнгөт бус хөгжлийн зам гэдгийг тунхагласан. 1924 оны Үндсэн хуулиар ангийн ялгааг тунхагласан. 1924 оны Үндсэн хуулиар нэг үзэл бодол, бусад үзэл бодлоо устгахын эх үүсвэрийг тавьсан. Ингэснээр 1924 оны Үндсэн хууль бол Монголын олон ургальч үзлийг хаасан, Монголын олон шилдэг хүмүүсийг хэлмэгдүүлэхийн эрх зүйн үндсийг бэлдэж өгсөн. Энэ эрх зүйн үндэс байхгүй байсан бол 1930 хэдэн оны үед хэлмэгдүүлсэн тэр хүмүүс зоригтой хөдлөж чадахгүй байсан. Яагаад гэвэл олон сүсэг бишрэлтэй хүмүүс, өөр үзэл бодолтой хүмүүсийг устгах эх үндсийг 1924 оны Үндсэн хуулиар тавьсан. Үүний өнөөдөр түүх нь давтагдаж байна гэж би хэлэх гэж байна. Яагаад гэвэл 1924 оны Үндсэн хуулийг хэлэлцэхэд Данзан, Бодоо нар илүүдэж байсан бол, тэд хувь хүнийхээ хувьд илүүдээгүй, үзэл бодлынхоо хувьд, Монголоо гэсэн сэтгэлийнхээ хувьд илүүдэж байсан бол, өнөөдөр 1991 оны Үндсэн хуулийг хэлэлцэхэд Улсын Бага Хурал, түүний гишүүд, түүний байгуулсан комисс, түүнийг түшиж ажилласан эрдэмтэд, мэргэд өнөөдөр үзэл бодлынхоо хувьд Үндсэн хуулийг хэлэлцэхэд илүүдэж байна. Үүнийг би түүх давтагдаж байна гэж би хэлэх гээд байгаа юм.

Данзан, Бодоо нар хувь хүнийхээ хувьд Үндсэн хуулийг хэлэлцэхэд илүүдээгүй. Тэр хоёрыг устгаснаараа тэр Үндсэн хууль гарч ирсэн юм. Тэр хоёрыг хэрэв устгаагүй бол 1924 оны Үндсэн хууль тэр заалтаараа гарч ирэх ёсгүй байсан юм. Тийм учраас би үүнийг хэлэхдээ тэр өвөг, дээдсийнхээ ариунхээл санааг бид өвлөж авах уу, үгүй юу. Тэр алдааг бид өнөөдөр давтах уу, үгүй юу? Яагаад бид бусдын үгийг сонсохгүй гээд зүтгээд байгаа юм.

юм бэ? Зарим депутатууд хэлж байсан намайг юу гэж ч ятгаад хэрэг байхгүй ээ, би өөрийн юмтай л ирсэн хүн гэж байна. Энэ нь зөв үү, буруу юу?

Парламент гэдэг нь ийм байдаг юм уу, үгүй юу? Саяны эмгэнэл нь зөвхөн хэлмэгдэгсдийн төлөө эмгэнэл биш ээ. Өнөөдөр биднийг ийм байдалд хүргэсэн ийм Үндсэн хуулийг 1924 онд эхлэж батласан энэ Үндсэн хууль нь буруу байсан юм гэдэгт улс төрийн дүгнэлт өгөөсэй гэдэг нь Улсын Бага Хуралд олон удаа яригдаж байсан. Улс төрийн нэг дүгнэлтийн нэг юу нь энэ.

Бид хөрөнгөт биш хөгжлийн зам гэдгийг тунхагласнаараа өнөөдрийн хямралын үр хөврөлийг тэнд тавьсан байхгүй юу даа. Ийм учраас нэрээр санал хураагаа чээ гэж би санал тавьж байна. Одоо Их засаг гэх үү, Их цааз гэх нь хамаа байхгүй. Зөвхөн нэрээр санал хураагаад, үүнийг өөрчлөх гэсэн нь ийм хүмүүс байсан юм байна, өөрчлөхгүй гэсэн нь ийм хүмүүс байсан юм байна гэдгийг түүх харах байх аа. Ингээд түрүүчийн уншдаг текст эмгэнэл дээр ч гэсэн санал нэрээр хураагаад өгөө чээ.

Ж. Уртнасан — Депутат аа, хажуугийн хоёр санал дээр үү? Өөрөөр хэлбэл Их засаг, Үндсэн хууль гэсэн 47, 47 хувьтай хоёр хувилбар байгаа шүү дээ. Тэр хоёр дээр та нэрээр санал хураая гэж байгаа юм уу?

Д. Чилхаажав — Сая эмгэнэлийн бичиг уншсан шүү дээ. Үүн дээр нэрээр санал хураагаад, дараа нь Их засаг гэдэг дээр цөөнх болсон дээр мөн нэрээр санал хураая гэж байгаа юм. Ажил хойш нь татаж байгаа юм биш ээ. Та битгий хүнийг эсэргүүцээд байгаарай. Ажлаа урагш нь явуулъя гэж байна шүү дээ. Яахаараа хуучин юман дээрээ хавхаатраа суугаад байдаг юм бэ?

Ш. Шагдарсүрэн 283-р тойргийн депутат — Би эхлээд нэг зүйлийг хэлмээр байна, олон депутатуудад. Хүн үг хэлж байхад

II.

хашгиралдаж бүдүүлэг зан гаргадагаа болино уу, яагаад гэвэл дэгийнхээ дагуу ажиллах ёстой. Нэгийгээ сонсох ёстой. Өөрсдөө сонсохгүй гэж байгаа бол би заавал сонсох гэж байгаа юм биш. Сонсохгүй гэж байгаа нь чихээ бөглөөд сууж байж болно, энэ нь хүний эрх юм. Тэгээд би саяны уг хэлсэн депутат Чилхаажавын саналыг дэмжиж байна. Өчигдөр би мөн дэмжсэн. Энэ нь ямар учиртай юм бэ гэхээр ноднин тэмдэглэсэн гэж ярьж байна. Үүнийг би сайн бодож үзээд юу гэж ойлгож байна вэ гэхээр энэ нь депутатуудын ой, тоонд үлдээгүй учраас ингэс, тэгисхийгээд өнгөрсөн юм байна гэсэн сэтгэгдэл нэгдүгээрт төрч байна.

Хоёрдугаарт юу гэж бодож байна вэ гэхээр ер нь бид өнөөдөр энэ Үндсэн хуулийн дор, нэрийн дор хэлмэгцүүлсэн тэр хуулиас шинэ хуульд шилжих гэж байгаа энэ үе мөн.

Гуравдугаарт өнөөдөр шинэ Үндсэн хуулиар ахин ийм зүйл гаргуулахгүй гэсэн баталгааг бид хийж өгч байгаа.

Гуравдугаарт бид өмөөдөр улсынхаа нэрийг өөрчлөх тухай ярьж байгаа юм. Шинэ Монгол улсад орох гэж байгаа. Үргэлж БНМАУ-ын нэрийн өмнөөс уявж, тэр хүнүүсийг цааш нь харуулах байсан ийм тохиолдол бий. Тийм учраас өчигдөр Билигсайхан депутатын тавьсан саналыг хэрвээ хүлээж авдаггүй юм бол, одоо орхих гээд байгаа бол санал хурааж байж шийдэх ёстой. Үүнийг босож хүндэтгэх үү, үгүй юу. Бид ийм учир шалтгаанаар тавьж байгаа болохоос бэлн, ноднин шиг хүний ой, тоонд үлдэхээргүй босоод өнгөрчихсэн юм шиг ойлголтоор хэлээгүй юм гэдгийг би тодруулж хэлмээр байна.

Р.Ёндондэмбэрэл 36-р тойргийн депутат -...

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



Ц.БАТРМАА

Бичээч С.ТУУЛ

23

Ардын Их Хурлын 36 дугаар тойргийн депутат Ёндондэмбэрэл:— Би ер нь санал бодлоо хэлээгүй байгаа.Өнөөдөртэй 8 хонолоо.Хурлын үйл ажиллагаатай холбож еерийн зарим саналыг хэлье гэж бодсон юм аа.Энэ найм хоног хуралдахад үр дүн багатай хуралдлаа.Энэнийг олон депутат хэлсэн. Цаашдаа ингэж үргэлжлэх юм бол бид ерөөсөө энэ Үндсэн хууль гэдэг юм чинь батлагдахгүй тарахад хүрэх нь ээ.Ганцхан нэр дээр бүтэн өдөр маргалдаад шийдэж чадаагүй.Нэрийн асуудал ер нь Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх ерөнхий шүүмжлэлийн хоёр хоногт үндсэндээ мэдэгдчихсэн байсан.Энэнийг бол ерөнхий хэлэлцүүлгээс ч танхимын уур амьсгал их тодорхой байсан.Гэтэл төслөө хамгаалахын тулд Улсын Бага Хурал тухайлбал Чимид тэргүүлж энэнийг эсэргүүцэх янз бүрийн тактик боловсруулж байна.Өнгөрсөн хавар Улаанбаатар хотын 60 гаруй депутат Засгийн газрын үйл ажиллагааны явц, Үндсэн хуулийн анхны төслийг хэлэлцэж ээлжит бус чуулган зарлахыг шаардсан боловч Улсын Бага Хурал,Ерөнхийлөгчийн хамт маргааш нь60 гаруй депутатыг цуглуулж бүлэглэн дайрч энэ саналыг няцааж зөвлөлгөөн гэсэн мөнгө үрсэн, ач холбогдолгүй зүйлийг зохион байгуулсан.

Ээлжит бус чуулган зарлахыг санал болгосон депутат нарыг төрийн эргэлт гаргах нь ч гэж дайрч цавшилсныг манай Улаанбаатар хотын нэлээд депутат мэднэ.Үндсэн хуулийн төсөл хангалтгүй, муу боловсруулагдсан гэж би депутатын хувьд, хуульч хүний хувьд үзэж байна.Олонхийн санал аваагүй,энэ дээр хоёр дахь хувилбарыг гаргаагүй, тухайн үед хавар энэ асуудлыг ярилцаж байхад ард түмнээс зарчмын асуудлууд дээр, одоо ард түмнээр хэлэлцүүлж санал авч болох байсан боловч хугацаа байхгүй гэдэг нэрээр энэ саналыг авахуулаагүй, Улсын Бага Хурал,Үндсэн хууль боловсруулах комисс энэнийг зөвшөөрөөгүй, Үндсэн хуулийн төсөл бол ганцхан хувилбараар хийгдсэн гэдгийг бид авч хэлж байна.Үндсэндээ Чимид гуайн үндсэн саналаар л боловсруулагдсан, гэвч Улсын Бага Хурал дотор бас цөөнхүүд байсан.Тухайлбал депутат Жанцан, Баяр, Лхагважав гуай нарын санал бодол бол бидэнд ойлгомжтой байгаа шүү дээ.Түүнчлэн Ерөнхийлөгчийн хүчтэй засаглалыг төсөлд тусгахыг санал бол-

2.

госон боловч хүлээж аваагүй, өнөөдөр ингээд засаглалын асуудал хэлэлцэхэд бол энэ бол нэг өдөр ч биш, хэдэн өдөр хэлэлцээд ер нь зөвшилд хүрэлцэхээргүй ийм асуудал болж хувирч байх шиг байна. Аливаа хууль боловсруулахдаа заавал тайлбартай боловсруулдаг...

Т.Очирхүү:—Хурлын дарга аа! Та ямар асуудлыг хэлэлцүүлэхээр энэ улсуудыг босгоод байгаа юм бэ? Ерөнхий хэлэлцүүлгийг та таслаа бие дээ!

Р.Ёнцондэмбэрэл:—Та хүлээж бай. Та үргэлж босдог шүү дээ. Улсын Бага Хурлынхаа саналыг хамгаалж.

Т.Очирхүү:—Чи намайг биш, бусдыг хүндэлж бай.

Р.Ёнцондэмбэрэл:—Зөвлөлгөөн дээр төслийг тайлбартай хамт боловсруулах санал тавихад Чимид дарга хүлээж аваагүй.

Ж.Уртнасан:—Уучлаарай депутатууд аа! Цөөнхийн саналыг сонсох ёстой гэж ойлгож байгаа шүү. Өчигдөр бид хоёр санал дээр 47, 47 хувийн санал аваад зогссон шүү дээ. Энэнийг та бүхэн мэдэж байгаа. Цөөнхийн санал. Товчхон ярмаар байна. Ерөнхий санал шүүмжлэлийг бид зогсоосон шүү.

Р.Ёнцондэмбэрэл:—Өнөөдөр бид энэ төслийг хичнээн хэлэлцээд ямар нэгэн зөвшилд хүрэхгүйгээр ийм тактик боловсруулчихаад нийт депутатуудын эсрэг энэ тактикаа тулгаад байна аа. Үүнийг Улсын Бага Хурал, түүнийг дэмжигчдийн хурал бол, ер нь хурлыг үймүүлэх байдалтайгаар явагдаж байна. Жишээлбэл депутат нөхөр Тангад, Чилхаажав мэтийн хүмүүс байнга босч, энэ танхимын уур амьсгалыг хордуулж, өөрийнхөө санал боллыг тулгаж байгаа. Төслийн асуудалд ямар нэгэн өөр санал гарангуут Улсын Бага Хурлын зарим депутат гишүүд хуучин төслийг хамгаалсаар хойно хойноосоо босч ирж байгаа.

Танхимаас Б.Галсандорж:

—Дарга аа. Энэ доромжлолыг зогсоогоочээ. Энэ гүтгэлгийг зогсоогоочээ. Нөлөөлөх гэсэн оролдлогыг ганцыг ч хүлээж аваагүй



3.

байж байж энэ цоромжлолыг чөлөөтэй хэлүүлдэг ямар учиртай юм бэ? Хурлаа гартаа аваачээ царга аа!

Ш.Уртнасан:—Уучлаарай депутатууд аа. Ингэж хурлын уур амьсгалыг, танхимын уур амьсгалыг хэт туйлшруулж, хурцатгаж болмооргүй байна. Хардаж, сэрдэж, Улсын Бага Хурлаа харцдаг явцыг зогсооё. Энэ болохгүй байна. Ингэж хурцатгаж болохгүй шүү дээ.

Р.Ёндондэмбэрэл:—Хоёрдугаарт, хурал удирдаж байгаа царга ч гэсэн зарим зүйл дээр өөрийнхөө бодлогыг хамгаалахын тулд ерөөсөө цөөнх гэдэг саналын нэрийн дор ерөөсөө туйлшруулж байгаа шүү.

:— Га Үндсэн хуулийнхаа нэмэлтийг уншчихаад хүн цоромжлооч.

Р.Ёндондэмбэрэл:—Би хүн цоромжлоогүй, би бодлоо хэлж байна.

—Га нар бод л доо. Ерөнхийлөгч ч гэсэн өөрийнхөө бодол санааг хэлж чадахгүй байгаа шүү дээ. Зарцыхан гуай ч мөн хэлж чадахгүй байгаа. Улсын Бага Хурлын юун дээр анх зөвшилцчихөөд өнөөдөр өөрийн бодол байвч юмаа хэлж чадахгүй байгаа. Жижигхэн тайлбар тавих гэсэн ч ерөөсөө болохгүй байгаа шүү дээ. Тэгэхэд чинь эхнээсээ депутат босч ирээд цоромжлоод байдаг.

—Би ер нь болилоо. Эцэст нь ерөөсөө депутатууд сонор сэрэмжтэй баймаар байна. Ер нь энэ янз бүрийн элдэв ятгалга ухуулгад ороод өөрийнхөө, ард түмнээсээ, сонгогчдоосоо хүлээж ирсэн өөрийн бодол, санаанаас ухарч байгаа депутатууд их олон байгаад би их харамсаж байна.

Ш.Уртнасан:—Депутатууд аа! Нэг ерөнхий хүсэлт байна. Нийт депутатуудаа. Ингэж хурлын уур амьсгалыг хурцатгаж, ингэж бие биенээ хардаж, туйлшруулж болохгүй. Бид уужуу ухаалаг сэтгэлээр гол чигч шийдвэрлэх ёстой, бид ухаалаг шийдэх ёстой. Ингэж хамаагүй туйлширч бие биенээ хардах явцыг би их харамсаж байна.

Нэгдүгээр микрофон.Цөөнх шүү.

Танхимаас:

-Би тэр эмгэнэл илэрхийлэх дээр саналаа хэлээдэхье.

Танхимаас:

-Дарга аа! Энэ чинь нэг асуудлаа шийдэж байгаад цаашаа явмаар байна шүү дээ.Тааер юм уруу явуулаад байна шүү дээ энэ чинь.Бид санал хэлсэн шүү дээ.Цөөнх нь энэнийхээ дараа ярьдаг юм байгаа биз.Эхнийхийгээ шийдчихээд цаашаа явмаар байна.

Ш.Уртнасан:-Санал хураалтанд бэлтгэнэ үү депутатууд аа! Депутатууд суудалдаа суухгүй юу.Санал хураалтанд бэлтгэе. Та бүгдийг суудалдаа суухыг урьж байна.Санал хураалтанд бэлтгээрэй.Өчигдөр ирсэн хэд хэдэн санал, өнөөдөр ардчилсан эвсэл бүлгээс ирсэн 102 депутатын саналыг бид хүндэтгэж байна.Санал хураалт явуулъя.Хэлмэгцэгсдийн дурсгалыг босч хүндэтгэе гэсэн томъёоллоор санал хураалт явуулах гэж байна.Уучлаарай депутатууд аа! дахин хэлье.Дахин сонордуулъя. Хэлмэгцэгсдийн дурсгалыг босч хүндэтгэе гэсэн томъёоллоор санал хураалт явуулах гэж байна.Бэлтгээрэй.Санал хураалт явуулж байна.

Танхимаас:-Энэ дээр юм хэлмээр байна.Өөр санал байна.

Ш.Уртнасан:-Зарим депутатуудын болон бүлгийн хүсэлтээр бид санал хураалт явууллаа.327 хүн санал хураалтанд оролцсон байна.147 хүн буюу 45 хувь эвшеерч, 115 хүн буюу 35 хувь татгалзаж, 65 депутат буюу 22 хувь түүдгэлэсэн байна.Аль аль нь олонхийн саналыг авч чадсангүй.

Одоо хоёр дахь санал хураалтанд бэлтгэнэ үү.Бид сая цаг дэндүү үрлээ. 427 толгой, 427 хүн зохиолч болох юм бол бид үнэхээр Үндсэн хуулиа баталж чадахгүй.Ийм учраас өчигдрийн бүлгийн ажлагч нарын саналыг сонсоё гэсэн энэ маань ч талаар өнгөрлөө.Ийм учраас хурлыг бид шуурхай,цэгцтэй явуулахын тулд өчигдрийн хоёр санал дээр дэгийнхээ дагуу

5.

хоёр санал дээрээ санал хураалт явуулъя. Дахин сануулахад хэрвээ хажуугийн хоёр санал, хажуугийн саналууд олонхийн санал авч чадахгүй бол үндсэн эх хүчин төгөлдөр үлдцэг парламентын ёсыг та бүхэнд дахин нэг сануулъя. Одоо бидэнд байгаа хувилбар маань Их засаг гэдгээр санал хураалт явуулна. Үндсэн хууль гэдгээр хоёр дахь санал хураалт явуулна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

**Танхимаас:**—Хурлын дарга аа, олонхийн санал авахгүй бол хуучин санал тогтоно гэсэн тийм юм бид нар дэгэндээ оруулаагүй шүү дээ. Яагаад энэ дундаас нь шийдэ юм гаргаж ирж байгаа юм бэ? Хоёрын хоёр хажуугийн санал байхгүй бол хуучин оруулж ирсэн нь хүчинтэй болно гэсэн тийм юм хаанаас гаргаж ирж байгаа юм. Ер нь ийм юм байхгүй шүү дээ. Хурлыг дундаас нь үймүүлж байдгаа татвал таарна.

**Ж. Уртнасан:**— Уучлаарай. Аль ч парламентын асуудлыг хэлэлцдэг түгээмэл хууль иймбайдаг. Хажуугийн санал олонхийн саналыг авч чадахгүй бол эх төсөл хэвээрээ үлддэг.

**Танхимаас:**—Дарга аа, зөвшөөрсөн хүмүүс нь босоод эмгэнэл илэрхийлэх бололцоо олгоно уу

Ардын Их Хурлын 134 дүгээр тойргийн депутат **Ч.Найдан:**— Монголчууд Үндсэн хуулийг баталж байгаа учраас монгол ухаанаар л шийдье. Тэр олон улсын парламента битгий яриачээ. Хэрэггүй, Монголынхоо хуулийг л баталъя. Монгол ухаанаар л шийдье.

**Ж. Уртнасан:**—Таны хувилбар ямар санал байгаа юм бэ? Өөрийнхөө саналыг хэлэхгүй юу?

**Ч.Найдан:**— Санал үндсэнтээ гарчихсан гэж бодож байна. Тэрийгээ дэгийнхээ журмаар бид сонгуулиа явуулаад, үндсэнтээ хажуугийнхаа хоёр саналыг хэлэлцээд, эцсийн хамгийн сүүлийн шийд нь 60 хувь аваад шийдэл нь Үндсэн хуулиар орсон л доо.

Би далимд нь хэлчихмээр байна.Өчигдөр Даш-ёндон дарга яагаад МАХН-ын гишүүцийн саналыг тулган хүлээлгэж байгаа юм бэ? Энэ бол буруу болов уу гэж бодож байна.Ерөөсөө л бид Үндсэн хуулиараа баталмаар байна.Үндсэн хуулиар л баталмаар байна ерөөсөө.

Ж.Уртнасан:—Санал хураалт явуулаад шийдчихье л дээ.Ингэж бухимцаад яах вэ.Депутатууд аа хоёр хувилбар дээрээ санал хураалт явуулъя.Тайван байна уу?

Арлын Их Хурлын 427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж:—Саян тэр эмгэнэл илэрхийлэх дээр зөвшөөрсөн 147 хүнийг босч эмгэнэл илэрхийлэх бололцоо олгоно уу.Та хэрвээ тэр текстийг уншиж чадахгүй бол хажуу дахь орлогчдоо өгөөд уншуулаачаачээ.Текстийг уншаад , тэгээд эмгэнэл илэрхийлье.

Ж.Уртнасан:— Энэ дээр бичсэн зүйлийг би уг үсэг алдалгүй уншсан гэж ойлгож байгаа.

—Хурлын дарга аа! Эмгэнэл илэрхийлэхэд татгалзаж байгаа, зөвшөөрч байгаа хоёрыг нэрээр санал хураагаад хэвлэл мэдээлэлд өгье.

Ж.Уртнасан:—Нэрээр санал хурааж болно оо.

СОРОНЗОН ХАЛБСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



П.ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

Ш.Гүрбазар /167 дугаар тойргийн депутат/ -Энэ эмгэнэлийн асуудлыг би өөрөөр ойлгож байна.Хэрэв бид эмгэнэвэл чин сэтгэлээсээ эмгэнэх ёстой.Монголын ард түмэн энийг эмгэнэх...

/Танхимаас/

-Гүрбазараа

битгий доромжлоод байгаарай.Чин сэтгэлээсээ хэн эмгэнэхгүй байгаа юм бэ?

Ш.Гүрбазар -Асуудал яаж гарч ирсэн бэ гэдгийг бид бодъё. Энэ хүмүүс улс төрийн тоглоомд орж хэлмэгдсэн.Гэтэл өнөөдөр энийг улс төрийн тоглоом болгож гаргаж ирсэн.Үндсийг нь ерөөсөө ингэж гаргаж ирсэн.Өөрөөр хэлбэл энэ тоглоом шиг юм болгож байна. Үндсэн хууль гэсэн нэрийг батлах уу үгүй юу? Батлах юм бол та нар эмгэнэлийг, тэр хүмүүсийг, хэлмэгдэгсдийг доромжилж байна гэдгээр ингэж тулгаж гаргаж ирж байна шүү дээ. Мартаж мартаж байгаад, энийг санаж байгаа юм шиг ингэж улс төрийн хэлмэгдэлд энэ хүмүүсийн гэгээн дурсгалыг оруулж яагаад ч таарахгүй.Ийм учраас бид хүндэтгэвэл энэ Үндсэн хуулиа баталсны дараагаар, энэ Үндсэн хууль маань цаашид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гэдэг үүднээс дараа нь хүндэтгэх ёстой гэж бодож байна.

Б.Чимид /396 дугаар тойргийн депутат/ -Өчигдөр орой санал хураахад 47, 47 болсон.Протокол үзэж болно.Тэгэхээр 47,47 чинь цаад талд нь энэ бол 94 боллоо гэсэн үг. Цаад талд нь цөөнхийн санал гэдэг нь тэр үлдэж байгаа 7 хувийн санал байх ёстой.Тэр зургаагийнхаа саналыг сонсох ёстой юм. Өөрсдийнхөө санал өгснийг мэдэж байгаа байх.Жишээлбэл би түдгэлзсэн.Энэ бол номоороо явна.Яг номоороо явах ёстой байна. Тэгэхээр 47,47 энэ бол тэнцсэн.

Ж.Уртнасан -6 хувь, цөөнх нь саналаа хэлэх ёстой.

Б.Чимид -Тэгэхээр одоо цөөнх нь хэлэх ёстой.

Ийм юмаа надаар хэлүүлнэ гэвэл би хэдэн юм хэлмээр байна.

2.

Энийгээ хурлын дарга баримаар байна. Хамгийн бага тоогий нь цөөнх гэж үзмээр байна. Тэрнээс биш хайнцсан юмыг хэлмээргүй байна.

Ж. Уртнасан -6 хувь буюу цөөнх л саналаа хэлж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ.

Б. Чимид -Тийм, тэгэхээр яагаад түдгэлзээд байна вэ гэхээр монгол үгийг монгол үгээр тайлбарладаг тийм улс байхгүй. Тэгэхээр тайлбарласан биш хоёр нэр тавьсан. Тэр минийх биш. Ер нь энэ хууль бол миний төсөл бишээ. Бага Хурлын төсөл. Бид хуйвалдаан зохион байгуулаагүй. Энийгээ хэлчихье. Тэгэхдээ Их Хурал дээр энийг заргалдахгүй. Нэгдүгээрт энэ байна.

Хоёрдугаарт, Их засаг гэдэг дээр Их засгийн хууль гэж хийхгүй бол болохгүй. Тэгэхээр монголчууд нэг үгэнд их дурлагдгийг би мэднэ. Нэг л шинэдүү үг гараад ирвэл төрийг юм болгон дээр хэрэглэдэг. 1960-аад онд боловсронгуй болгох гэдгийг юм болгон дээр хэрэглэсэн. Тэгээд ямар ч амжилт олоогүй, одоо юм болгоныг засаг гэдэг үгээр төлөөлүүлдэг болчихжээ. Гүйцэтгэх засаг, төрийн засаг, засаг дарга, гэр бүлийн засаг, засаг хууль, номонд биччихсэн байгаа, би худлаа юм ярьдаггүй. Ийм байна. Энэ болохгүй байна. Засгийн хууль гэдэг асуудал /та бид хоёр нас ойролцоо/ ийм байна. Тэгэхээр одоо удахгүй ингээд улсынхаа нэрэн дээр маргана. Улсын нэрэн дээр энэнээс ч ширүүн маргаж магадгүй харагдаж байна. Тийм учраас энэ Үндсэн хуулийн нэр гэдэг чинь болбол Монгол улсын Их цааз гэж дөрвөн үгнээс бүтсэн төсөл байгаа. Хуучин БНМАУ-ын Үндсэн хууль гэж долоон үгнээс бүтэж байгаа. Ингээд бөгснөөс нь авч яриад, сүүлд нь толгой руу нь ороод хачин юм болох нь ерөөсөө.

Бид маргааш яахав гэдгээ ярилцах нь зүйтэй байна. Тэгэхээр энэ БНМАУ-ын Үндсэн хууль гэдэг долоон үгэнд ямар нэгэн өөрчлөлт орох ёстой. Бид дэлхийн жишгээр харах ёстой. Дэлхийн жишгээр харахгүй юм бол Үндсэн хуулиараа дэлхийтэй харилцана. Манай улсын төрийн тэргүүн эхлээд Үндсэн хуулиараа эхлээд төрийн

## 3.

тэргүүнүүдтэй эхлээд ярих болно. Парламент ялгаагүй, депутат ялгаагүй. Ямар ч өөрчлөлт оруулахгүй гээд энэ долоон үгэн дээр зүтгэвэл хэтэрхий харанхуй хэрэг болно. Жишээ нь социалист систем гэж байгаагүй, Бирмийн улс, дотор нь социалист бирм гэж Үндсэн хуулийнхаа дотор нь бичсэн тэр үгээ хүртэл авчихаад, нэрээ хүртэл сольчихоод байна. Тэр Дорнод европын орнуудыг больё гэж бодъё. Ард гэдэг үг өнөөдөр болохгүй гэдэг нь тодорхой. Ийм учраас Үндсэн хуулийнхаа нэр, Улсынхаа нэрийг нэгэнт овогтой, нэртэй гэж бодвол бүхэлд нь авч үзэж ганцхан санал хураамаар байна.

Ж. Уртнасан - Ингэж задалмааргүй байна.

Б. Чимид - Задлаагүй, би харин нэгтгэж байна. Энэ ганцхан саналыг Монгол улсын Үндсэн хууль гэж санал хураалгах санал оруулж байна.

85-р тойргийн депутат К. Сайраан: - Эрхэм дарга, саяын эмгэнэл илэрхийлэх зөвшөөрөл өгсөн 147 хүнд ганц минутын бололцоо олгохгүй юу. Эмгэнэл илэрхийлэх. Би энэ текстийг дахин уншъя. Монголчуудын эртний уламжлалт төрт ёс, монгол түмний сэргэн мандалтыг бататгах тулгар их хуульдаа нэр хайрлахын өмнө монгол улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөө, сайн сайхны төлөө алд биеэ алдруулан зүтгэж яваад, большевизмын гар хөл болсон гадаад, дотоодын харгис хүчний аймаглан устгах балмад үйл ажиллагаанд өртөж амь үрэгдсэн гэм зэмгүй олон мянган хөвгүүд охидныхоо гэгээн дурсгалыг хүндэтгэн гүн эмгэнэл илэрхийлье. Ардын Их Хурлын II чуулганд оролцогчид. Саяын 147 хүнд нэг минутын бололцоо олгохгүй юу. Ганц минутын зөвшөөрөл хүсч байна. Тэгээд үндсэн энэ хурлын асуудалд оръё.

Ж. Уртнасан - Уучлаарай эрхэм депутатуудаа. Бид ийм зарчмын асуудал дээр бас ухаалаг, харилцан бие биеэ ойлгосон шийдвэр гаргах нь зүйтэй гэж бодож байна. Бид нэг минут босож хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэхэд илүүдэхгүй гэж бодож байна. Ийм учраас энэ депутатуудын саналыг хүлээж аваад...

Танхимаас -Хүсэхгүй нэг нь сууж байж болно шүү дээ.

Ж.Уртнасан -Та нар тэвчээртэй сонсоно уу. Дахин санал хураалт явуулж, энэ хүмүүсийн нэрийг авъя. Хүндэтгэлийг босож хүндэтгэе.

Танхимаас -Хүсэхгүй нэг нь сууж байж болно шүү. Хүн ардын дурсгалыг хүндэтгэхгүй гэсэн улсууд сууж байгаарай.

Ж.Уртнасан -За депутатууддаа дахин сануулъя. Одоо та бид Чимид депутатын хэлснийг санахад зүгээр байна. 47,47 хувь болсон. 6 хувь цөөнх нь саналаа хэлж байгаа гэж ойлгож байгаа шүү.

И.Бадарч /293 дугаар тойргийн депутат/ -Эрхэм хүндэт хурлын дарга, орлогч нараа, эрхэм хүндэт депутат нараа. Бид ингэж хурлаа улс төржүүлж болох уу? Бид эв зүйгээ ололцоно. Яагаад гэвэл бидний цаана бидний сонгосон ард түмэн байна шүү дээ. Энэ саяын хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэж байгаа нь ч мэдэгдэхгүй, үл хүндэтгэсэн нь ч мэдэгдэхгүй юм болж өнгөрлөө. Бид ингэж туйлширмааргүй байна. Бид энэнээс илүү зохицох арга вариант байна. Энэ талаар Ерөнхийлөгч ч гэсэн уулаасаа тогтворгүй байдал гаргаж энийг дэмжсэн үг хэллээ. Ямар үед нь хэлмэгдэгсэд хүчингүй болдог, ямар үед нь хэлмэгдсэн нь өнөөдөр хөндөгддөг юм бэ? Чингис болон Чингисийн аян дайнд оролцогчдод хэлмэгдсэн үй түмэн хүн бий. Энэний тооцоог өнөөдөр хэн гаргаж ирж тавьж байна вэ?

Энэний дараа дараагийн хувьсгал манжийн дарлалын үед бид үхэр тэрэгнээс илүү гарснаараа цавчуулж байсан нэг хэлмэгдэл бий. Энэ бүгдийн түүхийг бид эргэж хармааргүй байна. Тэгвэл тэр шат бүгдэд нь эмгэнэл илэрхийлэх болно. Ийм зарчимгүй байдал гаргаж, ингэж улс төржүүлж байдаг энэ явдлыг одоо зогсоож өгөөчээ.

Ийм учраас ганцхан санал байна. Бид нар чинь юуны тулд энд ирсэн юм бэ? Бид нар өөрсдөө ийм байдлаар нэг нэгэндээ ихэрхсэн, элдэв үг хаясан, хавчиж шахсан, сүрдүүлсэн, микрофоны өмнө зогсож зарласан ийм тэмцлийн хэлбэр бидэнд хэрэггүй.



Өнөөдөр энд чинь бид ууртай шартай хүнийг шалгаруулах гэж байгаа юм бишээ. Бид улсынхаа Үндсэн хуулийг батлах гэж байна. Энд зарчмын ганцхан асуудал дээр хурлын дарга та өнөөдөр нэг шийдэмгий хандаад санал хурааж өгөөчээ. Бид Үндсэн хууль гэдэг дээр нэг санал гарсан, нэг хэсэг жаахан олонхийн саналыг авсан. Дахиад Их засаг гэдэг дээр бас санал авсан. Ийм хоёр вариантаар үлдэж байгаа. Гэтэл гурав дахь нь өчигдөр Чимидээс урд, Чимидэд дургүйцээд байгаа бол, Чимидийн санал ч бас ээв юм шүү дээ. Чимидэд дургүйцээд байвал өчигдөр гарсан саналын дагуу гуравдахь, энэ хоёрын дундаас гарч ирсэн чинь Их засаг хууль гэдэг нэртэй, хууль гэдэг үгийг нэмснээр санал авчихвал энэ өнөөдөр хэрүүл маргаан тасарчихаж мэднэ шүү.

Их засгийн хууль биш, Их засаг хууль гэдэг нэрээр нь ганцхан санал хураагаад өгөөчээ. Энэн дээр бид нар тохиролцоонд хүрчихэж мэдэх байгаа юм. Их засаг хууль. Өнөөдөр засаг гэдгийг ард түмэн ойлгохгүй байгаа учраас хууль гэдэг ганцхан үгийг нэмье. Энэ саналыг өчигдөр хэдэн хүн гаргасан шүү дээ. Тэгээд бид дараагийн хэлэлцүүлгэнд үлдээх ёстой гэж санал гаргасан. Энийг хэрэгссэнгүй. Тийм учраас та одоо миний хүсэлтээр, би ч бас Билэгсайхан шиг энэ микрофоны ард зогсолт зарлаж чадна. Ийм учраас Их засаг хууль гэж нэрлээ гэдэг дээр бүх нийтийн санал хураалт явуулж өгнө үү. Бид тохиролцоонд хүрье л дээ. Хурлын даргаа. Их засаг хууль гэдэг дээр санал хураалтыг дахин явуулж өгнө үү. Залуучууд минь энийг ойлгож үзээчээ.

Ж. Уртнасан – За баярлалаа. Энийг анхааралдаа авлаа.

Ц. Хаадгар /210 дугаар тойргийн депутат/ – Хуулийн хувьд нөхөр Бадарчийн саналыг дэмжиж байна. Ингээд би депутатуудад хандаж нэг хүсэлт гаргамаар байна. Энэ хуулиас бид сая тэр хэлмэгдэгсдээ хүндэтгэж байгаа нь ч мэдэгдэхгүй, яаж байгаа нь ч мэдэгдэхгүй, Бадарчийн хэлдэг шиг ийм болоод өнгөрчихлөө. Тэгэхээр тэднийг хүндэтгэхэд буруудах юм байхгүй. Гэхдээ өнөөдөр нэгэнт тэднийг хүндэтгэж байгаа юм бол энэ Үндсэн хуулиас буруудаж, Халх голд амь үрэгдсэн, эх орноо хамгаалах ёстой

дайчдынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэе.

Хоёрдугаарт, хамгийн ойрхон жишээг хэлэхэд өнгөрсөн жил мөн Үндсэн хуулиас болж хөдөлмөрлөх эрхтэй, хөдөлмөрлө гэсэн ийм заалттай, өнөөдрийн бидний яриад байгаа хуулинд ийм заалт байхгүй. Тэрнээс болж Налайхад амь үрэгдсэн улсуудынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэе.

Гуравдугаарт нь, жилийн жилд хүйтэнд малаа маллаж явж байгаад осгоод үхчихдэг малчид олон бий. Одоо тэднийхээ дурсгалыг босож хүндэтгэе. Нэгэнт ингэж л туйлшрах юм бол, энэ хурлыг зориуд ийм байдалд оруулж байгаа юм бол бид энэ саналыг хэлэх ёстой. Энийг хүлээж авч бид тэр Халх голын, Налайхын, малчдынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэж нэг минутын, энийг одоо зөвшөөрч өгөөчээ гэсэн ийм саналыг хурлын даргад санал хураалгаж өгөөч гэсэн хүсэлт байна.

Ч.Тэрбиш /406 дугаар тойргийн депутат/ -Эрхэм депутатуудад хандаж нэг хүсэлт байна. Бид ер нь монгол ёсоо алдаад, нөгчигсөдийнхөө гэгээн дурсгалыг хүндэтгэж чадахгүй, тэдний нэр алдраар хожоо олох гэсэн, улс төрийн наймаа хийх гэсэн ийм юмаа дахин гаргамааргүй байна. Билэгсайханы эхлээд гаргасан санал ч яг ийм зорилготой нь ойлгогдож байсан учраас хүмүүс татгалзсан. Тэрнээс тэр Үндсэн хуулийн хүрээнд хэлмэгдсэн хүмүүс ч бай, ямар хуулийн хүрээнд ч хэлмэгдсэн бай, тэр хүмүүсийн дурсгалыг хүндэтгэхгүй гэсэн хүмүүс нэг ч байхгүй. Одоо ингээд Хаадгар сайд санал гаргаж байна. Ингээд яваад байх юм бол бидний өнөөдрийн энэ эдэлж байгаа жаргалыг, бидний амьдарч байгаа эх орныг авчрахын тулд амь насаа алдсан үе үеийнхэн бий. Энэ үе үеийнхнийг бүгдийг нь хүндэтгэж дурсгана гэвэл, дурсгаж босож хүндэтгэе гэвэл бид нэг минутаар зогслоо ч гэсэн бараг бидний нас гүйцэхгүй байх гэж бодогдож байна. Тэгэхээр энийг бас хэлчихье гэж бодож байна.

Хоёрдугаарт, зүгээр хуулийн саналын хувьд Чимид гуайн

хэлдэг маш зөв юм шиг санагдаж байгаа юм, нөхөд өө. Бид нэг юм бодмоор байна. Хэн хэлж байгаадаа биш. Тэрийг нэг ямар юм хэлж байна гэдгийг бид сайн анхаармаар байна. Тэгэхээр бид чинь Үндсэн хууль гэдэг саналыг баталъя гэж Чимид гуай санал оруулж байна шүү дээ. Тэгэхээр Үндсэн хуулийн нэрэнд зүтгээд байгаа улсууд энийгээ бодъё.

Хоёрдугаарт, Монгол улсын Үндсэн хууль гээд тэгэхээр бид монгол гэдэг нэрэн дээр маргах гээд байна. Яаж ч бодлоо гэсэн бид, ямар ч тодотгол хийсэн бүгд найрамдах ч гэнэ үү, хаант ч гэнэ үү, ардын засаг ч гэнэ үү, ямар ч тодотгол хийсэн монгол гэдэг нэр бол ерөөсөө байх шүү дээ, нөхөд минь. Монгол улс гэдэг нэрнээс дангаар нь нэрлэхэд айх ч юм байхгүй. Зарим хүмүүс нармай монголын үзэл сэргэх гэж байна гэж бичдэг юм билээ. Би бол өшөө тэр нь сэргэвэл сэргэнэ л биз, тэгж бодвол бодно л биз. Ер нь яадаг байна гэж бодож байна. Дэлхий нийтээр үндэстнүүд нийлж, нэгдэх үйл явц явж л байна шүү дээ. Хоёр герман нэгдэж байна, хоёр вьетнам нэгдэж байна. Хоёр солонгос, хоёр хятад өчнөөн, төчнөөн салсан үндэстнүүд нэгдэх тухай яриад, тэрийг чинь одоо нөгөө дэлхийн том гүрнүүд, америк, зөвлөлт, хятад бүгдээрээ зөвшөөрөөд, хүлээн тэмцэж байна. Тэгвэл одоо дэлхий нэгээр тарсан хил залгаа хэдэн монголчууд нэгдэх тухай үзэл энэ монгол улс гэдэг нэрийн цаана байвал байна л биз, ер нь яадаг юм. Тийм учраас бид зүгээр Чимид даргын хэлснийг ухаалаг бодоод Үндсэн хуулийн саналынхныгаа, Их засаг санал өгч байгаа улсууд нь дэмжээд, Монгол улс гэж санал өгч байгаа улсуудаа БНМАУ гэж нэрлэх гэж байгаа улсууд нь дэмжээд, хоёр талаасаа зөвшилцөн тохиролцоод ингээд Монгол улсын Үндсэн хууль гэсэн нэрээр саналаа хураачихвал яасан юм бэ? Чимид гуайн саналаар гэж. Ийм саналтай байна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*Ш. Ганзориг* БУРМАА

Бичээч Уранчимэг

1991.XI.19.

Кассет №60

9.55-10.15.

19% дугаар тойргийн депутат Г.Бөхчүлун: -депутатууд та бүгдэд нэг зүйлийг анхаараач гэж туйлын их хүсмээр байна. Миний хувьд босч нэг их ярьж хэлээгүй болохоор сайн мэдэхгүй байна. Урьд өмнө депутат болж төрийн жолоог атгалцаж явсангүй. Ганц гол бодож яваа юм маань ард түмнийхээ хүсэн хүлээж байгаа Үндсэн хуулийг хэлэлцэнэ гэж ирсэн. Өчигдрөөс хойш манай танхимын уур амьсгал үнэхээр өөр болчихлоо. Энүүнд би одоо үнэндээ их эмзэглэж байна. Ингэж бие биендээ цэцэрхэж бие биендээ хуурай үг хаялцаж ингэж баймааргүй байна. Өдий хэмжээний өчигдрөөс хойш бүхэл бүтэн ганц үг хуулийн нэрийн төлөө энэ сайхан хайран цагаа алдлаа. Үнэхээрийн энэ бүхэнд харамсаач ээ. Өөрийн чинь үзэл бодол нь таардаггүй, зарим нэг дотор цухалзсан, ийм бачимдсан зүйл байдаг бол энийгээ депутатууд минь дор бүр хүн болгон өөр өөрсдийгөө бариач ээ. Одоо ингэсээр байгаад хурал хурал биш болох юм байгаа. Ард түмэн бид нарыг чих, нүд болгоод хараад сууж байгаа шүү дээ. Энэ чинь 400 хүний эмх замбараагүй, зохион байгуулалтгүй, бие биенийгээ давах гэсэн биенийгээ ойлголцож чаддаггүй ийм 400 хүний цуглуулга биш шүү дээ. Энэ Их Хурлаа хүндэтгээд та нөхөд маань жаахан ухаан зараач ээ. Хайран сайхан цаг ард чинь хоцорч байгаа юм биш үү.

Одоо Монгол улсын хэмжээгээр эдийн засаг ямар байгаа билээ, байгаль, цаг уур ямар болж байна вэ? гэж өчүүхэн депутат би залуу хүний хувьд ингэж бодож байна. Энэ дээр манай нам, эвсэл холбоодын, ахмад тэргүүний ийм олон улсууд байх юм. Тэгээд янз янзын юм ярьж, биендээ хэв хэлмээргүй, биенийгээ давах гэж оролдсон ийм арчаагүй байдал харагдаад байна. Энэ чинь гадны улс амьтан, депутат биш хүний нүдэнд ямар харагдах вэ гэдгийг та нөхөд маань дор бүрнээ бодож үзээч гэж хүсмээр байна. Энэ үнэхээрийн зовлонтой, ингээд өчигдрөөс хойш улс төрийн танхимын уур амьсгал нэг л эвгүй болчихлоо шүү. Ингэж бие биендээ соёлтой буулт хийгээч ээ. Ингэж соёлтой буулт хийж асуудлыг шийднэ үү гэхээс уурсмогтой чанга дугаар өндөр хашгиралтын үр дүнд асуудал шийдэхгүй

байх. Аль болохоор бие биенээ ойлголцдог тийм юм байна. Энийг би ойлголоо. Тэр асуудлаа би татаж авъя. Миний энэ асуудлыг хэлэлцэж өгнө үү. Санал хурааж өгөөч. Нөгөө талаар хурлын дарга асуудал дээрээ эргэж буцмааргүй байна. Ялангуяа асуудал давхардаж байгаа асуудлыг нөхөр депутат тэрний асуудалтай давхардсан учраас та зогсоогоод нэг дэхэнд нь ямар санал байна, хоёрт нь ямар байна, гуравт нь ямар байна, шинэ шинэ саналуудыг дор нь нэрлүүлэх гээд тайлбар тавиулаад зогсох юм бол хэн ч гэсэн олон цагдирх тийм юм байгаа. Энэ дээр манай депутатууд их ухаалаг хандаач ээ. Сэтгэл их зовж байна.

Д. Уртнасан: -депутатууд аа. Санал хураалтандаа орвол ямар байна вэ? Санал жигдэрлээ гэж бодож байна. Их засаг, Үндсэн хууль хоёр дээрээ санал хураалт явуулъя гэсэн санал оруулж байна.

Депутат тойрог, нэрээ хэлээгүй:

-Та анхнаасаа санал хураах ёстой байсан юмыг Их Хурлын дарга байж үймүүлчихээд ийм байдалд шилжүүлчихлээ шүү дээ. Ийм учраас энийг чинь эхлээд сонсох ч үгүй байсан. Энэ хоёр саналаа хураачихаад хураасныхаа эцэст саяын асуудлыг шийдэх байсан. Өнөөдөр монгол овогтонгууд анх бий болсон цагаасаа хуультай явж ирсэн үү гэвэл хуультай явж ирсэн. Тэгээд хамгийн сүүлд нь эцсийн эцэст 1921 оны хувьсгал руу залгахад сайн ноён хан Намнансүрэн гуай, Ханддорж гуай, Цэрэнчимэд гуай, Богд хаан, үүнийг Балдандорж шахсаар байгаад эд нарын амийг устгаад эцсийн эцэст бид нар анхны үндсэн хуулийн тухай 1924 оны тухай асуудлыг ярьсан л даа. Тэгэхээр энэ чинь яагаад вэ гэхээр ноднин жил яг 9-ний өдөр энэ хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэсэн. Энийг өчигдөр олон таван юм ярихгүйгээр анхдугаар хурлаараа бүгд л хүндэтгэсэн шүү дээ. Тэрийг ийм явуур болгохгүйгээр дор нь хүндэтгэж байсан, энэ талаас нь ингэж аваад үзэхээр. Тэгэхээр өнөөдөр ганцхан нэрийн төлөө, хоёрхон нэрийн төлөө, бид нар ямар хоёр морины наймаа ярих гэж ирсэн биш. Улс эх орны эдийн засаг өнөөдөр тэг дээрээ оччихсон, одоо ч,

цаашаа тэг рүү явж байгаа. Өнөөдрийн амьдрал хүнд байж байхад энэ хууль дүрмийг чинь дор нь батлаад эх орондоо хэрэгтэй юмаа хийх болохоос биш өнөөдөр нэг нэрний төлөө, хоёр нэрний төлөө, одоо ухаан нь гурав гурван нэр байсан л даа. Үндсэн хууль дээр ч 3 нэр гарах байх. Монгол улсын нэрэн дээр ч одоо 3 нэр байгаа байх гэж би бодож байна. Энэ ганц ганц нэрийнхээ төлөө шууд хураагаад жинхэнэ энэ боловсронгуй болсон эх орныхоо төлөө зүтгэх зүтгэлийнхээ энэ Үндсэн хуулиа баталбал яасан юм бэ? Ингээд уул нь сөөм газрын төлөө бүгд үхсэн улсуудын төлөө гэхэд түрхүний Бадарч депутатын хэлээд байгаа дандаа дурсч хүндэтгэсээр байгаад таарна. Одоо 2000 он хүртэл бараг дандаа сонгууль хийгээд дуусна гэнэ. Ийм учраас ерөөсөө хоёулаа хажуугийн санал даа. Их засаг, Үндсэн хууль хоёр чинь. Их цааз бол үндсэн төсөл. Тэгэхээр энэ хоёр дээрээ л шууд саналаа хураагаад тэгээд дараагийнхаа ажилд шууд ормоор юм шиг санагдаад байна, миний бодлоор.

Депутат тойрог, нэрээ хэлээгүй:

Энэ дээр түрүүнээс хойш харагдаад байгаа нэг юм байгаа. Энийг бас мэдэж авмаар байна. Одоо ухуулганд орохгүй, одоо ухуулаад ятгаад байхаа боль гэдэг ийм юм чинь ойлголцохыг хүсэхгүй ч гэж байгаа, ойлгохгүй ч гэж байгаа юмуу, нэг ийм санал байна шүү дээ. Хэрвээ яг энийгээ бид нар сайн тогтож авмаар байна. Хэрвээ тэр ухуулганд үнэхээр яаж ч бид нар хэдэн өдөр ч ярилцаад орохгүй, ойлгохгүй гэж байгаа бол бид нар энд хөрөнгө мөнгө зараад хуралдахын хэрэг алга. Орон нутагтаа очоод захиа явуулчихъя, би эндээсээ хөдлөхгүй гээд. Тэрнээс биш ингээд ярьж ярьчихаад худлаа дараа нь битгий ухуул, би ойлгохгүй гээд нөгөө хуучнаараа байх юм бол үр дүнгүй хөрөнгө зарах гээд байна.

Нөгөө талаар, бид нар 30, 40-өөд оныхоо хэлмэгдлийн ирмэг дээр ирчихээд байж байна. 30, 40-өөд онд тэр эрдэмтэн мэргэдийг бүгдийг аймаглаад устгаад хаясан бол өнөөдөр бүгдээрэнгийн үгийг сонсохгүй байна. Бадрга гуай чинь түүх уншсанаараа буруутай юмуу? Тэр хүмүүс чинь юм мэдсэнээрээ хэлсэнээрээ буруутай юмуу? Эрдэмтдийнхээ үгийг сонсохгүй байж бид нар яаж урагшаа явах юм бэ?

- Депутат тойрог, нэрээ хэлээгүй:

- Уртнасан дарга аа, та ерөөсөө жаахан санаачилгаа гартаа авч энэ удирдлага төвлөрүүлж энэ хурлаа удирдаач ээ. Хүн хүн ам амандаа босоод ингэж халшираад иймэрхүү янзаар ингээд яваад байвал бид ерөөсөө хурал хийж чадахгүй нь байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь одоо хурлын дарга гэдэг чинь таныг яах гэж сонгосон билээ. Та тэгэхээр санаачилгаа тэндээ аваад ер нь одоо тэндээсээ жаахан удирдаж зүгжүүлэхгүй бол 430 хүн гэдэг чинь ингэж цэц булаалцалдаад ингэж үг уралдуулаад ийм янзаар хуралдах юм бол бид ерөөсөө хуралдаж чадахгүй нь, асуудлаа шийдэж ч чадахгүй. Тэгэхээр та бүгд хурлын дарга, орлогч нар жаахан санаачилгатайхан шиг тэндээсээ тэнд бодлогоо төвлөрүүлж жаахан ажил явуулахгүй бол ингэж хуралдаад бид яах юм бэ? Одоо энэ депутатуудаа суулгаад та саналаа хураалгаач. Чимид даргын хэлдэг бол зүйтэй. Тэр саналаар хураах нь зүйтэй байгаа юм.

Д. Уртнасан: - Олноо хүндэтгэе, эрхэм депутатууд аа. Бид бас ард түмнээ хүндэтгэе. Ийм эмх замбараагүй байдал, аргагүй хатуухан гараар барихад хүргэж байгааг болгооно уу, депутатууд суухыг хүсч байна, та бүгдийг. Санал хураалтад бэлтгэе.

Депутат Ламжав санал хураалтад оролцохоос татгалзаж бололтой байх юм. Би тэгэж ойлгож байна, болох уу?

39 дүгээр тойргийн депутат Д. Ламжав: - Би дэгийг сахихгүй байгааг хэлье. Тэгээд одоо саналаа таслах ёстой, нэг талаасаа. Та санал таслаагүй, тэгээд өөрөө суу гэж депутатуудыг уриалж байхын оронд уриалаад депутат хүлээж авахгүй байвал та санал хураалгах хэрэгтэй. Санал хураагаад олонх нь суу гэх юм бол би суулаа. Саналаа хураалга, дэгэнд заасан ёсоор.

Ж. Уртнасан: - Санал хураахад бэлтгэж байна, таныг санал хураахад оролцохыг хүсч байна.

Д. Дамжав: -Та саналаа тасалъя гэж эхлээд санал хураалгачих.

Ж. Уртнасан: -Цөөнхийн саналыг тасалъя.

Уучлаарай, депутатууд аа, энэ техник гацаж байгаа юмуу, аль эсвэл бид ингэж будилж байгаа юм уу. Санал хураалтад 240-хөн хүн оролцсон байна. Ийм учраас та бүгдийг анхааралтай байхыг хүсч байна. 240 депутат санал хураалтад оролцсон байна.

дахин саналыг тасалъя гэсэн санал хураалт явуулж байна. Санал өгсөн депутатуудын 96 хувь нь саналаа тасалъя гэсэн санал ирүүлсэн байна, 382 хүн, 13 хүн татгалзаж, 3 хүн түдгэлзлээ. Санал тасаллаа.

Одоо та бидэнд ирсэн хувилбар дээр та бид хоёрхон хувилбар байгаа. Их засаг, Үндсэн хууль гэсэн хоёр үндсэн хувилбар байгаа шүү, хажуугийн хоёр санал. Тэгэхээр санал гаргасан зарим депутатууд монгол улсын Их засаг хууль гэдэг бүрэн томъёолол оруулж ирсэн. Үүнийг бодолцоно биз, үүнийг зүгээр санаандаа бодоорой. Бид санал хураасан хоёр хувилбараа та бүгд хэвээр нь томъёолж байна. Их засаг, Үндсэн хууль гэдэг хоёр хувилбараар санал хураалт явуулна.

Одоо Монгол улсын Их засаг хууль гэдэг бол таны сүүлчийн гурав дахь томъёолол. Үүнийг бид үлдээж байна. Чимид гуай томъёоллоо хэлнэ үү. Монгол улсын Үндсэн хууль гэдгээр үү? Гурав дахь хувилбар шүү дээ, тэр чинь. Гурав дахь хувилбар болгож байна шүү дээ, та.

396 дугаар тойргийн депутат Б. Чимид: -Тэгэхээр би ийм л юм бодоод байгаа хүн л дээ. Их засаг гэдгийг авах нь авах бодолтой байх шиг байна, нэлээд нь. Тэгэхээр энэний улс төрийн үр дагаврыг бид харах ёстой. Их засаг гэдгийг Иранаас авахуулаад Солонгос хүртэл мөрдөж байсан хууль аа. Тэгэхээр энүүгээр бол бид гадаад талаасаа жаахан



сөрөг үнэлэлтэд орж магадгүй байгаа юм. Ялангуяа өмнөд, баруун, дундад ази гэх мэт. Тийм учраас бид улс төрийнх нь талаас бодвол яасан юм бэ? Тэгээд Үндсэн хуулийнхаа, улсынхаа нэртэй хамт Монгол улсын Үндсэн хууль гээд гаргавал яасан юм бэ гэсэн саналтай байна.

И. Уртнасан: -Хажуугийн хувилбар Монгол улсын Үндсэн хууль, улсынхаа нэртэй, хуулийнхаа нэртэй ийм санал орж ирж байна. Энэ бол Чимид гуайн сая оруулж ирж байгаа хажуугийн хувилбар юм.

Энэ хажуугийн хувилбар саналыг депутат хүлээж авч байна уу. Санал хураая. Ийм гурав дахь хувилбар орж ирж байна. Үүнийг зөвшөөрнө, зөвшөөрөхгүй гэдэг дээр бид санал хураалт явуулчихаад та бидний үндсэн хоёр хувилбар Их засаг, Үндсэн хууль хоёр хэвээрээ байгаа. Үүнийг нээлттэй орхиод зөвхөн Чимидийн нэмэлт санал дээр санал хураалт явуулах уу? Санал хураая.

танхимаас:

-Хоёр нэрэн дээрээ санал хураагаач ээ. Улсын нэр ярьж эхлээгүй байгаа шүү дээ. Тэгэхээр хоёр нэр дээр саналаа авбал зүгээр байна шүү дээ. Тэгээд дараа нь дэгээр улсынхаа нэрийг ярина бие.

Ж. Уртнасан: -Хүлээгээрэй. Чимид гуайн оруулж ирж байгаа хувилбар дээр санал хураалт явуулах уу, үгүй юу гэсэн санал хураалт явуулж байна. Ингэж шийдье. Тайван байна уу, депутатууд аа.

танхимаас:

-Тэгэж яаж болдог юм бэ? Одоо бид нар хуулийн нэр тогтоох гэж байна шүү дээ. Хуулийн нэр тогтоох гэж байхад та нар улсын нэр тогтоогоогүй юмуу оруулж будилуулаад байхдаа яадаг юм бэ?

танхимаас:

-Ингэж үймүүлэх хэрэг алга шүү дээ, Их Хурлын дарга битгий гуйваад байгаач дээ.

танхимаас:

-Чимидийн саяын санал хүчингүй ээ. Санал тасалсан хойно гарсан. Энэ бол улсын нэр, хуулийн нэр хоёрыг хольж хутгаж шийдүүлэх гэж байна. Ингэж болохгүй.

ж. Уртнасан:

-Баярлалаа депутатууд аа. Энэ саналыг хүлээж авахгүй байгаа юм байна. Их засаг санал хураалтад бэлтгэнэ үү.

Их засаг, Үндсэн хууль хоёр дээрээ санал хураалт явуулна. Одоо эхлээд хуулийн нэрийг Их засаг гэдэг томъёоллоор оруулж байна.

284 дүгээр тойргийн депутат ш. Бадам:

-Их Хурлын дарга аа, санал хураахын өмнө юмаа ойлгомоор байна шүү дээ. Хэрвээ энэ хоёр хажуугийн санал чинь олонхийн санал авч чадахгүй бол та хуучнаараа Их цаазаар тогтоно гэсэн. Тэгэхээр чинь ийм, Тэр их цааз чинь 12-хон хувийн санал авсан юмыг бид эргээд тогтох болж байна уу. Энийнхээ учрыг олж байж саналаа хураая л даа.

ж. Уртнасан:

-Санал хураалтад бэлтгэнэ үү. Бидэнд хоёр хувилбар байгаа. Их засаг, Үндсэн хууль хоёр. Энийг дахин сануулъя. Одоо Их засаг, хуулийн нэр Их засаг.

Санал өгсөн депутатуудын 44 хувь буюу 175 нь зөвшөөрч байна, 190 хүн буюу 47 хувь нь татгалзлаа, 36 хүн буюу 9 хувь нь түдгэлзэж байна.

Одоо хоёр дахь хувилбар.Хуулийн нэр Үндсэн хууль.  
Үндсэн хууль гэсэн хувилбараар санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатуудын 63 хувь нь буюу 252 хүн  
Үндсэн хууль гэсэн хувилбарыг зөвшөөрч байна.123 хүн буюу  
31 хувь нь татгалзаж, 23 хүн буюу 6 хувь нь түдгэлзсэн  
санал ирүүлээ.

Бид хуулийнхаа нэрийг дийлэнх олонхийн саналаар баталж  
чадахгүй юм байна.Нээлттэй орхиод цаашаа хэлэлцүүлгийг  
үргэлжлүүлбэ гэж бодож байна.

39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав: —Улсын анх-  
дугаар Үндсэн хууль ямар гарчигтай байсныг л нэг хэлэх  
гэсэн юм.Монгол Ардын Засагт Бүгд Найрамдах Улсын I дүгээр  
улсын хурал баталсан Үндсэн хууль цааз гэж нэртэй батлагдсан  
юм байна шүү.Би энүүгээр юу хэлэх гэж байгаа юм бэ гэхээр  
энэ цааз гэдэг үг угаасаа явж ирээд энд хүртэл салж ядан  
байсныг та бүхэнд сануулах гэсэн юм.

Их цааз гэдэг дээр төслийн ёсоор үлдэх юмуу, эсвэл  
санал авах юмуу? Одоо бол үндсэн юм үлдсэнгүй шүү дээ.  
Тийм учраас төслийг хүндэтгэх тэр зам руу орохоос.

танхимаас:

—Их засаг гээгүй Их засаг хууль гэж олон үе дамжсан,  
Их засаг хуулийг хасаад ингээд нэг үймүүлчихлээ, нэгд.  
Хоёрдугаарт, Чимид яг хэрэгтэй үед нь үймүүлээд Монгол  
улсын Үндсэн хууль гэж хоёр нэрээ ингэж үймүүлж байна шүү  
дээ.Эсвэл Монгол улстай нь хамт батална гэж ойлгоно.Монгол  
улсын Үндсэн хууль гэж.Хамт баталсан гэж ойлгоно.

238 дугаар . . . тойргийн депутат Г.Төмөрбаатар:

—Тэгэхээр энэ саяынхаа санал хураасан дүнгээ, хоёрду-  
гаар хэлэлцүүлэгтээ энийгээ оруулаад дараачийнхаа асуудалд  
орох саналтай байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*М.Дар*  
Ж.НАРАНТУЯА  
Бичээч Ө.Оюунчимэг

71 дүгээр тойргийн депутат Ядамсүрэн -Тэгэхлээр бид ганц ч асуудал шийдэхгүйгээр цаашаа явж болохгүй ээ. Эхнийхээ асуудлыг шийдье. Аливаа асуудлыг эхнээс нь аваад л нээлттэй нээлттэй гээд л хаяад байвал бүгдээрээ л нээлттэй болоод орхигдоно. Ийм учраас яах хэрэгтэй байна вэ гэвэл ерөөсөө Их засаг гэдгээр нэрлэж болохгүй байна аа. Захиргаадалтын хууль гээд ард түмэн нэрлэчихвэл яах вэ. Ийм учраас бид Үндсэн хууль гэдэг саналыг 3 удаа 60-аас дээш хувийн санал авлаа. Энэ дээрээ эргэж тогтоё. Тэгээд энэ гуравдахь хувилбар оруулж ирсэн энэ Чимид гуайн саналыг би дэмжиж байна. Энүүгээр санал хурааж өгөөч ээ.

33 дугаар тойргийн депутат Мөнхөө -Ер нь монголын үе үеийн бүсгүйчүүд бид эрчүүлийнхээ уужуу тайван ухаан, төрийн ноён нуруунд итгэж, шүтэж, дээдэлж явсан. Өнөөдөр ч гэсэн манай эрчүүл уужуу тайван ухаантай, төрийн нуруу түших ноён нуруутай ергөн дэлгэр цэлмэг сайхан улсууд болохоо ард түмэндээ энэ зааланд сууж байгаад цөөхөн ч гэсэн бүсгүйчүүд бидэнд харуулахыг хүсч байна. Ингээд би хоёрхон санал хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт, хуулийн нэрийг таслаж шийдэхэд бид амжилт олсонгүй. Өдөр гаруй хэлэлцээд. Ийм учраас улсынхаа нэртэй хамт авч үзээд монгол улсын Үндсэн хууль гэдэг энэ нэрээр санал нэгдэж санал хураалгавал яасан юм бэ. Энэ бол өнөөгийн манай зааланд хоёр хуваагдаад байгаа энэ хүмүүс хоорондоо саналын зөвшилд хүрэхэд хамгийн хүлээж авч болох вариант мэт депутат хүний хувьд бодож байна аа. Ийм учраас энэ саналыг дэмжиж өгөхийг эрхэм депутатуудаас хүсч байна. Гуравдугаарт, нэг асуудал дээр нэг хүн 3-аас илүү босох учиргүй ээ манай дэгэн дээр. Гэтэл зарим тохиолдолд зарим хүн 6 хүртэл босч байна аа. Ийм учраас манай хурлыг удирдаж байгаа хүмүүс нэг хэлэлцэж байгаа асуудал дээр нэг хүн хэд босч байна вэ гэдгийг нилээн бүртгэж үзэж байвал дээр биш үү. Энэ маань хурлын минь цаашдын дэг журам, цаг хэмнэхэд хэрэгтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

413 дугаар тойргийн депутат Насан-Очир -Би хоёр санал байна. Их хурлын удирдлага хуралдааныг цааш нь залж явах найдвар

итгэл алга байна. Ийм учраас бараг хуралдааныхаа удирдлагыг солих асуудлыг дэвшүүлж байна. Хоёрдугаарт, ард түмнийхээ эрх ашиг, депутатуудынхаа санал бодлыг харгалзан үзэж энэ бүлгүүдийн ажлагч нарын зөвлөлгөөн хийвэл яасан юм бэ завсарлага авч гэсэн ийм хоёр санал хэлье.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

85 дугаар тойргийн депутат Сайраан -Би горимын хоёр санал хэлмээр байна. Аливаа улсын парламентад аливаа хууль хэлэлцэхэд тэрний оруулж ирсэн субъект бол гол улсууд байдаг юмаа. Нэг талаас нь субъект, нөгөө талаас нь хэлэлцэж байгаа парламентын гишүүд. Бидний өчигдөрөөс хойш энэ 7 хоногийн турш хэлэлцсэн ажил маань зөвхөн нэг талын зүйл яваад байгаа юм. Тийм учраас Эрхэм бага хурлын гишүүд, түүний удирдлагад хандаж хэлмээр байна. Энэ гаргаж ирсэн өөрийнхөө хууль, хуулийнхаа үндсийг хамгаалах талаар идэвхтэй ажиллаач ээ, суугаад байх юмаа. Нөгөө талаас Их цаазын хуулийн төслийг хэлэлцэхэд төслийг боловсруулсан комиссын ажлагч нь манай ерөнхийлөгч бас дуугай суугаад байх юмаа. Тийм учраас хоёр талын харилцан ярилцаж байгаад манай дэгэнд байсан зарчмаараа 3-ны 2-нн санал авч чадахгүй юм бол тэр оруулж ирсэн төсөл бол хүчинтэй үйлдэх ёстой. Энэ бол хууль байгаа юм. Үүнийг л бид нар нэгдүгээрт хэрэгжүүлмээр байна. Би үүнийг л хэлэх гэсэн юм.

Ж. Уртнасан -Парламентын энэ дүрмийг бид танилцуулсан Сайраан депутат санаж байгаа байх. За 6 дугаар микрофон.

Д. Маам: -Их хурлын даргаа таны сонорт нэг зүйлийг хүргэх гэсэн юм. Та нэг зүйлийг эхэлж ярьж байгаад тэгээд хажуугийн үгнүүдийг сонсоод, гол зүйлээ, гол зүйл биш байлаа ч гэсэн тэр хавьд нь төгсгөхгүйгээр ингээд явахлаар барих үзүүргүй, татах барьцгүй ийм юм болоод хувирч байна аа. Үүнийг би жишээлбэл сая эрхэм нөхөр Сайраан хэллээ. Та түрүүн хэлсэн. Дэлхийн парламентын практик ардчилал тогтсон ийм хэв галбир байдаг. Хажуугийн саналуудыг хэлэлцээд зохих ёсны хувийг авахгүй болбоос төслөөр орж ирсэн хууль дэвшүүлэгчийн үндсэн санал

нь хэвээр үлддэг гэж.Төгээд үүнийгээ дараа нь мартчихаад төгээд нээлттэй үлдлээ гээд яриад байх юм.Энэ бол нээлттэй үлдэж байгаа биш Их цааз гэдгээрээ үлдэж байгаа шүү дээ.Хэрвээ энэ далхийн парламентын энэ ардчиллын хэв горимыг хэрэглэхгүй юм бол тэрнийгээ тохиролцооор байна.Ёстой санал хураагаад дур зоргоороо загнацгаая гэж.Энэ бол дэгээ өөрчлөнө гэсэн үг.

И.Уртнасан -Эцсийн хэлэлцүүлэг хүртэл шүү дээ.Маам депутат аа.За 7 дугаар микрофон.

314 дүгээр тойргийн депутат Гантөмөр -Эрхэм депутатуудад би үндэслэл тайлбар хэлэхгүйгээр шууд горимын саналаа хэлбэ гэж бодож байна.

Хэлэлцэж байгаа асуудлыг одоо Их цаазаар байх уу Үндсэн хуулиар байх уу гэдэг дээр маргаж мэтгээд яах вэ.Төслийнхөө саналыг хэвээр үлдээнэ,хажуугийн хоёр санал дээр хэлэлцэнэ гэдэг дээр маргамааргүй байна.Тэрийг санал хураалтаар шийдэж болно.Ямар журмаар шийдэж болох вэ гэхээр бид бол ерөнхий хэлэлцүүлэг дээр улсын нэр,хууль тойрсон нэрээр олонхи депутатууд энэ хоёрыг,ер нь боссон депутатууд улсын нэртэй холбогдолтой санал хэлээгүй хүн бол байхгүй.Улсын нэрний талаар бидний хэлэлцсэн хэлэлцүүлэг бол ерөнхий хэлэлцүүлгийн үед хангалттай,үндэслэгээ дүгнэлт нь гарсан гэж үзэж байна.Тийм учраас Монгол улсын Үндсэн хууль гэсэн саян саналаар шууд санал хураах хүсэлтэй байна.

И.Уртнасан -8 дугаар микрофон.

288 дугаар тойргийн депутат Баярцогт -Би гурван санал хэлэх гэж байна.Нэгдүгээрт,хууль оруулж байгаа субъектынхаа талаар тогтохгүй бол ер нь бид учир зүйгээ ололцохгүй нь ээ. Энэ олон улсын парламент,энэ тэр ёсны юм гэж хэлээд яахав.Энд байгаа Их хурлын гишүүд 427-уулаа шийднэ гээд маргалдаад ч яахав.Энэ дээр учир зүйгээ ололцож тогтох ёстой.Би бага хурлынхаа гишүүнийхээ хувьд Бага хурлыг өмөөрөөд энэ дээр үгээ хэлээд байгаа юм биш.Ерөөсөө ямарваа нэгэн тохиролцоонд хүрье гэх юм

бол энэ хууль оруулж байгаа эзэнтэй, үүнийг хамгаалж, хтайлбарлаж байх хүнтэй байх ёстой. Нөгөө талаас нь АИХ-ын депутатууд үүнийг шүүж хэлэлцээд ерөнхий тохиролцоонд хүрч байх ёстой. Ямар нөхцөлд энэ төсөл дээр орж ирсэн үндсэн саналууд үлдэх ёстой вэ гэдгээ энэ дээр бидэнд ярьж тохирсон байх ёстой. Энэ хүмүүсийн яриад байгаа ардчилал хөгжсөн орнуудад энэ бичигдээгүй хууль үйлчилдэг. Тэр хуулийн тухай л яригдаад байна. Магадгүй биччихсэн ч байж магадгүй. Үүнийг бид нар аль аль талаасаа хүлээж авах ёстой. Энэ нэгдүгээр санал.

Хоёрдугаарт, ёс зүйн хувьд депутатуудад анхааруулж ганц зүйл хэлэх гэсэн юм. Бага хурал болон тодорхой хувь хүний эсрэг дайралт хийж байхад хүлээж аваад зүйтэй зүйтэй, үүнийг хэлүүлэх нь зүйтэй гээд, тодорхой нэг Бага хурлын гишүүн хэлэхбосоод үг хэлэхлээр чий боль, дуутай бол гээд ингээд байх бид еерее өөрсдийгөө хэмжиж үзэх ёстой. Бид ёс зүйн хувьд, ёс суртахууны хувьд бид нар ямаршуу хүмүүс болоод энд сууж байна. Ямар хүнийг нь хэлэхлээр дэмжээд, ямар хүнийг нь хэлэхлээр эсэргүүцдэг. Энэ дээрээ бодож үзэж цэгнэх ёстой. Бид ёс суртахуун, ёс зүйн хувьд бол илүү цэвэр ариун байх ёстой. Ингэж байж л бид хуулиа хийх ёстой гэсэн хоёрдугаар санал байна.

Наад зах нь ингээд л бодох хэрэгтэй. Тэр нь цэвэр, энэ нь цэвэр биш гэж хэлээгүй байна. Бид нар бодох ёстой гэдгийг л хэлж байна. Гуравдугаарт нь, тодорхой бүлэг хүмүүс Бага хурал болон Засгийн газрын эсрэг, тодорхой хүмүүсийн эсрэг үгээ хэлж лүд барамд гаргаж сонгуулийн компаниа АИХ-ын чуулганаас эхлэхгүй байхыг хүсч байна.

Ж. Уртнасан - I дүгээр микрофон.

72 дугаар тойргийн депутат Болат - Би энд горимын чанартай ганц нэгэн саналаа хэлье гэж бодож байна. Юуны өмнө хурлын удирдлага ийм асуудлыг анхаармаар юмуу гэж надад санагдсан. Нэг асуудлыг хэлэлцэж байх явц зуураа завсраас нь зарчмын өөр асуудал руу бид хутгалцаж ормооргүй байна. Үүнийг бид хатуу тогтмоор байна нэгдүгээрт. Сая жишээлбэл эмгэнэл илэрхийлэх

тухай асуудал бол би ингэж ойлгож байгаа. Хуулийнхаа нэр, өөрөөр хэлбэл Үндсэн хуулиа хэлэлцэх асуудлаа бид дуустлаа тэр саналыг хүлээж аваад нээлттэй орхиод боловсруулаад, нилээн улсуурьтайгаар энэ асуудлыг шийдсэний дараа үүнийг авч хэлэлцэж болох байсан. Тэгснээрээ бид юу ч хожигдохгүй байсан юм. Ер нь цаашдаа бол ямар ч асуудал хэлэлцэхэд явж байгаа тэр сэдвийг дуусан дуустлаа завсраас нь юм оруулахгүй байх зарчмыг баримтлах арга байхгүй юу нэгдүгээрт. Хоёрдугаарт, саяных шиг их бидний дэгэн дээр тодорхой заагаагүй тулгамдах асуудал гарч байна. Нэг бол санал тэнцэх юмуу эсвэл аль санал дийлэнхийн түвшинд хүрээгүй ийм нөхцөлд бид хэлэлцэж байгаад хязгаарлагдмал тооны саналыг аль аль талаас нь сонсмоор байна. Жишээлбэл, хоёр санал хоёулаа тэнцлээ гэхэд тэр аль нэгэн нэрийг хамгаалж байгаа тав, таван хүний саналыг, хоёр талаас нь зэрэг сонссоны дараагаар дахин санал хурааж үэмээр байна. Үүнийгээ ч бид нар цаашдынхаа горимынхоо нэг зарчим болгож баримтлах арга байхгүй юу. Гуравдахь горимын санал болгож хэлж байгаа асуудал маань саяных шиг асуудал шийдэгдэхэд хүрээгүй тохиолдолд хязгаарлагдсан тооны хүмүүсийн санал сонссоны дараагаар бид нэрээр санал хураах зарчмыг баримталмаар байна. Ийм 3 зүйлийг би горимын шинжтэйгээр энэ дээр дурьдаж хэлэх нь зүйтэй гэж үзсэн.

Хоёрдугаарт би эрхэм депутат Чимидийн гаргасан саналыг бодолцож үзэх ёстой юм. Энэ хүн бол саналаа гаргахдаа улсын нэртэй хамт хэлэлцүүлэх санал оруулсан учраас л зарим хүмүүсийн талархал дэмжлэгийг хүлээгээгүй байж магадгүй. Өөрөөр хэлбэл хоёр асуудлыг зэрэг холбож ярьсан учраас. Тэрнээс биш Их засаг гэсэн энэ нэр томъёо гадаад талаасаа ямар үр дагавар ургуулж гарах вэ гэдэг утгаар энэ хүний ярьсан санааг бид бас тунгааж бодох ёстой. Ерөөсөө Их засаг маань өөрөө үйлчилж тэр түүхэн нөхцөлд угаасаа Үндсэн хууль байгаагүй. Энэ чанарыг бас бид бодолцож үзэх ёстой юм. Дараачийн нэг асуудал бол бид гадаадын парламентын үлгэр загвар гэсэн энэ нэр томъёогоо оржих нь зүйтэй болов уу даа. Эрхэм депутат нарын хэлж байгаа-<sup>Зарим</sup> шиг л монгол улсынхаа хуулийг монголын иргэд өөрсдөө монгол ухаанаараа шийдье гэж үзэж байгаа бол гадаадын тийм газрын



хуулийг дуургаж, ийм загвар байдаг гэсэн батлагдаагүй, магадгүй баталгаагүй ийм нөхцөл дуулианаар асуудлыг бид үлгэр загвар болгож хэлэлцэж өрөөсөө таарахгүй гэж үзэж байна.

168 дугаар тойргийн депутат Ванцанцагва –Байдлаас үзэхэд танхимын уур амьсгал нилээн түвэгтэй болж ирэх нь. Энэ байдлаар бид нар зөвхөн хуулийн нэр ч битгий хэл, цаашилбал улсын нэр, тухайлбал бэлэгдлийн тухай асуудал, ийм уур амьсгалаар шийдэхэд бэрхтэй болох нээ. Тэгэхээр бид хэлэлцэн зөвшиж тохиролцоонд хүрэх зарим арга замаа дөрөөлөх хэрэгтэй болж байна. Бидний саян яриад байгаа энэ бүгдээс огт хамаарахгүйгээр эхний ээлжинд депутатууд бид санал бодлоо нэгтгэж чадах ийм хэсэг бол хоёрдугаар бүлэг болох хүний эрхийн тухай асуудал. Үүнээс цааш гуравдугаар бүлэг буку төрийн байгуулалтынхаа асуудлыг хэлэлцэн зөвшиж чадах байх гэж бодож байна. Төрийнхөө байгуулалтын мөн чанар, шинж тэмдэг, мөн чанарыг илэрхийлсэн улсын нэр, цаашилбал бэлэгдэл, хуулийн нэр гэх мэтчилэн бид нар урвуу хамаарлаа зөвшилцөөнд хүрч болох байх. Депутат нөхөд минь энэ зөвлөлийг бас бодолцож үзэж үүний зэрэгцээгээр зарим түвэгтэй асуудлуудыг нээлттэй үлдээх зарчим бол бидний цагаа хожиж, тодорхой тохиролцоонд хүрэх арга зам гэж бодож асуудалд хандахыг уриалж байна.

Ж. Уртнасан –3 дугаар микрофон.

7 дугаар тойргийн депутат Ц. Балдорж –Энэ танхимд өнөөдөр бид 10 дахь өдрөө хуралдаж байна. Бид бол ямар ч асуудлыг шийдэж чадахгүй юм байна гэдгийг бид нарын энэ хуралдаанаас ажиглагдлаа. Тэгэхлээр надад горимын санал байна. Их хурал таръя. Яахав гэхлээр зэрэг Үндсэн хуулиа баталж чадахгүй болбол Үндсэн хуулийг батлах үүргийг Бага хуралд олгох юмуу эсвэл сонгуулийн хуулийг батлаад дараачийн сонгуулийг явуулахыг Бага хуралд даалгах юмуу, тэгээд дараачийнх нь хуралдаж чаддаг, юм шийдэж чаддаг тэр шинэ парламент нь энэ Үндсэн хуулиа батлаг зэ. Бид бол өнөөдөр энд 420 зөргүүд, бие биеэ доромжилдог, хэрэв саналыг нь хүлээж авахгүй бол хүч хэрэглэдэг.

ямар ч учир замбараагүй ийм 420 хэдэн хүн энд хуралдаад, бид хичнээн олон хоног хуралданав төдий чинээ шившиг болно сонгогчдынхоо өмнө. Ийм учраас надад горимын санал байна. Энэ Их хурлыг тарааж өгөөч ээ. Бага хуралд эрхийг нь олгоё гэдэг дээр санал хураалгаж өгөөч гэсэн санал байна.

Ж. Уртнасан -4 дүгээр микрофон.

145 дугаар тойргийн депутат Лантуу -Тэгэхлээр эрхэм хүндэт депутатуудад би еерийнхөө санал бодлоо хэлмээр байна. Нэгэнт нийгмийн харилцаа үндсээрээ еерчлөгдөж байгаа учраас бидний батлах гээд байгаа, хэлэлцэж байгаа энэ Үндсэн хууль бол ихээхэн хэмжээний еерчлөлт орох нь зүй ёсны зүйл болов уу гэж бодож байна. Энд юуны өмнө эхлээд бидний анхаарах ёстой асуудал бол 4 асуудал байгаа гэж бодож байна. БНМАУ-ын нэр, сүлд, далбаа, Үндсэн хуулийн нэр. Нэгэнт нийгмийн шинэ харилцаа бий болж байгаа учраас энэ дөрөвт бол ямар нэгэн еерчлөлт орохгүйгээр бид энэ Үндсэн хуулийг баталж болохгүй гэж бодож байна. Заавал аль нэгэнд нь еерчлөлт орж байж, эсвэл дөрвүүлэнд нь, эсвэл гурвууланд нь, эсвэл хоёрт нь байдаг юмуу. Ямар нэгэн хэмжээний еерчлөлт орох ёстой гэж бодож байна.

Миний хувийн бодол, хөдөлмөрчдийн санал бодлыг судалж байгаагийн хувьд юу бодогдож байна вэ гэхлээр, уул нь бол шинэ монголын үндсэн хуулийг бий болгох гэж байгаа учраас энэ дөрөвт бол дөрвүүлэнд нь еерчлөлт оруулахад болохгүй юм байхгүй гэж бодож байгаа. Гэхдээ өнөөдөр улсынхаа эдийн засгийг бас бодмоор байна. Жишээлбэл, манай аймагт гэхэд 9 сараас хойш тэтгэврийнхээ мөнгийг авч чадаагүй олон зуун хөгшчүүл байж байна. II, I2 дугаар сарын тэтгэврийн мөнгийг өрөөсөө өгч чадахгүй гэж манай холбогдох мэдлийн байгууллагууд ярьж байгаа. Сүлд, БНМАУ-ын нэрийг еерчилнэ гэдэг явдал болбол энэ бол цэвэр эдийн засгийн асар их хэмжээний хөрөнгөтэй холбоотой асуудал. Тэгэхэд өнөөдөр юу юуны тухгүй энэнээсээ эхлэх үү, энэнээс эхлэхэд монгол улсын нэр хүнд сайжирч, гадаад, дотоодоос тусламж дэмжлэг олж, монголын ард түмний амьдрал сайн сайхан болох юмуу үгүй юм уу гэдэг тухай асуудлыг их бодмоор байгаа юм. Тэгэхдээ

бусад асуудал дээр тухайлаад Үндсэн хуулийн нэр, туган дээр еөрчлөлт оруулахад болохгүй юм байхгүй гэж бодож байна. Энэ хоёр дээр оруулахад нэг их хөрөнгө шаардахгүй. БНМАУ-ыг еөрчлөөд л үүний аль нэг үсгэнд нь еөрчлөлт орох юм бол сүлд еөрчлөгдөнө, бусад бүх юм бүгдээрээ еөрчлөгдөнө. Тийм учраас би хурлын даргад ийм санал оруулж байна. Энэ дөрөв бол дөрвүүлээ еөр хоорондоо маш их холбоотой. Асар их холбоотой. Нэг нь нөгөөгүйгээрээ явж болохооргүйгээр ийм холбоотой зүйл учраас ереесөө сүлдэндээ еөрчлөлт оруулах уу, тугандаа еөрчлөлт оруулах уу, оруулахгүй юу, улсынхаа нэрэнд еөрчлөлт оруулах уу, Үндсэн хуулийнхаа нэрэнд еөрчлөлт оруулах уу, үгүй юу гэдэг талаар санал авмаар байна. Нэг санал хураагаад. Хэрвээ депутатуудын ихэнх нь БНМАУ-д **еөрчлөлт оруулъя**, нэрэнд нь еөрчлөлт оруулъя, улсын нэрэнд еөрчлөлт оруулъя, сүлдэнд еөрчлөлт оруулъя гэдэг ийм л санал дийлэнх байх юм болбол бид энэ асуудлуудыг нилээн сайн ултай авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Тийм нөхцөлд Монгол улсын хэрвээ улсынхаа нэрийг еөрчилъе гэж ингэж депутатуудын ихэнх нь үзэж байгаа болбол эсвэл сүлдийнхээс, сүлдэнд өчүүхэн жаахан еөрчлөлт орлоо л гэж бодоход үүнийг еөрчлөхөөс еөр арга байхгүй. Тэгвэл Монгол улсын нэрийг ч еөрчилж болно, сүлдийг ч еөрчилж болно. Тийм учраас ийм нөхцөлд бол хэрвээ дийлэнх нь сүлдийг юмуу улсын нэрийг еөрчилъе гэдэг санал дээр байх л юм бол тэгвэл бид Чимид гуайн ярьдагаар Монгол улсын Үндсэн хууль гэхэд болохгүй юм ор байхгүй ээ. Ереесөө ор байхгүй. Үүнийг Монголын ард түмэн ч хүлээж авна. Гэхдээ эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд энэ сүлдэн дээр бууу улсын нэрэн дээр еөрчлөлт оруулах уу үгүй юу гэдэг тухай асуудлуудыг бид их бодмоор байгаа юм. Нэгдүгээрт ийм санал байгаа юм.

Хоёрдугаарт, түргүн нөхөр Насан-Очирын хэлсэн саналыг би дэмжиж байна. Гуравдугаарт яг миний хувийн бодлыг сонсоё гэвэл Их засаг гэдэг бол Дорж гэдэг нэртэй хүн гэсэн ийм юмтай ижил юмаа. Өөрөөр хэлбэл бид Үндсэн хуулийгаа Их засаг гэж нэрлэе гэсэнтэй ив ижил зүйл юм. Тийм учраас миний бодоход Их засаг гэдэг дээрээ манай депутатууд, ер нь бид еөрчлөхгүйгээр


энэ Үндсэн хуулийг хийж болохгүй. Тийм учраас Их засаг гэж ямар ч байсан Үндсэн хуулийнхаа нэрийг өөрчилбөл яасан юм бэ, Тугаа өөрчилбөл яасан юм бэ гэсэн саналтай байна. Тэгээд Их засаг гэдэг дээр тогтоод санал хураалгавал маш зүйтэй болов уу гэсэн санал байна.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

178 дугаар тойргийн депутат Энхбаатар - Би хоёр горимын санал хэлэх гэсэн юм. Горимын санал хэлэхийнхээ өмнө Их хурал ямаршуу байдалтай байгаа тухай ганцхан уг хэлье гэж бодож байна.

Бид нар чинь Үндсэн хууль хэлэлцүүлэхэд Үндсэн хуулийг Улсын их хурал, Бага хуралд оруулсан. Тэгээд хэлэлцүүлж эхлэхэд Улсын бага хурлын дарга Үндсэн хууль оруулж нэг субъектын толгойлж байгаагийнхаа хувьд оочер дугааргүй дуртай цагтаа тайлбар хэлж бай гэсэн. Үүнийг эсэргүүцсэн. Үгүй хэлүүлэхгүй гэсэн. Дараа нь Улсын бага хурлын гишүүдээр уг хэлүүлэхгүй гэсэн. Ингээд энэ төслийг чинь хамгаалж хэн хэлэх юм бэ. Үндсэн хуулийн чинь комисс уг хэлье гэсэн. Тайлбар авахгүй гэсэн. Мэргэжлийн хүмүүсээр шинжлэх ухааны үндэслэлтэй тийм юунуудыг гаргаж ирж тайлбарыг нь тавиулья гэсэн. Хэрэггүй, бид нар бүгдийг өөрснөө мэднэ, бид бүгдийг өөрснөө шийднэ гэсэн. Улсын бага хурлын ч тэр шинэчлэлт хийнэ, Засгийн газрыг ч огрцуулна. Бүх юмыг өөрснөө хийнэ, өөрснөө мэднэ гэж хэлээд Улсын их хурал авсан, тэгэж ярьсан бүх хүмүүс. Тэр протоколуудаа үзэцгээгээрэй. Одоо тэгээд ямар байдалтай байна вэ. Чадахгүй байна шүү дээ, юу ч чадахгүй байна. Чадвар нь барагдсан юм уу. Ямар ч шийдвэр гаргаж чадахгүй байна. 8 хонож байхад юу хийж байна тэгээд. Яс хаясан юм байхгүй, үнэн байдлыг чинь хэлж байна шүү дээ. Ийм байна шүү дээ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



/Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

төслөө хүндэтгэе. Ингээд Их цааз, Үндсэн хууль хоёроор санал хураалгая. Их хурлын даргаа. Тэгээд нэртэй болж авъя гэж бодож байна.

185 дугаар тойргийн депутат Д.Жанцан: Тэгэхээр депутатууд бид бүхэн өнөөдөр ард түмнээс сонгогдож өнөөдөр энэ Үндсэн хуулийг батлах үүрэгтэй ирсэн. Болохгүй болбол, хоорондоо эвлэрэхгүй, таарахгүй болбол ингээд буцаад ирээрэй гэсэн даалгавар бидэнд өгөөгүй. Ийм эрх ч байхгүй бидэнд. Ийм одоо хариуцлагагүй юм ярьж байна гэж бодож байна. Депутатууд өнөөдөр бие биенийхээ үгэнд дүгнэлт хийж байна. Тийм ёс байхгүй. Дургүй юмандаа бол эсэргүүцэл үзүүлж байна бие биеэндээ. Бие биенийхээ үгийг сонсож чадах чадваргүй улсууд болбол энэ дотор их байна. Буруу ч ярьж байсан, зөв ч ярьж байсан хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үүрэгтэй. Тэр тусмаа Ардын Их Хурлын чуулган дээр бол депутат бүхэн хэлэх үгээ, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ёстой. Ийм чадвартай байх ёстой, ийм улс төрийн соёлтой байх ёстой гэж бодож байна.

Нөгөө талаараа энд энийг хэлэлцэж чадахгүй депутат өнөөдөр бид энэ тасалгаанд болбол төрийн төлөөлөгч гэдгээ хатуу ухамсарлаж ойлгомоор байна. Түүнээс намархсан, асуудлыг үзэл сурталжуулсан, өөрийнхөө санасан бодсоноор зүтгэсэн асуудал энд нэмэр болохгүй, Монгол улсад тус болохгүй гэдгийг ойлгомоор байна. Нөгөө талаар өнөөдөр хурлын дэг болбол дэг шиг явагдахгүй байна. Зарим хүн нэг асуудалд гурван үг хэлэх ёстой дэгтэй. 6,7 удаа босоод зогсож байна. Яагаад хурлын удирдлагууд энийг эмхэлж цэгцэлж, дэглэхгүй байна. Ийм байдлаар бол хурал явж болохгүй. Нэг асуудал дээр гурван удаа санал хураах ёстой. Яагаад 4,5 удаа санал хураалгаад хурлын дэг журам алдагдуулаад байна. Нэг асуудлын талаар хэлэлцэж байхад бол саналаа эхлээд таслах ёстой. Хэдэн жин үг хэлэх юм бэ. Санал тасалчихаад завсраар нь элдэв хангайн асуудал оруулаад тасралтгүй үргэлжлүүлж байна. Ийм байдлаар бол хурал явж болохгүй. Нөгөө нэг асуудал юутай холбогдсон асуудлаар ер нь одоо энэ хурлыг ийм байдлаар цаашид явах юм болбол хурал түргэвчлэхгүй, асуудлыг бүрэн шийдэхгүй.

Тийм учраас горимын хоёр санал гаргая гэж бодож байна.

Нэгдүгээрт нь бүлгүүд хурлаа түргэвчлэхийн тулд одоо бүлгүүд, энэ хурлыг завсарлагаа авч бүлгүүд дотроо ярилцмаар байна. Хоёрдугаарт нь дараагаар нь бүлгийн ахлагч нар энэ хурлыг түргэвчлэх талаар ярилцалгүй болохгүй. Ийм хоёр горимын саналтай байна. Энийг одоо хураалдаж өгөхгүй, ийм байдлаар хурал үргэлжлээд цаашдаа явахгүй.

316 дугаар тойргийн депутат Г. Сосорбарам: Би хурлын дарга, орлогч дарга руу хандаж хоёр гурван санал хэлдэг юмуу гэж бодож байна. Сая зарим хүн хэллээ.

Нэгдүгээрт энэ хурал бол замбараагүй болох нээ. Тийм учраас ерөөсөө хурлаа замбараатай болгохын тулд түр хэлэлцэх асуудлаасаа завсарлага авч яаж явуулах вэ гэдгээ яривал яасан юм бэ. Хоёрдугаарт бол дэг баригдахгүй байгааг сая хүмсүүд хэллээ. Энэ чинь нэг асуудал дээр нэг хүн дурав л босно гэсэн дэггээ бариад өгөөчээ. Нөгөө 7 минут, 5 минут, 3 минут гэдгээ бариад өгөөчээ. Энийг бүртгээчээ орлогч дарга нараа. Ингээд энэ чинь арай замбараатай болох болов уу. Хоёрдугаарт санал авалт, хураалтан дээр дэггээ бас барьж чадахгүй байнаа. Олонхийн санал аваагүй 50-иас дээш хувийн санал аваагүй асуудал дээр сая босоод хүндэтгэчихлээ шүү дээ. 47 хувьтай санал дээр аваад. Ингээд хурлын дарга маань өөрсдөө энүүнийгээ зохион байгуулж явуулаачээ. Ингэвэл жаахан журамд орох байх гэж ийм юм бодогдоод байна. Олонхийн санал авсан асуудалд саналаа авчихаад л дахиад л санал авдаг, саналаа авчихаад дахиад л санал авдаг. Санал чинь шийдчихээд байна шүү дээ. Тэгээд тэр саналаараа шийдчихээч дээ. Тэгвэл энэ хурал чинь замбараатай болно биз дээ гэж нэг ийм юм байна.

Хоёрдугаарт энэ хэлэлцэж байгаа асуудал дээр бидний маргаад байгаа хоёр нэрэн дээр маань нэг горимын нэг юм байна. Ерөөсөө энэ оноосон нэр гэдэг дээр чинь Их цааз гэдэг нэр чинь үгүй ер нь төмөр хууль, мод хууль гэдэгтэй адилхан болчихоод байгаа юм биш үү. Хууль гэсэн агуулга чинь заавал уялдсан нэг юм байх юм байгаа биз дээ. Үгүй бол Их цааз, ядахдаа Их цааз

хууль байх юмуу. Тэгээд баталчихдаг юм болбол хамаагүй л дээ. Мод, чулуу, төмөр гээд ингээд нэрлэчихье л дээ. Тэгвэл энэ хууль чинь одоо хууль болох юмуу. Энүүнийг анхаармаар юм бишүү, манай депутатуудын хувьд.

Дараагийн горимын чанартай бид хаана хаанаа анхаармаар нэг зүйл болбол үгүй нөхдөө энэ ясан муухай харагдаж байна аа. Уурлаад босоод ирэх чинь тун муухай харагдаж байна аа. Ерөөсөө энэ хурлаас тийм депутатыг сонгогчид нь хариуцаач гэж хэлмээр байна. Энийг сонгогчид дуулж байгаа байх. Хүчээр тулгах гэсэн, уурлаж босож ирдэг, энэ зүсээ хувиргадаг, том, жижиг дугардаг, энэ байдал чинь ерөөсөө дэндэж байгаа юм биш үү. Муухай юм. Олон улсын таазан дээр ч энэ, гадаадын парламент хэлэлцэж байгаа олон хурлаас харахад ингэж манайх шиг жигтэйхэн байгаа ийм хурал ердөө ч үзэгдэхгүй байгаа. Энэ дээр чинь өөрийн чинь л мөн чанар, миний мөн чанар гэдгийг өөрсдөө бодмоор юмаа депутатууд аа. Энийг бас хэлчихэд илүүдэхгүй юм шиг байна. Хүн сайн ч гэсэн хэлэхээс наашгүй, цаас нимгэн ч гэсэн чичихээс наашгүй гэдэг үг байдаг. Нэг ийм юм байна.

167 дугаар тойргийн депутат Ш. Гурбазар: Би энд ярьж байгаа зүйлээс бүр өөр зүйл депутатууддаа зүгээр танхимд дуулгах үүднээс сонсоё гэж бодож байна. Түрүүн миний индэр дээр гүйж гардаг бол их учиртай юм. Өчигдөр орой Махвал гуай бид хоёр хурал тарахын өмнө хэлэх гээд амжсангүй. Тэгэхээр энийг уг нь депутатуудынхаа сонорт хүргэсэн бол цагийн байдал юмнуудыг жаахан мэдэрч байх болсон болов уу гэж.

Өчигдөр гэртээр Их Хурал дээр мэдэгдсэн тэр Буджав, Авирмэд гэдэг хоёр хүнтэй өчигдөр бид нар энд цаг гаруй ярилцлага хийгээд өчигдөр үдээс хойш 16 цагт өлсгөлөн зарласан. Тэгээд Лоохууз дарга бид хоёр 2,3 хүнтэй очоод цаг гаруй ярилцлага хийгээд ямар нэгэн тохиролцоонд хүрч чадаагүй. Нэг хүн одоо өлсгөлөнгөө зарлана сууна гэсэн. Урд шөнө дээлээ дулаалаад одоо энэ Ордоны урд талд сууж байгаа. Тэр хүмүүс бол

## 5.

Монголын бүх хэлмэгдэгчдийг хоёулаа уриалж байгаа юм байна лээ. Хэлмэгдэгчдийг. Тэгэхдээ ямар шаардлага тавьж байна вэ гэвэл заал мэдэж байх хэрэгтэй байх гэдэг үүднээс хэлж байгаа юм шүү. Бид нар бол эцэстээ нэг л ажил хийж байгаа л даа. Хичнээн хоёр тал болж янз янзаар маргалаа ч гэсэн. Ямар шаардлага тавьж байна вэ гэвэл бид ечигдөр зарим талаас нь Ерөнхийлөгчид ч асуудлыг танилцуулж байсан, Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга нарт ч ярьж байсан. Улсын Бага Хурлын нарийн бичгийн даргаа Чимид тэргүүтэй, тэрний гар хөл болсон хуульчид хийсэн Монгол улсыг цаазлах энэ Үндсэн хууль бол олигтой хууль болохгүй ээ. Тэгэхээр шинэ сэргэг тийм одоо Чимид гуай ч байдаг юмуу, тэд нарын шавь ч байдаг юмуу, тэр Дэмбэрэлцэрэн ч байдаг юмуу, тэр улсууд оролцохгүй тийм шударга хуульчид байж байж тэр эасаг ариун болно энийг олцуул гэдэг шаардлага тавиад байгаа юм байна л даа. Тэгэхээр бид бол хэлсэн. Та нар хуулиа хүндэтгээ. Энэ чинь Монгол улсын Их цааз хэлэлцэж байнаа. Ядаж энийхээ дараа тэр тодорхой Бага Хурал ярьдаг юмуу, тодорхой хуулийн тухай ярих үед нь асуудлаа тавиад гэсэн чинь Их хурал дуустал, Их цааз дуустал дараагийн асуудал хэлэлцтэл сууна. Олон жил шоронд орсон бид нар бол тэвчнээ гэсэн ийм маягийн юм хэлээд ингээд дийлэхгүй ечигдөр орой суусан юмаа.

Эндээс би яагаад хэлж байгаа юм бэ гэвэл бид нар дотор гадрынхаа мэдрэмжийг барьж байхгүй бол хэлмэгдэгсдийг өмөөрөхгүй гэсэн дээ бишээ, миний, би эгчтэйгээ, миний эгч амьдаараа энэ хэлмэгдлээс болж одоо салсан хүн. Миний ээжийн төрсөн ах Улсын Бага Хурлын дарга байж байгаад бас л хэлмэгдсэн ийм. Би бол хэлмэгдэгсдийн үр садных нь хүүхэд байгаа юм. Тэгэхээр би дэмжихгүй гэсэн үндэс байхгүй. Тэгэхдээ бид дотор, гадраа бодож байхгүй бол, зөв бодохгүй бол тэр улсуудыг л Их Хурал дэмжээд л сая босчихлоо шүү дээ. Ний нуугүй хэлэхэд. Ийм учраас сайтар бодож юу яа. Толгой хагаравч малгай дотроо гэдэг. Тийм учраас бид хоорондоо ингэж хэрэлдээд байвал дундаас нь юм хулжсаар байгаад Их Хурал нэр хүндгүй болох нээ. Ер нь жаахан бодож байя гэдэг талаас нь хэлэх гэсэн юм. Одоо тэр улсууд хичнээн өдөр ч суух юм билээ, жагсах юм билээ, эа Дащдэмбэрэл гуай байж байна.



Тамгын газар өнөөдрөөс улсууд явуулж уулзуулаад аль болохоор бас нэг зөвшилд хүрэх талаас нь бодохгүй бол Лоохууз гуай, бид хоёр бол дийлэхгүй л юм байна. Энийг хэлэх гэсэн юм. Тийм учраас бас нэг хоёр талаас нь бодож гадаа юу болж байгаагаа мэдэхгүй энд ялгах гэсээр байтал чинь хэцүү байна энэ чинь. Бид нар хэлмэгдлийг дэмжих хүн гэж хаа байхав. Биеэрээ хүртэл жишээ авсан хүн зогсож байна. Бас бодох юм хэрэгтэй байна. Энэ хурлаа бас тун учиртай явуулахгүй бол тун хэцүү боллоо шүү. Бүгдээрээ тал талаасаа бодье.

186 дугаар тойргийн депутат Р. Чойжинням: Би ерөнхий шүүмжлэл дээр ч яриагүй. Анх удаа босож байна.

За ингэхлээр энэ манай их хурлын танхимд нэг уур амьсгал бий болж байгаад сэтгэл түгшиж байгаагаа хэлэх гэж байна.

Юу вэ гэхдээр зэрэг хуучин Үндсэн хууль дээр ч тэр, одоо батлах гэж байгаа Үндсэн хуульдаа ч тэр, бид нар төрийн эрхийг бүх ард түмний гарт бариулна гэсэн байгаа. Бид нар хөдөлмөрчин ард түмэн, сонгогчдоороо дамжуулж төрийн эрхийг барина гэсэн байгаа. Үгүй ингэж эрхийг нь олгосон атлаа одоо энд зарим нэг депутатууд тэр сонгогчидоо битгий барьж яриач, тэр хөдөлмөрчидөө битгий барьж яриач гэх дээр зэрэг тэнд сууж байгаа энэ 400 гаруй депутатыг харж сууж байгаа тэр хөдөлмөрчин олон түмэн маань төрөө барилцаж байна гэж бодож байгаа атлаа гэнэт эрхээ хасуулж байгаа юм шиг бодох юм бол ямар сэтгэгдэлтэй болох вэ. Би үүнд үнэхээр санаа зовж байна. Тэгэхээр би сумын дарга хүн. Хөдөлмөрчидтэйгээ өдөр болгон уулздаг, ярьдаг. Тэгээд хөдөлмөрчдөө болон сонгогчидоо ярихгүй хэсэг бүлэг хүмүүс гэж би ярих уу. Ийм учраас хөдөлмөрчин олон түмнээ төлөөлж энд төрийн эрх тэдний барьж сууж суугаа бол энэ дээр яахаараа эвгүй яриа үүсэх гээд байгаа юм бэ. Би энүүнд сэтгэл санаа зовж байгаадаа нийтэд хэлье гэж бодож байна. Энэ учраас би тэр хөдөлмөрчин олон түмэн л гэнэ, хоёрт сонгогчидоо төлөөлж тэднийхээ эрх ашгийг хамгаалж би ер нь уг ярина гэж бодож байгаа. Тэрнээс биш энд

байгаа хэсэг бүлэг улсуудыг би барьж ярьж байгаа юм бишээ.

Хоёрдахь асуудал энд юу байна вэ гэхээр үнэхээр өчигдрөөс хойш одоо үдээс хойш багахын одоо цөөнхийн санал гэдэг үүднээс өөр нь Бага Хурлынхан ихэнх нь бослоо. Та нар одоо уг хэлсэн байдлаа шүүгээд үзээрэй. 10 гаруй хүн босоод, өнөө өглөө л гэсэн, эд нар бидэнд чөлөө олдохгүй байна гэж яриад байна. Харин мань мэтийн улсуудад чөлөө олдохгүй байгааг ярих нь зүйтэй. Сэтгэлээ илэрхийлчихэж чадахгүй ийм хэмжээнд байж байна. Энийг нөхөд минь бодолцож үзвэл яасан юм бэ.

Гуравт бид нар юу вэ гэхээр одоо ингээд сэтгэл санаагаа хөдөлмөрчин олон түмнийхээ, сонгогчдынхоо захиа даалгаврыг биелүүлж чаддаг ийм депутат биш юм бол одоо бид нар Үндсэн хуулийнхаа доторхи агуулгыг хэлэлцэнэ, цаана нь Бага Хурлын тайлан байна, Засгийн газрын тайлан байна бас нэг 10-аад хоногийн хугацаа байна. Одоо Монгол улсын хөгжлийн төлөө шуурхай арга хэмжээ авахад бэлэн байгаа байх гэж бодож байна. Тэгвэл би ганц санал оруулах гэж байна. Одоо хөдөлмөрчин олон түмний дунд сануулга, асуулга явуулна. Одоо төрийн энэ сүлд, билэг тэмдэг болсон туг, энэ Үндсэн хуулийнхаа нэрийг наж нэрлэх вэ гэдэг асуулга явуулна. Энэ бараг 7,8 хоног дотор бүтчих байх гэж бодож байна. Бид нар энийг төлөөлж хөдөлмөрчин олон түмэн оролцог юм бол оролцог, одоо харя. Бид нар буруу онол барьж ярьж байгаа бол энд бид буруугаа хүлээгээд уучлалт гуйгаад ингээд зогсох болов уу гэж ийм санал оруулах ёстой.

154 дүгээр тойргийн депутат Е. Моголцог: Би зарим санал хэлье гэж бодож байна. Үндсэн хуулийг бид нар хэлэлцдээ, олон хоног хэлэлцлээ. Ерөнхий хэлэлцүүлэг дууслаа. Одоо бид нар нэрэн дээрээ хүрч ирээд зогсчихоод байна. Бид энд ухаан бодлоо уралдуулах биш, уур хилэнгээ уралдуулсаар олон хоногийн барлаа. Одоо бид нар жинхэнэ Үндсэн хуулин дээрээ яримаар байна. Үндсэн хуулийг бидэнд судлах, ярилцах бололцоо олгосон. Олон 14 хоногийн өмнө шинэ төсөл бидэн дээр ирсэн. Бид энэ дээр зарчмын зарим асуудлаа ярьж тохироод тэгээд шулуухан шийдээд явбал бол-

моор байна.

Хамгийн нэгдүгээрт хурлын дарга дэгээ буруу барьж байгаа. Зарим хүн хэд хэд долоо, найм дахин босч байгаа. Зарим хүн ялгүй жаахан асуудлаар асар их маргаан үүсгэж байгаа. Энэнээс болж бид нар аюултай их удааширч байна. Ард түмэн биднийг хүлээж байна. Их Хурлын нэр хүнд муудаж байна. Нэгэнт л ард түмнийг төлөөлж бид энд хүрч ирсэн. Ард түмнийхээ хувь заяаны төлөө асуудлыг шийдэх гэж байгаа юм бол жаахан буурьтай, суурьтай ярмаар байна. Манай зарим депутатууд дэндүү их доромжилж байна. Хөдөөнийхөн муйхар, ухааны хомсдолтой л гэнэ. Бид ингэж нэг нэгнийгээ уралшахаар энд хүрч ирээгүй шүү дээ. Тийм учраас бид асуудлыг өнөөдөр арай, хурдан түргэн шуурхай шийдмээр байна. Хамгийн гол асуудал Үндсэн хуулийн нэрийг манай ард түмэн зөвшөөрнө. Танцхан цааз гэдэг үгнээс л улсууд их дургүйцээд байгаа юм. За тэр ажил хаях, өдсгөлөн зарлаж байна, цаана нь бид нар 10 хүн амь насгаа хөнөөнө гэж бичиг ирчихээд байж байгаа. Тэгэхдээр энэ Цааз гэдгийг л аятайхан шийдэх юм бол бид нар цаашаа гараад явчих хугацаа өнгөрлөө шүү дээ. Тийм учраас өнөөдөр би зарчмын ийм санал хэлмээр байна. Түргүүн Бага Хурлын нарийн бичгийн дарга нөхөр Чимидийн гаргасан Монгол улсын Үндсэн хууль гэдэг асуудлаар санал хураалгаж батлуулаад хоёр асуудлыг нэгмөсөн шийдээд цаашаа холхон алхаж үзмээр байна. Дараачийн миний хэлэх гэж байгаа асуудал бол ердөө л хэдэн асуудал байгаа. Сүлд байна, далбаа байна, засаг захиргааны тогтолцоо байна. Энэ асуудал дээр ерөөсөө бушуухан бушуухан саналаа хуваагаад ярилцаад, ойлголцоод ингээд явчихмаар байна. Урьдын журмаар маргалдах юм бол бид нар сар ч хуралдаад асуудлыг шийдэж чадмааргүй байна.

Ийм учраас би хурлын даргад ийм санал тавьж байна. Дэгээ сайн бариацээ. Дэг муу барьснаас болж энэ дотор замбараагүй байдал гарч зарим депутатууд дархан эрх эдлээд байна. Доромжлох эрхтэй байна тэр чинь шүүхэд яагаад өгч болдоггүй юм бэ. Тэр ухааны хомсдолтой гээд хашгирч байгаа хүнийг чинь шүүхэд өгье л дээ. Хөдөөнийхөн мулгуу байна, мулгуугаа битгий гайхуул

ном унш гээд бидэнд даалгаж байна. Бид ном уншихаар ирээгүйээ. Асуудал хэлэлцэхээр ирсэн. Энэ асуудал дээр Их Хурлын даргад би бичиг өгсөн, хариу өгөхгүй байна. Яахаараа ингэж зарим нь илүү дархан эрх эдлээд бусдыгаа доромжилж байдаг, зарим нь эндээ хориглоод сууж байдаг, энэнээс болж өнөөдөр Их Хурлыг тараах тухай асуудал ярьж байна. Ард түмнийхээ өмнө шившиг болж байгаа юм бишүү. Ард түмнийхээ итгэл найдварыг хүлээгээд энэ сонгуульд хүрч ирчихээд хууль батална, хувь заяанд чинь их том хийнэ гэж хүрч ирчихээд өнөөдөр больё, тарья гэж зогсож байхад арай л нэг таарахгүй болов уу. Ийм няцамтгай, ийм депутатыг тавьчихаад тэр ард түмэн, тэр тойрог нь юу харж суудаг юм болоо. Ийм учраас зарим депутатыг тойргоор нь ярилцуулах л хэрэгтэй байна. Бид бол үлдсэн хэсэг нь 75 хувь байдаг ч юмуу, ямар ч байсан зорьсон хэргээ бүтээе, хурлаа шуурхайлая, саяын миний саналыг хүндэтгэж үзээд Чимид даргын саналыг би дэмжиж байна. Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр санал хураалгаж өгөөчээ гэж хүсмээр байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн  
Бичээч



ЭНХТУЯА  
В.ОМН

Г.Ганболд /18 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр эрхэм хүндэт депутатуудаа нэгд, одоо бид үнэхээр маш олон өдөр ярьж байна, хариуцлагатай үед цуглачихаад, хариуцлагатай асуудал шийдэж байна.Нэг ийм сэтгэгдэл үнэхээр залуу хүний хувьд надад төрөөд байна.Одоо ингээд бид нарын энэ 430 депутатын 427 депутатын энэ зааланд байж байгаа байдал бол ерөөсөө монгол улсын маань байгаа байдал бага хувилбараараа байгаа юм биш биздээ гэсэн ийм сэтгэгдэл төрөөд байна шүү.

Яагаад гэхээр зэрэг хэрэв бид өнөөдөр энчээ учраа олохгүй бол, бид өнөөдөр энэ асуудлаа бүгдийг нь цэгцэлж авахгүй бол эцсийн эцэст энэ зааг дээр ирчихээд Ардын Их Хурал тарах дээрээ хүрэх юм бол цаашдаа монгол улс сэргэн мандах нь битгий хэл учир цэгцтэй байж чадах уу үгүй юу гэдэг асуудал тулгарна. Энхийг би хоёрдугаарт нь юу хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг өнөөдөр энэ хурал удирдаж байгаа үйл явдал, ерөөсөө энэ хурлын явц ганцхан Улсын Их Хурлын даргын асуудал бишээ.Өнөөдөр энэ хурлыг удирдах асуудал бол БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий сайд, манай улсын бүх удирдлагын асуудал.Яагаад өнөөдөр хүн бүхэн ганцхан долоохон өдрийн өмнө сонгогдсон энэ Их Хурлын дарга руу дайраад байгаа юм бэ?

Тийм учраас энэ асуудлыг гартаа авах асуудал бол улсын удирдлагын асуудал гэж би ойлгож байна.Ерөнхийлөгчийн асуудал. Би өнөөдөр ерөөсөө ойлгохгүй байна.Өнөөдөр ингээд 430 депутатын асуудлыг гартаа авахгүй юм бол 430 депутатад энэ асуудлыг задгай оруулж, ингэж хаясантайгаа адилхан монгол улсын хувь заяаг, хоёр сая иргэнд нь даатгачихаж байгаа юм биш биз дээ.Ийм сэтгэгдэл төрөхөд хүрч байна шүү.Тийм учраас би бол ямар саналтай хандаж байна вэ гэвэл ийм байдлаар цаашдаа санал хураагаад ерөөсөө ашиг олохгүй.Яагаад гэвэл санал хураагаад тодорхой нэг санал дээр тогтсон ч гэсэн, үлдсэн хэсэг нь сэтгэл өндөр гарахгүй. Асуудал шийдлээ гэдэг сэтгэгдэл үлдсэн хэсэгт нь төрөхгүй байхаа гэж бодож байна.

юм өгчихөөд хэдхэн хоногийн дараа за болж өгвөл Их засаг болгоорой гэж. Яагаад би ийм юм хэлээд байна вэ гэхээр ээрэг, яагаад төрийн удирдлага оролцохгүй байна гэхээр ээрэг өнөөдөр энэ асуудал базагдаж орж ирээгүй байна. Улсын Ерөнхийлөгч нэг юм хэлэхдээ хоёр үзүүртэй юм хэлдэг. Чимид гуай хүн болгон харж байгаа гол хууль чинь нэг юм хэлээд гурав хоногийн дараа өөрчилдөг. Монгол улсын төрийн жолоо барьж байгаа улсууд нь юмаа зангидаж орж ирээгүй байхад, 430 хүн энд зангидна гэвэл ихээхэн хэцүү гэдгийг би дахин дахин хэлмээр байна. Тийм учраас, тэгээд хоёрдугаарт бид өнөөдөр Ардын Их Хурлыг тараачихаж болно. Бид Үндсэн хуулийн замаар асуудлаа шийдэхгүй бол Үндсэн хуулийн бус замаар асуудал шийддэг арга байдаг гэдгийг хойд хөршийн маань асуудал харуулсан шүү.

Үнэхээр Үндсэн хуулийн замаар бид бүх асуудлаа шийдэхгүй бол энэ асуудал Үндсэн хуулийн бус замаар, магадгүй янэ бүрийн замаар шийдэгдэх ийм нөхцөл бололцоо, гадаад, дотоод хүчин зүйл байж болохыг эрхэм депутатууд анхаарах ёстой. Тийм учраас бид энэ танхимдаа энэ асуудлаа шийдэх ёстой, ер нь бол Балдоржийн гаргаж байгаа санал бол үнэхээр бодох санал. Ийм зарчим байдаг. Хэрэв энэ зарчмыг эсэргүүцэж болохгүй. Хэрэв энэ зарчмыг хэрэгжүүлэхгүй бол хоёр дахь арга үлдэж болно гэдгийг л анхаарах хэрэгтэй.

Ингээд эцэст нь би саналаа дахин хэлье. 14.30 цаг хүртэл завсарлага аваад энэ хүртэл хоёр үе шаттай зөвлөлдөөн хийгээд эргэж орох саналтай байна. Энэ байдлаараа асуудал ерөөсөө явахгүй. Хурлын удирдлагад хэлэхэд хурлын удирдлага бол би бодож байна, хурлын хөтлөгч биш, хурлын удирдлага. Тийм учраас энд байгаа хурлын удирдлага ер нь амжиллахгүй байх шиг байна. Бүх бий болж болох асуудлуудыг урьдчилан хэлэлцээд орж ирж удирдах ёстой. Дүрмийн хүрээнд удирдах ёстой, хөтлөгч биш. Тийм учраас энэ удирдах үүргээ биелүүлээч гэдгийг хэлэх байна. Их баярлалаа.

Ж. Уртнасан - Дэгийн дагуу завсарлага. Депутатуудаа ардчилсан эвсэл бүлгийнхэн II цагийн завсарлагаанаар 2 дугаар давх-

рын "А" танхимд цуглаарай гэсэн байна.

Орон нутгийн бүлгийн дарга нар завсарлагаанаар заалын ард талын суудалд цуглая гэсэн байна.Орон нутгийн бүлгийн удирдлагууд заалын ард талд цугларна уу.Аймаг, хотын дарга нар.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*Д.Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.19  
Кассет Ш-64  
11.28-11.37

Ж.Уртнасан: Их Хурлын депутатууд аа хүлээнэ үү.Одоо БНМАУ-ын Ерөнхийлөгч та бүхэнд хандаж үг хэлнэ.

П.Очирбат:/Ерөнхийлөгч/

Эрхэм хүндэт депутат нөхөд өө?

Үндсэн хуулийн төсөл хэлэлцэж байгаа байдлаас харахад бидэнд бас хоорондоо ,дотоо нарийн ярьж хөөрөх нэлээн юм байх шиг байна.Ер нь та биднүүд, цугаараа монгол улсын үндэсний эрх ашгийг бодож түүнд захирагдах учиртай.Бид төрийн тогтолцоо, шинэ тогтолцоонд шилжээд, нэг жил хэртэй болж байна.

Бид ардчилал, шинэчлэлийн замд шилжээд мөн жил гаруй болж байна.Энэ шилжилт, шинэчлэлтийг монголын ард түмэн зөв зүйтэй гэж бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа.Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дагуу энэ хуулийг хэрэгжүүлэхийн төлөө манай нийт депутатууд та бүхэн өнгөрсөн сонгуулиас хойших хурацаанд үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Энэ болгоныгоо бид энэ шинэ тогтолцоо, энэ шинэ нөхцөл, энэ шинэ шилжилтээ хуульчилж, баталж авъя.Энэ бол монголын ард түмний, монгол улсын эрх ашигт бүрэн нийцэж байгаа зүйлээ гэдэгт цугаараа санал бодол нэгтэй байгаа.Үндсэн хуулийн төслийг хэлэлцүүлэх үед ирсэн саналдээр ийм хууль хэрэг байхгүй гэсэн санал ерөөсөө ирээгүй юм.Аль ч хэлэлцүүлэгт. Хэлэлцүүлгийн ямар ч хэлбэрээс үзсэн, утсаар ярьсан хүмүүсийн, бичрээр ирүүлсэн хүмүүсүүдийн, хурал, зөвлөлгөөн дээр ярьсан хүмүүсүүдийн үг яриа, энэ болгон дээр ийм санал ерөөсөө байгаагүй.Үндсэн хуулийг ийнхүү шинэчилж батлах асуудал зайлшгүй чухал.гээд тэгээд доторхи зүйлүүд дээр нь ирсэн олон зуун, мянган санал бий тухай түрүүн би та бүхэнд бас илтгэсэн.

Тийм учраас бид монгол улсынхаа үндэсний энэ эрх ашигт захирагдаж энэ асуудал дээрээ бас бодолтой, хүлээцтэй



## 2.

гол зарчмаасаа хазайлгүй энэ асуудалдаа ормоор байна. Тэгэхээр би нөхдүүдтэй бас ярьж хөөрлөө. Нөхдүүд зөвлөж хэлж байна. Орон нутгийн болоод, намуудын хэсгүүд, нутаг дэвсгэрийн байж байгаа хэсэг, бүлгүүд, энд албан ёсоор бүртгэлтэй 8 байна. Энэ 8 дээр өөр бас хэсэг бүлэг ийм байгаа бол эргээд бид цуглаж энэ хэсэг, бүлгийн удирдлагуудтай цуглаж, ярьж хөөрч, нэг санал солилцвол ямар вэ гэдгийг Ерөнхийлөгч миний бие удирдаад тэгээд нэг санал бодлоо ярьж хөөрөөд, тэгээд бүлгүүдийнхэн өөрсдийнхөө тэр бүлэгт байгаа депутатуудтайгаа бас нэг зөвлөлдөөд, тэгээд депутат болгон өөрийнхөө санал бодлыг хэлэх биш, тэр төлөөлж байгаа хүмүүсүүдээрээ олон хүнтэй, хэсэг, групп байгаа бол, хоёр гурваараа байдаг ч юм уу ингээд санал бодлоо яриад, нэг зөвшөл ямар вэ? Тэгэхгүй бол бид үнэхээр та биднүүд мэдэж байгаа, нэг минутанд 118 төгрөг, хамгийн гол нь энэ Үндсэн хуулийнхаа юмыг нэг ярьж тохироод, ингээд баталж аваад л дуусгах ёстой.

Тэгээд ч өөр бас хэлэлцэх асуудлууд бий. Тийм учраас энэ зүйлийг нэг бодож, хэрэв та бүхэн зөвшөөрвөл ер нь одоо хурлынхаа ажиллагааг түр завсарлаад энэ хэсэг бүлгүүдтэйгээ ярьчихаад, тэгээд хэсэг бүлгүүд очиж яриад, үдийнхээ хоолыг идчихээд, тэгээд 3 цагт ирээд ярихдаа арай жаахан цэгцтэй, зохион байгуулалттай ингэж яривал ямар вэ? гэж хэлэх гэсэн юм.

Танхимаас:

Хурлын даргаа, Ерөнхийлөгчийн саналыг дэмжиж байна. Та саналаа хураалгаач.

Ж. Уртнасан: Ерөнхийлөгчийн саналыг депутатуудаар хэлэлцүүлбэ, санал хураахад бэлтгэнэ үү. Бүлэг, намын бүлэг, орон нутгийн бүлэг, энд байгуулагдаж, хурлын удирдлагад бүртгүүлсэн 8 бүлгийн ахлагч нарыг Ерөнхийлөгчийн өрөөнд урьж байгаа. Ерөнхийлөгчийн саналыг Улсын Бага Хурлын удирдлагуудтай урьж байгаа. Ерөнхийлөгчийн саналын талаар санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Одоо завсарлаж, намын бүлэг, орон нутгийн бүлэг, Ерөнхийлөгчтэй уулзана гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Үдийн хоол хүртэл нам, орон нутаг дэвсгэрийн бүлгүүд, бусад бүлгийн ахлагч нар уулзана.

Баярлалаа, санал өгсөн депутатуудын 97 хувь нь буюу 380 хүн зөвшөөрлөө. 2 хувь буюу 6 хүн татгалзаж байна. Намын бүлэг, орон нутгийн бүлэг, энд бүртгэгдсэн 8 бүлгийн ахлагч нар Ерөнхийлөгчтэй уулзана.


Танхимаас: 15-р тойргийн депутат Д.Лундээжанцан:

Орой сунгаж хуралдах хэрэгтэй болно шүү, ийм учраас. Тийм учраас бусад юмыг нь зохицуулах, орой нэлээн сунгаж хуралдана ийм ойлголттой явах нь дээр байх аа.

Ж.Уртнасан: Тэр саналыг хүлээж авч байна.

Бүлгийн удирдагчид Ерөнхийлөгчийн өрөөнд цугларна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.19.  
Кассет Ш-65  
15.07-15.25

Ж. Уртнасан -Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Өдрийн цайны өмнө бид та бүхэнтэй хэлэлцэж тохирсон ёсоор намын бүлгийн ахлагч, орон нутгийн бүлгийн ахлагч нар, бусад эвсэл, бүлгийн ахлагч нар Ерөнхийлөгчийн өрөөнд зөвлөлдөж ярилцсан, санал солилцсон. Ерөнхий тохиролцоогоор бид Монгол улсын Үндсэн хууль гэсэн томъёолол дээр шууд санал хураах хувилбар байж болохоор байна. Эсвэл санал зөрөлдөөнтэй санал хураахаас өмнө бүлгийн ахлагч нар депутатуудтайгаа уулзсан дүнгээсээ депутатуудын сонорт хүргэвч гэвэл депутатын бүлгийн ахлагч нар нээн хүн үг хэлж болох хувилбар байна. Тэхээр депутатын бүлгийн ахлагч нар Ерөнхийлөгчийн өрөөнд ярилцсан зүйл дээрээ депутатуудтайгаа нэлээн сайн санал солилцсон гэж бодож байна.

Депутатын намын бүлгийн ахлагч нар, орон нутгийн бүлгийн ахлагч нараас үг хэлэх хүн байна уу?

За баярлалаа, тэгвэл депутатууд санал хураалтандаа бэлтгэнэ үү. Бид баримжаатай байхын тулд эхлээд ирцээ авч, хүнийхээ тоог гаргаж авъя. Депутатууд анхаараарай, одоо хурлын ирцийг авч байна. Ирц авлаа.

Ирвэл зохих 427 депутатаас 403 депутат буюу 94 хувийн ирцтэй, ирц тогтвортой хэвээр байна. Эрхэм депутатууд санал хураалтандаа бэлтгэнэ үү.

Монгол улсын Үндсэн хууль гэсэн томъёоллоор санал хураалт явуулах гэж байна. Саналаа төвлөрүүлнэ үү. Бид дэгээ барьж, олонхдоо захирагддаг гэдэг дээр санал тохирсон шүү.

Монгол улсын Үндсэн хууль гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

За баярлалаа, та бид нэгдсэн тохиролцоонд хүрч, олонхийн санал, дийлэнх олонхийн санал буюу 69 хувийн саналаар

2.

273 хүн Монгол улсын Үндсэн хууль гэж зөвшөөрч байна. 83 хүн татгалзаж, 42 хүн түдгэлзлээ.

Одоо цааш нь явъя. Монгол улсын Их цаазын тунхаглалын хэсэг байна. Монголын ард түмэн бид Монгол улсын Үндсэн хууль... Цөөнхийн нэр жагсаалтаар авна.

Уучлаарай депутатууд аа! Дийлэнх олонх нь цаашаа ахия гэсэн бодолтой байна. Гэтэл хурлын дэг нь цөөнхөө хүндэтгэж саналыг нь сонсоно гэсэн заалт бий. Цөөнхийн саналыг сонсоно гэдэг дээр санал хураалт явуулья.

Цөөнхийг сонсоё гэсэн хүмүүс 48 хувь, татгалзсан 46 хувь, түдгэлзэж байгаа 6 хувь байна. Тэхдээ бид дэгийн дагуу явъя. Харин сая дарга нар бүлгийн орон нутгийн удирдлагуудтай бидний ярилцаж тохирсон нэг зүйл бол дэг дээр хэдий байхгүй ч гэсэн амьдрал баян юм. Хуралданы явцад цөөнх үг хэлнэ гээд бараг олонх болтлоо үг хэлдэг энэ зарчмаас бид татгалзая гэсэн тохиролцоонд хүрсэн.

Тэхээр өнөөдөр цөөнхийг төлөөлж цөөхөн хүн үг хэлж баймаар байна. Одоо энэ микрофоны ард зөгсож байгаа 5 хүнээр таслая. Энэ тавая хүний үгийг сонсоод, дараа нь таслая. Энэ 7 хүнээр саналаа таслая гээд бид санал хураалтаа таслаж байна. Энэ 7 хүнээс өөр дахин битгий нэмээрэй депутатууд аа! Цөөнхийн саналыг сонсоё. Санал хураалт явуулж байна.

За баярлалаа, 86 хувь<sup>нь</sup> энэ хүмүүсээр саналаа таслая гэж байна. 312 депутат, 2-р микрофон,

Ж.Ядамсүрэн 69-р тойргийн депутат/ -Цөөнх болж би үг хэлбэ гэж бодохгүй байна. Би өнөөдөр энд үг хэлэхдээ дахин санал хурааж өгөөч гэсэн үүднээс хэлэхгүй. Би ямар нэгэн нам, эвсэл, бүлэг төлөөлөхгүй, зөвхөн өөрийгээ төлөөлнө. Тэхээр энэ хэлж байгаа үгийг манай хэвлэл, мэдээллийн нөхдүүд гадагш нь сурталчлахгүй байх, протоколд үлдэх байх гэж найдаж байна.

## 3.

Бидэнд зөв шийдэх ёстой зарчмын асуудал гэж бий. Ямар нэгэн асуудлыг зөвхөн нонкоор шийдэж болохгүй асуудал ч бий, шийдэж болох асуудал ч бий. Үндсэн хуулийн нэрийн тухай асуудал дээр энд бид шийдэж болох байсан. Өнөөдөр би юу хэлэх гэж байна вэ гэвэл би өөрөө түүхийнхүзэж хараагүй, 1914 онд хаант Орос, Хятад хоёр гадаад Монгол бол Хятадын бүрэлдэхүүн хэсэг мөн гэж нууц хэлэлцээр хийж, гарын үсэг зурсан юм гэнэ лээ. Тэр нь одоо хүчингүй болсон гэж би дуулаагүй. нэгдүгээрт.

Хоёрдугаарт 1945 онд бүх ард түмний санал асуулга явуулж БНМАУ тусгаар тогтносон бүрэн эрхт улс гэдгийг ард түмэн маань зөвшөөрсөн. 1962 онд зөвхөн Хятад ард улстай манайх хилийн тухай хэлэлцээрт БНМАУ-ын нэрийн өмнөөс гарын үсэг зурсан юм гэнэ лээ. Бид шийдэж болно, өөрчлөж болно. Би өөрчлөхгүй гэсний төлөө биш юм. Гэхдээ өнөөдөр энэ цаг, үе мөн үү гэдгийг бид бодох ёстой. Түүхээс бид сургамж авах ёстой. Өнөөдөр Шри Ланк нэрээ өөрчлөөд, Энэтхэгтэй юу болж байна. Бирм нэрээ өөрчлөөд яаж байна. Үүнээс ч бид сургамж авах ёстой гэж бодож байна.

Тэхээр би бол энд байгаа нөхдүүд зөвхөн Бага Хурал тэгж л байвал түүний эсрэг, МАХН-мөн тэгж л байвал түүний эсрэг гэсэн байдлаар хандаж болохгүй. Улс орны эрх ашгийн үүднээс асуудалд хандах ёстой гэж ойлгож байна. Тийм учраас манай өнөөдрийн биш, 30 жилийн дараа, 100 жилийн дараа, 200 жилийн дараа энэ нь ямар байдалд орох бол, өнөөдрийн дэлхийн олон нийтийн, дэлхий дахины байдал ямар байна гэдгийг депутатууд бодох хэрэгтэй юм.

Нөгөө талаар олон улсын хууль зүйгээр НҮБ-ийн гишүүн зөвшөөрчихсөн гэж хэлэх байх. Хүн төрөлхтөнд хуулиар гадуурх үйл ажиллагаа зөндөө явдаг гэдгийг бид бодолцох хэрэгтэй юм. Тийм учраас бид асуудлыг шийдэхдээ ярих хэрэгтэй. Тал, талаас нь ярих хэрэгтэй, гол нь Монголын ард түмний эрх ашгийн үүднээс шийдвэрийг гаргах хэрэгтэй гэж би ойлгож байна.

Өнөөдрийн бидний ярьж, хөөрч байх ёс нь Парламентын ёсонд зүй ёсны асуудал гэж үздэг юм. Үрихгүйгээр асуудлыг шийдэх юм бол энэ нь буруу болно шүү. Тэр байтугай Парламент хөгжсөн орны Парламент дотроо гар зөрүүлдэг тийм юм байдаг юм гэнэ лээ. Тийм учраас аль болохоор асуудлыг ярьж бай, бид хоёр сар ч хуралдаж болно. Түүнээс их юм манай улсын өмнө тулгарах вий. Үүнийг и би хэлэх гэсэн юм.

И.Баларч294-р тойргийн депутат/ -Бид олон өдөр маргалдаад, Ерөнхийлөгч, Хурлын даргын санаачлагаар ахлагч нарын зөвлөлгөөний саналыг амархан хүлээн авч, бид зөвшилд хүрлээ. Энэ нь дэвшил юм аа. Их маргааныг ингэж төгсгөж байна. Энэ нь зүйтэй юм. Би цөөнх нь, сая олонхдоо захирагдах боллоо. Миний үндсэн санаа бол Үндсэн хууль гэдэг нь орлоо. БНМАУ хэвээр байна гэсэн үг нь үүнд тушигдаад, Монгол боллоо. Би үүн дээр ганцхан асуудлыг та нөхдүүдэд хэлье гэж бодож байна.

Монгол улс бид болсноор Монгол үндэстнийг төлөөлөх шинжтэй болж байгаа юм аа. Хэрэв бид Монгол улс болсноор хойт, урд талын хөршүүдтэйгээ эвгүй байдал хүрэх, түүнээс гарах хор уршигийг манай ахлагч нар сайн зөвлөсөн юм байх даа. Бид анхаарал татаж ярих энэ асуудлаа их амархан зөвшилд хүрлээ. Үүнээс үүдэж ард түмэн маань давхар гачигдал зовлонд орох юм биш биз ээ. Ийм үгийг би түүхийн өмнө хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Би гол нь ерөнхий саналаа өгөх хүн юм.

Жанцансамбуу/358-р тойргийн депутат/ -хариуцлагатай ажлыг хариуцлагатай хийе гэсэндээ нэлээд маргасан байх гэж бодож байсан. Гэтэл тийм биш, хариуцлагагүй хийе гэж маргасан байна гэсэн дүгнэлт өгөх гэж байна. Би хувьдаа ажилчин хүн, надад боловсрол, мэдлэг, түүхийн ухааныг судалсан юм байхгүй. Гэхдээ хуулийн нэрээ улсынх нь нэр дагадаг гэдгийг би өнөөдөр ойлголоо. Ард түмэн ч гэсэн тэгж ойлгох байх. Хуулийн нэрийг солиход хажууд нь улсын нэр солигддог гэж би мөн ойлголоо. Үүнийг тодорхой зөвлөсөн хүмүүс зөвлөөд хүрсэн хэмжээ нь эцэстээ улс, орон ард түмний, ажилчин ангийн минь эрх ашигт

хүндээ харшилчихгүй байгаасай гэж бодож байна. Миний санал нь түрүүнд 2-р микрофон дээр уг хэлсэн хүнтэй маш их нийцэж байна. Саяны асуудал дээр миний хувьд олонхоо дагах шаардлагатай боллоо, цөөнх нь болсон. Гэхдээ цаашдаа асуудал нь яг ийм байгаасай, бүх асуудал нь. Олонх нь цөөнхөө дагаж байгаасай гэдгийг би тодорхой хэлсэн шүү. Бид ганц асуудал шийдэх биш, Үндсэн хуулийн 70 зүйл ангитай юман дотор олон асуудал шийдэх байх л даа.

Ард түмэн юуг хүсэн хүлээж байсан, ард түмнийг төлөөлж ирсэн 427 депутат юу шийдэнэ гэж амлаж ирсэн, энд юу ярьж эхэлсэн бэ, эцэстээ бид эхний асуудал дээр ямар тохиролцоонд хүрч байна гэдэг нь тодорхой боллоо нөхдүүд минь.

БНМАУ гэсэн нэрийг ингэж шийдэнэ гэхэд би үнэхээр уйлмаар санагдаж байна. Би Монгол улсын төрийн төлөө зүтгээгүй ч гэсэн Монгол улсад бид хүч хөдөлмөрөө зориулж, өнөөдөрийг хүртэл 41 нас хүртлээ эрүүл мэндээ хайрлахгүйгээр энэ биеэ зориулж явсан би. Би хүнд цагт, дайны талбарт ажиллаж явсан гэж хэлэхгүй, гэхдээ би санаа сэтгэлээ тэгж зориулж явсан юм. Гэтэл манай сэхээтнүүд бидний тухай ажилчин анги, хөдөлмөрчин, малчин олсон ашиг, орлого, байгуулсан зүйл дээр олсон мэргэжил, мэдлэг боловсролоо ард түмний төлөө өнөөдөр зориулахгүй байна. Би голдуу сэхээтнүүд гэж хэлнэ. Манай боловсролтой эрдэмтэд, сэхээтнүүд төв орон нутагт байшин, барилгад сууж байсан, олон орноор дамжсан хүмүүс маань ард түмний аж амьдралаас, Монгол ёс заншлаасаа тасар чээ гэдгийг би хэлэх гэж бодсон юм. Би энэ хурал эхэлснээс хойш маш тэвчээртэй сонссон. Би үнэхээр дүгнэж, цэгнэсэн. Би энэ үгийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Би хэлсэн үгэндээ эзэн болдоггүй, хоолондоо сав болдоггүй юм бол яах гэж ард түмнийгээ төлөөлж ирсэн төлөөлөгч байх вэ дээ.

Зарим хүмүүс хэлдэг юм Их Хурлын чуулган дээр хүн нь хэлсэн үгэндээ эзэн болдоггүй гэж Зориг, Бат-Үүлээс авахуулаад хэлснийг сонссон. Энэ нь манай монгол ёс мөн үү. Би үүнийг хүлээн дөвшөөрөхгүй. Миний цаад талд байгаа Монголын ард түмэн

хүлээн зөвшөөрөхгүй гэж ойлгож байна. Би хариуцлагаа хүлээнэ. Энэ нэрийг үнэжээр ингэж шийдвэл харамсалтай байна. Бид цаашдаа энэ байдлаас болж шахалтанд орвол хэн хариуцлага хүлээх вэ? Ард түмнээс шахалт ирвэл хэн хариуцлага хүлээх вэ? Цаашдаа мөн НҮБ болон дэлхийн олон нийт үүнийг хүлээн зөвшөөрнө гэдгийг хэн баталгаа гаргасан юм. Үүнийг бодолцох шаардлагатай байна.

Ж.Уртнасан -Жанцансамбуу гуай, бид сая тохиролцоонд хүрсэн юм. Танд тайлбар тавья. Улсын нэрийн талаар манай Гадаад харилцааны яамнаас та бидэнд албан ёсоор ирүүлсэн баримт бичиг байгаа. Түүнийг Бага Хурлын дарга бидэнд уншиж сонсоно.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн.

Ц.БАТРМАА

Бичээч С.Туул



Ардын Их Хурлын 394 дүгээр тойргийн депутат С.Дувсандаш:— Тэгэхээр улсын нэрийг бодох ёстой асуудал мөн. Үндсэн хуулийн нэрнээс ч илүү ач холбогдолтой гэж үзэж байна. Ингээд дээрх нөхдийн саналыг дэмжээд цөөнх болсныхоо хувьд хэлэхэд Монгол улс гэхэд улс орны хувь заяа ард түмний эрх ашигт эерэг, сөрөг нөлөө хэзээ нэгэн цагт нөлөөлөхгүй гэх баталгаа байна уу. Энэ талаар бодох юм шиг санагдах юм. Ерөнхий хэлэлцүүлгийн явц, байдлаас үзэхэд Монгол улс гэж нэрлэх учир шалтгааныг юугаар тайлбарлав аа гэдгийг бодоод надад нэг сэтгэгдэл төрж байна. Энд эрхэм депутатууд хэлсэн. Нэгдүгээрт, хойд, урьд хөршид маань монголчууд амьдарч байна. Өвөр монгол, Шинжааны монгол, Давуур монгол гээд. Хойд хөршид амьдарч байна. Ингээд Монгол улс гээд нэрлэх юм бол яваандаа нэгдсэн монгол улс болж, бий болох юм аа гэсэн, нэгцэх юм аа гэсэн ийм санаагаар ярьж байгаа юм. Хоёрдугаарт нь юу гэж ярьж байна гэвэл хойд урьд хөршид маань монгол улс гээд зарлачихвал яах юм бэ гэж, энэ учир шалтгаан мөн үү нөхөд минь. Энэнийг бодож үзмээр байх юм. Ер нь бусад орны ард түмний эрх ашигтай холбоотой асуудлыг ингэж бид хөндмөөргүй байна.

Эрхэм депутат Энхсайхан хэлсэн. Манай улсын хувь заяа хойд, урьд хоёр хөршөөсөө ихээхэн хамаарна гэж. Энэнтэй санал нэг байна. Ард түмэн ч тэгж бодож байгаа. Гэтэл бид Монгол улс гэж нэрлэснээр хойд, урьд хоёр хөршөөс нөлөөлөхгүй гэх баталгаа байхгүй байх гэж би бодож байна. Монгол улс гэж нэрлэснээр далайн чанад дахь орнууд харин талархаж хүлээж авах байх. Хойд, урьд хөрш маань яаж хүлээж авах вэ гэдгийг бид нар бодвол яасан юм бэ? Энэнийг бодоод, ийм вариант хэлмээр байна.

Ер нь тэр ард гэдэг үгнээс цэрвээд, ингээд олон хүн ярьсан. Тэгвэл БНМ У гээд нэрлэхивэл яасан юм бэ? Ийм завсрын вариантгаар энэнийг Бүгд Найрамдах Монгол Улсын Үндсэн хууль гэдэг юмаар санал хураалгаж өгөөчээ гэж хүсч байна. Цөөнх болсны хувьд. Дэгэд ч ингэж заасан.

Хоёрдугаарт, ер нь депутатуудад хэлэхэд 1924 онд батлагдсан

Үндсэн хууль хүчингүй болгох одоо ярьж байгаа ийм байна. Хэрвээ бид 24 онд батлагдсан Үндсэн хуулийг хүчингүй болгох км бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнол ч гэсэн байхгүй боллоо гэсэн үг. Тэгвэл тэр үед одоо 39 онд Японы түрэмгийлэгчдээс манай улс уруу довтолж байсан нь зөв болох нь уу. Монгол Улсыг хятадын нэг хэсэг гэж байсан зөв болох нь уу. Энэнийг ч гэсэн нөхдүүд минь эрхэм депутатууд энэнийгээ бодолцоор байна. Ер нь сүлд, тэмдэг, цалбааг еөрчлөх энэ талаар нөхдүүдтэй санал нэг байна. Тэгэхдээ км-ыг еөрчлөхийн тулд биш агуулга талыг нь бодож, ер нь Үндсэн хуулиа яаж хэрэгжүүлэх км бэ гэдгийг нь сүүлд нь бодож, ямар бэрхшээл гарах талаас нь, ард түмнийхээ эрх ашгийг бодож ярилцамаар байна шүү гэдгийг би хэлмээр байна. Баярлалаа.

Ардын Их Хурлын 165 дугаар тойргийн депутат Ч.Гомбосүрэн:— Би элдэв нам, эвсэл холбоод км уу тийм зүйл төлөөлөхгүй, гаргасан шийдвэрийг эсэргүүцэж, аль болохоор буцлиантуулах ийм зорилго агуулаагүй байна. Зүгээр еерийнхөө саналыг хэлж гэж бодож байна. Энэ бүхэл бүтэн Үндсэн хуулийн нэрийн тухай асуудлыг хоёр өдөр хэлэлцчихээд тэгээд нөгөөдөх нэрийнхээ асуудалдаа тохирохгүй асуудлаа арван тав зургаан хүн нийлж байгаад 30 минутын дотор БНМАУ гэдэг нэрийг энэ хуулийн нэртэй хамтатгаад нэгмөсөн гар өргүүлээд шийдчихэж байгаа асуудлыг буруу гэж үзэж байна.

Энэ яагаад буруу байдаг км бэ? Нэгдүгээрт түүхийн өмнө ямаршуу янзын гуйвуулгатай дүгнэлт хийгээд байгаагаа ухаарч байна уу? Сэтгэлийн хөдөлгөөндөө автаж болохгүй ээ. Бид бол эдийн засаг нэгтэй, амьдрал нэгтэй, үзэл санаа, угсаа бүгд нэг ийм хүмүүсүүд энэ танхимд сууж байгаа. Бид нэг хэсэг нь дайсан, нэг хэсэг нь монголыг аврагчид биш ээ. Цөмөөрөө монголынхоо төлөө зурх цохилж байгаа ийм хүмүүсүүд энд байж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Би юу хэлэх гээд байна вэ гэвэл энэ асуудалд нухацтай хандахгүй бол бид ингээд нэг гар өргөлтөөр нэг танхим дотор арван хэдэн хүн, хорин хэдэн хүн тохироод энэнийг депутатуудад элдэв янзаар зөв

3.

талаас нь хүчээр тулгах талаас нь тайлбарлаад, асуудлыг ингэж шийдвэл үнэхээр ард түмэн маань хүлээж авахгүй. Өнөөдөр ард түмэн тун хүнд амьдарч байгаа шүү. Ер нь энэнийг мэдэрч байгаа хүн байна уу үгүй юу. Цаана чинь идэх хоол байхгүй, өмсөх зүүх юм байхгүй, ер нь яадаг дээрээ тулчихаад сууж байгаа шүү. Зарим нь урд талбай дээр амиараа дэнчин тавьчихаад сууж байгаа шүү. Зарим хүмүүсүүд хэрвээ энэ асуудлыг буруу талаар шийдвэл би энэний төлөө амиа өгнө гээд Ардын Их Хурлын хуралдаанд мэдэгдэл өгсөн шүү. Энэ бүгдийг жаахан бодож, хэрээ мэдэж, жаахан одоо шинэчилж өөрчилсөн юмаа нэг тийш нь бүр астаад хаячихалгүй, гойжуулчихалгүй, тогтоож өөрчилсөн юмаа сайхан ултай суурьтай өөрчлөөд өөрчлөхгүй оролдохгүй юмаа хэвээр нь үлдээгээд та биднээс ухаантай хүмүүсийн өгсөн нэр томъёоллоор Бүгд Найрамдах Монгол Ард Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүнд элссэн, түүгээр ч барахгүй, манай улсыг хүлээн зөвшөөрсөн дэлхий дахинд.

Биднийг, Монгол улсыг манай амьд махнаас тасалдсантай адилхан, монгол улс бол манай улсаа гэж зарлаж байсан улс орон манайхад ойрхон байгаа. Тэгэхлээр бид автоматаар ингээд нэг нэр өгөөд, ингээд олонхи нь цөөнх уруугаа, цөөнх нь олонхи уруугаа уусах маягаар ингээд явах уу? Эсвэл тэр оролдохгүй юмаар нь оролдолгүй байж байгаад энэ эцэг өвгөдийн үлдээсэн энэ нэр томъёогоор нь нэг жаахан царуухан шиг явах уу гэдэг ийм асуудал тулаад байгаа шүү. Түүхийн өмнө бид нар хариуцлага хүлээх тухай хоёр гурван жил сонссон. Харин энэ чинь их хариуцлагатай байгаа шүү. Эрхэм депутатууд, эрхэм хүндэт Их Хурлын дарга, удирдагчид жаахан олон талаас нь бодоорой. Нэг талаас нь биш. Манай улсын хүндэт Ерөнхийлөгч адилхан. Нэг талаас нь одоо асуудалд хандаж болохгүй, арав хорин талаас нь асуудалд хандаарай гэдгийг зориуд хэлэх гэж бодсон юм аа. Ингээд миний санал бол бид өөрчлөхгүй гэдэг асуудлуудаар ганц хүн суухгүй, Үндсэн хуулийн нэрийг тэр Засаг хууль ч гэнэ үү энэ бол өөрчилж болно оо. Бүгд Найрамдах гэдгийг өөрчилвөл алсдаа Монголын ард түмний энэ сайхан үр садн өмнө бид түүхийн өмнө жаахан нүгэлтэй юм хийчих гээд байна шүү. Жишээ нь ингээд Монгол улс гэдгээр батлагдаж гэж

## 4.

бошье. Магадгүй хоёр гурван жилийн дараа манай казахын ард түмэн үгүй энэ чинь би монголын иргэн биш шүү дээ. Бид чинь бол казахын ард түмэн. Бид буриад чинь монгол биш шүү дээ. Бид буриадын ард түмэн. Ингээд салаад явахыг хэн байг гэх юм бэ? Салъя гэж хэлвэл яах юм. Гэх мэтчилэнгээр нарийн юм бий шүү. Энэ бүгдийг харгалзаж үзэж, хэрвээ даруухан авч үзвэл Бүгд Найрамдах гэдэг үгээ үнэхээр өрөөсөө гээж болохгүй, Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг юм уу, Монгол Ард Улс гэдэг юмаараа үзээд, харин тэр Үндсэн хууль гэдэг юмаа харин тэр Их засаг гээд нэрлэчихээ. Тэр хамаа алга. Тэр юу гэж нэрлэсэн ч нэд алга. Тэгэхгүй шүү. Хэрвээ энэнийг ингээд өвтгүүлээд байх юм бол өрөөсөө салахгүй шүү.

Ардын Их Хурлын 10 дугаар тойргийн депутат

О. Дашбалбар:

—Депутат нөхөд өө! Сая бүлэг, нам, группүүдийн ахлагч нарыг цуглуулаад уулзалт хийж ярилцлаа гэж тохирсон. Тэгэхээр энэ тохиролцоог хүлээж аваагүй цорын ганцхан групп бол бие даасан депутатуудын бүлэг бөгөөд, тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ийн холбоо энэнийг хүлээж аваагүй. Яагаад хүлээж аваагүй вэ гэхлээр улс орныхоо нэрийг хэвээр үлдээх, Үндсэн хуулийнхаа нэрийг хэвээр үлдээх бол манай тусгаар тогтнолтой холбоотой учраас бид лангаараа эсэргүүцсэн. Зүгээр өнөөдөр танилцуулахдаа бүгдээрээ ээвлэлдөөд шийдсэн юм шиг ингэж танилцуулж байна. Бид энэнийг зөвшөөрөхгүй ээ. Би бол энд, энэ дөрвөн асуудал дээр яах вэ хэлэлцэж тохирье гэж бодож байгаа. Үндсэн хуулиа үлдээе, Улсынхаа нэрийг хэвээр үлдээе. Сүлдээ бол яах вэ өөрчилж болж байна. Тэгэхдээ тэр шувууг авахгүй, зүгээр өөр маягаар өөрчилж болно. Далбаагаа өөрчилье, тавь тавь хувир санал нэгдье гэдэг тийм санал тавьсан.

Чи зүгээр хуцаж бай гэх нь холгүй байна лээ. Би зүгээр энд өнөөдөр үнэхээр, түрүүн нэг хүн хэллээ. Уйлмаар байна гэж. Бараг миний эх орны тусгаар тогтнол өнөөдрөөс эхлээд алдагдах зам уруугаа орлоо гэж хэлэхэд илүүдэхгүй гэж бодож байна. Өмнөд их хөрш маань мянга мянган жил, зуу зуун жилээр

## 5.

манай тусгаар тогтнолд шунаж ирсэн. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэрийг байхгүй болгож, Монгол улс гэдэг нэрийг бий болгож байгаагаараа бид эх орноо худалдах анхны алхмыг хийж байна гэж ингэж бодож байна. Цаашид энэ бүлгүүдийн хуралдаанаар шийдсэн асуудалдаа тийм тийм группүүд нийлээд шийдлээ, тийм нь зөвшөөрсөнгүй гэгцгийг заавал хэлж байх ёстой. Би энэнийг хэлмээр байна.

Хоёрт гэвэл ерөөсөө бид энэ Чимид гэгдэг хүнийг би өчигдөр ардын дайсан гэж хэллээ гэж Ламжав намайг шүүмжилж байсан. Би үнэхээр ардын дайсан гэж хэлж байсанд аа одоо би баярлаж байна. Хуралдаан болох тусам энэ хүн босч ирээд нэг км хэлдэг. Эцсийн эцэст бүх км энэ хүнийхээр л болдог. Монгол улсын Үндсэн хууль гэж хэлүүлбэ гэж энэ хүн санаачилсан, энэ хүн үнэхээр ардын дайсан байна, би энэ үгнээсээ буцахгүй, ингээд намайг шүүхэд өгвөл өгөөрэй, хамаа алга. Миний хамгийн харамсаж байгаа км бол Их Хурлын депутатууд дэгээ барихгүй, асуудалд зарчимч хандахгүй байна. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нэрийг Үндсэн хуулинд аа улсынхаа нэрийг хэлэлцэхдээ шууд зүгээр 30 минут ярилцахгүйгээр бид санал хураалгалаа. Гэтэл бид зөвхөн Үндсэн хуулийг хэлэлцэхийн тулд, нэрийг нь хэлэлцэхийн тулд бүтэн хоёр өдөр болсон. Өөрөөр хэлбэл би удаа дараа хэлж байгаа. Үхлийг сана гэж. Энэ үг бол тоглоом биш байсан.

Хоёрт гэвэл би нэг үг байнга хэлж байгаа. Өмнө зүгт Тангуд улс байгааг өглөө болгон надад сануулж байгаарай гэж Чингис хаан хэлж байсан. Өнөөдөр бид нар Бага Хурал жүжиг тоглож байна гэж намайг хэлж байхад зарим хүн Бага Хурлыг гутаах гээд байна гэж хэлээд байх шиг байна. Тийм биш. Үнэхээр энэ найруулсан жүжигт бид автагдаж байна. Би өдөр болгон энэнийг сануулж байгаа, энэ жүжгийг гол найруулагч, гавъяат жүжигчин нь Дэд Ерөнхийлөгч Гончигдорж, голлон найруулагч нь Чимид санасандаа хүрлээ, та нар эх орныг минь худалдах кмаа хийж байна шүү гэгцгийг би харин хатуу хэлчихье.

Монгол Улсыг бид худалдаж болохгүй. Дахиад ийм явдал болдог км бол энэ бол арай өөрөөр эргэнэ байх шүү.

## 6.

Ардын Их Хурлын 235 дугаар тойргийн депутат Ц.Өөлд:—Сая одоо манай хүндэт депутатуудын ихэнхийн саналаар Монгол улс гэдэг нэр дээр тохирч байх шиг байна. Тэгэхдээ Монгол улс гэж нэрлэхдээ Нэгдсэн Монгол Улс байгуулахыг цаашдаа бодож та бүгд санал өгсөн байлгүй дээ.

Хоёрдугаарт, гадаадад байгаа монгол ах дүү нартаа нутгаа бэлтгэж өгөх санаанаас санал өгсөн км болов уу даа гэж бодож байна. Буруу байж магадгүй шүү уучлаарай. Хэрвээ тэгж өгсөн бол одоо байгаа хоёр сая цөөхөн монголчууцныхаа үндсийг уусгах эх сурвалж тавьчихаж байгаа км биш байгаа даа гэж хэлэх байна.

Гуравдугаарт, Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэрийг авахдаа 1945 онд бүх ард түмнээс санал асуулгаж байж тэр энэ нэр дээр тогтож авсан энэ нэрийг бид ардчилал, шинэчлэл, өөрчлөл хөгжүүлж байна гэж байгаа. Ямар ардчиллаараа энэ нэрээ тэр бүх ард түмнийхээ авсан саналаас ухарч байгаа км бол оо гэж. За яах вэ тэр ухардаг км байна гэж бодоход би өөрийнхөө горимын саналыг хэлье. Хэрвээ бид иргэний ардчилсан нийгэм байгуулах гэж байгаа бол бид тэр Ерөнхийлөгчөө, засаг төрөө сонгодог улсаа гээд Бүгд Найрамдах гэж нэрлэж байгаа учраас бид тун болдоггүй км бол Бүгд Найрамдах Монгол Улс гэж нэртэй болмоор байна. Ийм учраас Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг нэр дээр санал хурааж өгнө үү гэж хүсмээр байна. Баярлалаа.

Ж.Уртнасан:—Цөөнхийн саналыг сонсоё гэж та бид ярилцаж тохирсон. Цөөнхийн саналыг сонслоо. Харин одоо улсын нэрийн талаар БНМАУ-ын Гадаад явдлын яамнаас ирүүлсэн баримт бичиг бий. Уучлаарай депутатууд аа. Бид сая нэг ийм зүйл дээр тохирсон км. Бид нэгэнт итгэл найдвар хүлээлгэж энэ Үндсэн хуулийн төслийг Бага Хурал оруулж байгаа учраас Бага Хурлын зарим нөхдийг байн байн танин мэдэхүйн чанартай тодотгол хийх ийм зүйлүүд дээр асууж танилцаж байх, мэдээлэл авч байх

7.

нь зүйтэй гэдэг дээр бид тохирсон юм. Тэр Гадаад явдлын яамнаас ирүүлсэн баримт бичгийг та уншиж сонсноо уу. Бага Хурлын орлогч дарга аа.

Улсын Бага Хурлын орлогч дарга К.Зардыхан: Эрхэм депутат Ядамсүрэн асуудалд гурван асуулт тавилаа. Энэ <sup>гурван</sup> асуултанд товчхон энэ асуудлыг Бага Хурал дээр ярьж байхад сонирхож байсны хувьд хариулж болж байна. Хэрвээ хариулах болоогүй ээ, дараа болъё, бид эхлээд ярина гэвэл би депутатуудыг бас хүндэтгэж байна. Хурал шийдэх асуудал гэж бодож байна.

Ж.Уртнасан: Ярих нь зүйтэй байна л даа.

К.Зардыхан: Тэгэхээр энэ дээр Бага Хурлаас хэсэг гишүүн депутатуудын Бага Хурлын даалгавраар энэ асуудлыг нэлээн судалж үзсэн л дээ. Мэддэг хүмүүсүүдээс асууж, баримт баримтуудыг тодруулж нэлээн үзсэн. Хэрвээ дэлгэрэнгүй ярь гэвэл хэрвээ энэнийг би гуч, дөчин минут ч ярьж болж байна. Ингэх шаардлага байхгүй байх. Та бүхнийг чилээж магадгүй, ажлын бус цагаар, хамаагүй сүүлд депутатуудад ийм шаардлага, тайлбар хэрэгтэй гэвэл ямар нэгэн хорь гучин минут гаргаад хурлын бус цагаар би ярьж болох болов уу гэж бодож байна.

Сая гурван асуулт тавилаа. Эрхэм гишүүн Ядамсүрэн. 1915 оны гурван улсын гэрээ өнөөдөр мөрдөгцөж байгаа юм биш үү. Тэр гурван улсын гэрээ хүчинтэй байгаа юм биш үү гэж ингэж байна. Энэ гурван улсын гэрээ болсон. Гурван улсын гэрээнд Хаант Орос, Гоминданы Хятад, тэгээд Хаант Монгол улс орсон. 1915 онд Монголын автономийн асуудлыг ярьсан. 1917 онд Орост Октябрийн хувьсгал ялж, орос орон өөр орон болсон. Хятадад 1949 онд хувьсгал ялж өөр орон болсон. Хаант монгол улс өөр орон болсон. Ийм учраас 1915 оны гурван субъект бол өнөөдөр байхгүй нэгдүгээрт. Хоёрдугаарт 1945 оны бүх ард түмний санал асуулт тухай ярилаа. Үнэхээр энэ бол явагдсан. Энд үс нь буурал сор сууж эхэлж байгаа улсууд мэдэж байгаа. Тэрнээс. Энэ бол Монгол улсын нэрийн тухай санал яваагүй, Монгол улсын тусгаар тогт-

нолыг зөвшөөрч байна уу үгүй юу гэдэг асууцлаар ард түмний санал асуулга явагдсан. Ингээд энэнийг та бүхэн мэдэж байгаа. Энэний өнөөдөр ул мөр гэж бидэнд байхгүй.

Дараагийн асуудал бол энэ улсын нэрийг өөрчлөх юм бол бусад орон, улс орнууд хүлээж авахгүй юм биш үү гэдэг асууцлаар бид Нэгдсэн Үндэсний Байгууллагад манай галаадыг төлөөлж байгаа байгууллагуудын тусламжтайгаар хоёр ч удаа санал авсан юм. Улсын нэрийг өөрчлөхөд ер нь яадаг юм, ямар үр дагавар гардаг юм, бусад орнууд ямар байдаг юм бэ гэж асуусан. Тэгээд ирсэн албан ёсны бичгийг та бүхэнд уншиж сонсгоё.

Аливаа улс бүрэн эрхт тусгаар тогтносон улсынхаа хувьд албан ёсны нэр, туг, далбаа, сүлд, тэмдэг зэргээ өөрчлөх бүрэн эрхтэй. Гэхдээ ингэж өөрчлөх шийдвэрийг уг улсын хууль ёсны төрийн дээд байгууллага гаргах ёстой. Хөндлөнгийн ямар нэг, хэсэг бүлэг ингээд өөрчлөх юм бол энэ бол болохгүй, албан ёсны хууль тогтоох дээд байгууллага нь энэнийг шийдэх ёстой гэдэг утга энд байна. Улсынхаа нэр буюу туг, далбаа зэргийг өөрчилсөн тухай дипломат харилцаатай улсууд элсэн орсон олон улсын байгууллагуудад албан ёсоор мэдэгдэх шаардлагатай байдаг. Улсын нэр өөрчлөгдсөнөөс тэр улсын хувьд хууль зүйн ямар нэг үр дагавар гарахгүй гэж ингэж ирүүлсэн байна. Бас нэг депутатын, нэрийг нь анзаарсангүй уучлаарай, 24 оны Үндсэн хуулийг хүчингүй болгож байгаа юм уу гэж ярьж байна. 24 оны Үндсэн хуулийг 1940 онд хүчингүй болгосон, 40 оны Үндсэн хуулиар. Энэнээс гарах зардлын хувьд бид урьдчилж хийсэн тооцоо бий. Эртээд Бага Хурлын гишүүн Товуусүрэн товч танилцуулсан.

Энэ тооцоо, товч илтгэл бий. Тэрнийг та бүхэнд бичиж тараая. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, Ийм зүйлийг би одоохондоо хэлэх байна. Цаашид улсын нэрийг өөрчлөх жинхэнэ бусад шаардлагын хувьд ярих шаардлага гарвал, би хэрвээ шаардлага болбол яривал ярихад бэлэн байна.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛЭЭН

Л. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо



1991.XI.19.

Кассет № Ш67

15.40-15.57

М. Уртнасан: -Та бид ярилцаж тохирсон, цөөнхийн саналыг 7 хүн, микрофоны ард байсан 7 хүнийг сонсьё гэсэн. Бид сонслоо. Тайлбар асуултыг бас сонслоо. Одоо хэрэв та бүхэн дэгийнхээ дагуу явбал цөөнхөөс гарч ирсэн БНМУ гэдэг дээр санал хураалт явуулж болох нэг ийм хувилбар байна.

Одоо бид хуулийнхаа нэрийг тогтсон. Хэрэв та бүхэн дэгийнхээ дагуу явахаар бол бид одоо цөөнхийн саналыг сонсчихлоо. цаашаа явмаар байна.

Уучлаарай, депутатууд аа, бидэнд ер нь хурлын удирдлага дэгээ сайн барьж байхыг олон хүмүүс сануулсан. Бид ч дэгээ сайн баримаар байна, та бүхэн ч дэгээ сайн баримаар байна. Бид нэг оруулсан томъёолол дээр цөөнх санал гаргавал дахин санал хураалт явуулдаг. Ийм учраас бид Монгол улс гэсэн энэ томъёолол дээрээ дахин санал хураалт явуулж байна.

Монгол улсын Үндсэн хууль. Санал хураалт бэлтгэнэ үү. Монгол улсын Үндсэн хууль гэдгээр санал хураалт явуулах гэж байна. Эрхэм депутатуудыг суудалдаа суухыг хүсч байна. Санал хураалтад оролцохыг хүсч байна. Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр бид санал хураалт явуулсан. Цөөнхийн саналыг үндэслэж дахин санал хураалт явуулж байна. Монгол улсын Үндсэн хууль. Санал хураалтад бэлтгэнэ үү. Монгол улсын Үндсэн хууль гэдгээр санал хураалт явуулъя. Бид хурлынхаа дэгийг баримаар байна. Тэгэж байж бид дэгтэй, журамтай хуралдах болно. Санал хураалтад бэлтгэнэ үү.

депутатууд аа, та нар цөөнхийн саналыг сонслоо. Суудалдаа суухыг хүсч байна.

Бид хуулийнхаа нэр дээр л авч байгаа шүү дээ. Монгол улсын Үндсэн хууль. Улсын нэрийн асуудал зүйл ангиар хэлэлцэхэд очно шүү дээ, эрхэм депутатууд аа. Бид Үндсэн хуулийнхаа нэр дээр л авлаа шүү дээ.

Улсын нэр дээр зүйл тус бүрээр ярихад та бүхэн ярьж амжина шүү дээ. Бид сая хуулийнхаа нэрийг л баталлаа шүү дээ.

Та бид хэдхэн минутын өмнө санал хураалт явуулж олонхийн саналаар, дийлэнх олонхийн саналаар хуулийнхаа нэрийг тогтлоо шүү дээ. Одоо цаашаа явах юм биш үү.

Монгол улсын Үндсэн хууль гэдэг томъёоллоор бид дахиж санал хураах гэж томъёолж байгаа шүү дээ. Дэгийн дагуу бид тийм л байгаа. Монгол улсын Үндсэн хууль ...

Бид хурлынхаа дэгийг хүндэтгэмээр байна, эрхэм депутатууд аа. Бид цөөнхийн саналыг сонслоо. Одоо цөөнхийн саналыг үндэслэж дахин санал хураалтаа явуулмаар байна.

Уучлаарай, бид дэгийнхээ дагуу хуралдаж гэвэл ингээд дэгийн дагуу хуралдмаар байна. Хэрэв эмх замбараагүй зааландаа хөтлөгдөө гэх юм бол бид эмх замбараагүй ярьж шуугиж болохоор боллоо. Улсын нэрийг зүйл тус бүрээр хэлэлцэхэд хэлэлцэнэ. Та бүхэн ойлгооч дээ. Тэрэн дээр хажуугийн санал орж ирж болно шүү дээ. Хажуугийн санал, цөөнхийн саналыг хураалгаж болно. Тийм нээлттэй хувилбар бий шүү дээ.

Уучлаарай, депутатууд аа, хэрэв бид дэгийнхээ дагуу явж хуралдах ёстой бол бид эрхээ эдлээд үүргээ биелүүлж чадахгүй байна, ний нуугүй хэлэхэд. Хэрэв дэгийн дагуу явахаар бол бид хоёр удаа цөөнхийн саналыг сонсоод, хоёр дахь удаа санал хураалт явуулах ёстой. Би та бүгдийг санал хураалтад урьж байна.

Монгол улсын Үндсэн хууль гэдэг томъёоллоор дахиад санал хураалт явуулъя. Цөөнхийн саналыг сонслоо. Монгол улсын Үндсэн хууль гэдэг томъёоллоор хоёр дахь удаа санал хураалт явуулахад бэлтгэнэ үү.

Бид нэг л томъёоллоор санал хураалт явуулдаг зарчимтай шүү дээ, эрхэм депутатууд аа. Бид 8 өдөр хуралдаж байна. Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр санал хураалт явуулсан.

Та бид бүгдээрээ оролцсон. Энэ томъёоллоор дахин санал хураалт явуулъя гэж би та бүгдээс хүсч байна шүү дээ.

Бид хурлын дэгийн дагуу санал хураалтад орох хэрэгтэй байна. дэгийн дагуу л явж байна, бид нар. Санал хураамаар байна. Бид дэгийнхээ дагуу явж байна шүү дээ, эрхэм депутатууд аа. дахин шаардая. Саян томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Хэрэв тэгээд цөөнх болж чадахгүй бол та бүхэн үгээ хэлэх ёстой шүү дээ. Бид дэгээрээ л явж байна шүү дээ.

Уучлаарай, депутатууд аа, санал хураалтад орох юм биш үү, бид дэгээ баръя. Монгол улсын Үндсэн хууль гэдэг томъёоллоор бид санал хураалт явуулсан шүү дээ. Улсын нэрийг оруулахгүйгээр Үндсэн хууль гэдэг дээр санал хураалт явуулъя гэсэн томъёолол гарч ирж байна уу?

Улсын нэрийг нээлттэй үлдээ. Уучлаарай, депутатууд аа, суудалдаа сууж санал хураалтад бэлтгэнэ үү. Та бүгдийн хүсэлтээр улсын нэрийг нээлттэй үлдээж болно, хажуугийн санал, болно. Хуулийнхаа нэрийг Үндсэн хууль гэдэг дээр санал хураалт явуулъя. Суудалдаа сууна уу.

Санал хүчинтэй байгаа.

Уучлаарай, депутатууд аа, энэ бол маргаантай асуудал. Бид та бүхэнд дахин сонордуулъя. Бид жаахан уужуу тайван ухаанаар хандмаар байна. Та, бид завсарлагааны дараа орж ирээд Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр санал хураалт явуулсан. Монгол улсын Үндсэн хууль гэдэг томъёоллоор санал хураалт явуулсан. 273 депутат буюу 69 хувь нь саналаа өгч зөвшөөрсөн, 83 депутат буюу 21 хувь нь татгалзсан, 42 депутат буюу 10 хувь нь түдгэлзсэн. Энэ санал хураалтыг бид хүчингүй болгож чадаагүй байгаа шүү, нэгдүгээрт үүнийг хэлье.

цөөнх, дээгийн дагуу цөөнх саналаа хэлсэн.7 хун саналаа хэлсэн.Хоёр дахь удаагийн санал хураалт явуулбал бид мөн энэ томъёоллоор Монгол улсын Үндсэн хууль гэдгээр санал хураалт явуулах ёстой байсан.Гэтэл маргаан их гарлаа, харамсаж байна.

Намын удирдлагууд 30 минутын завсарлага авахыг хүсч бидэнд санал ирүүлж байна.Хэрэв бид ийм явзаар хуралдах юм бол ард түмэндээ эрхээ эдлээд үүргээ биелүүлж чадаагүй гэсэн ийм дүгнэлттэй Их Хурал тарж ч мэдэхээр байна. Хэрэв заал ийм замбараагүй байх юм бол бид хурлаа хааж ч болох юм.Ийм учраас намуудын бүлгийн хүсэлтийн дагуу 30 минутын завсарлага олгож байна, та бүхэнд.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:



Ш.БУРМАА

Бичээч

Ө.Оюунчимэг

1991.XI.19.  
Кассет № 368  
17.15-17.30.

Н. Уртнасан: -Нам, орон нутгийн бүлэг, эвслүүд тохиролцоонд хүрэх зорилгоор, саналаа солилцох зорилгоор завсарлага авсан. Одоо нам, орон нутгийн бүлэг, эвслийн дарга нар ямар тохиролцоонд хүрэх гэдэг талаар саналыг сонсьё. Намын бүлгийн удирдлагууд микрофон дээр очихыг урьж байна.

Б. Даш-Ендон: /4/ дугаар тойрог/ -Ярилцлаа. Шууд тохиролцоонд хүрч болохгүй байна. Манай бүлгийн нөхдүүд яриад юу гэж шийдэв ээ гэвэл улсын нэр, хуулийн нэрийг тус тусад нь ярьж тогтё, гэхдээ улсынхаа нэрийг ярихдаа хаалттай хуралдаан хийе. Хурлын удирдлагад дамжуулж өг гэсэн. Би түүнийг дамжуулъя.

3 дугаар тойргийн депутат Р. Барсболд: -Манай бүлгийнхэн хуралдаад түрүүний бидний санал хурааж байсан үдийн өмнөх хуралдаанаас, завсарлагаанаас өмнө, завсарлагааны үеэр нэг багц зангилаатай асуудал Монгол улсын Үндсэн хууль гэдэг энэ нэр томъёолол уг нь зөвшилцөх үндэс суурийг нэлээд сайн тавьж өгсөн гэж үзэж байсан юм.

Иймэрхүү саналыг ч бид, өмнө нь Ерөнхийлөгчтэй уулзаж, ярилцахаас өмнө бид бас санал солилцож байж ийнхүү чиглэлийг гаргасан байсан юм. Одоо бид энэ нэр томъёоллын аль ч хэсэг дээр Үндсэн хууль гэсэн хэсэг дээр ч, Монгол улс гэсэн хэсэг дээр ч, өөрөөр хэлбэл, улсын нэр, хуулийн нэр дээр ч гэсэн ярилцаж бодмоор юм гэж үзэж байна. Гэхдээ чухам яг нууц хаалттайгаар хуралдах эсэхийг бид нэг их ярилцсангүй.

39 дүгээр тойргийн депутат Д. Дамжав: -Тэгэхээр хуралдаанд сая ардчилсан эвсэл, бүлэг ярилцаад хамгийн гол нь энэ хурлын дэгийг нарийн сахих шаардлагатай. Түрүүний санал тасалснаас хойш гарч шуугилдсан депутатуудын яриа, санал хураалтын томъёоллыг ойлгохгүй байгаа явдал бол тэр дэгийг буруу ойлгож байгаатай холбоотой байна

гэдгийг ярилцсан. Энд жишээлбэл, Монгол улсын Үндсэн хууль гэдэг нэр бол улсын нэрийг ч өгч байгаа хэрэг, хуулийн нэрийг ч өгч байгаа хэрэг. Энэ дээр эргэлзээд байх юм алга. Энэ дээр зохих хувь процентоо авчихаад байгаа. Хажуугийн саналууд гарсан, цөөнхөөс цөөнхийг хүндэтгэж санал хураах ёстой. Гэхдээ энд эрхэм депутатууд нэг зүйлийг дэгтэй холбогдсон, цаашдаа ч их олон гарах байх, ойлгох ёстой.

Тэр цөөнхийн саналыг хүндэтгэхийн тулд өмнө хувь процентдоо хүрсэн тэр саналыг яг тэр томъёоллоор нь хэлж л санал хураалгуулдаг юм аа. Зарим хүмүүс, миний тавьсан саналаар хэлж санал хураалгахгүй, тэрүүгээрээ яваад байна гэж гомдож байна. Яагаад гэхээр, хэрвээ тэр хуучин санал чинь процент нь буугаад уначих юм бол таны хэлсэн тэр юугаар ингэж дахиж санал хураалгуулна. Хэрвээ тэгэхгүй хамаагүй гарч ирсэн юм бүхнээр хураагаад байх юм бол нэг асуудал дээр 10 шийдвэр ч гарч болно. Тэгээд сүүлд нь утга учраа алдсан юм болно. Тэгээд бид нар юу гэж ярьсан гэхээр дэгээ сахъя. Хурал амжилттай болох хамгийн чухал зүйл бол дэг. дарга дэгийн талаар заримдаа оновчтой оновчтой сануулж баймаар байна. Үг өгөөгүй байхад амаа нээж болохгүй. Ингэж байж сая одоо ардчилалд ч бас эмх журам гэж бид нар зөндөө ярьдаг. Ийм л гол тохиролцоо бас байгаа гэдгийг хэлье.

187 дугаар тойргийн депутат О. Очиржав: — Монголын Ардчилсан Намын бүлэг ардчилсан эвсэл бүлэгт хамаарч яваа л даа. Тэгээд бүлгийн ахлагч депутат Р. Барсболд тодорхой байр суурийг илэрхийлсэн тул давтах шаардлагагүй болов уу гэж бодож байна.

дашням: — Энэ асуудлаар манай бүлэг тусдаа цуглаж ярьсангүй. Бид ардчилсан эвсэл бүлэгт орж байгаа. Тэнд саналаа солилцсон. Ер нь ойлголт ийм нимгэн байх үед түрүүн ч Барсболд хэллээ. Бид нар бүгдийг эхнээс, харамсалтай нь, их харамсаж байна. Бүгд юм эхнээсээ эхлэх юм шиг байна, одоо яая гэх вэ? Ойлголцлоо бий болгоход бэлэн байна гэж бодож байна.

д. Уртнасан: -баярлалаа. депутатын бүлгүүд, ардчилсан намын бүлгүүд саналаа солилцсон шиг байна. Тэгэхээр бид үндсэн хоёр хувилбар байгаа юм. МАХН-ын бүлэг улсын нэр, хуулийн нэрийг салгаж, дахин ярилцаж гэсэн ийм санал оруулж байгаа юм байна. Улсын нэрийг хэлэлцэхдээ хаалттай явуулъя гэсэн саналтай байгаа юм байна.

Бусад бүлгүүд бол санал хурааж тохиролцоонд хүрсэн та бидний 69 хувийн санал авсан Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр байгаа юм байна. Тэгэхээр би та бүгдийн санаа бодлыг еер зүгт эргүүлэх гэсэн ийм бодол агуулахгүй байна. Түрүүчийн санал гаргасан улсууд дотор Бүгд Найрамдах, улсын нэрийн өмнө Бүгд Найрамдах гэдэг үгийг нэмье гэсэн санал гарч байна лээ. Тэгэхээр Бүгд Найрамдах гэдэг үгнээс нэг их зайлж байгаа юм байхгүй ээ. Гэхдээ та бүхэн одоо олон улсын тавцан дээр болж байгаа үйл явдлыг ажиглаж байгаа байх. Саяхан Тува улс бүгд найрамдах улс гээд зарлачихлаа, өөрийгөө. Бүгд Найрамдах Буриад улс гээд зарлачихлаа.

Ийм учраас бид чинь өөрсдөө жижгэрч ний нуугүй хэлэхэд жижгэрч Бүгд Найрамдах Тува, Бүгд Найрамдах Буриадтай бүгд Найрамдах Монгол болж жижгэрэх юмуу, тэд нараас ялгарах монгол, Өвөрмонголын өөртөө засах орноос ялгарах монгол бий. Бид чинь монгол гэдэг нэрнээсээ монголчууд зугатаагаад яагаад байгаа юм бэ гэдгийг бид бас нэг бодож үзмээр байгаа юм. Үүнийг би зүгээр та бүгдийн оюун сэтгэлгээнд сонордуулаад орхий гэж бодож байгаа юм. Ингээд бид хурлын дэгийн дагуу санал хураалт явуулахад бэлэн болж байх шиг байна. Хэрвээ бид МАХН-ын бүлгийн дагуу улсынхаа нэрийг тусад нь авч хэлэлцье гэвэл томьёоллоо Ламжав депутат хэлсэн, Монгол улсын Үндсэн хууль гэдэг энэ санал дээрээ дахин санал хураалт явуулж салгах хэрэгтэй болно гэдгийг та бүхэн ойлгож байгаа. Ингээд хэрвээ бид монгол улсын Үндсэн хууль гэдэг олонхийн санал авч чадахаа больсон тохиолдолд улсын нэр, хуулийн нэрийг бид салгаж ярих хоёр дахь хувилбарт орох юм. Одоо санал

хураалтад бэлтгэнэ үү. Томьёоллоо дахин хэлье. Ламжав депутат нэлээн тодорхой хэлсэн гэж бодож байна. Бидний санал авсан дахин санал хураах гээд байгаа анхны томьёолол 69 хувьтайгаа байгаа. Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээрээ бид санал хураалт явуулъя.

Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээрээ санал хураалт явуулахад гурван янзаар гарна шүү дээ. Дэмжсэн, татгалзсан, түдгэлзсэн. Хэрвээ бид олонхийн санал авч чадахаа байсан тохиолдолд саян хажуугийн санал бууу улсын нэрээ салгаж ярина. Улсын нэрээ салгаж ярихад хүрвэл дахин санал хураалт явуулна. Хуралдааныг хаалттай хийх үү, нээлттэй хийх үү, улсын нэр хэлэлцэж эхлэх учраас. Одоо томьёолол ойлгомжтой болсон гэж бодож байна. Монгол улсын Үндсэн хууль гэдгээр санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатын тоо 590 буюу 91 хувь нь байна. 123 хүн хуучин саналаа зөвшөөрч, 230 хүн буюу 59 хувь нь улсын нэр, хуулийн нэрийг ярилцъя гэсэн хоёр дахь хувилбарыг сонгож байх шиг байна. Хэрвээ бид хоёр дахь хувилбарыг хэлэлцэж эхлэхээр бол улсын нэрийг хэлэлцэхэд хуралдааныг хаалттай явуулна гэсэн хажуугийн томьёолол дээр санал хураалт явуулах гэж байна, бэлтгэнэ үү. Томьёоллыг дахин хэлье. Улсын нэрийг хэлэлцэнэ. Хуралдааныг хаалттай явуулна.

39 дүгээр тойргийн депутат Д. Ламжав: -Саян санал дээр үг хэлье.

М. Уртнасан: -Ламжав депутат аа, бид ямар нэг хэмжээгээр уур амьсгалыг намжааж тохиролцоонд хүрч байгаа гэж ойлгож байгаа. Бид хэрвээ олонхийн саналд хүрэхээ боливол хоёр дахь хажуугийн хувилбараа авч санал хураалт явуулъя гэсэн. Санал хураалтад бидэнд хоёр хувилбар бий. Хуралдааныг хаалттай явуулна, улсынхаа нэрийг хэлэлцэнэ гэж. Тийм учраас бид улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэсэн санал хураалт явуулах гэж байна. Санал хураалтад оролцохыг урьж байна.



Д.Ламжав: -Намайг суулгах ганцхан арга бий шүү дээ, дарга аа.

М.Уртнасан: -Эрхэм депутатууд аа, санал хураалтад бэлтгэнэ үү. Улсын нэрийг хэлэлцэнэ, хуралдааныг хаалттай явуулна гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Баярлалаа. Нийтдээ санал хураалтад 39% депутат оролцсон байна. 86 хувь буюу 336 хүн хаалттай хуралдаан хийе гэсэн хувилбарыг зөвшөөрч байна. Татгалзсан 49 хүн буюу 13 хувь, түдгэлзсэн хүн 7 буюу 1 хувийг эзэлж байна. Ийм учраас улсынхаа нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэх болж байна. Цөөнхөө саналаа хэлье.

39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав: -Тэгэхээр Монгол улсын нэрийг хэлэлцэх асуудал дээр нууж хаагаад байх юм байхгүй юм. Энэний цаад талын улс төрийн зорилгыг их тод харж байна. Энэ бол айхтар юм яригдах гэж байна. Их улс төрийн аймшиг төрүүлэх замаар санал авах гэсэн олхиогүй арга гэж үзэж байна. Тийм учраас эрхэм улс төрийн бодлоготон депутатууд энд хууртагдаж байгаад би их харамсаж байна. Тийм учраас би энийг нээлттэй явуулах тухай асуудал тавьж байна.

Энэ бол маш хуучирсан бөгөөд үеэ өнгөрөөсөн арга гэдгийг би давтан хэлж байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУУНА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан - Цөөнх одоо энэ таван хүнээр таслая.

7 дугаар тойргийн депутат Балдорж -Бид Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг бүх ард түмнээр хэлэлцүүлээд намаржин, зунжин хэлэлцсэн. Ард түмэн маань улсын нэр ямар болох бол гэдэг дээр их санаа зовж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулах комисст, Бага хуралд их олон санал ирүүлсэн. Гэтэл бид нар улсынхаа нэрийг яг хэлэлцэх болох дээр ээрэг хаалттай хэлэлцэнэ гэдэг бол утга учир муутай асуудал байгаа. Бид үүнийг юунаас нуух гээд байгаа юм бэ гэдгийг учрыг би огтхон ч ойлгохгүй байна. Бид одоо ардчилал руу явж байна. Ил тод байдал манайд тогтож байгаа. Ардчилал тогтож байгаа гээд байдаг. Гэсэн мөртлөө яг ард түмний маань хүсэн хүлээгээд байгаа, сонсох гээд байгаа юмыг хаалттай хэлэлцэнэ гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Би үүнийг утгыг огтхон ч ойлгохгүй байна.

Ж.Уртнасан 4 дүгээр микрофон.

31 дүгээр тойргийн депутат Дожоодорж -Сая Балдоржийн саналтай нэг байгаа. Тэгэхлээр энэ дээр Үндсэн хууль, Монгол улсын Үндсэн хууль гэдгээр нэр өгөөд 69 хувийн санал авсан. Тэр санал бол хүчинтэй хэвээрээ байж байгаа. Гэтэл одоо энэ хооронд заль гарлаа. Яагаад вэ гэвэл улсын нэрийг Үндсэн хуулиас нь салгаж, Үндсэн хуулиар санал авах юм бол Их засаг гэдэгт хамт хоёр нэр байгаа. Хоёулангийг нь санал авах ёстой. Тэгэхгүйгээр ганцхан Үндсэн хууль нь улсын араас эүүж 69 хувь авчихаад одоо ганцаараа үлдэж байна. Энэ бол болохгүй ээ. Тэгэж ярих юм бол Их засаг чинь Үндсэн хуулиас хамаагүй өндөр санал авсан. Энэ хоёрыг эрх тэгш хэлэлцүүлж өгөхийг шаардаж байна. Улсын нэрний тухай энд яриагүй, улсын нэрийг дараа ярих хэрэгтэй. Одоо эхэлж Үндсэн хуулийнхаа нэрийг тогтох хэрэгтэй. Тэгээд дараа нь улсынхыгаа тогтоё. Тэгэж л санал хураах хэрэгтэй.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

55 дугаар тойргийн депутат Альяасүрэн -Бид нар өчигдөр, өнөөдөр хоёр үндсэн хуулийн нэрийг хэлэлцэж баахан цаг өнгөрөөлөө. Энэ бол маш их зардал гарч байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Ингээд яг өнөөдөр улсын нэрийг хэлэлцэх дээр хүрээд ирэхлээр хуралдааныг хаалттай хийх гэж байгаа энэ асуудал бол хуралдааныг цаашид улс төржүүлж, хуралдааны уур амьсгалыг хурцатгах гэсэн бодлого болов уу гэж их болгоомжилж оөрэмжилж байгаа. Бид нар харин энэ улсын нэрийн асуудлыг ард түмнийхээ өмнө ил нээлттэй хуралдаанаар хийх шаардлагатай, ийм учраас радио телевизээр энэ улсын нэр хэлэлцэх асуудлыг шууд дамжуулж өгөхийг хурлын даргаас депутатын хувьд санал болгон хүсч байна.

Ж. Уртнасан -6 дугаар микрофон.

Бага хурлын гишүүн Галсандорж -Би тэгэхлээр өрөөсөө ойлгохгүй байна. Өөрөөр хэлбэл энэ хурлыг хаалттай явуулна гэдгийг, тэр тусмаа улсынхаа нэрийг хэлэлцэх асуудлыг хаалттай хийнэ гэдгийг би өрөөсөө ойлгохгүй байна. Нэг талаар би монгол улсын тусгаар тогтнолыг доромжилж байгаа гэж ойлгож байна. Тийм учраас энэ асуудлыг санал хураахгүй ч уг нь байх ёстой юм даа гэж ойлгож байна. Тийм учраас энэ асуудлаа шийдвэрээ эргэж харж үзээч эз гэж хүсч байна.

Ж. Уртнасан -7 дугаар микрофон.

Улсын бага хурлын гишүүн Улаанхүү -Улсын нэрэн дээр би их гайхаж байна. Бид бол дотроо монголчууд дотроо ойлголцож болно л доо. Гэтэл үүнийг дэлхий даяар яаж хүлээж авах вэ, монгол улс өөртөө нэр өгөх гэсэн чинь яаж өгөхөө мэдэхгүй, дотроо жаахан нууцаар ярьж ярьж байгаад нэг нэр гаргая гэсэн ийм инээдэмтэй шу бол дэлхийн олон нийтэд хүрчих юм биш байгаа гэсэн юм байна. Хоёрдугаарт нь, өчигдөр тавьж байсан асуудлаа дахиад тавъя. Бид нар өнөөдрийн хуралдааны явцыг харахад намын бүлгүүд, эвсэл хэд хэдэн удаа завсарлага авлаа. Ийм байдлаар асуудал шийдэгдэхгүй. Асуудал яаж шийдэх вэ

гэх дээр зэрэг хуулийг хэн хэлэлцүүлж байна тэр хүн бол хуулиа хэлэлцүүлээд, нөгөө талд нь бол Их хурал бүлгүүддээ болж хуваагдаад, хууль хэлэлцдэг ёс журмаар нь явах ёстой. Үүнийг би эхэлж хэлэлцүүлж өгөөсөй, Энэ дээр Их хурал өөрөө шийдчихээд цаашаа яваасай гэж. Тэгэхгүй бол эргэлзээд байна. Дараагийн асуудал бол түрүүн хэлж байсан. Хуулийн нэрний асуудал үлдчихлээ гэж. Үүнийгээ шийдэхгүйгээр дараагийн асуудал руу орж байна. Улсын нэр лүү. Тэгвэл хуулийн нэрийг юу гэж шийдсэн юм бэ. Нээлттэй гэдэг нь үндсэн төслөөр Их цаазаараа юмуу, Үндсэн хуулиараа юмуу, Их засгаараа юмуу. Нээлттэй гэдгийг тодорхой томъёолчихоод миний бодож байгаагаар бол хэрвээ хууль оруулж байгаа улсууд, Бага хурлаас асуух юм бол нээлттэй гэдэг бол хуучин төслөөрөө үлдлээ гэсэн үг. Их цаазаар үлдлээ гэсэн үг. Үүнийг та бүгд зөвшөөрч байгаа юмуу үгүй юу. Хэрвээ үүнийгээ зөвшөөрч байгаа бол цаашаа улсын хоёрдахь хэлэлцүүлэг рүү орохдоо өнүүгээрээ орчихоод улсын нэр лүү орж болж байна. Энэ бүгдээ шийдчихээд явмаар байна шүү дээ. Хамгийн гол юм бол хуулийг хэн хэлэлцүүлж байгаа юм бэ гэдэг дээр тогтмоор байна.

Ж. Уртнасан – 8 дугаар микрофон. Энэ таван хүнээр тасалсан шүү. Дэгээ хатуу барья.

288 дугаар тойргийн депутат Баярцогт – Улсынхаа нэрийг хэлэлцэхэд хаалттай хуралдаанаар хийвэл олон улсынхан ойлгохгүй, монголын ард түмэн ч ойлгохгүй. Гуравхан хувилбар байгаа гэдгийг мэдэж байгаа. БНМАУ, Монгол улс, БНМУ гээд, ард түмэн өрөөсөө ойлгохгүй. Энэ гурван үсэгний ар талд монгол улсын тусгаар тогтнол, хувь заяатай холбоотой юм байгаа. Тэрийг ард түмнээсээ нууцалж байгаад хэлэлцэнэ гэвэл ард түмэн маань өрөөсөө ойлгохгүй. Энд ийм нууц юм байгаа гэдэгт өрөөсөө итгэхгүй байна. Тэгээд санал оруулж байгаа МАХН-ын бүлгийнхнийг маш их гайхаж байна. Үнэхээр үзэл бодлын нэгдэл мөн үү, үгүй юу гэдэг бол энэ дээр гарч ирж байгаа. Улсынхаа нэрэн дээр, энэ улсыг 70 жил удирдаад явж ирсэн нам маань улсынхаа нэрэн дээр тодорхой саналтай орж ирж чадахгүй байна аа гэдэг бол өрөөсөө ойлгомжгүй, энэ бол нам биш гэдгээ харуулж байна. Ингэж хэлэх ёстой. Энэ улс төржүүлж байгаа юм өрөөсөө биш. Энэ дотор

байгаа хүмүүс үзэл бодлынхоо нэгдлээр бүлэг болж тодорхой асуудал дээр ярилцах ёстой. Намууд өөрийнхөө байр суурийг олоогүй цагт тэр улс маань тогтож чадахгүй. Энэ утгаараа хэлж байна. Ийм санал оруулж байгаа намьг нам биш гэж хэлэхэд ерөөсөө буруутахгүй гэж бодож байна.

Ж. Уртнасан -2 дугаар микрофон.

УБХ-ын гишүүн Маам -Тэгэхлээр бага хурлын дарга аа, надад нэг зүйл ойлгомжгүй байгаа юм л даа. Юу вэ гэвэл. Уучлаарай Их хурлын дарга аа. Бага хурлын даргаа гэснээс Бага хурлын дарга өргөн дөвшүүлсэн Үндсэн хуулийн ажлын хэсгийн ажлагч нь гэж бодож байгаа. Тэр Бага хурлын даргыг би харахгүй байгааг далимд нь сонордуулъя, телевизээр л хараад байгаа.

Тэгээд Улаанхүүгийн саналтай нэг байна. Би ийм юм бодож байна. Энэ МАХН-ын бүлгийн үзэл баримтлал яахад товчоологдож нилээн сайн эв зүйгээ олж бөөгнөрсөн байх л даа. Тэгэхдээ энэ оруулж ирж байгаа бүлгийн ажлагч нь Даш-Ёндон дарга өөрийн үндэслэлийг хэлэхгүй байж болно оо. Тэгэхдээ Даш-Ёндон даргаас оруулж ирж байгаа саналынх нь үндэслэлийг Их хурал сонсохгүй байж болохгүй ээ. Үүнийг би Их хурлын даргад маш хариуцлагатай анхааруулахыг хүсч байна. Юуг далдлах гээд байгаа юм бэ. Депутатын саналтай санал нэг байна. Харин бүр эсрэгээр нийт ард түмэнд телевиз радиогоор, сонин хэвлэлээр энэ асуудлыг дэлгэрэнгүй тавих хэрэгтэй. Яагаад гэвэл дэлхийн сонорт хүргэх ёстой асуудал энэ мөнөөс мөн. Ард гэдэг үгийг улсын нэрээс авах тухай жишээлэхэд би 30 минутын лекц ярьж чадаж байна. Үүнийг би хэнээс ч нуухгүй. Нуух үндэсгүй тийм зүйл. Харин хэлэх ёстой тийм зүйл. Ийм учраас энэ 80 хувийн саналаар батлагдах тийшээ хандаж байгаа нууц байдалд улсын нэрийг хэлэлцэнэ гэдэг бол үнэхээр бухимдлын үндэс энэ байдаг байх даа. Ингэж болохгүй байх.

Ж. Уртнасан -3 дугаар микрофон Сайраан.

85 дугаар тойргийн депутат Сайраан -Би Даш-Ёндон даргаас шууд асуумаар байна. Ямар учраас, ямар шалтгаанаар ийм хаалттай

хурал явуулах болсныг, тийм санал оруулсныг асуумаар байна. Хэнээс **нууж байгаа** бол. Тийм учраас хурлыг нээлттэй явуулах талаар санал хураалгаж өгөхийг дарга танаас хүсч байна. Гэхдээ нэрээр санал хураамаар байна. Нэрээр санал хурааж өгөхийг. Сонин хэвлэлд хэрвээ нэрээр санал хураагаад дахиад олонжи нь нууцаар, хаалттай хурал хийнэ гэх юм бол эсрэг санал өгсөн нээлттэй хурал хийнэ гэсэн хүмүүсийн хэлсэн үгийг ил хэвлэлд тавих зөвшөөрөл хүсч байна. Түүнээс гадна энэ заалын дотор дотоод бичлэг хийх хэрэгтэй байна видеогоор. Анхдугаар хуралд ийм бичлэг хийж байсан. Энэ бол түүхэнд ч хэрэгтэй. Хэзээ ч хэрэгтэй, цаашдаа юу ч болж мэдэх юм. Тийм учраас заалан дотор дотоод бичлэг хийлгэхийг АИХ-ын удирдлага та бүхэн анхааралдаа аваасай гэж хүсч байна.

Ж. Уртнасан - Дотоод бичлэг хийх асуудлыг. За. Бид микрофоны урд талд 5 хүнийг бүртгэж авсан. Уучлаарай Эрхэм депутат Элбэгдорж, бид 5 хүнийг яриулаад цөөнхийг сонслоо. Тэгэхлээр томъёолол гарч ирж байна. Хоёр гурван депутат өөрийнхөө хүсэлт тавьж байна. МАХН-ын бүлгээс, Даш-Ёндон даргаас хуралдааныг хаалттай хийе гэдэг үндэслэлийг оонсоё гэж. Даш-Ёндон дарга үндэслэл тайлбарыг хэлж өгөхгүй юу.

2 дугаар микрофон Б. Даш-Ёндон - Манай дэгд хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хуралдаанд оролцсон депутатуудын ердийн олонхийн саналаар хуралдааныг хаалттай явуулж болно гэж бичсэн байгаа. Бодоход манай гишүүд үүнийг мэдэж байгаа. Ямар учир шалтгаанаар энэ хурлыг хаалттай явуулъя гэж байгаа юм бэ гэдгийг үнэндээ намын бүлгийн хурал дээр шалтгааных нь талаар хэлэлцээгүй. Тэр ямар шалтгаантай байгаа юм бэ гэдэг дээр эргэлзэж байгаа хүмүүс бол хаалттай хурлаа яваад ирэхлээр өө ийм юм хэлэх гээд хаалттай хийх гэж бодсон юм байжээ гэж ойлгох байлгүй.

Ж. Уртнасан - Тайлбарыг сонслоо. Цөөнхийн саналын дагуу дахин санал хураалт явуулъя. Нэрээр санал хураалт явуулна. Цахим техник та бидний нэрийг бичнэ. Томъёоллыг бид дахин хэлье. Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Уучлаарай дахин хэлье. Цөөнхийн саналыг сонсоод бид дахин санал хураалт

явуулж байна. Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Санал хураалт явуулж байна анхаараарай.

-За баярлалаа. Бид цөөнхийг сонсож, цөөнхийн хүсэлтээр дахин санал хураалт явууллаа. 227 депутат буюу 59 хувь нь хуралдааныг хаалттай хийе гэж байна. 116 хүн буюу 30 хувь нь татгалзаж, 39 хүн буюу 11 хувь нь тудгалзжээ. Ийм учраас ердийн олонхийн саналаар хуралдааныг хаалттай хийх болж байна. Уучлаарай. Энэ микрофоны ард 5 хүн байна. Одоо бид цөөнхийн саналыг сонсоод хуралдааныг дахиж битгий нэмээрэй. Цөөнхийн саналыг, бид ингээд тогтоё. Хэрэв тэгэх юм бол бид цөөнх гээд эх адаггүй гэж ярьдаг. Тэр л дэггүй байдалдаа дахиж орох нь байна.

-За 2 дугаар микрофон.


9 дүгээр тойргийн депутат Зориг -Горимын санал байна. Энэ юу вэ гэвэл улсын нэр түрүүлж хэлэлцэнэ гэсэн заалт бол дэгэнд байхгүй. Тийм учраас улсын нэрийг хэлэлцэх юм бол дэгэндээ еерчлөлт оруулж байгаад тэгээд хэлэлцэхээс еер арга байхгүй ээ. Тийм учраас дэгэн дээр байгаа шүү дээ. Зүйл зүйлээр дараалж явна гэсэн. Их цаазын нэрийг шийдээгүй байж шууд энэ улсын нэр лүү ордог бол миний ойлгож байгаагаар бол дэгийг зөрчиж байгаа хэрэг. Тийм учраас нэгэнт ийм зөрчилтэй шийдвэр гаргаж байгаа юм бол дэгэндээ еерчлөлт оруулаад эхлээд улсын нэрийг ярина гэдгээ тогтож байж тэгээд дараа нь саналаа хураах ёстой. Тийм учраас дахиад түрүүчийн анх гардаг тогтоолтой адилхан өөрийнхөө гаргасан шийдвэрийг зөрчсөн хоёрдахь шийдвэрээ өнөөдөр АИХ-ын эрхэм депутатууд гаргасан гэдгээ ойлгож байгаа биз дээ.

Ш. Уртнасан -3 дугаар микрофон.

Самат - Эрхэм депутатууд аа. Би ер нь их гайхаад болохгүй юмаа. Гайхаш төрж байна. Энэ бол өөрийнхөө нэрийг хэлж чадахгүй улсыг хэн уло гэж үзэх юм бэ, ил хэлж чадахгүй. Юунаас айгаад байгаа юм бэ. Ер нь манай депутатууд уучлаарай. Гэхдээ та нар хулчгар байна шүү. Өөрийнхөө толгойгоор ажиллаж үзээч.

Нэг бол сонгогчдынхоо захиа даалгавар гээд тэр нь ард нь нуугдчихдаг. Нэг бол намынхаа юунд орчихдог. Тэр карманаасаа тэр лавлагаа аваад хая. Ямар хэрэг байгаа юм бэ. Ингээд нэг кнопоо дарчихаад сууж байдаг. Бид нар зүгээр өөрийнхөө толгойгоор ажиллая л даа. Та нар депутат учраас хүн чинь төрийн тэргүүн хүн шүү дээ. Төрийн бодлогыг ард түмэн боловсруулдаггүй юмаа. хэзээ ч. Төрийн өөрийнх нь сонгосон төлөөлөгч нь боловсруулна, та нар боловсруулна. Та нар өөрсдөө тэр ард түмнийг араасаа дагуулах ёстой. Өнөөдөр энэ улсын нэрийн асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж байна гэдэг бол ерөөсөө бид нар ямар нэгэн нүглийг нуух гээд байгаа юмуу гэсэн сэтгэгдэл төрүүлж байна. Юугаа нуух гээд байгаа юм бэ. Нэг юм хэлчихнэ гээд айгаад байгаа юмуу. Тэр Хятад улс чинь ил байгаа шүү дээ. Одоо бүх юм ил шүү дээ. Тэр /сонсогдоогүй/ гэж юу байна, манай улсын эрх ашиг гэж юу байна, бүх юм тодорхой шүү дээ. Энэ дээр нуугтаад байх юу байгаа юм бэ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



/Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш



171 дүгээр тойргийн депутат Ж. Дхагважав: Энэ хуулийн төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлэх тухай асуудлыг одоо сонин, хэвлэлээр нийтлэгдсэн, радио, телевизээр нийтлэгдсэн. Бид өнөөдөр юу вэ гэхээр нэрнээс гол асуудал шалтгаалж эхэлсэн. Энэ төслийг анх эхлээд одоо сонин хэвлэл, радио телевизээр тараахдаа үндсэн, оноосон нэр гэдэг асуудлаар ард түмэнд тараагаагүй. Үндсэн хууль, Их цааз, Их засаг гэсэн ийм 3 нэрээр тараасан. Хэрвээ оноосон юмуу үндсэн нэртэй гэсэн энэ асуудлаар тараасан бол өнөөдөр ард түмний санал бас нэгэн тийшээ хандах ёстой байсан. Өнөөдөр зарим хүмүүс ард түмнийг, сонгогчдыг буруугаар ихээхэн үгүйсгэж ярьж байна. Энэ юу вэ гэхдээр нэгэнт ард түмэнд энийг чинь тараачихсан юм чинь энэ ард түмэн, тэр сонгогчид сонсдогоо сонсоод, үздэгээ үзээд, ярьдагаа яриад, хэлдэгээ хэлээд саналаа хийгээд өгсөн юмыг өнөөдөр энэ ард түмэн ингэж авчирч өнөөдөр энэ Их Хуралдаа ~~төлөөлж~~ тайлагнаж хэлж байгаа байх гэж бодож байна. Тийм учраас зарим улсууд элдэв юм яриад байна шүү дээ. Монгол улсын улсын нэрийн тухайд бид өнөөдөр тогтчихвол амархан тогтож болох байсан. Нэг саналыг эргүүлж хураагаад, хоёрдогч болгож хураагаад ингээд байгаа асуудлыг бас бодож үзэх ёстой. Нэгд.

Хоёрдугаарт энэ улсын нэрийг хаалттай хураана би МАХН-ын гишүүн хүн. Гэхдээ энэ Монгол улсын нэрийг хаалттай хураана гэдэг асуудлыг болбол хэлэлцүүлнэ гэдэг асуудлыг татгалзаж байгаа. Энэ юу вэ гэвэл өнөөдөр манай ард түмэн энэ хуулийг нэгэнт хэлэлцүүлчихсэн, өнөөдөр энэ сонгогчид гэсэн, тэр ард түмэн ч гэлээ гэсэн биднүүдийн энэ олон хоног ярьсан, өөрөөр хэлбэл юу гэвэл Улсын нэр, Үндсэн хуулийн нэрийн тухай асуудлыг хамгийн урьдаар өнөөдөр сонсож, хүлээж суугаа. Тийм учраас өнөөдөр илээрээ энэ ард түмэнд шударгаар сонсох ёстой гэж би бодож байна.

55 дугаар тойргийн депутат Ц. Агъяасүрэн: За яахав бид нар улсын нэрийг хэлэлцэхэд гуравхан нэр л байгаа шүү дээ. Монгол улс, БНМАУ, Бүгд Найрамдах Монгол Улс гэж. Энэ гурван

нэрийг хэлэлцэхдээ болбол хаалттай биш байхаа. Зүгээр энэ нэрэндээ гол асуудал биш байгаа байх гэж бодож байна. Дэгэнд бол тэртэй тэргүй бий л дээ. Зарим асуудлыг хаалттай хэлэлцэж болно гэж. Тийм учраас энэ нэрийг үндэслэж гаргах тэр үндэслэлгээгээ хийхдээ зарим нэгэн асуудлыг зайлшгүй хаалттай хийх шаардлага, үндэслэл байж болох юм. Тийм учраас ингэж хаалттай хийж болох юм. Тэгэхдээ бид нар цөөнх болоод ингээд дахиад санал хураалгалаа ч гэсэн энэ 59 хувьд хүрч чадахгүй байх. Тийм учраас бол хаалттай хийхээс өөр аргагүй байдалд хүрэх байна. Гэхдээ энэ дээр Улсын нэрийг хэлэлцэж байгаа хэлэлцэх үедээ тэр үндэслэлүүд бол янз бүрийн байдлаар гарч ирнээ. Тэр бол зайлшгүй түүхэн хариуцлага, түүхэн үндэслэгээтэй ийм юмнууд гарч ирэх учраас энэ хэлэлцэлгийн бүх ярьсан зүйлийг видео бичлэг хийх хэрэгтэй байна. Видео бичлэг хийхийг би депутатын хувьд хурлын удирдлагаас хүсч байна. Тэгээд яахав энэ тал дээр дахиж нэг санал хураая. Одоо цөөнхөд чинь бол хоёрдахь юмуу гуравдахь удаагаа санал хураалгах хэрэгтэй шүү дээ. Тэрнийхээ дагуу дахиж нэг санал хураалгая. Ийм л саналтай байна.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: Надад ямар нэгэн хардсан сөрдсэн юм алгаа. Гэхдээ би хоёр, гурван зүйл дээр үндэслэл хэлбэ.

Нэгдүгээрт бид нар улсынхаа нэрийг өөрчлөх гэж байгаа юм бишээ. Монгол улс гэдэг энэ нэр байсан, байсаар ч байгаа, өөрчлөнө барина гэсэн ийм сонин юм яриад байгаа. Харин улсынхаа нэрэнд аваачиж зүүсэн тэр зүүлтүүдийг л авах тухай асуудал ярьж байгаа. Бид шинээр нэр өгөх гэж байгаа юмуу, аль эсвэл өөрчлөх гэж байгаа, аль эсвэл солих гэж байгаа юм энд ердөөсөө байхгүй. Тэгэхээр бид энийг хэн нэгнээс нуух шаардлагагүй юмаа. Бид тэр нэрээ л байна, хойшдоо ч байх болох нээ гэдгийг л их хуулиндаа бататгах гэж байгаа. Дараачийн нэг зүйл манай депутатууд миний үгийг ард түмэн сонсох ёстой, сонгогчид сонсох ёстой гэж ярьдаг. Энэ үнэхээр гол зүйл. Улсын нэрэн дээр ярих таны үгийг ард түмэн сонсохгүй, сонгогчид сонсохгүй болбол таныг хэн ч ойлгохгүй, бидний гаргасан шийдвэрийг ойлгохгүйд хүрнэ. Дараачийн нэг зүйл болбол бид хоорондоо юу гэж ярилцаж байж энэ Ардын Их Хурал, ард түмнийг төлөөлсөн энэ Их хурал юу гэж ярилцаж байж, ямар то-

хиролцоонд хүрч энэ шийдвэрийг гаргасан юм бэ гэдгийг монголын ард түмэн харин мэдэх ёстой, тэр сонгогчид ч мэдэж байх ёстой гэж би ингэж бодож байна.

За дараачийн нэг асуудал бол бид улсынхаа, энэ өөрийнхөө улсын нэрээ л хэвээр нь байлгаж байна гэдгээ ярьж байгаа. Энэ шийдвэрээ гаргасан тохиолдолд үнэхээр монголчууд өөрийн толгойтой болжээ гэдэг асуудал байна. Гэхдээ бол тэр Хятад ч гэдэг юмуу, Зөвлөлт гээд янз бүрийн юм яригдах байх, хэл мэл гэсэн юм яригдах байх гэж бодоод байгаа юм шиг байна л даа. Тэр арван хэдэн оны хэлэлцээр энэ тэр гээд. Тэр үед байсан Богд Хаант Монгол тэр чигээрээ биш байна шүү дээ. Өөр байдалтай байна. Тэр Гаминдааны Хятад, тэр Хаант Орос, тухайн үед байсан хуулийн субъектүүд өнөөдөр өөр болсон. Ер нь ямар нэгэн байдлаар нуух юм байхгүй. Зүгээр хаалттай хуралдааны цаана бол их олон нүгэл болж байсан л даа. Энийг бас санах хэрэгтэй. Хаалттай хуралдаан юмыг нуух тусам энэ өөрөө маш их илрэх, маш их ил болох энэ юмыг л бид нар тавьж өгдөг. Нуусан юмыг илрүүлэх гэж хүмүүс их хойноос нь явдаг. Нэмж олон юм илрүүлдэг. Илрүүлсэн дээрээсээ нэмж олон юм зүүдэг. Ингээд тэр тухайн үед хэлэлцсэн юмыг гутаадаг. Ийм учраас бидний энэ ярьсан зүйлийг ард түмэн маань бас сонсох, ойлгох учиртай. Харин энэ хариуцлагатай үед телевизээр, радиогоор шууд энийг нэвтрүүлж ярих юм бол илүү ойлгомжтой болно гэж бодож байна.

#### Улаанхүү:

Депутатуудаа энд бол нууц биш байна л даа. Энд бол тэмцэл явагдаж байна. Хоёр блок болчихоод хоорондоо тэмцэж байна. Тэгэхлээр бид эхний асуудлаа шийдэлгүйгээр дараагийн асуудалдаа орж байгаа маань дараагийн асуудлаа бүр тэгэхдээ хаалттай хийж байгаа маань энэ бол зүгээр олонхийг авах гэсэн арга л даа. Тэрнээс биш улсын нэрэндээ ач холбогдол өгч байгаа юм биш. Хоёрдахь асуудал дээрээ хаалттай олонхоор шийдчихээд эргэж ирээд нэгдэх асуудлаа авах гэж байна. Тэгээд ингэж яах юм бол энэ юунд хүрэхгүй. Харилцан ойлголцонд хүрэхгүй. Хэрвээ хоёрдахь асуудал. Хоёрдахь асуудал гэдэг би улсын нэрийг ярьж байна. Хоёрдахь асуудал дээрээ хаалттай хийх юм бол энэ бол үнэхээр Монгол улсын түүхэнд бол би шившиг болно байх гэж бодож байна. Ийм муухай

юманд би ардчилсан хүчнийхнийг битгий оролцоосой гэж санаж байна. Тийм учраас дэгээ бариад нэгдүгээр асуудлаа шийдчихээд яваасай гэж бодож байна. Хэрвээ ингээд үсрээд байх юм бол дэггүйгээр хуралдах нь байна шүү дээ. Дэггүй асуудлаа эхэлж заавал шийдэх хэрэгтэй. Хуулийн нэрийг яахав гэдгээ.

399-р тойргийн депутат Д. Чилхаажав: Би бас Улаанхүүтэй санал ойролцоо байна. Түрүүн бид нар бас горимын, зарчмын алдаа хийчихшиг боллоо. Монгол улсын Үндсэн хууль гэдэг нэрээр санал хураагаад дийлэнх олонхийн саналаар тогтсон юмыг ердийн олонхийн саналаар эргүүлээд хүчингүй болгочихлоо. Энийг бол бас тэгж болохгүй байх л даа. Яагаад гэвэл бид Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр санал хураагаад дийлэнх олонхийн 69 хувийн санал авсан. Гэтэл энийг зүгээр ердийн олонхийн саналаараа зарчмын асуудал л гэж үзэж бид нар энийг шийдсэн бол, дийлэнх олонхийн саналаар шийдсэн юм бол эргээд тэр байхгүй болохдоо мөн дийлэнх олонхийн саналаар байхгүй болох ёстой. Ийм учраас энд зарчмын бус юмруу орчихвуудаа гэж байгаа юм. Монгол улсын Үндсэн хууль гэдэг санал хураалт хүчинтэй байна гэж үзэж байна. Яагаад гэвэл дийлэнх олонхийн саналыг авсан, эргэж хураахад ердийн олонхийн санал авсан учраас энэ бол ийм байгаа байх. Тэгэхээр энэ асуудлыг нэг саналаа хураачихвал яасан юм бэ энэ дээр.

6-р тойргийн депутат Б.Нямбуу:

Монгол улсын нэрийг хэлэлцэхэд Монголын ард түмнээс нууж, нууцаар далд хэлэлцэхийг би зөвшөөрөхгүй. Энэ арга бол манай МАХН-ын хэзээнээсээ баримталж ирсэн ийм аргаа. Монголын ард түмнээс нууж өөрс дотроо элдэв янзын арга мэх хэрэглэж монголын ард түмнийг хуурч байсныг би мэднэ. Шинэчлэгдэж байгаа МАХН юм бол энэ хуучин элдэв залыт мэх аргаасаа салах хэрэгтэй. Ингэхгүйгээр МАХН нам байж чадахгүй. Нахдээрээ монгол улсын нэрийг хэлэлцэхэд монголын ард түмнээсээ нууж байгаа юм бэ. Ер нь ийм байдлаар намын гишүүд давамгайлж энэ чуулганы ажлыг чиглүүлэх гэж байгаа бол энэ чуулган хуралдаж чадахгүй. Энэ бол тэгж хуралдаач гэсэн ирээдүйдээ монголын ард түмний эрх ашигт тохирсон тийм хуулийг гаргаж чадахгүйээ. Би ийм л замаар явах юм бол нөхөр Балдоржийн гаргасан саналын ёсоор энэ чуулганыг ерөөсөө хойшлуулах хэрэгтэй. Ийм янзаар бид хэзээ ч үр дүнд хүрэхгүй.

Уртнасан: За бид цөөнхийн саналыг 5 депутатын санал сонсоё гэсэн 5 депутатын саналыг сонслоо. Эрхэм депутатуудыг суудалдаа сууж санал хураалтанд оролцохыг урьж байна.

Бид цөөнхийг хүндэтгэж саналыг сонслоо. Санал хураалт явуулах гэж байна. Томьёолол улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэе. Томьёоллыг бид нар өөрчлөхгүй. Саналыг цөөнхийн саналыг сонссон. Цөөнхийн саналаар дахин санал хураалт явуулах гэж байна. Бэлтгэнэ үү.

Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэе. Санал хураалт явуулж байна.

Уртнасан: За уучлаарай депутатуудаа. Ер нь манай бага хурлын хуралдаан дээр ч гэсэн санал солилцсон эцэст санал ийш тийшээ гүйдэг ийм явдал тохиолддог. Хурлыг хаалттай хуралдаанаар хийе гэж байсан хүмүүс одоо 42 хувь буюу 165, татгалзсан буюу нээлттэй хуралдаанаар хийе гэсэн хүмүүс 170 буюу 44 хувь нь байна, түдгэлзсэн 54 хүн 14 хувь байна, цөөнх саналаа хэлэхийг урьж байна.

Олонхи байсан хүмүүс цөөнх боллоо. 5 хүнийг бүртгэе. 5 хүнийг бүртгэлээ. За баярлалаа. Энэ 5 хүн.

5 хүнээр санал тасалж байна. цөөнх үгээ хэлнэ үү.

10-р тойргийн депутат О. Дашбалбар:

За эрхэм депутатууд уучлаарай. Би бол МАХН-ын бүлгийн хүн бишээ. Тэгэхдээ энд бол өнөө хардаж сөрдөхгүй гэдэг уур амьсгал бий болгоё гэж яриад байгаа боловч бид хардаад байна. Яагаад гэвэл МАХН-ын асуудлыг энд бид хэлэлцэхгээгүй, БНМАУ-ын Үндсэн хуулийг Их Хурал маань хэлэлцэж байгаа. Хоёрт гэвэл би хэллээ. Хаана ч нууц байхгүйгээ гэж хэлж байна. Бид өнөөдөр нууц байхгүй гэж хэлсээр байгаад бүх улсынхаа нууцыг задлаад өөр Хятадад ч нууц байхгүй гэж ингэж хэлээд байгаа юм. Тэгэхээр би энийг ганцхан юм л сануулах гэсэн юм. Яагаад би хаалттай хуралдаан хийх ёстой гэж байгаа юм бэ гэхээр хаалттай хуралдаан хийж болно гээд энэ дэгэн дээрээ заачихсан байгаа. Тэгэхээр манай нөхдүүд өөрсдөд нь хэрэгтэй юм гарвал хаалттай хуралдаан хийнэ гээд л

үзчихнэ. Өөрсдийнх нь санаанд тохирохгүй юм гарахаар хаалттай хуралдаан хийхгүй гээд л үзээд байдаг. Энэ юмаа нэгдүгээрт болимоор байна.

Хоёрт гэвэл би ганцхан юманд санаа зовж байна. Монгол улсад бол өөрийн нууц бий. Би яагаад энийг хаалттай хийе гэж байгаа юм бэ гэхээр улсын нэр хэлэлцэхэд БНМАУ-ын аюулгүй байдлын тухай, улсын тусгаар тогтнолын тухай онц ноцтой асуудлуудыг бид хөндөж тавьж өөрсдийнхөө үндэслэлийг хамгаалах учраас энд бол тэгсэн болов уу гэж бодож байна. Түүнээс биш хэн нэг хүний хэлж байгаа шиг МАХН тэр бузар булай аргаа хэрэглэх гэж ингэж олон түмнээс нугтаагүй байхаа. Үнэхээр аюулгүй байдал хэлэлцэхэд бол гадагшаа яригдахгүй, зөвхөн парламент дотроо яригдах ийм асуудлууд байдаг. Энэ нэрэн дээрээ биш байх гэж ингэж санагдаж байна. Хоёрт гэвэл би нэг юмыг ойлгохгүй байна. Түрүүчийн санал дээр 168 хүний санал авсан учраас Монгол улсын Үндсэн хууль гэдэг нэрийг хэвээр нь үлдээнэ анхны саналаар гээд байгаа. Тэгвэл Үндсэн хууль гэдэг нэрээр удаа дараа санал явуулаад 168 хүний санал авчихаад байхад энэ саналыг яахаараа харгалзахгүй байгаа юм бэ. Энэ бол шударга бус явдлаа гэж ингэж бодож байна. Хоёрт гэвэл яахав ер нь ингээд ажиглаад байхад манай Бага Хурлын нөхдүүд маань өөрсдөө анхаараасай. Бид аль аль талаасаа хичээе. Яагаад гэвэл энд ч Улаанхүү босож ирээд, тэнд ч Элбэгдорж босож ирээд, энд ч Чилхаасүрэн билүү хэн ч билээ босож ирээд, ингээд хараад л байхад дандаа л Бага Хурал маань босож ирээд байгаа шүү дээ. Ингэхээр энэ чинь эцсийн эцэст Бага Хурал нь Их хурал дотроо орчихоод хуралдаад Их Хурлаа зохион байгуулаад байж байгаа ийм сэтгэгдэл төрүүлээд байгаа юмаа. Тийм учраас энэ ардчилсан хүчин гэдэг чинь ганцхан Бага Хурал байв гэгч. Идэхдээ хааяа больж өөр хүмүүс ч гэсэн үг хэлмээр байна шүү дээ. Тэгэхгүй бол би бага хурлын, нэг хүн хичнээн удаа үг хэлэх эрхтэй байдгийг ч ингээд гайхаад олохгүй юм. Би нэг юмыг сануулчихъя гэж бодож байна. Бид бол микрофоноос хол, микрофоноор үг хэлбэ гэхэд заримдаа ийм боломжгүй, ард тийшээ ингэж гүйж байдаг, зарим хүний өмнө бол яг эрүүн дор нь микрофон аваачаад зориуд тавьчихсан. Мишээ нь Элбэгдорж бол хорин удаа ч үг хэлж байсан болж л байдаг. Тэгэхээр

байдал маш хэцүү болсон. Дээд түвшинд одоо өнөөдрийн бид нарын тэр барьж байгаа Их Хурал бол хуучнаараа явах арга бололцоогүй болчихоод ингээд тэмцэлдээд, зөрөлдөөд учраа олохгүй тарая гэдэг асуудлыг ярьж байна. Энүүний гадны нэг нөхцөл шалтгаан байх ёстой гэж байгаа. Тэр нөхцөл шалтгаан болбол өнөөдөр манай улсын хувьд бүрэн бий болчихоод байгаа юм. Бид нар бол бүх юмнаас тусгаарлагдсан, бүх юмаараа зогсож байгаа ийм нөхцөл байдалд бид нар ингэж хоорондоо муудалцаад тэр бүлэг, энэ нам, энэ эвсэл гээд ингээд байвал энэ чинь хэний эрх ашиганд нөлөөлөх юм бэ явж явж. Тийм учраас би энэ олон бүлэг төлөөлж байгаа хүмүүсийг жаахан ухаалаг, жаахан хоорондоо бас нэг учир зүйгээ олъё. Зөвхөн удирдагч нар нь биш, бас гишүүдий нь. Зүгээр монгол хүн зүгээр эх орноо гэсэн үндсэн дээр нэгдээд бие биеэн рүүгээ жаахан итгэлдээчээ. Тэгэхгүй чи ч ингэх гэж байна, би ч ингэх гэж байна, тэр ч бүлэг, энэ ч бүлэг гээд яваад байвал бид нарын энэ асуудал юунд хүргэх бол. Энэ асуудлыг ашиглах хүмүүс байгаа болов уу гэж би бодож байна. Ашиглах хүмүүс гарч ирдэг ч тийм туршлага бий. Тэгэхээр энэ асуудал дээр та нар нэг бодолцоочээ.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

*Мунла*

ЭНХТУЯА

В.ОЖУН

Г.Зүүнай /I43 дугаар тойргийн депутат/ -Би цөөнх болж уг хэлж байна, сая түдгэлзсэн.Тэгэхээр энэн дээр миний өмнө уг хэлсэн депутатуудтай би санал нэг байна.Бид нэг ийм нарийн нандин юм ярихдаа их эмзэглэмээргүй байна.Би МАХН-ын гишүүн.Энэ бүлэг дотор байсан.Түрүүн бол тийм муу муухай юм яриагүй.Улсын тусгаар тогтнолтой холбоотой нарийн ширийн юмаа хаалттай хуралдаанаар яривал яасан юм бэ гэж санал тавья гэж хоёр гурван хүн хэлэхээр Даш-Ёндон дарга босоод л санал хэлнэ билээ.Тэгэхээр энэнд бид ухаалаг хандах ёстой.

Ер нь зүгээр би бодож байна.Юмыг хаалттай хийхийн уршиг их бий.Мэдээлэл нууц болох тусмаа үнэд ордог.Уг дайвал нэмэгдэж хүрдэг, мөнгө дайвал хорогдож хүрдэг гэсэн монгол ардын зүйр уг бий.Тийм учраас их бодмоор байна.Дэлхийн шатрын аварга Гари Каспоров одоогоос хоёр жилийн өмнө ЗХУ гурван удаа мөнгөөр сэхэх нь ээ гэж Плебой гэдэг сэтгүүлийн ярилцлагад хэлсэн байсан.Бид тэрийг бас нэг санахад илүүдэхгүй гэж бодож байна.

Хоёр германыг нийлүүлээд зөвлөлт нэлээн мөнгө авна гэсэн.Зөвлөлт нэлээн мөнгө авсан. Курилийн аралыг японд өгөөд зөвлөлт нэг сэхэж магадгүй гэсэн, одоо өгөх янзтай байгаа.Гуравдугаар асуудал нь бол монголыг хятадад нийлүүлээд одоо бас нэг сэхэх байх гэсэн.Тэгэхээр энэ бол тохиолдлын яриа байгаагүй гэж би боддог.Каспаров их ухаантайдаа ч энийг бодож хэлээгүй гэж би боддог.Улс төрийн тийм далд хар хайриганд байдаг бодлогыг олж үзсэнийхээ буянд л тэр хүн өөрөө юмнаас хараат бус, дэлхийн аварга том бие даасан хүн энийг л дэлгэж тавьсан.Тийм учраас бид энэ асуудлыг яаж ярих вэ гэдгийг их бодож ухаан зармаар байна.Ийм учраас одоо энэн дээр нэлээн бодож байж тогтож шийдээсэй гэж миний нэгдүгээр санал.

Хоёрдугаар миний хэлэх гэж байгаа санал бол зарчмын санал юм.Яагаад гэвэл бид өнөөдөр улсын нэрийг тогтоод энэ хур-



үзчихнэ.Өөрсдийнх нь санаанд тохирохгүй юм гарахаар хаалттай хуралдаан хийхгүй гээд л үзээд байдаг.Энэ юмаа нэгдүгээрт боли-моор байна.

Хоёрт гэвэл би ганцхан юманд санаа зовж байна.Монгол улсад бол өөрийн нууц бий.Би яагаад энийг хаалттай хийе гэж байгаа юм бэ гэхээр улсын нэр хэлэлцэхэд БНМАУ-ын аюулгүй байдлын тухай, улсын тусгаар тогтнолын тухай онц ноцтой асуудлуудыг бид хөндөж тавьж өөрсдийнхөө үндэслэлийг хамгаалах учраас энд бол тэгсэн болов уу гэж бодож байна.Түүнээс биш хэн нэг хүний хэлж байгаа шиг МАХН тэр бузар булай аргаа хэрэглэх гэж ингэж олон түмнээс нуугаагүй байхаа.Үнэхээр аюулгүй байдал хэлэлцэхэд бол гадагшаа яригдахгүй, эвхэн парламент дотроо яригдах ийм асуудлууд байдаг. Энэ нэрэн дээрээ биш байх гэж ингэж санагдаж байна.Хоёрт гэвэл би нэг юмыг ойлгохгүй байна.Турүүчийн санал дээр 168 хүний санал авсан учраас Монгол улсын Үндсэн хууль гэдэг нэрийг хэвээр нь үлдээнэ анхны саналаар гээд байгаа.Тэгвэл Үндсэн хууль гэдэг нэрээр удаа дараа санал явуулаад 168 хүний санал авчихаад байхад энэ саналыг яахаараа харгалзахгүй байгаа юм бэ.Энэ бол шударга бус явдлаа гэж ингэж бодож байна.Хоёрт гэвэл яахав ер нь ингээд ажиглаад байхад манай Бага Хурлын нөхдүүд маань өөрсдөө анхаараасай.Бид аль аль талаасаа хичээе.Яагаад гэвэл энд ч Улаанхүү босож ирээд, тэнд ч Элбэгдорж босож ирээд, энд ч Чилхаасүрэн билүү хэн ч билээ босож ирээд, ингээд хараад л байхад дандаа л Бага Хурал маань босож ирээд байгаа шүү дээ.Ингэхээр энэ чинь эцсийн эцэст Бага Хурал нь Их хурал дотроо орчихоод хуралдаад Их Хурлаа зохион байгуулаад байж байгаа ийм сэтгэгдэл төрүүлээд байгаа юмаа.Тийм учраас энэ ардчилсан хүчин гэдэг чинь ганцхан Бага Хурал байв гэгч.Идахдаа хааяа болж өөр хүмүүс ч гэсэн үг хэлмээр байна шүү дээ.Тэгэхгүй бол би бага хурлын, нэг хүн хичнээн удаа үг хэлэх эрхтэй байдгийг ч ингээд гайхаад олохгүй юм.Би нэг юмыг сануулчихъя гэж бодож байна.Бид бол микрофоноос хол, микрофоноор үг хэлье гэхэд заримдаа ийм боломжгүй, ард тийшээ ингэж гүйж байдаг, зарим хүний өмнө бол яг эрүүн дор нь микрофон аваачаад зориуд тавьчихсан.Жишээ нь Элбэгдорж бол хорин удаа ч үг хэлж байсан болж л байдаг.Тэгэхээр

энийг зохион байгуулалттай ингэж байна гэж би муу санаж чадахгүй байна. Ер нь зүгээр анхаараасай гэж бодож байна.

23 дугаар тойргийн депутат Ш.Энхбат: Саяны энэ санал хураалтан дээр цөөнх боллоо. Тэгэхээр цөөнхийг төлөөлж үг хэлье гэж бодож байна.

Тэгэхээр энд болбол бид өнөөдөр хэсэг бүлгээрээ хуваагдачихаад ингээд хоорондоо үзээд байна гэж байгаа дүгнэлттэй би санал нэг байна. Ингээд одоо нэг бүлэг нь нөгөө дийлэх гээд байгаа юм шиг нэг ийм үзэгдэл харагдаад байна. Энэ асуудал дээр бол миний хувийн бодол бол энэ чинь нэг их тийм нэг бүлэг нь одоо нэрээ хамгаалахын тулд хаалттай хийж байгаа юм биш гэдэг талд нь би бас байна. Яагаад гэвэл ямар ч улсад өөрийн гэсэн нууц бий. Тэр тусмаа хоёр том хөрштэй ганцхан ийм жижигхэн буурай орон. Энэ хоёрынхоо эрх ашгийг ч юмуу, аливаа нэгэн асуудлаар хөндсөн ийм маргаантай асуудал дээр хэлэлцэх асуудлаа радиогоор, телевизээр, сонин хэвлэлээрээ зарлаад, дэлхий нийтэд сонсгоод, ингээд бид нар хүссэн ч, хүсээгүй ч энэ хоёр хөршийн тухай асуудал хөндөгдөж л таараа, орж л ирнэ. Гол асуудал энэн дээр л байгаа гэж бодож байна. Тийм учраас энэ хоёр хөршийнхөө хамар руу өвс хийчихээд ингээд эргүүлээд байх уу, зүгээр энэ асуудлаа дотроо хэдүүлээ яриад тохирох уу гэдэг энэ асуудал бол ард түмнээсээ нууж байгаа асуудал бишээ. Энэ бол явж явж ард түмнийхээ эрх ашгийг хамгаалахын тулд, улсынхаа эрх ашгийг хамгаалахын тулд бид нар нэг ийм жижигхэн асуудал дээр түр хаалттай хуралдаан хийе гэсэн санаа байгаа юмуу гэж би ингэж бодож байна.

Хоёрдугаарт энэ явцаас харагдаж байна л даа. Ер нь одоо хэлье гэж бодож байсан юмаа ч хэлчихье гэж бодож байна. Яагаад гэвэл өнөөдрийн улс орны нөхцөл байдлыг ингээд ажихад та биднарын муу талаас нь ч ингээд ярьж байгаа нэг хүний сургааль болбол хэрэгжихэд маш бэлхэн болчихож. Энэ юу вэ гэвэл Лениний хувьсгалын тохироо бол Монголд үндсэндээ бүрджээ. Энэ бол миний хувийн дүгнэлт. Доод хүмүүс бол дээд зэргээр доошоо амьдралын түвшин буурсан. Тэд нар бол дургүйцэл нь ихсээд одоо амьдрах

лаар шийдэж чадахгүй нь ээ. Бид ардчиллаа их зөрчиж байна. Би шүүмжлэлтэй нэг юм хэлмээр байна. Үдээс өмнийн хурал дээр бүлгүүдийн ахлагч ардчилсан намынхаас бусад нь бүлэгтэйгээ уулзалгүй гүйж очиж бие даасан, их эрх эдэлсэн ингэж зөвлөж, тэгээд эргэж ярихаар зэрэг энэ чинь бүтэхгүй байна шүү дээ. Тийм учраас бид яасан бэ гэхээр хуулийн нэрийг тогтох гээд тогтодогийн толгой дээр улсын нэртэй аваачиж хольж наймаа хийж гурилдаад, ингээд өнөө орой едийд тулж ирлээ. Тийм учраас одоо миний зарчмын санал бол өнөөдөр хуулийнхаа нэрийг тогтчихоод амаръя гэсэн ийм санал дэвшүүлж байна. Амрах юм уу, шөнөжин хуралдах юм уу? Ямар ч байсан энийгээ эхэлж шийдье. Тэгэхээр манай энэ Үндсэн хууль гэдэг санал дээр санал өгч байсан голдуу МАХН-ын гишүүн депутатууд Их засаг гэдэг нэр рүү эргэж нэгдээч гэж би уриалмаар байна.

Монголын ард түмэн Их цааз гэдэг нэрэнд дургүйлэхээд байсан болохоос Үндсэн хууль Их засаг хоёрыг чинь адилхан хүлээж авна. Тэгэхээр бид нар ухаалаг дундын хувилбарыг олж харъя л даа. Тийм учраас би хурлын даргад ямар санал тавих гэж байна вэ гэхээр улсынхаа нэрийг түр, нэг юм ядаж шийдье. Улсынхаа нэрийг түр зогсоод Их засаг хууль гэдэг дээр санал хураалгаж өгнө үү гэсэн горимын санал дэвшүүлж байна. Миний энэ саналыг дэмжиж өгөөчээ гэж та бүхэнд бөхийн гуйх байна.

Ц. Жумдаанбаатар /180 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр одоо хүүхэд өлсөж байна. Баруун аймгуудад зуд болж малчид сандарч тэвдэж байна. Гадаа гудамжинд бидний ямар янзтай хуралдаж байгааг хөдөлмөрчид даарч хөрөн автобусны буудал дээр зогсоогоод ажиглаж байна. Гэтэл одоо бидний энэ байж байгаа байдал үнэхээр хэмжээнээсээ хэтэрч байх шиг санагдах юм. Тэгэхээр сая МАХН-ын бүлгийн хурал дээр бид суусан. Би өөрөө намдаа биширч, шүтэж ингэж явдаг хүн. Гэтэл энэн дээр үнэхээр туйлшрах хандлага гарч байгаад би маш их харамсаж байна.

Ерөөсөө хэрэв энэ хурлын хувь заяа өөрчлөгдөх юм бол арыг МАХН үүрнэ. Яагаад вэ? Бүх депутатуудын ихэнх нь манай нам. Хурал

удирдаж байгаа хүмүүст ч гэсэн манай хоёр гишүүн сууж байна. Энийгээ сайн бодоочээ. Ийм учраас МАХН-ын гишүүд их хүлээцтэй их ухаалаг, уян хатан хандаасай билээ гэж би хүсч байна. Ингэж л энэ хурлын хувь эаяаг шийдэхгүй бол өөр аргагүй боллоо шүү.

Б.Сумъяа /340 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр миний түрүүн уг хэлсэн улсууд хангалттай ярьчихлаа. Ер нь хувь хүнд ч гэсэн, гэр бүлд ч гэсэн, улсад ч гэсэн нууц байдаг, ер нь нууцалдаг зүйл байдаг. Тэр бол нийтэд тодорхой юм. Бидний ярьж байгаа зүйлд ч гэсэн нууцлах зүйл бий. Тэгэхдээ энэн дээр юу хэлэх гэж байна вэ гэхээр ер нь та бүхэн ажиглаж байгаа байх. Би бол аль болохоор харилцан буулт хийж, аль болохоор оновчтой, нааштай шийдэх юмсан энэ асуудлыг, тэгж цагаа оновчтой ашиглах юмсан гэж бодож байна. Тийм учраас би зүгээр ийм хувилбар байж болохгүй юу гэж. Ер нь бид хуулийнхаа нэрийг хоёр хоног ярьчихаад шийдээгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бас улсын нэрийг өшөө хоёр хоног ярихгүй гэсэн баталгаа алга. Хоёр хоног бид хаалттай хуралдана гэдэг маань үнэндээ ард түмний дунд, телевиз үзэгчдийн дунд, сонсогчдын дунд нэлээн бухимдал төрүүлнэ.

Тийм учраас харилцан буулт хийгээд хуралдаанаа нээлттэй явуулъя. Хүн, тухайн хүн хэрэв миний ярих зүйл одоо нийтэд гадагшаа, дэлхий дахинд ч юм уу цацаж болохгүй гэж үзвэл тэр хүн миний хэлж байгаа үгийг радио, телевизээр нэвтрүүлэхгүй, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулахгүй байхыг хүсч байна гэж хэлбэл, тэрийг би хурлынхан ч хүлээж авч болно байх гэж бодож байна, тэр бол бүрэн хэм хэмжээний тодрох зүйл байх гэж бодож байна.

Зүгээр бид гуч юм уу дөчин минут яриад өнгөрөх юмыг хаалттай хийж болно. Гэтэл энэ улсын нэр гэдэг маань аягүй л бол хоёр өдөр явчихаж мэдэх юм. Тийм учраас ийм вариант, хувилбар байж болох уу үгүй юу. Хэрэв энэн дээр байж болно гэж үзвэл санал хурааж болох юм гэж бодож байна. Баярлалаа.

Ж. Уртнасан — За баярлалаа. Таван хүн цөөнхийг төлөөлж үг хэлбэ гэсэн үг хэллээ. Тэгэхээр дахин цөөнхийг хүндэтгэж байна. Та бидний хувьд дөрөв дэх санал хураалт явах гэж байна. Тэгэхээр энэнд их ухаалаг шийдвэр гарах болов уу гэж бодож байна. Хүмүүсийн үзэл бодол ийн тийшээ их туйлширч их савж байгааг анхааруулж байна. Томъёоллоо хэлбэ. Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцье гэдэг томъёолол дээр санал хураалт явуулж байна. Цөөнхийн саналыг үндэслэе. Дахиад хэлэх үү? Улсын нэрийг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Сүүлчийн санал хураалт шүү.

Аль нь ч олонхи болж чадахгүй байна. Уучлаарай тэгэхээр нэг ийм тохиролцоонд хүрч болох болов уу гэж бодож байна. Бид хаалттай нээлттэй гээд хоёр тийшээ дөрвөн удаа санал хураалаа. Тэгэхээр бид хурлаа ердийн байдлаар үргэлжлүүлье. Харин зарим депутатуудын санал, зарим үг нь зайлшгүй тийм эмзэглэх, манай зарим депутат хэллээ, хойт урд хөршийн хамрыг сөргөөсөн юм болох вий гэж. Хэрэв депутат үгээ миний энэ үгийг хэвлэл мэдээлэлээр битгий дамжуулаач гэвэл бид ёсоор болгож энэн дотроо шингээе. Зарим депутатын хэлэх үгийг. Ер нь хурлыг ердийн байдлаар үргэлжлүүлье гэдэг ийм тохиролцоонд хүрвэл ямар вэ гэсэн ийм санал байна. Бид дөрвөн удаа санал хураалаа шүү дээ эрхэм депутатуудаа. Цөөнх олонхи, цөөнх олонхи гээд бид дөрвөн удаа санал хураалт явууллаа. Бид аль нь ч олонхи болж чадахгүй байна. Тийм учраас саяын хувилбарыг бид санал оруулж байна. Хурлыг ердийн байдлаар үргэлжлүүлье. Харин үг хэлж байгаа депутат миний энэ хэлж байгаа үгийг радио, телевиз, хэвлэлээр битгий гаргаач гэвэл түүнийг ёсоор болгох ийм арга хэмжээ авъя.

Энэ саналыг оруулж байна. Хуралдааныг ердийн байдлаар явуулъя. Харин үг хэлэгч өөрийн үгийг хэвлэн нийтлэхийг хаалттай байлгая гэвэл бид зөвшөөрч байна. Ийм томъёоллоор. Хурлыг хэвийн үргэлжлүүлье. За санал хураалт явуулъя, анхаараарай. Санал хураалтад бэлтгэнэ үү эрхэм депутатуудаа. За санал хураалт явуулж байна. Хурлыг ердийн байдлаар үргэлжлүүлнэ. Хэрэв үг хэлэгч өөрөө хэвлэн нийтлэхийг хоригловол зөвшөөрнө.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 82 хувь нь буюу 260 депутат хурлыг ердийн дэгээр үргэлжлүүлье гэсэн ийм санал ирүүлж байна. Татгалзсан хүн 9 хувь буюу 30, түдгэлзсэн хүн 9 хувь буюу 29 хүн байна. Бид хуралдааныг хэвийн нээлттэй үргэлжлүүлье. Харин үг хэлэх, зарим үгээ хэвлэн нийтлэхийг хоригловол бид зөвшөөрнө.

За одоо Зориг депутатын санал байгаа. Бид хэрэв одоо ингэж хурлаа үргэлжлүүлэхээр болбол хуулийн нэрнээсээ эхлэх ёстой. Хавтсан дээр тавих хуулийн нэр. Хуулийн нэрийг Дожоодорж депутат бас бидэнд сануулсан. Үндсэн төслөөс гадна бидэнд үлдэж байгаа хоёр төсөл л байдаг. Энэ хоёр дээрээ л бид санал хураалт явуулах ёстой болов уу гэж бодож байна. Их засаг, Үндсэн хууль гэсэн хоёр хувилбар л та бидэнд бий. Их засаг хууль.

Нэг дэх хувилбар бид хуулийнхаа төслийг Их засаг хууль гэж нэрлэе гэж санал хураалт явуулна. Хоёр дахь нь Үндсэн хууль гэж санал хураалт явуулна. Депутатууд битгий будлиарай. Нэг л санал өгнө гэдгийг дахин хатуу анхаарахыг хүсч байна. Санал хураалтад бэлтгэнэ үү. Их засаг хууль. Хуулийн нэрээ юу ч гэсэн тогтож авбал цаашаа үргэлжилнэ. Их засаг хууль гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Их засаг хууль.

За баярлалаа. Нийт санал өгсөн депутатуудын 68 хувь нь буюу дийлэнх олонхи нь 273 хүн хуулийг Их засаг хууль гэж нэрлэе гэж байна. 99 хувь буюу 25 хүн татгалзлаа. 28 депутат буюу 7 хувь нь түдгэлзэж байна. Одоо санал хураалтын хоёр дахь хувилбарыг томъёолъё.

Хуулийг ... за баярлалаа. Дийлэнх олонхи болсон учраас хоёр дахь хувилбарыг хэлэлцүүлэхээ больё. Одоо хоёр дахь санал байна. Улсынхаа нэрийг хэлэлцэж эхлэхэд бэлэн болох шиг боллоо. Улсынхаа нэрийг хэлэлцье.

Уучлаарай депутатуудаа одоо горимын саналаа хэлэлцье. Бид хуулийнхаа нэрийг тогтчихлоо. Баярлалаа. Одоо тэгэхээр

та бидний түрүүн тохиролцсон ёсоор улсынхаа нэрийг хэлэлцье. Энэн дээр санал хураалт явуулах гэж байна. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Улсын нэрийг хэлэлцье гэсэн санал хураалт явуулах гэж байна. Депутатуудаа санал хураалтад бэлтгэнэ үү. За баярлалаа улсынхаа нэрийг хуулийн нэрээ тогтлоо. Одоо та бид улсынхаа нэрийг хэлэлцэх ажилд орох нь. Нийт санал өгсөн депутатуудын 94 хувь нь буюу 346 депутат улсынхаа нэрийг хэлэлцье гэж санал ирүүлж байна. 6 хувь нь буюу 21 хүн татгалзаж, 3 хүн түдгэлзлээ. Улсынхаа нэрийг бид хэлэлцэж эхлэх боллоо.

Тэгэхээр дэгийнхээ дагуу микрофон дээр дарааллаар үг хэлнэ.

Шууд бид нарт томъёологдож байгаа гурван нэрэн дээр санал хураалт явуулах уу? За баярлалаа.

Депутатуудаа, уучлаарай депутатуудаа. Та бид нар ингэж тогтсон шүү дээ. Энэ манай субъект буюу Улсын Бага Хурлаас оруулж ирсэн нэр Монгол улс гэдэг нэр байгаа. Тэр бол төслийн жинхэнэ бидэнд оруулж ирсэн нэр. Хажуугийн санал Бүгд Найрамдах Улс гэсэн нэг томъёолол, Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн хоёр дахь томъёолол бий. Энэ хоёр дээр бид санал хураалт явуулъя. Хэрэв тэгээд цөөнх болбол горимын дагуу саналаа хэлэхийг хүсч байна.

Үндсэн санал монгол улс. Энэ бол бид санал хураалт явуулахгүй. Хоёр томъёолол дээр бид санал хураалт явуулъя. Нэгдүгээрт нь Бүгд Найрамдах Монгол улс, хоёрдугаар томъёолол нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс, за санал хураалтад бэлтгэнэ үү.

Бүгд Найрамдах Монгол улс гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Бүгд Найрамдах Монгол Улс. Бүгд Найрамдах Монгол Улс гэсэн томъёоллоор санал хураалт явууллаа. Санал өгсөн де-

7.

путатуудын 40 хувь нь буюу 156 нь зөвшөөрч, 204 хүн буюу 52 хувь нь татгалзаж, 32 хүн түдгэлзлээ.

Хоёр дахь томъёолол, санал хураах хоёр дахь томъёоллыг оруулж байна. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн томъёоллоор санал хурааж байна. За хажуугийн хоёр санал аль аль нь дийлэнх олонхийн санал авч чадсангүй. Тийм учраас одоогийн хэлэлцүүлэгт Монгол улс гэсэн нэрээр эх төслөөр бид цаашаа хэлэлцэж эхлэх нь ээ.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН

*Д. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг



1991.11.19

Кассет № III-73

№18.20-18.35

Ж.Уртнасан: Хуралдааныг цааш нь үргэлжлүүлбэ.Цөөнхийн саналыг сонсбё.

156 дугаар тойргийн депутат Гантөмөр:

Ж.Уртнасан: Уучлаарай, Гантөмөр депутатаа, микрофон дээр гарсан, 5 хүний саналыг сонооод бид хуралдаанаа цаашаа үргэлжлүүлж болох байх гэж найдаж байна.

156 дугаар тойргийн депутат Гантөмөр: Монгол улсыг...

Ж.Уртнасан:Уучлаарай, Гантөмөрөө, хүн бүртгээд авья. 3,4,5,6,8 дугаар микрофон дээр нэг, нэг хүн үг хэлэхээр байна.

Гантөмөр:Бид еерийнхөө улсын нэрийг юу гэж нэрлэхээс манай эх орны тусгаар тогт нол, их хамаарна.Тийм учраас энэ дээр маш их нухацтай хэлэлцэх ёстой.Энд ТУРҮҮН бол манай намынх депутатуудын ихэнх нь Монгол улсын нэрийг хэлэлцэх асуудал дээр хаалттай хуралдаан хийе гэсэн.Олонхийн дэмжлэг авсангүй. Уг нь бол ард түмнээсээ нуух гэсэн асуудал бишээ.Эх орныхоо тусгаар тогтнолыг баталгаатай байхын тулд одоо ийм санал гаргасан.

Манай намын онолын баримтлал бол марксизм-ленинизм, Маркс, Энгельс нарт хэдийгээр зарим нэгэн харж үзүүштэй юм байдаг боловч хүн төрөлхтөний том генүүдийн нэг гэж үздэг.Энгельсийн гэр бүл, хувийн өмч, төрийн үүсэл гэдэг зохиол дотор улс төрийн оршин тогтнох эх үүсвэрийн нэг нь гэр бүл гэж үзсэн.Тэгвэл гэр бүлийнх дотор нууц бий.Өнөөдөр хичнээн ардчилал хөгжлөө ч гэсэн еерийнхөө гэр бүлийн нууцыг түмэнд дэлгээд явдаг эр ч байхгүй, эм ч байхгүй ээ.Үүнийг хүн болгон мэдэх ёстой.

Энэ онолын үүднээс л бид монгол улсынхаа нэрийг хэлэлцэхэд хаалттай хэлэлцье гэж бодсон юм.Тэгээд одоо би энд сууж байгаа улсууд, миний хэлж байгаа, ярьж байгаа үгийг радио,

телевизээр нэвтрүүлэхгүй, монгол улсын маань нууцыг маань задлахгүй гэсэн баталгаа байхгүй, бүрэлдээгүй байгаа учраас яагаад одоо бүгд найрамдах Монгол улс гэж хураалгая гэдгээ би тайлбарлахгүй. Зөвхөн депутатуудаас, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө, аюулгүй байдлын төлөө, амар жимэр амьдрахын төлөө энэ монгол улс гэдэг нэрээс жаахан *сөвотказалж*. Бүгд Найрамдах Монгол улс гэдэг нэрээр санал хураалгаж өгнө үү гэсэн санал байна.

Хэрвээ хаалттай хуралдаан хийвэл бид үндэслэлээ тодорхой хэлнэ.

15 дугаар тойргийн депутат Д. Лундээжанцан:

Тэгэхээр бид энэ завсрын юмнууд дээрээ, завсрынхаа асуудлууд дээр нэгдүгээр хэлэлцүүлгийн явцад аливаа асуудлыг ердийн олонхийн саналаар шийдэж явж байгаад, нэгдүгээр хэлэлцүүлэг дуусаад, хоёрдугаар хэлэлцүүлэгт асуудлыг оруулахдаа, дийлэнх олонхийн саналаар оруулбал уг нь зүйтэй юм болов уу гэж бодож байна.

Эхлээд заавал бүгдийг дийлэнх олонхи гээд ингээд авч чадахгүй үлдэхэд төсөл дээр байгаа Бага Хурлаас өргөн барьсан төсөл дээр байгаа тэр чигээрээ үлдээд байна гэвэл бас одоо тэр яг түүнийг баталгаж байх асуудал дээр бас бодвол яасан юм бэ? Гэхдээ үүнийгээ ердийн олонхиор л бодвол яасан юм бэ? Энэ бол ардчилалдаа нийцэх зүйл болох болов уу гэж бодож байна, нэгдүгээрт,

Хоёрдугаарт, манай саяны бүх депутатууд, түрүүн зарим гишүүд хэллээ. Хаалттай хуралдаан хийнэ гэж. Миний хувьд бол үүнийг заавал хаалттай хуралдаан хийх шаардлагагүй гэж үзэж байна. Гэлээ гэхдээ улс орны тусгаар тогтнолтой холбоотой энэ эмзэг асуудал дээр зарим зүйлүүдийг одоо бас л хаалттай байдлаар авч үзэх нь зүйтэй болов уу? Нэг тийш нь туйлшруулж аль нэг нам руу дайран довтлох явдал байж болохгүй гэж үзэж байна. 380 хүнийг зөвхөн 380 гаруй депутатыг зөвхөн нэг л үзэл бодлоор хатуу байр суурьтай бай гэж албадах арга байхгүй.

3.

Эрхэм депутат С.Баярцогт хүнийг одоо ийм нам байдаггүй юмаа гэж. Харин манай нам олон ургальч үзэл санааны нам байх ёстой. Бид олон ургальч үзэл санааны төлөө л тэмцэж ирсэн. Ийм учраас зөвхөн нэг санаа бодлыг уралдуулж болохгүй. Сая Гантөмөр депутат марксизм-ленинизмыг үйл ажиллагаандаа баримтална гэж байна. Би бол миний хувьд баримталдаггүй. Ийм ч учраас янз бүрийн үзэл бодол энэ дотор байгаа юм. Үүнийг ч манай мөрийн хөтөлбөрт зааж, тодорхой заасан.

Өөрчлөн байгуулалт, улсын нэрийн хувьд бол бид асуудлыг авч үзэхдээ би бол Бүгд Найрамдах Монгол улс гэдэг нэрийг дэмжиж байгаа. Би Монгол улсын тулгар цааз гэдэг баримт бичгийг боловсруулаад, монгол улс гэдгийг хэн ч гэсэн монголд хайртай, монгол хүн, үүнийг дэмжилгүй яах вэ? Гэлээ гэхдээ бусад улсуудад байгаа Монгол туургатнаасаа ялгагдаж байх, өөрийн нэг онцлогтой нэр хэрэгтэй байна.

Ийм учраас БН Монгол улс гэсэн ийм хувилбарын төлөө байгаа юм. Энэ дээр яривал их юм бий. Бид нэрийг сольсноор бидний тусгаар тогтнолд аюул занал учруулах, хууль зүйн үндэс байхгүй.

НҮБ ч тэр, дипломат харилцаатай 100 гаруй оронд ч тэр, ямар нэгэн тийм харшлах зүйл үнэндээ алга. Харин гэтэл энэ хууль зүйн үүднээс ийм юм байхгүй байлаа ч гэсэн, хэдэн жилийн дараа байдал янз бүрээр эргэсэн нөхцөлд Монгол улс гэдэг нэрийг энэ аваад үзсэн тохиолдолд зарим нэг улсын хувьд бол яаж үзэх бол гэдгийг бас янз бүрийн болгоомжлол бас байж болох юм гэж санаж байна.

Миний энэ ярьж байгааг заавал хэвлэл мэдээлэл дамжуулах хэрэггүй юм гэж бодож байна.

Гэхдээ тэндээс тэгнэ шүү гэсэн бидэнд баримт нотолгоо бас байхгүй. Ийм учраас энэ эмзэг асуудалд олон талаас нь хандаж, манай БН төрийнхөө уламжлалыг түүнчлэн тусгаар тогтносон бүрэн эрхт улсынхаа агуулгыг, мөн түүнчлэн үүгээрээ бусад монгол туургатан улсуудаас ялгагдах онцлогоо харуулж Бүгд найрамдах Монгол улс гэсэн нэр хувилбар дээр санал цахин хураалгахыг хүсч байна.

135 дугаар тойргийн депутат Мөнхбат:

Би энэ Бүгд найрамдах Монгол улс гэдэг дээр санал хураалгах зорилготой юм. Учир дундаа гэвэл, би бол 3 хувилбарыг гурвууланг нь сайн мэднэ. Би гурвууланг нь сайн ойлгож бодсон. Манай орны бүх үндэстэн ястнууд бол бүгд Монгол. Тэгэхдээ энэ дээр Монгол оронд бол хоёр үндэстэн байгаа. Өөрөөр хэлбэл казак гэдэг чинь нэг үндэстэн, ингэхээр бүгд найрамдах улс гэж, монгол улс гэж нэрлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Нөгөө талаар аваад үзэхэд Монгол улс гээд ингээд аваад үзэхэд хойд тал ч гэсэн, хилийн хувьд ч нэг хэсэгтээ эвгүй. Урд тал ч мөн ялгаагүй. Тэгтэл бид нар ганцхан том Монгол руугаа явлаа гээд, бүгдээрээ зугатаагаад дүрвээд орооц ирэхийг ч байг гэхгүй юм шүү. Тийм учраас хоёр үндэстэн байгаа учраас манайх Бүгд найрамдах гэж оруулах нь зүйтэй байхаа. Монгол улс гэж хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна, хоёр үндэстнийхээ хувьд хэлсэн юм шүү. Ястан, үндэстний хувьд бол монгол овогтнууд бүгдээрээ л дээ. Тэгэхдээ би казахын ард түмэн бол үндэстний соёлтой, үндэстний хэл бичигтэй нэгэн үндэстэн мөн юм шүү. Манай хэдий цөөн хэсэг ч гэлээ гэсэн. Би ийм саналыг хэлж байгаа юм.

10 дугаар тойргийн депутат О. Дашбалбар: Миний хэлж байгаа үгийг хэвлэл, мэдээллийн нөхдүүд дамжуулахгүй байхыг хүсье.

Телевизээ хаавал сайн байна. Тэгэхээр энд би өдөр ер нь жаахан уур хүрээц, тэгээд хашгирсан, одоо бол аль болохоор тайван, хүмүүсийг ойлголцуулахын үүднээс өөрийнхөө санаа бодлыг чөлөөтэй хэлье гэж санаж байна.

Гэхдээ яг энэ саналаа хэлэхийн өмнө би Уртнасан даргад нэг юм анхааруулья гэж бодож байна. Энэ бол едрийн группүүдийн ахлагч нар, намуудын дарга нар цуглаад ийм юм тохирсон. Депутатуудын бүлэг бол 2-3 хүнээр саналаа илэрхийлүүлнэ гэж.

Хоёрт гэвэл, цөөнхүүд ерөөсөө 8 хүн босоод л уг хэлнэ. Цаашаа нь 100 хүн ч байсан хамаагүй гэдэг ийм юм хэлж байсан,

үүнийг анхаарна биз дээ, арай цөөдөж байна, яагаад гэвэл тэр депутат чинь бүрэн эрх нь зөрчигдөхөөс гадна, ерөөсөө уг хэлэх эрх нь хурал дээрээ хаагдаж байгаа, ийм сөрөг юм байгаа гэдгийг анхаарна биз дээ гэж бодож байна.

Ж.Уртнасан: Анхааралдаа авъя.

О.Дашбалбар: Ингээд би еерийнхөө саналуудыг хэлье.

Яагаад монгол улс гэдэг нэрээс айгаад байгаа юм бэ гэж кмаа хэлье. Монгол улс гэдэг нэр бол миний хамгийн хайртай, хамгийн дотно нэр. Үүнийг би хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ өнөөдөр миний бодлоор бол энэ нэрийг улс орондоо бидэнд өгөх нь арай эрт бөгөөд, урьд маань айхтар том луу унтаж байгаа, ард маань нэг арслан нойршосоо сэрчихээд байгаа гэдгээ бид мартаж болохгүй ээ.

Монгол улс гэдэг нэрийг бид өгөхдөө бол дараагийн үндсэн хуулийн дараагийн үндсэн хуулийн хавьцаа юм уу? өөрөөр хэлбэл Монгол улс бар болчихсон хойноо Монгол улс гэсэн нэр өгсөн бол илүү их зохимжтой байсан байхаа гэж надад ингэж санагдаж байна.

Хоёрт гэвэл, би энд аюултай жишээ хэлье гэж бодож байна. 1950-иад оны сүүлчээр, төвдийг хятадууд гэв гэнэтхэн дайрч эзлээд, сая гаруй хүнийг устгаад, 6000 гаруй сум хийдийг хөнөөгөөд орхисон, ийм аймшигтай юм байгаа шүү. Олон улсын шүүх хуралдаад өнөөдөр олон улсын фактор бол дийлэгдэнгүй гэж ярьж байна. Гэтэл олон улсын шүүх хуралдаад энэ бол бузар ялт хэрэг гэж ийм дүгнэлт гаргаад л өнгөрсөн. Төнд орон өнөөдөр тусгаар тогтнолоо олж авч чадаагүй л байгаа. Энэ бол нэг том факт. Олон улс гэдэг бол хүч нь хүрэх юман дээрээ хүрдэг, хүрэхгүй гэсэн юман дээрээ хүрдэггүй гэдгийн жишээ бол энэ гэж бодож байна.

Хоёрдугаарт, энэтхэг рүү ч манай өмнөд хөрш маань дайрч байсан, ЗХУ руу 68 онд Дамаск Уссур мөрнөөр дайрч байсныг бид мартаагүй байх гэж бодож байна.

Нэлээн хэдэн арван мянган цэргээр дайрч байсан.  
 Вьетнам руу энх тайван найрамдал, нөхөрлөл бие биедээ тусалж байна гэснээ 1979 оны хаврын нэгэн сайхан өглөө 100 гаруй мянган цэргээр дайраад орчихсон. Ингээд хэдэн арванхмянган хүний цус астарч бөөн юм болж байж, хэрвээ тэр үед Зөвлөлт орно гэж хажуунаас нь цэргийн сургууль хийж ийм юм болоогүй байвал яах байсныг би мэдэхгүй байна.

Ийм болохоор тусгаар тогтнол гэдэг бол ямар нэгэн хэмжээнд би Монгол улс гэдэг нэрэнд дургүйдээ биш, ер нь энэ олон нэрүүдийг, олон талаас нь сайтар ярилцаж, маш олон хувилбар гаргаж байж, ингэж эцсийн зөв юмыг гаргаж аваасай гэсэндээ ингэсэн юм.

Яагаад гэхээр едөр бол шууд үндсэн хуулийн нэрээ хоёр хоног хэлэлцүүлсэн хэрнээ, Улсынхаа нэрийг ерөөсөө хэлэлцүүлэлгүй шууд явуулчихсанд л бидний гол уур бухимдал хүрсэн шүү дээ. Тийм учраас үүнийг хэлж байна.

Хоёрт гэвэл бид том улсуудад их найдаад байна.  
 Жишээ Америк биднийг аварна гэдэг юм уу? аль эсвэл НҮБ аварна ч гэж ингэж яриад байна. Том улс гэдэг чинь бол өөрийнхөө ашигтай юман дээрээ томоо гаргадаг болохоос биш, ашиггүй юман дээрээ томоо гаргадаггүй юм билээ. Жишээ нь, гранадаа гэдэг жижигхэн улсыг дайраад эзлээд авахад, тийм их ардчилалтай, тийм их шударга хүн хүн төрөлхтөн байдаг юм бол түүнийг яагаад хамгаалаагүй, дув дуугүй, амаа хамхиад сууж байдаг юм бэ? Яагаад Панамын ерөнхийлөгчийг улс оронд нь дайраад, аваад явж байхад тэр хүн төрөлхтөн, улс орон чинь дуугүй байсан юм бэ? Ингээд бодохоор энд нэг ноотой юм бий шүү. Үүнийг Их Хурал аль аль талаас нь авч үзээсэй гэж бодож байна.

Бид яах вэ? аль ч том үндэстэн, аль ч жижиг үндэстэнтэй тэр найрамдал нөхөрлөлийнхөө харьцааг барих нь барих л байх. Гэхдээ үндэсний дотоод эрх ашиг гэдэг ийм ийм юм зайлшгүй байх ёстой гэж ингэж санагдаж байна.

Үүнээс гадна миний хамгийн чухал хэлэх гээд байгаа юм бол 1915 оны хэлэлцээр хүчингүй болсон гэж зарим хүн хэлээд байх шиг байна. Түүнээс гадна Налтны хэлэлцээр гэж нэг юм байгаа. Ямар ч хэлэлцээр байлаа гэсэн, энэ бол хүчингүй болоогүй гэдгийг би хэлэх гэсэн юм. Яагаад, хууль эүйн хувьд хүчингүй болсон гэдэг юм уу, манай нөхдүүд баталгаа гаргаж чадна гэдгийг би ойлгож байна. Гэвчдээ Их гүрэн гэдэг бол Их гүрэн хэвээрээ үлддэг. ЗХУ, Хятад хоёрт нийгмийн ямар ч байгуулал бий боллоо гэсэн ямар ч төр, засаг хэн ч гарч ирлээ гэсэн. Их гүрний төрийн бодлого хэвээрээ үргэлжилдэг шүү. Үүнийг бид зайлшгүй бодох ёстой.

Олон зуун, мянган жилийн туршид манай өмнөд, хойд хоёр хөршийн маань барьж ирсэн, тэр бодлого мөнхөд хэвээрээ үргэлжилнэ гэдгийг бид санах ёстой. Ингээд бодохоор Монгол улс гэдэг нэрээ бид хойт, урд хоёр маань өөрсдийнх нь юм руу ямар нэгэн хэмжээнд, эд нар чинь юу болоод шал шал гээд байгаа юм бэ гээд, ингээд бас нэг, ... бид бол энэ хоёроос илүү их шалтгаалж байгаа шүү, дэлхийн олон нийтээс илүү их шалтгаалахаасаа. Ийм юм байн а.

Ингээд минут бага үлдсэн учраас би товчхон саналаа хэлбэ гэж бодож байна. БНМАУ гэсэн үгийг би өөр утгаар ойлгодог. Ард түмэн гэсэн утгаар нь ард гэсэн үг орсон байхаа гэж боддог. Тэгэхээр Бүгд найрамдах гэдэг үгнээс зарим улс сэжиглээд байх шиг байна. Сэжиглээд байгаа юм бол ардчилсан хүчний зарим нөхөд маань яагаад бүгд найрамдах нам байгуулчихаад түүнийгээ зөв гэж үзээд байгаа юм бэ? Ингэхээр бүгд найрамдах <sup>гэдэг</sup> байж болох нь ээ гэж бодогдож байна.

Хоёрт гэвэл ард гэдэг үгийг үнэхээр зөвүүцээд байгаа юм бол ардчилал гэдэг үгнээсээ ардыгаа хасч хаячихаад, "чилал" болгочих юм бол энэ зөвшөөрч болж байна. Иймэрхүү маягаар бид, ер нь тэгээд би энд нэг үг, за яах вэ дундын хувилбар гаргаад буулт хийж бодно. Буулт хийе, аль алиндаа буулт хийе. Тэгвэл яах вэ? ард <sup>гэдэг</sup> үнэхээр болохгүй, ард гэдэг үг

сонсогдохоор л алчих гээд байгаа юм шиг байгаа бол Бүгд найрам-  
дах Монгол улс гэдэг дээр эцсийн тохиолдолд, бүгд найрамдах  
монгол ард улс нь болдоггүй юм бол Бүгд найрамдах Монгол  
ард улс дээр үлдэж болох нэг зам байгаа шүү гэдгийг энд хэлэх  
гэсэн юм. Эд баярлалаа.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Д. ЧУЛУУНШЭЦЭГ



1991.11.19.  
Кассет № Ш-74  
18.35-18.50

М.Альятулгат /251-р тойргийн депутат/ -Тэхээр улсын нэрийн асуудал маш чухал асуудал юм.Энэ нь Үндсэн хуулийн нэртэй адил биш гэж би бодож байна. Бид тэхээр Монгол гэж нэрлээд муудахгүй нь мэдээж юм. Энэ нь Чингисийн Монголоо эргэж байгуулах гээд байна уу? Монгол туургатнаа нэгтгэх гээд байна уу гэсэн бас нэг асуулт тавигдаж мэднэ. Монгол гэдэг нь сайхан нэр ,энэ нэрнээс бид буцах ёс байхгүй.Гэхдээ бид үүн дээрээ нэлээд сайн ярилцах ёстой.

Эхлээд бид улсынхаа нэрийг ярих ёстой байсан.Улсын нэрийг шийдэж байж, дараагаар нь Үндсэн хуулийнхаа нэрэнд орох ёстой байсан. Тэхээр манайх тусгаар тогтнол нь баталгаатай гэсэн үндэс байна уу, Эдийн засгийн талаар баталгаатай гэх үндэс байна уу? Эдийн засгийн дампуурал,бүх л юм доошилж байна шүү дээ. Сэргээн мандалт гэж ярьж байна, энэ нь амьдралдаа доошоо сэргээн мандаж байна. Тэхээр үүндээрээс харж үзээд,улсынхаа нэрийг цаашдаа ирээдүйтэй байлгах талаас нь БНМУ гэж нэрлэх нэр дээр би санал өгч байна. Бидэнд нууцаар,хаалтаар ярих юм бий. Хүн дааганаас унаж үхдэггүй,даравгараас болж үхдэг гэж Монгол ардын зүйр үг бий шүү. Энэ нь ард түмнээсээ нуух гэж байгаа юм биш ээ. Гэхдээ олон улс үндэстнүүдийн хооронд асуудлыг хурцатгах, ийм эдийн засагтай ядуувтар улс олон улсын асуудлыг хурцатгах талаас нь хүмүүс ярьж байгаа болохоос бид ард түмнээсээ нууж, нууцаар нэрийг нь шийднэ гэж бодоогүй байх гэж бодож байна. Зарим зүйлүүдийг шаардлагатай бол ярина гэж бодож байна.

Нөгөө талаар Бүгд Найрамдах Ардчилсан Монгол Улс гэж нэрлэвэл болохгүй юм байхгүй. Үнэхээр ардчиллыг хөгжүүлж байгаа бол"ардчилсан" гэсэн үгнээс бид татгалзах ёс байхгүй шүү. БНАМУ гэж нэрлэх ийм вариантыг хэлье гэж бодож байна.

Ц.Дамчигдорж /166-р тойргийн депутат/ -Ард түмний эд эс гэж энд хуран цугларсан депутатуудын нэгийн хувьд ард түмнээрээ

эвэлж явах үзэл санааг дэмжжэ явдаг.

Хоёрдугаарт ургах нар, шингэх нарыг БНМАУ гэсэн бичигтэй хилийн багана дээр алба хаадаг, БНМАУ-ын 14 аймаг, 39 сумын нутаг дэвсгэрийг улсын хил алхаж яваагийн хувьд БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалахад оролцож явдаг гэж бодож байна.

Өнөөдөр манай улсын баруун, зүүн цэг, гурван улсын хэмжээнд нэрээ хэлэлцээрээр байгуулагдаж чадаагүй яваа хил, хязгаарын хувьд бид өгсөн, авсан гэж олон төрлийн зүйлийг ярьдаг. Тийм учраас газар, нутгийн бүрэн бүтэн байдлыг цаашдаа анхаарч үзэх ёстой гэж бодож байна. Тийм ч учраас БНМАУ гэсэн нэр бол дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, НҮБ-д бид энэ нэрээрээ бүртгэгдсэн, нөгөө талаар ЗХУ-тай байгуулсан хилд, тэнд байгуулах сүлд, тэмдэгтэй хилийн багана тэмдэгтийг барьж байгуулахад Сая 500 мянган төгрөг, өмнөт хил дээр босгосон БНМАУ гэсэн бичигтэй нөгөө талдаа Хятадын дундаулс гэсэн бичигтэй хилийн баганыг солиход хоёр улсын хэлэлцээр, хөрөнгө мөнгө ч хэрэгтэй гэсэн үндэслэлийг агуулаад, одоохондоо нэрээ хэвээр байлгах саналыг өгч байна. Цөөнх болсны хувьд БНМАУ гэсэн нэр дээр санал хураалгаж өгөө чээ гэдгийг хүсэж байна.

А.Болат 72-р тойргийн депутат/ -Би эхлээд горимын чанартай нэг асуудлаа энд дахин ярьж гэж бодож байна. Өөрөөр хэлбэл бид сая гурван санал дээр бид санал хураах байсан. Аль нэгэн санал илүү эрх эдэлдэг. Саналын хувьд ийм зиндаачилдаг ялгаа байж таарахгүй. Гурван саналын гурвууланд нь санал хурааж, дараа нь цөөнхийн утгаар нь яришвал энэ нь арай шударга болох байсан. Би гайхаж байна. Сая хоёр санал дээр санал хураасан байхад энэ хоёр санал нь нийт депутатуудын 98 хувийг хамаарсан. Тэгээд цаана нь үлдсэн хоёрхон хувийн санал хүлээж байгаа тэр нэр томъёон дээр бид илүү эрх хадгалуулж байна. Ийм дэг журмаар бид цаашдаа явж таарахгүй байх аа. Бүх юман дээр тэгш мичхэнэ ардчиллын зарчмыг баримталж явбал эгээ нь Парламентын дээд соёл болно. Түүнээс бид Америктай Парламент тэгдэг юм гэнэ лээ гээд. Энээдэр ямар ч бараалхааргүй зүйлээр бид сэтгэлээ хуурах нь

3.

онц биш юм шиг санагдаж байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би цөөнхийн саналаа хэлнэ. Энэ нь цөөнхийн саналаар ургаж байгаа санал юм. Би хоёрдугаарт улсын нэрийн тухай их санаа зовж байна. Нуух юм алга, Бага Хуралд оруулсан саналынхаа эсрэг санал өгөхөөс еер аргагүй болж байна.

Би Үндсэн хуулийн талаар Бага Хурлын оруулсан 70 зүйл, 270 гаруй хэсгийн бараг 90 хувьтай нь бараг санал нийлж байгаа хүн. Гэтэл түүн дээр цөөхөн асуудал дээр магадгүй 10 хүрэхгүй асуудал дээр цөөнхийн чанартай хоцорсон учраас тэр саналаа Ардын Их Хурлын депутатынхаа хувьд энэ танхимд би хэлэх үүрэгтэй гэж бодож байна. Тэхээр улсын нэрийг сольж байгаа асуудал дээр маш их сэтгэл зовж байна. Миний ойлголтоор хоёр янзын үр дагавар байгаа юм.

Нэгдүгээрт улс төрийн, хоёрдугаарт эдийн засгийн маш их үр дагавар гарна. Улсын нэрийн товчилсон таван үсэгнээс нэг л үсэг хасагдаж, эсвэл нэг л үсэг урагшаа, хойшоо болоход эдийн засгийн маш их үр дагавар гарч ирж байна. Би нөхдүүдийн цагийг авахгүйгээр хэдэн тайлбараар хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, улс төрийн талаас манай нөхдүүдийн хэлж байгаа нь үнэн. Яг миний хэлсэн үгний энэ хэсгийг нийтэд мэдээлэхгүй ч байсан болно. Манай урд талын улс юу гэж үзэх билээ. 15 оны хэлэлцээр юу билээ. Түүнийгээ ч болъё. Манай нөхдүүд ийм тайлбар тавьж байна. Тэр үеийн субъектууд алца болсон гэж байна.

1988 онд Хятадын ерөнхий сайд Чоь Энч дай, Янчи Бидеель демократ намны удирдлагуудыг зохион явцад, 87-аараа нь Монгол улс бол Хятад Ард Улсын бүтэцтэй гэдэгт анх удаа анхны анхны хоёр арга олоо. Тэр үед бид хятадын бүтэцтэй, хэл эрвэл ялгаа байсан. Сүүлд Хятад улс ихэнх эрх зургуудыг, зорилгыг зохиосон сурах бичиг дээр ямар ч зурал дээр Хятад улс ихэнх эрвэл нь Монгол улс ихэнх нэгэнхдэй нь хатуурын эсвэл тэр үеэр цахуудуудыг хятад улс анх байсан. Ийн нэгдүгээрт бид хэрвээр байсан улс улс ихэнх эрвэл.

дээр олж авсан нэр хүндээсээ өөрөө сайн дураар татгалзана гэдэг нь улс төрийн хувьд би ойлгохгүй байна нэгд.

Хоёрдугаарт эдийн засгийн маш их үр дагавар гарч ирнэ. Сая манай зарим нөхдүүд тайлбарлахдаа 830 байгууллагын тамга, хаягийг нь солиход 8,6 сая төгрөг гарна гэж байна. Гэтэл манай улсад II мянган байгууллага байгаа, тэр бүх байгууллагууд нь бүгд нэр, хаяг, тамгаа соливол 100 сая төгрөг гарах юм байна. Бид өнөөдөр II8 төгрөгний үнэтэй нэг минутын төлөө хичнээн ярьж байгаа билээ. Бид ямар баяндаа 100 сая төгрөгөө салхинд хийсгэж байгаа юм бэ? Манай улсын нутаг, дэвсгэрийг тойроон 2650 ширхэг хилийн багана байдаг юм байна. Түүн дотор ганцхан улсын сүлдийг аваад хаяна гэхэд 3,6 сая төгрөг гарна гэдгийг надад хилийн хариуцлагатай хүмүүс танилцуулсан. Ийм үр дагавар гарч ирэх нээ. Эдийн засгийн хувьд маш олон үр дагавар, зөвхөн мөнгөний дэвсгэрт солино, БНМАУ- гэсэн нэрийг авлаа гэхэд, мөнгөний дэвсгэрт дээр байгааг солиход хичнээн хэмжээний зардал гарах вэ? ЗХУ ганцхан 200-тын дэвсгэр үйлдвэрлэнэ гэхэд 100 сая доллар зарахаар төлөвлөж, хэвлэлдээ зарласан. Тэхэд манайх тийм их баян улс юм уу. Манай нэг удирдагч хэлсэн байгаа шүү дээ, Улс эх орноо бодоход хаврын онд орсон туранхай морь хүний сэтгэлд төсөөлөгдөж байна.

Эх орны маань эдийн засгийн байдал ийм байсаар байхад ямар ч хамаагүй, нэрийг сольё гэж туйлшираж таарамгүй юм шиг байна. Улсын нэрийг сольж болно. Үүн дээр би эсэргүүцэж байгаа юм алга. Цаад утга, үр дагаварыг нь бодолцоё. Бид улсын нэрийг солих олдож байгаа ганцхан боломж энэ биш шүү дээ. Бид Үндсэн хуулиа батлахдаа огт амьгүй, нэг баримал цутгаж хаяхтай адилхан бодож байна. Бид Үндсэн хууль дээр өөрчлөлт оруулна гэсэн бололцоо бий шүү дээ. Заавал бололцоо нь гараад, манай эдийн засгийн засгийн жигдрээд хөл дээрээ босоод ирвэл агуулгыг нь шинэчлээд, улсынхаа нэрийг өөрчлөхөөр болвол бид тухайн үед Үндсэн хуульд өөрчлөлт хийж байгаа ч гэсэн нэрээ сольж болно шүү дээ. Тийм учраас бололцоогоо харгалзан үзэж, байж бид энэ асуудлыг цаг хугацаанд нь тааруулж, сонгож шийдэх ёстой.

5.

Өнөөдөр улсын нэр солино гэдэг асуудал нь эртэдсэн асуудал болно.

Д.Солном/160-р тойргийн депутат/ -Бидний сая нэрлэсэн шинэ засаг, Их засаг хууль маань улс орны тусгаар тогтнод, аюулгүй байдлыг бэхжүүлэх, баталгаажуулахад чиглэгдэж чадах уу, үгүй юу гэдэг нь чухал асуудал юм. Биднийг ямар хууль батлахыг ард түмэн маань их харж байгаа. Түрүүнд нэг депутат ярьж байсан, дэлхий ч харж байгаа гэж. Тэхээр бид хуулийнхаа бүлэг, зүйл нэг бүрийг ярихдаа тэр бүлэг, зүйл нэг бүр маань хоорондоо яаж уялдаж, ямар дүн, дүгнэлтэд хүрч болох вэ гэдгийг харж баймаар санагдаад байгаа юм. Энэ талаас нь би бодоод, улсынхаа нэрийг яаж нэрлэх вэ гэдэг дээр саналаа нэлээд ноцтой яримаар санагдаад байгаа юм.

Өнөөдөр гурван нэрээр санал авлаа. Түүний дотор Монгол улс гэдгээр дотроо саналаа өгөх хүсэл байна, гэвч энэ саналыг би одоогоор өгч чадахгүй байна. Үүний цаана надад юу бодогдоод байна вэ гэвэл бид Монгол улс гэж нэрлээ, товч, тодорхой болно. Бахархал болно, мөн хэмнэлтийн асуудал гээд их олон юм бий. Гэтэл энэ шийдвэр нь сайн талаасаа дотроо ч бай, гаднаа ч бай ойлгогдох уу, эсвэл буруу талаас нь ойлгогдох юм гарах уу гэдгийг бид бодох ёстой юм.

Саяхан, дөрвөн хоногийн өмнөх хуралдаан дээр ч нэг депутатын өмнөөс ийм юм гарсан шүү дээ. Монгол туургатнаа нэгтгэхийг бодлоо ч гэсэн санаагаар Монгол улс гэж нэрлэх хэрэгтэй гэсэн санаа гарч ирж байсан. Тэхээр бид дотроо үүнийгээ шийдэхийн өмнө бидэнд ийм санаа бий юу, үгүй гэдгийгээ дотроо сайн учраа олж яримаар байна. Их дэлгэж яриад хэрэггүй, дотроо аминдаа үүнийгээ ярих ёстой.

Бид улсынхаа хилийн энэ хуулиндаа яаж тусгаж байгаа билээ. Монгол улсын хил бол тусгай хуулиар баталгаажигдана гэсэн зүйл бий. Түүнээс бид өнөөдөр хоёр их гүрэнтэйгээ хэлэлцээр байгуулаад, батлачихсан, хэлэлцээр байгуулчихсан хилээ өнөөдөр <sup>анд</sup> Үндсэн хуулиараа баталгаажуулаагүй байгаа юм. Гэтэл энэ хурлын эхний өдөр манай

Бага Хурлын даргаас, энэ дотор хоёр, гурван депутат хил ямар байна вэ, будлиан бий юу гэсэн асуудал гарч байсан. Бид будлиан байна гэж үзэх үү, үгүй юу, болох бүхий асуудал юм уу, үгүй юу. Бид одоо Монгол улс гэж тунхаглахаараа энэ байгаа хилээрээ Монгол улсаа хиллэж байгаа гэдгээ энэ хуулиараа хэлэх үү, үгүй юу гэдгээ бид дотроо аминчилж яримаар санагдаад байгаа юм. Үүнийгээ дэлхийгээр дэлгэж дэлгэрэнгүй ярих асуудал биш гэж санагдаад байгаа юм. Манай улсын сүлцийн талаар сүүлд ярина. Ер нь улсынхаа нэрийг өөрчилчихөөд, түүн дээрээ сайн тайлбар өгч чадалгүй, улсынхаа хилийг энэ хуулиар батлахгүй орхичихоод, тэгээд сүлд дээрээ сум барьсан, үгүй бол хажуудаа хамгаалалт барьсан морьтой байдаг юм уу, шувуутай болоод гарчихад бас яаж ойлгогдох вэ? Энэ нь мөн хуулийн үүнтэй холбогдсон хэдэн асуудлыг ярьж байгаа юм. Цаана нь мөн тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой бас хоёр асуудал байгаа юм.

Хуулийн төсөлд Монголын газар нутгийн ихэнх хэсэг болох бэлчээр, мөн газрын хэвлийг одоогийн төсөлд тусгаснаар Монголын төр ч өмчлөхгүй, иргэн ч өмчлөхгүйгээр тусчихаад байгаа юм. Бид үүнийгээ мөн сайн дотроо ярих ёстой асуудал юм шүү. Үүнтэй холбогдуулж Монголын иргэн гэдэг нь жинхэнэ цэвэр Монгол хүмүүсүүд, одоо байгаа монголчууд байх уу, үгүй юу, цаашдаа ямар Монгол хүмүүсүүд гарч ирэх, орж ирэх, гаднаас орж ирээд Монголын иргэн болох асуудал нь байх уу, үгүй юу, энэ нь яаж зохицуулахыг бид дотроо нэг их дэлгэлгүйгээр яримаар санагдаад байгаа юм.

Мөн цагаачлалын асуудал байна. Энэ асуудлаар бид сайн бодож боловсруулсан хуультай байх уу, эсвэл хуульгүй байх уу гэдэг дээр бид маргаад жил боллоо. Үүний оронд бид ингэж будилаж байсан дор цагаачлалын ийм хууль байх юм гэсэн төслөө гаргачихаад түүн дээрээ ухаанаа уралдуулж байх ёстой байсан. Түүнийгээ мөн холбож бодмоор юм. Цагаачлалдаа яаж нь гэдэг мөн дотроо хэлж үзжээ. Бид яриад, дараа нь хууль төсө, төслийг нь өөрчлөхөөр юм. Ийм зүйлүүддээ дотроо сайн ажиллаж ярих явдал,

цараа нь шийдвэл, ямар нэртэй байх нь оновчтой вэ гэдгээ зөв тодорхойлж чадмаар юм шиг байна. Хаалттай хурлаар хийе гэдэг санал гаргасан хүмүүсийн нэг нь би юм. Мөн муу нэртэй, модон улаатай гэдгийн нэг нь, миний саналыг дэмжиж байсны шалтгаан нь энд байгаа юм. Үүний цаана ямар нэгэн зүйлээ ард түмнээсээ нууя гэсэн бодол огт байхгүй.

Эцэст нь хэлэхэд өнгөрсөн, ирээдүйгээ бодох нь зүйтэй. Гэхдээ одоо үе, амьдарч байгаа бодит орчин цагаа харая гэдгээ депутатууд үүний урьд хуралдаанууд дээр хэдэн удаа анхааруулсан нь чухал юм.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



Ц.БАЯРМАА

Бичээч С.ТУУЛ

Ардын Их Хурлын II4 дүгээр тойргийн депутат Д.Ёндонжамц:  
БНМАУ гэж нэрлэгдэж ирснээр одоогийн гарч байгаа хямралд хүрсэн мэтээр яригдаж байгааг ойлгохгүй байгаа юм. Ял янханд орсон Дорж гэдэг хүн шоронгоос гарч ирээд одоо би цэвэр ариун замаар амьдаръя, Жамц гэдэг болъё, Жадамба гэдэг болъё гэж хэзээ ч тийм юм байдаггүй байх гэж бодож байна. Тийм учраас БНМАУ гэдэг дотор байгаа "ард" гэдэг үгнээс ихээхэн сэжиглэж ядуу ардын гаралтай, юу гэдэг юм, тэр одоо хөрөнгө чинээтэй холбоотой ийм юм байдаг юм гэсэн цуу сонсож байгаа. Тэгвэл тийм биш юм аа энэ бол. "Ард" гэдэг бол ард олныг төлөөлсөн, олон түмнийг төлөөлсөн ийм үг болов уу гэж ингэж бодож байх юм. Бид цөмөөрөө малчин ардын гаралтай, дийлэнх олонхийг маань нэрлэсэн ийм сайхан нэр болов уу гэж ингэж бодож байх юм. Буруу байж болно. Бид энэ нэрийг хэвээр үлдээснээрээ өөрийнхөө тойргийн сонгогчид, малчин ардыгаа хүндэлсэн хүндэтгэл маань хэвээрээ үлдэх болов уу гэж ингэж бодож байна.

Өнөөдөр улс оронд гарч байгаа хямрал цотроос хамгийн тогтвортой ажиллаж байгаа хүмүүс бол малчин ард маань гэж бодож байгаа бил. Өнөөдөр улсын нэрийг Бүгд Найрамдах ч гэсэн Монгол Ард ч гэсэн, Монгол ч гэсэн хонио ууланд туугаад явуулчих сэтгэл санааны хямралд орчих ийм малчин байхгүй болов уу гэж би бодож байна. Ингээд би малчин ард, олон түмнээ хүндэтгээд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нэрийг хэвээр нь байлгах саналтай байж байгаа. Сая ч нэлээн хэдэн депутат бол энэнийг ярилаа гэж бодож байна.

✓ Дараагийн дугаарт нэг бодогдож байгаа зүйл бол энэ нэр, улсын нэр, хууль хоёр цээр наймаа хийх маяг байх шиг байна гэж бодож байна. Энд юу вэ гэхлээр хэрвээ Монгол улс гээд нэрлэх юм бол хамаагүй, Үндсэн хууль гэхихье гэж байгаа бололтой байна Бага Хурал талаасаа бол, Бүгд Найрамдах Монгол Улс гэх юм бол Их засаг гэхихье гэж байгаа бололтой байна. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэх юм бол заавал Их цааз гэж нэрлэнэ



цээ гэж ингэж барьцаа, тавьцаа байгаа юм уу гэсэн ийм хуваагдмал бодол байна уу гэж ингэж бодож байгаа юм. Ер нь ингээд бид микрофон дээр олон гарч ирж чадахгүй юм шиг байна. Манай Бага Хурлын гишүүд, микрофоны ойрхон байгаа хүмүүсүүд бол дэндүү олон бидний эрхийг боогдуулж байгаа юм. Ингээд юу вэ гэхлээр бид Бага Хурлын депутат бус гишүүдийг депутат нарынхаа саналыг хэлэлцэж байгаа асуудал дээр авсны дараа Их Хурлын даргын зөвшөөрөлтэйгээр хэлүүлж байгаачээ гэж ингэмээр байна. Энэ талд дийлэнх олонхи гишүүд бол ямар ч очер, дугааргүй гарч депутатуудынхаа үг хэлэх эрхийг боогдуулж байна гэж бодож байгаа юм.

Дараагийн дугаарт нь үг хэлэх зүйл бол энэ зарим үг хэлсэн гишүүд биднийг бол, хөдөөний улсуудыг яаж байна л даа. Оюуны хомсдолтой, тэр өнөөх, одоо энэ хурлаа явуулах потенциал нь дууссан, шавхаж гүйцсэн, одоо ингээд та нар тарсан ч болно гэх шахуу юм өдөр хэлж байсан. Ингэж ярьж байвал бид нар улс төрийн хувьд тийм хомсдолтой байдаг юм байж, эдийн засгийн хувьдаа бол мандасаа цор хомсдолтой байгаа юм биш үү эд чинь, потенциал нь бол. Энэ хурлыг үргэлжлүүлэх, дэгийг нь эвдэх, болоод байсан юмныхаа хэв загварыг нь өөрчилж байж дахиж мөнгө төгрөг зарах, хөдөө орон нутагт болж байгаа зудны түрүүчийг нь ✓ пуулдаж л байна. Ажилхан олон төрлийн ажлууд байгаа. Энэ бүхний чинь талаар энэ харин төв талд байгаа хүмүүс маань эдийн засгийнхаа хувьд харин потенциал нь дуусчихаад байгаа юм биш үү гэсэн ийм бодолтой байна.

Ардын Их Хурлын III дүгээр тойргийн депутат Г. Бадарч:— Тэгэхээр манай сая одоо депутат бид нар баталж, гар санал хураалтаар батлагдсан Их засаг хууль гэдэг маань үнэхээрийн хуучин хуулиудтай бодоход агуулгынхаа хувьд ч, дотор нь бүтэц зохион байгуулалтынхаа хувьд ч гэсэн маш их өөр, энэ орчин цагтайгаа уялдаж гарахаас өөр аргагүй болж байна аа. Тэгэхээр энэ хуулийнхаа нэртэй холбогдуулж бид улсынхаа нэрийн тухай асуудал бол өнөөдөр манай улсын амин чухал асуудлын нэг гэж би хувьдаа үзэж байна. Депутатын хувьд. Тэгэхээр ер нь одоо би сайн мэдэхгүй юм аа. Монгол гэхэд нэг 2,1 сая хүнтэй, Өвөрмонгол

## 3.

гэхэд 3,6 сая хүнтэй, Буриад монгол гэхэд 260-аад мянган хүнтэй, Тува гэхэд 200 мянган хүнтэй, Халимаг гэхэд 200-аад мянган хүнтэй байдаг юм шиг байна. Ер нь бид ингээд аваад үзэхэд ар нь монгол туургатан, монгол угсаатан гэдэг чинь 6,4 сая хүн байгаа юм болов уу даа. Тэгэхээр энэ Монгол улс гэж нэрлэхэд үнэндээ би энэн дээр санал өгөөгүй ээ. Бидний хэсэг нөхөд энэ жил АНУ-д явж байгаад Конгресст нь уулзаад ярьж байсан л даа. Тэгэхэд Конгрессийн нэг гишүүн бидэнд ярьж байсан. Үгүй БНМАУ гэдэг чинь тэр хоёр том гүрний дунд тэр жаахан цөөхөн хүн амтай, энэ том газар нутагтай улс тусгаар тогтнолоо ингэж авч үлдэнэ гэдэг үнэхээрийн танай гайхамшиг, үндэсний бахархал гэж ярьж байсан. Тэгэхээр тэр алс хол байгаа Америкийн конгрессийн гишүүн ингэж сэтгэж байхад бид чинь улс орныхоо тусгаар тогтнолын төлөө өнөөдөр бүх юм маань, зүрх маань, цус маань гүйж цохилж байхаас өшөө арга байхгүй ээ. Тийм ч учраас би саналаа БНМАУ гэдэг дээр байлгах саналтай байгаа. Манай БНМАУ-ын маань нэр дэлхийн 140 оронд байж байна. Энэ манай Монголын алтан соёмбот далбаа энд хийсч байна. НҮБ-д ч гэсэн энүүгээр, БНМАУ гэдгээр зөвшөөрсөн.

Манай депутатууд, зарим хүмүүсүүд ард гэдэг дээр их болгоомжилж байх шиг байна. Ард гэдгийг Ардын хувьсгалын анхны жилүүдэд ангийн үүднээс авч үзэж байсан. Ард анги, феодал анги, хамжлага гэж. Тийм учраас энэнээс айгаад байх шиг байна. Тэгвэл өнөөдөр ард гэдгийн цаана ажилчин ч байна, малчин ч байна, сэхээтэн ч байна. Өнөөдөр манай Монголын ардчилсан холбооноос зориудын үүсгэн санаачилж бий болгосон Ардын аж ахуйтны холбоо ч энэний цаана байгаа шүү. Тэгэхээр бид ард гэдгээс айгаад байх юм байхгүй ээ гэж хэлмээр байна.

Нөгөөтэйгүүр энэ улсынхаа нэрийн тухай, БНМАУ гэдгийг чинь 1945 онд бүх нийтийн санал хураалт явагдсаны үндсэн дээр бид нар чинь тусгаар тогтнолыг маань бусад улсууд бататгасан байгаа шүү. Тэгэхээр энэнийгээ ч гэсэн болох хэрэгтэй байна. Цаана нь эдийн засгийн талаар ямар байх вэ, улс төрийн талаар ямар байх вэ, энэ талаар манай депутатууд үнэтэй санал

гаргасан учраас би цөөнхийн санал авсны хувьд улсынхаа нэрийг БИМАУ гэдэг нэр дээр саналаа өгч байгаа.

Ж.Уртнасан: Уучлаарай депутатууд аа! Тэгэхээр бидний дэгийн цагуу бол хурал завсарлах цаг болж байна. Тэгэхдээ та бид шийдэх асуудалдаа хүрч чадахгүй, хоног хугацаа их алдаж байгаа учраас горимын нэг санал байгаа юм. Бид өр нь өдөрт хуралдааныг 2 цаг үргэлжлүүлж байх уу гэсэн саналыг зарим депутатууд тавьж байгаа. Тэгэхдээ өнөөдөр 8 цагаас бүлгүүд уулзъя гэсэн хүсэлт бидэнд бас ирж байна. Одоо та бүгдээс энэ микрофоны ард арваад хүн байна. Хурлаа үргэлжлүүлэх үү, дэгийн цагуу завсарлах уу гэдэг асуудал байна.

✓ Санал хураалт явуулъя. Хурлыг үргэлжлүүлье гэсэн томъёоллоор. Нэг цаг, яцаж 8 цаг <sup>хүртэл</sup> Хурлыг нэг цагаар үргэлжлүүлье гэсэн санал байна.

Хоёр дахь санал ирж байна. Хоол идсэний дараа 8 цагаас цуглараад цааш нь үргэлжилье гэсэн.

За нэг цаг сунгая гэсэн.

За уучлаарай. Хуралдааныг сунгая гэдэг дээр депутатууд санал нэгтэй байгаа юм шиг байна. Эхний хувилбар нь одоо нэг цаг үргэлжлүүлнэ гэсэн хувилбар дээр. Одоо үргэлжлүүлье. Хэмжээ бол нэг цаг. Санал хураалт явуулж байна. Хуралдааныг нэг цаг үргэлжлүүлье гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

Хуралдаж байгаа хүмүүс, санал өгсөн депутатууд 381 хүмүүс санал өгсөн байна. 89 хувь нь. 70 хувь нь буюу 266 депутат хуралдааныг үргэлжлүүлье гэж байна. 101 буюу 27 хувь нь татгалзаж, 14 буюу 3 хувь нь түгтэлзэж байна. Энэ Улсын нэрийн асуудал дээр зарим депутатууд түргүүн хэлсэн. Давтаж санал хураалгаад яах вэ. Энэ бол чухал асуудал. Ийм учраас цөөнх хүнээр таслалгүй, саналыг төгөлдөр болтол санал хэлэх

5.

хүмүүсийг үргэлжлүүлбэ гэж. Ийм учраас хэрэв та бүхэн зөвшөөрвөл нэг цагийн дотор энэ хүмүүс ээлж дараагаар микрофоны дарааллаар үгээ хэлбэ. Та бид сонсоё гэсэн ийм томъёолол байна аа.

Б. Уртнасан:—Уучлаарай. 5 дугаар микрофон хүлээхгүй юу. Цөөнх ямар саналтай байна гэдгийг бид сонсох хэрэгтэй болох юм шиг байна. Хоёрдугаар микрофон дээр санал сонсоё. Цөөнхөө хүндэтгэе.

Арлын Их Хурлын 9 дүгээр тойргийн депутат С. Зориг:—Тэгэхлээр 9 хоног хуралцаад юу ч шийцээгүй байж байж, нэг орой хуралдахаас юунээс нь айгаад байгаа юм бэ би ерөөсөө ойлгохгүй байна. Эрхэм депутатууд аа. Нэрийн асуудлыг өнөөдөр суугаад, Ламжав депутатын саналыг дэмжиж байна. Шийцэхгүй бол хаалгыг түгжээд л суулгах хэрэгтэй. Өөр арга байхгүй.

Ж. Уртнасан:—За хуралдаанаа үргэлжлүүлбэ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

Д.Дэмбэрэл /234 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр бид Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэрийг дуусгавар болгож байгаа энэ мөчид нэг цөөн зүйлийг тэмдэглэж хэлье гэж бодож байна.

Ж.Уртнасан -Цөөнх үгээ товч, тодорхой хэлнэ гэдэгт найдаж байна.

Д.Дэмбэрэл -Монголын гал голомтыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэр хадгалж өдий хүргэсэн.Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Монгол улс болгоё гэсэн энэ санал дийлэнх болж байна. Тэгэхээр энэ Монгол улс гэдгийн цаана чухам юу болох вэ гэдгийг төсөөлөхөд бэрх боловч бас анхаарууштай эүйл байна гэж бодож байна.Хятадын хувьд хятад хүний ясны үзэл бодол нь өөрчлөгдсөн гэж би хувьдаа үзэхгүй.Манайтай янз бүрийн гэрээ хэлэлцээрүүд хийсэн зүйл бий.Миллиард гаруй хүнтэй хятадын олонхи нь бол Монгол улсыг залгих цаад бодлоосоо ангижирсан гэж би ерөөсөө үзэхгүй байна.Ийм учраас монголын гал голомтыг хадгалж байх гэсэн монгол хүний уг чанар, уг агуулгыг цаашдаа бид ч бас хадгалж, цаанаа энэ агуулгыг авч үлдэх ёстой гэж бодож байна.

Хоёрдугаарт, энэ янз бүрийн эрхийн актууд Бүгд Найрамдах Монгол Ард Улстай холбогдож гарсан.Тэгэхдээ дэлхий дахинд эрхийн акт бүхнийг хүндэтгэн баримталж байдаг тийм журам хараахан тогтоогүй байна гэж үзэж байна.Дэлхийд хүчээр түрээ барих, эзлэн авах бодлоо төгсгөл болоогүй.Ийм учраас монголын хувь заяаны асуудал тийм амархан шийдэгдчихээд байгаа зүйл биш гэж бодож байна.Ер нь монгол гэсэн ерөнхий нэрийг ингэж өгчихөөд, энэ монгол гэсэн нэрийн дор монголыг америкчилах, хятадчилах, япончлох ийм агуул нөмрөн ирэхгүй байх гэсэн баталгааг одоогоор хэн ч гаргаж чадахгүй гэж бодож байна.

Нэг жаран буюу, монголчуудын хэлдгээр 60 жилийн дараа дахиад бидний хойч үеийнхэн Үндсэн хуулийг батлах гээд сууж

байхдаа, даанч яав даа, бид нар энэ монголд их цөөхөн болчихож, гол нь монгол биш хүмүүс энэ монголоор дүүрчихсэн учраас, ерөөсөө монгол гэдэг үгийг авч хаяя гээд хэлэхэд бид цөөдөж байна, энэ бол 1991 онд хуралдаж чуулж баталсан Үндсэн хуулиас эхлэлтэй юм байна гэж хэлэх цаг ирэхгүй байхын баталгаа ч алга байна.

Ийм учраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Монгол улс гээд нэрлэхэд арай л ахадсан малгай юм шиг харагдаж байна. Их юмны төлөө санаж сарвайж яваад, өөрийн гэсэн эрх мэдлээ алдах вий гэж бодохоос Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэвээрээ байг гэсэн энэ саналыг дэмжихэд хүрч байна. Би энэ үед энийг л тэмдэглэж хэлье гэж бодсон юм.

Молом

-Би цөөнх

болж цөөнхийн тоонд орж санал хэлэхийг хүсч байна. Би Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэр томъёог монголын бүх ард түмнийг төлөөлүүлж, монгол улсаа тэгж нэрлэе гэсэн саналыг дахин хураалгаж өгөхийг та бүхнээс хүсч байна.

Учир байдлыг бид ойлгож байна. Ард гэдэг нэрийг татгалзая, Монгол улс гэж болгоё. Янз бүрийн санал гаргаж байна. Энэ ч болохгүй ч юу байхав. Би ард гэдэг үгийг иргэний хувьдаа өөрийнхөө зулай дээр шүтэж явах ёстой үг гэж би боддог юм. Бид бүхэн чинь бүгдээрээ ардын хүүхдүүд. Нарийн ярих юм бол тэр лам, хэлмэгдсэн лам хувилгаан чинь бүгдээрээ ардын хүүхдүүд. Бид чинь бол тухайн үедээ хэлмэгдэл гарч, завхрал гарч, энэ Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн энэ нэртэй энэ Үндсэн хуулийн дор ийм эвгүй байдал гарсан явдал бол тухайн нийгмийн гажуудал, гадна дотны оролцлогоо, овилгогүй улсуудын туушгүй, ард түмний төлөө үйлчилж байгаагүй, ард түмний төлөө байгаагүй хүмүүсийн үйл ажиллагаанаас болсон хэрэг шүү дээ. Ийм учраас би Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдгийн дотор "ард" гэдэг үгийг оруулах саналтай байгаа юм.

Түрүүчийн депутатууд тал талаас нь гүнзгий авч үзэж янз

бүрийн үндэслэл гаргаж байна. Би нэг хоёр үндэслэлийг давхардаж байгаа боловч хэлэхийг хүсч байна.

Нэгдүгээрт, Ялтын баримт бичгийг үндэслэж 1945 онд нийтийн санал хураалтаар Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж улсаа дэлхийд өөрийн бүрэн эрх, тусгаар тогтнолоо дахин баталгаажуулсан билээ. Мөн 1961 онд НҮБ-д Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг нэрээр манай улс элсэн орсон. Бүгд Найрамдах Монгол Ард Улс дээрх энэ 70 жилийн дотроо дэлхийн 100 гаруй оронтой янз бүрийн шатанд харилцаа, дипломат болон төрөл бүрийн харилцаа тогтоосон. Энэ бүх зүйлүүдийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нэрийн өмнөөс хийсэн тал бий. Тэгж явсан баримт байна. Энэ бүх зүйлийг тоомсорлохгүй өнгөрөөж өнөөдөр болохгүй байх гэсэн нэгдүгээр шалтгаанаа би ингэж хэлж гэж бодож байна.

Хоёрдугаарт, өнөөдөр манай нутаг дэвсгэр хил хязгаарын хүрээнд үйлчилж байгаа Үндсэн хуулийн бүрэн эрх нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ойлголтоос хэтэрвэл юунд хүргэх вэ гэдгийг хүн бүхэн нухацтай бодох хэрэгтэй асуудлын нэг гэж би үзэж байна. Бид өөрөө өөртөө эзэн болж, улс орноо хөгжүүлэх бүрэн боломжтой, ирээдүйтэй. Ийм учраас би Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдгийн төлөө саналтай байгаа хүн юм.

Ш.Бадам /284 дүгээр тойргийн депутат/ -Би улсынхаа нэр, сүлд, далбаа, энэ юмнуудыг өөрчлөхөд татгалзах зүйлгүй гэдэг тал дээр нь байдаг хүн. Харин энэ удаа энэ өөрчлөлт хийх цаг нь болоогүй байна. Энийг өөрчлөх эдийн засгийн болоод, улс төрийн ноцтой шалтгаан байна гэж ингэж үзэж байгаа хүн юм.

Эдийн засгийн шалтгааных нь талаас та бүхэн тодорхой ярилаа. Энэнд мөнгө их орно. Энэ бол Чимид гуайн хэлдгээр төсвийн хийдэгдлээс 200 төгрөг гарах зүйл бишээ. Товуусүрэнгийн хэлдгээр 12-13 сая төгрөг орчих асуудал бишээ. Энэ бол миллиардаар яригдана. Би энийг юуг үндэслэж хэлж байна вэ гэвэл Цейлон гэдэг улс Шри ланк гэдэг нэрээ солиход олон арван сая доллар

орсныг дорно дахиныг судлагч манайхны эрдэмтэн, доктор, профессор хүн нэлээн олон сая доллараар ярьж, тэрийг нь би монгол төгрөгт шилжүүлэхэд I биш миллиард төгрөг гарч байгаа юм. Тэгэхээр бидэнд ийм их хөрөнгө мөнгө гаргах бэл бэнчин бий юу. Бид 90 сая доллараа салхинд хийсгээд үгүй болгосон. Энэ 90 сая доллар бол хоёр сая хүнтэй монгол орны маань 4-5 жилийн идэх хоол байсан байхаа. Дээрээс нь бид миллиард миллиардаар төгрөгийг энэ нэр солих асуудалдаа зарцуулах юм бол ард түмэн маань одоо юу идэх юм бэ? Одоо зарим хүмүүс монголын ард түмэн элгээрээ хэвтчихээд байна гэж ярьж байгаа. Үнэхээр өнөөдөр идэх хоол, өмсөх хувцас ихээхэн гачигдалтай байна. Идэх хоол, эмийн зүйл дутагдсанаас болоод өнөөдөр хүн ард маань амьдралын хувьд үхэл зовлон их учирч байна. Эхний 9 сарын байдлаар, өнгөрсөн 9 сартай харьцуулахад хүн амын нас баралт 9,1 хувиар өссөн. Үүний дотор I-3 насны хүүхдийн эндэгдэл 3,2 хувиар өссөн. Энэ бол баталгаатай тоо. Энийг та бүхэн нотлох юм харъя гэвэл харж болох байх.

Дээрээс нь хөдөөгийнхөө малчдаар одоо та бүхэн явж үзээч. Одоо мордоод буухад эрэгтэйчүүд нь биднээс тамхинаас чинь нэг ороогоод хоцоръё гэж хэлнэ. Их сайн таньдаг хүн байвал нэг соороод хоцоръё гэж байгаа хүн байна. Надтай хамт явж байсан хүн энийг нотолно.

Эмэгтэйчүүд нь, саяхан төрсөн эмэгтэй хүнтэй айлаар би орж үзсэн. Тэгэхэд одоо хамгийн гол хэлж байгаа юм нь хоол гуйхгүй байна. Барааны саван, хирнээсээ салах юмсан гэж уйлж байгаа эмэгтэй хүнтэй таарсан. Ийм нөхцөл байдалд бид нар энэ хүнээ идэх хоолтой, өмсөх хувцастай болгох энэ баталгааг хангахад одоо байгаа энэ хөрөнгө мөнгөө зарцуулчих юмсан. Тэрний дараагаар бид илүү, тэр нэг бамбар болох янзтай болсон хойноо энэ нэр усаа солих барих юмандаа энэ зарцуулах мөнгөө зарцуулах юмсан гэсэн ийм бодлого байна. Энэ бол миний эдийн засгийн талаас ярьж байгаа шалтгаан юм.

Улс төрийн шалтгаан бас байна. Энийг хүмүүс хэллээ. Бид



## 5.

хоёр том гүрний хооронд байгаа. Энэ хоёр том гүрэнд маань хоёу-  
ланд нь монгол нэртэй улсууд бас бий. Тэгж байхад бид Бүгд Най-  
рамдах Монгол Ард Улс гэдгээ өөрчилчихөөд Монгол улс гэх юм  
бол энэ улсуудад лав таагүй л байх. Манай улсын хөгжлийн ирээдүй  
энэ хоёр гүрнээс шалтгаална гэдгийг хүмүүс маань нотолж өчигдөр  
энийг олон удаа нотолж ярьсан. Ийм байдлын үүднээс бид энийгээ  
солих гэж өнөөдөр тэмцэх хэрэг байна уу? Өнөөдөр бид бусад ул-  
сын жишгээс ч гэсэн авмаар байгаа юм. Түрүүн Цейлон улс  
Шри ланк улс болсон гэсэн. Бас өнгөрсөн жил Бирм улс Мьяма  
гэдэг нэртэй болсон. Энэ хоёр улс маань өнөөдөр хоёулаа үндэстэн  
хоорондын мөргөлдөөнтэй дотроо байгааг энэ сонин дээр манай со-  
нинууд бичээд байгаа, та бүхэн харсан байгаа байх. Энэ улсуудын  
нэрээ сольсноос болоод Энэтхэг улс гэхэд Шри ланк руу Тамилийн  
асуудлаар хил хязгаарын байнгын өнгөлзлөгөөтэй байгаа. Энэ ул-  
сууд ямар шалтаг ярьж байна вэ гэхээр бид хилийн гэрээгээ Цей-  
лон улстай хийсэн болохоос биш Шри ланктай хийгээгүй гэдэг  
энэ томъёоллыг хэлж байгаа юм гэнэ билээ. Би энийг зарим  
улсаас дуулсан, өөрөө нотолж чадахгүй. Ийм шалтгаан гарахгүй гэх  
үндэс байна уу?. Ийм учраас бид нар энэ энэ талуудаа бодоод  
өнөөдөр энэ нэр ус солих тухай асуудлаа жаахан хойш тавиад,  
нээлттэй орхиод дараагийнхаа Үндсэн хууль дээр оруулах талын  
асуудлыг тавьж орхиод үлдээвэл ямар вэ гэсэн ийм саналтай байна.

Тэр нэр ус юмнуудаа сольжээ гэж бодоход сүлдэндээ би тэр  
шувуу байна гэдэг нь ямар учиртай байдаг юм байгаа юм, тэрэн-  
тэй санал нийлэхгүй байгаа. Ер нь солиход болох юм. Цаг нь болох  
юм бол гэж, тэгэхээр энэ шувуу байна гэдгийг нотолж ярьж  
байгаа хүн ч гэсэн одоо Бадраа гуайн хэлж байгаагаар бидний л  
өчигдрийн танил биофизикч Баабар маань өнөөдөр эрдэмтэн түүхч,  
зохиолч болоод нотолж ярьж байгаа юм, 1200-гаад оны юмыг. Гэтэл  
энэний цаад тал чинь өшөө олон, зөвхөн түүхээр мэргэшсэн олон  
доктор профессорууд маань юу хэлж байдаг юм бол, тэднийхээ үгийг  
бас бид нар сонсох юмсан, тэдний үгийг яагаад сонсохгүй байгаа  
юм гэдэг асуудал бас эргэлзээ төрүүлж байгаа юм.

Ингээд эцэст нь

хэлэхэд өөрчлөхийн тулд юмнуудыг

өөрчилж болохгүй.Энийг Адъяасүрэн хэлсэн.Улс төрийн тогтолцоо өөрчлөгдөх учраас бүгдийг өөрчлөх юмаа гэж.Ингэж туйлширч болохгүй.Өөрчлөхийн хийрхэлд автаж болохгүй.Бид өөрчлөх юмаа л өөрчилье.Өнөөгийн амьдралаа бодъё.Энэ хуулиа өнөөдрийн болоод ирээдүйн хүмүүсүүддээ зориулж гаргая.Тэрнээс биш Манжийн үеийн хүнд юм уу, Чингисийн үеийн хүнд зориулсан Үндсэн хууль бид нар батлах гээгүй шүү дээ.Манжийн үеийн нэр томъёонуудыг ихэвчлэн сэргээхийн тулд улайран хөөцөлдөж байгаа явдал үнэхээр харамсалтай байна.Бид өнөөдрийнхээ хүнд, өөрсөндөө, ирээдүйдээ зориулсан Үндсэн хуулиа гаргая гэж бодож байна.

У.Баянбилэг /349 дүгээр тойргийн депутат/ -Би Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдгийг хэвээр нь байлгах саналтай байдаг юм.Харин төрийн сүлд, далбааг өөрчлөх саналтай байдаг. Хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэрийг өөрчлөх юм бол бүх ард түмний асуулга явуулж байж өөрчлөх хэрэгтэй гэж боддог.Төрийн сүлд, далбааг солих хэрэг гарах юм бол тэр Азийн бархан болсоны дараа сольчихвол эүгээр юм уу гэж ингэж бодож явдаг юм.

Бид бол цөөхөн хүн амтай улс, харин жижиг улс гэдэгтэй би санаа нийлдэггүй.Монгол үндэстэн дэлхий даяар тархсан.Ийм үндэстэн.Энэ дэлхий даяар тархсан энэ үндэстэн бидний эцэг өвгөдийн маань алтан шарил, эзэн богдын маань онгон энэ монголын газар шороон дээр байгаа гэдэгт бид нар итгэж явдаг.Ийм учраас бид нарыг монгол улс гэдэг нэртэй байсан ч, Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэртэй байсан ч бид нарын санаа сэтгэл энэ газар шороотой холбоотой гэдэгт би бас итгэж байдаг юм.

Ийм учраас энэ монголчуудын сэтгэлд бид нарын нэрээ сольсон ч солиогүй ч өөрчлөгдөхгүй.Бидний энэ газар шороон дээр байгаа монголчууд маань маш их цөөхөн.Ийм учраас бид нар энэ Монгол гэдэг нэрэндээ ямар нэгэн тодотголтой баймаар байна.Бүр болдоггүй янз бүрийн хавчилга шахалтад ороод энэ нэр төрөө өөрчлөх хэрэг гардаг юм бол Хөх монгол гэсэн ч яахав, Чингисийн

монгол гэсэн ч яахав. Ер нь тодотголтой л байх хэрэгтэй. Ийм учраас Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдгийг еөрчилж болохгүй. Энэ бол улс орон даяар төрийн байгууламжаасаа шалтгаалаад энэ Бүгд Найрамдах гэдгийг хэрэглээд байх шиг болоод байгаа юм. Хараад байхад хаант улсууд бол дангаар нь хэрэглээд байх шиг болоод байгаа юм. Ухаандаа япон ч гэдэг юм уу. Ийм учраас энэ Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг нь байж байх хэрэгтэй юм гэж ингэж бодоод байгаа юм. Ард гэдэг дээр хүмүүсийн санал янз янзаар нотолж байна. Ард гэдэг үгийг байлгах тал дээр. Би ч гэсэн ардыг ер нь байлгавал яасан юм бэ гэж үзээд байгаа. Бидний энэ хавийн депутатууд ч тэгж үзээд байгаа юм.

Яагаад гэвэл Бүгд найрамдах буриад улс гэж байна. Бүгд Найрамдах Тува Улс гэж байна. Энэ улсууд маань нэрээ солиод ийм нэртэй болчихлоо. Тэгвэл бид нар эд нараас өөр "ард" гэдэг үгтэйгээ байя. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэртэйгээ байя гэсэн ийм саналыг дэвшүүлж байгаа юм.

Хэрэв өнөөдөр, за яахав бусад асуудлуудыг нь манай депутатууд ярилаа. Эдийн засаг маань болохгүй байна. Хэрэв төрийн сүлд, туг, далбааг өөрчлөх юм бол гадаа байгаа тэр макетууд дотроос Дулаанхааны Ганбаатарын төрийн сүлд байна. Энийг яваандаа авч болдог юм байгаа биз гэсэн ийм санал байна.

Ж. Уртнасан - Хэлэлцэж байгаа асуудал дээрээ ярья.

У. Баянбилэг - Баярлалаа.

Соронзон хальстай тулгаж

нийлсэн

*Ш. Цэцэг*

БҮРМАА

Бичээч Уранчимэг

104 дугээр тойргийн депутат Д.Жагварал: -Тэгэхээр бид нар БНМАУ-ын нэрний тухай ярьж эхэллээ.Энэ маш их ярих ёстой зүйл байх.Би энэ дээр эхлээд хэлсэн.Бид засгийн эрхийг гартаа авч байгаад дараа нь ямар үндсэн хуультай байх вэ гэдгээ ярьж байгаа учраас энийг их ярих хэрэгтэй байх.Энэ БНМАУ гэсэн нэр бол гарч ирэхдээ цустай гарч ирсэн нэр. Энийг би ойлгож байсан юм.Хөдөөнөөс наашаа гарахдаа ч тэгэж бодож байсан юм.Нэрнийгээ буудаж байж энэ нэр солигдож энэ хөгжлийн зам солигдсон нэр.Энэ өнөөдөр яг тэр нөгөө шатан дээрээ хүрч ирчихээд зогсч байгаа юм.Тэгэхээр бид нар өнөөдөр нэгнийгээ бууцалдахаар байхгүй үнэхээр боломжтой сайхан нөхцөлд оюун ухаанаараа цэц булаацалдаж байгаа буюу монгол улсынхаа хувь заяаг шийдэх гэж үзэлцэж байна.Тэгэхээр би оршил үгэндээ хэлсэн.Ялалтыг гай дагадаг юм.Энэ ялсан ялалтдаа хэт их хөөрцөглөхгүй юмсан.Үүний тулд дахин дахин ярихаас өөр арга байхгүй.Манайд нэг ийм юм болох гээд байх шиг байна.Ярихаа больё гээд тэгээд санал хураах гээд байна.Энэ чинь аюулд орж мэднэ.Тэгэхээр энэ БНМАУ гэхгүй гэж байгаа хүн болгон бүр бахаа ханатал гурав, дөрөв ярих ёстой.Энд цус урсаагүй, энд мөнгө урсч байна, яах вэ, дүүрч, ерөөсөө ярьж байж ойлголцох ёстой.

Манай залуучууд, манай хүүхдүүд их сайхан зоригтой байна.Ийм бололцоо гарсандаа бид зоримогхон шиг өөрчлөлт хийе гэж бодож байна.Энэ зүйтэй байх л даа.Тэгэхдээ ярьсаар байгаад, ярьсаар байгаад харилцан компромисс гэдэг юмуу харилцан буулт хийгээд эцсийн эцэст монголын ард түмэндээ ашигтай, нэг нэрэн дээр тогтох ёстой.Энүүнд цаг хайрлалгүй, мөнгө хайрлалгүй сайн ярья.Сайн ярихдаа нэгнийгээ доромжилж, нэгнийгээ гутааж яришгүй, хүндэтгээд "та", "эрхэм депутат" гэдгээрээ, манай парламент чинь сайхан тогтсон юмбайна шүү дээ.Тэрэн дээрээ ярья гэж бодож байна.Тэгээд энд онолын маргаантай юм байх юм.Хөдөөгийн бид нар болохоор бүгд найрамдах үгийг чинь бүгдээрээ найрамдах гэсэн үг ээ.Казах түмэнтэйгээ, буриад түмэнтэйгээ мон-

голчууд тэгээд бусад жижиг ястангуудтай бүгдээрээ найрамдана гэсэн үг. Тийм учраас бүгдээрээ найрамдан гэдэг үгээ авна гээд, Би бол ийм саналтай байна. Манай малчид тийм саналтай байгаа. Гэтэл онолтон манай эрдэмтэнгүүд болохоор тэр ямар лад байсан юм. Энэ чинь республик гэсэн үг ээ, орчуулга, энэ чинь засгийн тогтолцооны нэр. Тийм учраас бүгд найрамдах гээд эхэнд нь хийсэн учраас энийг хас гэх юм. Тэгэхээр бүгд найрамдах гэдэг монгол санаагаараа үлдээе гэж би бодож байгаа юм.

Ийм учраас БНМАУ гэдгийг өөрчлөх гээд байгаа энэ улсуудынхаа санааг ч өнөөдөр сонслоо, Элбэгдорж маань сайхан цагахан хэллээ. Энэ чинь цустай нэр. Энийн чинь нэрийн өмнөөс хайрхан сайхан улсуудыг минь буудсан нэр гээд хэлж байна л даа. Энэ чинь тийм юм байж л дээ. Гэхдээ энэ нэр буудсан юмуу, өөр хүн буудсан юмуу, энэ чинь одоо яах юм бэ? Энэ дээрээ улсынхаа эрх ашгийн үүднээс л бодохгүй бол Элбэгдорж тэрийгээ дахин дахин сайн яриг, гэмгүй. Тэгэж байгаад нийтээрээ энэ ярих юмыг хааж боож битгий үзээрэй, депутатууд минь гэж ингэж сайн хэлье. Тэгээд ярьсаар байгаад тохиролцоонд хүрэх байх гэж бодож байна.

Эцэст нь хэлэхэд парламентын нарийн горим байдаг юм байна. Бид мэдэхгүй юм. Тэр төсөл онгоноороо үлддэг, хажуугийн санал дэвшүүлсэн бид хэд хооронд нь булаацалдуулаад унавал тэр онгон юм үлддэг юм байна. Ингээд хоёрхон хувийн саналтай монгол нэр үлдэж магадгүй байгаа учраас Волатын саналыг дэмжиж гурван нэрээ мөн сайн санал шалгаруулж үзээрэй гэж гуймаар байна. депутатууд ч гэсэн БНМУ чинь бүтэхгүй бол БНМАУ-тай санал нэгддэг гэж байлаа. Энэ нэр чинь их учиртай, монголоороо үлдэхийн баталгаа даа. Баярлалаа.

105 дугаар тойргийн депутат Б. Чойжилсүрэн:

—Энэ хуулийг хэлэлцэхийн тулд депутат бүр маш их санаа тавьж чармайж байна. Ийм ажлын үр дүн хэзээд гардаг

юм аа. Тийм болохоор бид энэ Их эасаг гэж нэрлэдэг юмуу, эцсийн байдлаар ямар ч нэртэй болдог юм. Энэ хуулийг ямар ч гэсэн баталчих хэмжээнд ажиллаж чадах болов уу гэж дотроо бодож байгаа юм. Энэ хуулийг хэлэлцсэнээс хойш 10-аад хоногийн дотор асуудал бүрд их нухацтай хандсан боловч хамгийн чухал, ер нь төрөөгүй хүүхдээс өгсүүлээд одоогийн өтгөс өвгөд цаашдын ирээдүйн бүх амьдрал хувь заяаг тольдож харуулсан улс орныхоо нэрийн асуудал дээр хамгийн их цочирдож богино хугацаанд шийдвэрлэх шахлаа. Харин олон түмэн депутатууд та бүхэн их хухаалаг хандсан учраас энэ асуудлыг бид нар задалж өдий хүртэл үргэлжлүүлж ярьж байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн нэр, улсын нэрийг өөрчлөх асуудал байж болно. Энийг өөрчлөхгүй гээд хад, мод шиг хөшиж суух явдал бол одоо үнэхээр утгагүй юм. Гэхдээ улсын нэрийн асуудал бол улсын тусгаар тогтнолын асуудалтай холбоотой. Энийг холбоогүй гэж нотлох хэн ч байхгүй юм.

Ийм болохоор өөрийнхөө улс орны нэрийг тогтоох асуудал дээр манай депутатууд маш их ухаан гаргаж олон талаас нь бодож тунгааж үзэж байж энэ асуудлыг шийдэх хэрэгтэй байгаа юм. БНМАУ-ын сая 500 мянган кв. км газар нутаг дээр ямар ч хүн гэрээ авчраад барьчихдаг, модыг нь огтлоод түлчихдэг, газрын доорх баялгийг ашигладаг ийм байж үнэхээр болохгүй ээ. Энэ таарахгүй. Энэ дээр ямар ч заяагаар өдий хүртэл байж байгаа 2 саяхан хүн байна. Энэ 2 саяхан хүний хувь заяа бид нарын гарт өнөөдөр үнэндээ байна. Ирээдүй нь бид нарын гарт байна. Тийм учраас улсын нэрийг яаж өгөх вэ гэдгийг тал талаас нь тунгааж бодож үзэх явдал ялангуяа улс орны тусгаар тогтнолын асуудалтай тал бүрээс нь холбож бодох явдал илүү биш ээ. Энэ бол монголын бүх хүний, ялангуяа Ерөнхийлөгч хүртэлх хүний тархи толгоог эзэмдсэн хамгийн нэг номерийн асуудал байх аа гэж бодож байгаа.

Хуулийн төслийг уншаад үзэхэд ер нь улс орны тусгаар тогтнолтой холбогдолтой бусад асуудлууд нэг л суд,

нэг л чөлөөтэй, хэн ч ирээд байшингаа барьчихдаг, хэн ч газрыг хөлслөөд үнэлээд авчихдаг, хэн ч баялгийг ухаад авчихдаг байдаг юмуу ийм маягаар тусгагдах өнгөтэй ийм юмнууд их байна.

Тэгэхээр ганцхан нэрийн асуудалтай холбох төдийгүй ер нь тусгаар тогтнолтой холбогдолтой бусад асуудлууд дээр манай депутатууд ихээхэн анхаарал тавьж ажиллах шаардлагатай байна гэж үзэж байна. Энэ нэрийг хэлэлцэх асуудал дээр БНМАУ, БНМУ, Монгол Улс гэсэн энэ гурван нэрийг гурвуулангий нь хэлэлцүүлээд тэгээд хамгийн бага санал авсныг хасаад дараагийн хоёр нэрийг хэлэлцүүлээд тэрэн дээрээс гарсан мэтчилэнгээр өчигдрийн хэлэлцүүлж ирсэн дэг журмынхаа дагуу асуудалд хандах ийм саналыг оруулж байна. Энэ дээр ийм санал хураалт явуулж өгөөч гэж бодож байна.

Би энд Монгол улс гэсэн санал дээр байгаа хүмүүсүүдийг тунгааж бодож яагаад Монгол улс гээд нэрлэх гээд байгаа билээ. Энийгээ бодох хэрэгтэй. Энэ монголчуудыг нэгтгэх, нэгдсэн том гүрэн байгуулах ийм санаа байгаа. Энэ одоохондоо манайд хэрэгжихэд хүнд байгаа шүү. Энийг бодох хэрэгтэй. Чөмөггүй мөртлөө туг ширээ гэж үг байдаг. Одоо өвгөд маань тэтгэврээ авч чадахгүй байна. Хүүхдүүдэд эм олохгүй, сүү олохгүй ядарч байна, өлсөж байна. Өмсөх хувцас байхгүй байна. Ийм нөхцөлд энэ зарцуулах төгрөгөө харин зарцуулж жаахан аргалж янзлах юм биш үү. Улсын нэрийг өөрчлөх, солих асуудал монголчуудын гарт байна. Ийм учраас НҮБ-д бүртгүүлсэн БНМАУ гэсэн энэ нэрээ хэсэгхэн хугацаанд хадгалж авч байвал яадаг юм бэ? Энэ бидэнд өлзийтэй юм биш биэ дээ. Энийг тал бүрээс нь тунгааж үзэхийг та бүхнээс хүсч байна.

59 дүгээр тойргийн депутат Ч. Цэрэвдорж: -Би бол, миний хүслэн бол монгол улс гээд нэрлэчихмээр байна л даа, дотроо бол тэгэж хүсч байна, бүгд л тэгэж бодож байгаа байх. Гэтэл энүүнээсээ ухрах учир шалтгаан байна.

Му гэхээр энэ олон улсуудын гаргаж байгаатай үндсэндээ санал нэг байна. Энэ дээр хамгийн гол нь тусгаар тогтнолын асуудал дээр би эргэлзэж байна. Нагаад тэгэх үндэс байна вэ гэхээр, бид өнөөдөр энүүнийг нэг тийм улс орон өөрийнхөө нэрийг сольчихлоо, үнэндээ коммунист дэглэмтэй явж байсан улс орнууд бол өөрийнхөө нэрийг сольчихлоо. Тэд нартай зэрэгцүүлээд өөрсдийгээ тавихад газар нутгийн болоод хүрээлж байгаа байдал, олон жилийн туршид явж ирсэн энэ байдал, явж ирсэн бодлогыг аваад үзэхэд арай адилтгаад тавьж болмооргүй бодогдож байгаа юм.

Му гэхээр, надад, үнэн худал нь мэдэгдэхгүй ийм мэдээ байна л даа, улсууд олон мэдээ гаргаж ирж байх шиг байна, баримтууд. Тэгэхээр өнөөдөр Хятад коммунист нам төрийн эрхийг барьж байгаа. Энэ коммунист нам бол 1930-аад онд бол Өвөрмонголын тусгаар тогтнолыг бол Японы эсрэг хэрвээ ажиллах юм бол тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрнө гэж хэлсэн байдаг, жишээтэй. Тэрнээс хойших үйл явдлуудыг бид нар аваад үзэж байхад бидний харьцаа ямархуу байж байхад, харьцаа муудаж байх тэр нөхцөлд ямар байдалтай байж байсан билээ гэдгийг бид дөнгөж саяны зүйлүүд учраас тэрнийг мэдэж байна.

Тухайлбал, манай хоёр орны хооронд хилийн хэлэлцээр байж байсан явдал бол ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан, манай байдал бол хэвийн байлгах гэж. Ийм баримт бичиг байж байсан явдал. Гэтэл Хятад манай орныг өнөөдөр энэ нэрээр хүлээн зөвшөөрсөн байж байгаа. Би БНМАУ гэдэг энэ их урт алдартай нэрэндээ дурлаад байх үнэхээр сонирхол алга л даа. Гэхдээ энэ нэрээр хамгийн гол нь хүлээн зөвшөөрсөн байж байгаа. Энэ байдлаас нь аваад үзэхэд бид нар чинь өөрсдөө хэрүүлийн алим тарьчих гээд байгаа юм биш биз дээ, арай. Ийм юм гараад ирэх үндэслэл байдаг юм биш байгаа гэж бодож байна.

Өөр нэг санаа зовж байгаа зүйл бол хятад хүн гэдэг бол монгол, өнөөдрийн биднийг бодоход өнөөдрийн хятад



хүн бол ихээхэн хятад хүн хэвээрээ байж байгаа. Бид чинь түүх түүхээ, өвгөд дээдсийнхээ захиасыг, дэргэд чинь ямар хүн байдаг вэ гэдгийг өөрийн биеэр ч үзээгүй, түүх судраасаа ч олж хараагүй иймэрхүү байдалтай байж байгаа. Тэгэхээр энэ хүчин зүйлүүдийг харгалзаж үзээд ямар ч байсан өөр тусгаар тогтнол хүлээн зөвшөөрөөд байгаа энэ байдлуудыг жаахан харгалзаж үзэмээр юм шиг ингэж бодогдож байгаа юм.

Тэгээд БНУ гэж нэрээ хоёрын хооронд солиод эндээс юу гарахгүй байх л даа гэж бодож байна. Соливол солиод ард талынх нь ямар юу ирдэг юм, хэрвээ солихгүй байх юм бол энэ нэрээрээ явах нь ямар ч байсан хэдэн жилдээ энэ улс төрийн бодлого байдал өөрчлөгдтөл хэдэн жилдээ хэрэгцээтэй болов уу гэж бодогдож байгаа юм.

Нөгөө талаар энэ улсуудын гаргаж ирээд байгаа хүчин зүйл байж байгаа. Энэ хүчин зүйл бол өнөөдөр бидний очоод одоо уулзаад ярихад ч гэсэн ярьж байгаа. Бид бол монголчууд та нарыг харж байна шүү. Та нар бол гал голомтон дээр байгаа улсууд шүү гэдэг ийм үгийг цэвэр иргэнийхээ шугамаар ч хэлдэг. Энэ бол тийм бодолтой, олон монголчууд байж л байгаа байх. Энэ хүчин зүйлийг хүртэл харгалзаж үзэх нь зүйтэй болов уу гэж бодогдож байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж. Уртнасан -3 дугаар микрофон.

145 дугаар тойргийн депутат Лантуу -Үүний өмнө депутатууд Бүгд Найрамдах гэсэн хоёр үгийг байх тухай, үлдээх тухай гадаад, дотоодын олон шалтаг шалтгаануудын талаар тодорхой ярилаа. Энэ депутатуудын ярьсан зүйлийг би нэгдүгээрт дэмжиж байна. Нэгд хэлэхэд бол НҮБ-ын дэргэд БНХАУ-ын хүн ам ямархуу янзын байдлаар яаж өсөж байна вэ гэдгийг судалдаг тусгай институт байдаг гэж байгаа юм. Энэ институтийн судалснаар Хятад хэрвээ миллиард 500 сая болбол хятадын газар нутаг өөрийгөө ард түмнийг даахгүй гэсэн ийм чиг баримжаа гаргасан байгаа. Хятадын хүн ам өнөөдөр барагцаалбал 20 орчим сая ийм хүнээр жил тутам өсөж байна. 20-иод сая хүнээр. Ингээд бодоход удахгүй энэ тоо гарч ирнэ ээ. Хятад өөртөө бол хатуу бодлого явуулж байгаа. Тэгэхдээ үндэсний цөөнхдөө бол арай хөнгөвтөр, би саяхан Хятад яваад ирлээ. Тэнд нөхдүүл ярьж байгаа нь юу байна вэ гэхлээр хөдөөд байж байгаа <sup>оур хөдөөд байгаа</sup> малчин, тариачиндаа арай өөр байдлаар хандаж байгаа юм байна. Хөдөөд мөртлөө хот сууринд байж байгаа хятадад бусад үндэстэн хятад биш үндэстэнгүүдэд хуучин үзүүлж байсан хөнгөлөлтөө больж байгаа юм байна. Хэдийгээр ийм байлаа ч гэсэн хятадын хүн ам маш түргэн өсөж байна. Нэгэнт газар нутаг нь даахаа боливол энэ орон газар нутгаа тэлэх буюу өөр бусад арга хэмжээ авна гэдэг нь зайлшгүй асуудал юмаа. Тийм учраас бид бол ер нь өөрийнхөө хил, тусгаар тогтнолын ас тухай асуудал бол манай орны хувьд бол энэ хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий гэдэг шиг хоёр том гүрний дотор байж байгаа ийм жаахан орны хувьд бол бид үнэхээр их болгоомжтой, үнэхээр буурь суурьтай, алсын хараатай хандах ёстой зүйл гэдгийг нэмж хэлмээр байна аа.

Энэ дээр голчилж ард гэдэг үгийн талаар ярих гэсэн юм. Тэр түрүүчийн депутатуудын хэлдэгээр би үнэхээр Монгол улс гэж байвал зүгээр юм гэж боддог хүний нэг нь. Гэхдээ яг өнөөдөр бол БНМАУ гэж байх нь үнэхээр зүйтэй байна гэж үзэж байгаа.

Ялангуяа ард гэдэг үгийг авч хаях явдал буруу юм гэж үзэж байна. Яагаад вэ гэвэл ард гэдэг чинь хэдийгээр ангич шинж чанартайгаар энэ Үндсэн хуульд орсон гэж манай зарим нэгэн **нөхдүүд** тэр үеийн хүмүүсүүдийн ярьсан, сэтгэсэн энэ зүйлүүдээс иш татаж ярьж байгаа ч гэлээ гэсэн ард гэдэг чинь хувьсгалын өмнө ч гэсэн, хувьсгалын дараахан ч гэлээ гэсэн, өнөөдөр ч гэлээ гэсэн энэ чинь малчин хүмүүсүүдийг хэлж байгаа юм. Тэгэхдээр ардыг авна гэдэг чинь малчныгаа авна гэсэн үгээ. Малчин гэдэг чинь та бидний нүдэнд орсон мод бол бишээ. Энэ бол монголын ард түмэн. Ийм учраас бид очоод малчид хөдөлмөрчиддөө ард гэдэг үгийг чинь аваад ирлээ гэвэл малчин гэдэг та нөхдүүдэд хэрэггүй болжээ гэсэнтэй ижил утгаар яригдах юм. Ингэж асуух юм болбол энэ үгэнд чинь хэн, яаж хариулж өгөх юм бэ. Хэн ч хариулж өгөхгүй. Улс гэдэгт нь багтаж байгаа юмаа гэж. Тэгэхлээр ард гэдэг үг чинь ерөөсөө бид нар чинь та нарт илүү санагдсан юм байна, илүү хүмүүсүүд байна аа гэдэг ийм ойлголтыг ард түмэнд төрүүлэх юм шүү. Ийм учраас ард гэдэг үг бол заавал байх хэрэгтэй гэж бодож байна.

Хоёрдугаарт, тэр түрүүн эдийн засгийн талаар нөхдүүд маш тодорхой ийм зүйлүүд ярьж байна аа. Үнэхээр энэ бол 10 хэдэн сая төгрөг биш байх аа. Энэ олон зүйлүүд байгаа. Тийм учраас энэ дээр юу гэж хэлэх гэж байна вэ гэхлээр ард гэдэг үгийг авлаа л гэхэд сүлд тэр чигээрээ өөрчлөгдөнө шүү. Тийм учраас энэ бол эдийн засгийн үнэхээр чухал асуудал фактор байгаа учраас сүлдийг ч ярьсан тэр, БНМАУ-ыг ч ярьсан тэр, өнөөдөртөө хэвээр нь үлдээх ийм саналтай байна. Эцэст нь хэлэхэд гурван нэр байгаа. Энэ гурвуулангий нь оруулж өгмөөр байна. Олон улсын парламентын хууль гэж, дүрэм гэж тусдаа юм байхгүй ээ. Тийм учраас бид монгол хууль хэлэлцэж байгаа, монгол хүмүүсүүд учраас монголынхоо журмаар явъя, гурван нэрийг гурвуулангий нь зэрэг хэлэлцүүлэх нь зүйтэй.

Ж. Уртнасан -5 дугаар микрофон.

240 дүгээр тойргийн депутат С. Цэрэв -Би энэ Их хурал дээр хүмүүсийн ярьж байгааг ойлгож байна аа. Манай Их хуралд

олон эрдэмтэн, мэргэжилтэн депутатууд нилээд ойлгоцтой үүнийг ярилаа. Миний хувьд бол энд ирэхдээ БНМАУ-ын Үндсэн хуулиа батлах гэж яваа гэж ойлгож байгаа. Би өөрөө ч гэсэн хөдөө байгаагийн хувьд хөдөө байгаа малчидтайгаа адилхан боловсролтой, тэрний олонхитой адилхан ийм хэмжээний хүн. Бидний ойлгож байгаагаар бол улсынхаа Үндсэн хуулийг батлах гэж байгаа гэж ирж байгаа. Тэгээд Үндсэн хууль дээрээ бид ярьж байгаад өөр хувилбар гаргах шиг боллоо. Тэгээд би хэдэн өдрийн урдаас асуусан. Энэ БН гэдэг үгийг яагаад авах болсон юм бэ, ард гэдэг үг нь юугаараа саад болоод байгаа юм бэ гэдгийг. Энийг ойлгоод үнэхээр авчих ёстой юм бол аваад очоод сонгогчидцоо хэлбэ гэсэн ийм бодолтой суусан. Гэтэл энүүнд заавал авах баталгаа байхгүй юм шиг санагдаад байх юмаа. Үндсэн хууль гэдгийг нэргүй юмаа. Үндсэн хууль бол үндсэн нэр ээ гэсээр байгаад өөр нэр өгнө гэж байгаад өнөөдөр бараг шийдэх шиг боллоо. Тэгвэл БНМАУ гэж бусад монголоос ялгаж байсан энэ нэрийг өнөөдөр авч хаях гээд байх юмаа. Нэгийг нь болохоор нэрлэсэн, тодотгосон нэртэй байлгая гээд байдаг. Нэгийгээ болохоор алга болгох гээд байдгийн учир чухам юундаа байдаг юм бол оо. Ийм учраас би БНМАУ гэсэн энэ нэрийг хэвээр нь байлгах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг алга болгох тийм тоймтой баримтыг энэ дотор сууж байгаа, энэ олон дахин босож байгаа энэ эрдэмтэн, энэ мэргэжилтнүүдийн хэлж ярьж байгаа, энэ хуульчдын хэлж ярьж байгаагаас үнэхээр болохоо байсан юм гэж миний тархинд, толгойд тусахгүй байна. Тийм учраас би энэ нэрийг хадгалах хүсэлтэй байна.

Ж. Уртнасан -6 дугаар микрофон.

413 дугаар тойргийн депутат Насан-Очир -Тэгэхлээр манай эрдэмтэд, Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс, Улсын бага хурал шинэ Үндсэн хуулийн төслийг чамбай боловсруулжээ гэж үзэж байна. Энэ дотор эсэх ч юм байлгүй яахав, залруулах ч юм бий, тодотгох ч юм бий. Тэгэхдээ энэ дээр хэд хэдэн 10-аад зарчмын асуудал байгаа. Тэрний дотор Үндсэн хуулийн нэрийн асуудлыг түрүүн шийдлээ. Одоо энэ улсын нэр, сүлд, туг далбаа гэхчилэн хэдэн асуудал байна. Ингэхлээр сүүлийн хоёр жилд манай улсын хэмжээн дээр маш олон өөрчлөлтүүд гарч байгаа. Үүний нэг нь

нэр хаяг өөрчлөх, солих асуудал аа. Одоо бараг 89 оны сүүлчээр байсан байгууллага тэр хэвээрээ, хаягаараа байгаа байгууллага байхгүй болсон байх. Ер нь олон байгууллагын хаяг, аж ахуйн нэгжийн хууль ч гарсантай холбогдуулж янз янзаар өөрчлөгдөж байна. Ер нь олон ч уг бол албан хэрэгцээний уг ч гэсэн монгол дээр бууж өөрийн гэсэн болж байна. Энэ сольдог сольдог юмаа гэхэд монгол улсынхаа нэрийг солих эрхийг манай ард түмэн бидэнд өгөхгүй байх, ийм эрх ч бидэнд байхгүй байх гэж бодож байна. Төр улсаараа төглөх болсон хэрэг болно. Сольдог дээрээ тулбал бүх ард түмний асуулга явуулах нь зүйтэй байх аа гэсэн саналыг би бас дэмжиж байна аа.

Энэ улсын нэр солихтой холбогдуулж гадаад орны туршилагыг ч гэсэн бид бодох хэрэгтэй. Жишээ нь Герман улс нэг хотынхоо нэрийг солиход өнгөрсөн жил I сая дойч марк орсон гэж мэдэх хэмжээний хүмүүс нь ярьж байсныг ч гэснийг сургамж авах байх аа гэж бодож байна. Нэр солино гэж, Монгол улс гэдэг нэр бол манайд байвал зохих нэр гэдгийг би бас бодож байна. Гэлээ гэхдээ үүнийг солих эдийн засгийн хүч чадал, ард түмний сэтгэл санааны бэлтгэл хангагдаагүй байх аа гэж үзэж байгаа юм. Нэр солино гэдэг бол эдийн засгийнхаа талаас гарах зардлаасаа гадна ард түмний оюун санааны их хэмжээний гомдол ч гэдэг юмуу, таалагдахгүй, төр засагтаа итгэл алдах явдал гарч магадгүй гэж бодож байна.

Манай улсын талаар ч гэсэн урд их гүрэн маань сүүлийн үед тааруухан яриатай болсон гэж байгаа. Энэ бол Өвөрмонголын нөхөд, очсон хүмүүст та нар минь маниар битгий оролдооч, их гүрнээс үзүүлэх дарамт, янз бүрийн зүйл элбөгшиж байна гэсэн жирийн ярианууд байгаа. Үүнийг ч гэсэн бас бодууштай зүйл байх аа гэж бодож байна. Ард гэдэг нэрээ авах юм бол Монгол Ардын Нам бол бараг дэмжигдэхгүй байх гэж бодож байна. Энийг ч гэсэн бас бодох зүйл байх аа гэж бодож байна. Ингээд манай депутатууд бас уг хэлсэн завшааныг ашиглаж хэлэхэд гуйвж дайвахгүй, өөрийн бодолтой саналаа өгмөөр байна. Үүнийг

баримтан дээр хэлэхэд хаалттай хуралдаан хийе гэхэд 86 хувь нь эхнийхээр өгч байснаа гуравдахь санал хураалт болоход 42 хувь болоод буучих юм. Хэн л томоохон уг хэлнэ вэ тэрнийг дагаад гуйвж дайваад байна. Энэ бол төрөөрөө тоглох, төрийн депутат хүнд байж болзошгүй зүйл гэж үзэж байна. Ер нь одоо дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олдоггүй гэж манай их хуралдаа намбатай, төрхтэй, зарчимтай, шүүмжлэлтэй, болохгүй бол улсын хэмжээн дээр дэг журам тогтооно, сахилга бэхжүүлнэ гэсэн яриа бол лоозон болж хувирах байх шүү нөхдүхд. Үүнийг өргөн олон түмэн харж байгаа. Энд тэнд очоод яриа хийхлээр та нар хуралдаан дээрээ тэгдэг юм байна лээ, бид яадаг юм бэ гэхэд ам таглагдах дээрээ хүрэх нь байна шүү гэдгийг бодоосой гэж бодож байна. Ингээд бид улсынхаа нэрийг сольчихоод, тэгээд сүлднээсээ морио авчихаад ингээд буцах юм бол лав л миний хувьд харих сонирхол, сэтгэл ч алга байна гэж бодож байна.

БНМАУ гэсэн саналыг хатуу дэмжинэ, үүнийг би нөхөдтэйгөө зөвлөцөн ярина гэж хэлье.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



/Д.БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбил

За 23,24 дэх хүн үг хэлэх гэж байна. Үүнийг анхаарна уу.

374 дүгээр тойргийн депутат Т.Санжаа: Улсын нэрийг шийдэхэд их ул суурьтай, ухаалаг хандаж шийдэх нь зүйтэй гэсэн ийм бодол байна.

БНМАУ гэсэн нэрийг өөрчилвөл миний санаа эмээглэж зовж байгаа нэг зүйл бол улсын маань тусгаар тогтнолд агуул занал учрахвий гэсэн ийм бодол байгаа юмаа.

Хоёрдугаартнь БНМАУ гэсэн нэрийг өөрчлөх ийм эдийн засгийн бололцоо нөхцөл муу байна, улсын эдийн засаг муу байна, ард түмний аж амьдрал, соёлын хэмжээ муу байна, ноднигоос энэ жил бараг муудсан байна. Энэ бүх асуудалтай холбогдож их хэмжээний зардал гарах ийм даацыг бид бодолцож үзэх хэрэгтэй юм гэж ингэж бодож байна. Энэ улсын нэрээс ард гэдэг нэрийг хассанаар энэ ач холбогдолтой боллоо гэж монголын ард түмэнд ойлгогдохгүй байх. Монголын ард түмэн бол ер нь бид бол цөм ард түмнээс гаралтай, бид цөм монголын ард түмэн гэж ингэж бодож байгаа юмаа. Ингээд улсын нэрийг өөрчлөхгүйгээр БНМАУ гэсэн энэ нэрээр шийдэж тогтох нь зүйтэй байна гэсэн ийм санал байна. За энэтэй холбогдуулаад хурлын даргад, аппаратад санал тавихад гурван нэрээр тус бүрд нь санал аваад тэр гарсан саналын хамгийн бага саналтай нэрийг хасаж сүүлийн хоёр үлдсэн нэрээр одоо саналыг шалгаруулж ингэж шат дараалж санал авах нь зүйтэй байна гэсэн ийм санал байна. За энэ гурав нь БНМАУ, Монгол улс, Бүгд Найрамдах Улс гэсэн энэ гурван нэрээр авч шалгаруулж тогтоох ийм саналыг дэвшүүлж байна. Үүнээс гадна энэ микрофон дээр үг хэлж, саналаа гаргах энэ асуудалд оролцогчгүйгээр хурлыг шуурхайлахын тулд зарим депутатууд бичгээр саналаа өгье, түүнийг харгалзаж цөөнхийн саналд тооцож өгөөч гэсэн ийм хүсэлт байгааг бас дамжуулъя гэж бодож байна.

Уртнасан:

Тэгэхээр зөв л дөө бид нар аваад түрүүчийг нь хэвлэлд өгчихөөд нийтэлж байгаа шүү.

410 дугаар тойргийн депутат Л.Баатарсүрэн: Би энд улсын нэр дээр нэг санал хэлье. За зүгээр манай хурлын уур амьсгал ийм юм яригдаад байгаа. Онолын өндөр түвшингээс нэг хэсэг нь ярьж байна, нэг хэсгийг нь ердийн ухамсрын түвшингээс ярьж байна гэж. Ийм нэг юм бие биенийгээ шүүмжлээд байгаа. Энэнд бол би энэ дээр ердийн ухамсрын түвшингээс нь нэг сонгогч өвгөний-хөө хэлсэн үгийг дамжуулъя. Энд бид наашаа явахынхаа наана уулзалт хийж байсан нэг өвгөн орж ирээд улсын нэрийн тухай асуудал яриут л гэв гэнэтхэн босчирээд бөхийн цол дуудлаа. Бүрэн эрхт бүгд найрамдах монгол ард улсын гээд, дархан аварга Бат-эрдэний-хээ нэрийг оруулаад бөхийн цолыг нэлээд урт дуудчихаад эа ийм байгаа юм, дараа нь улсынхаа нэрийг өөрчилчихөөд ирвэл депутатаа би гээд Монгол улсын гээд эхлэх гэсэн чинь эхэлж чаддаггүй ийм байна ард түмэн, тэгвэл улсынхаа нэрийг өөрчлөөд ирэх юм бол ирэх жил бид сум, улс, аймаг, сум наадмаа хийж чадахгүй, бөх, морь хоёроо л лав цоллож чадахгүй нь байна. Энийг эрхэм депутатуудад хэлээрэй гэсэн юмаа. Энийг би зүгээр ердийн ухамсрын түвшингээс хэлье. Энийг зүгээр та бүхэн тунгааж үзнэ биеэ.

За ингээд энд нэг зарчмын нэг, энэ дээр миний санал бол улсынхаа нэрийг хэвээр нь байлгая гэсэн санал байна. Энэ дээр зарчмын нэг хоёр саналыг хэлье. Энд цахим тоолуур дээр депутатуудаас санал авахад зөвхөн хоёрхон зүйл дээр, тухайлбал улсын нэр дээр санал хураахад 33 хүн түдгэлзэж байх юм. Энэ чинь одоо юу гэсэн үг вэ. Сонгогчдоо очоод би Монгол улс, улсаа би нэргүй болгочихоод ирлээ гэж хэлэх юм болж байна уу. Энэ дээр бодмоор байна. Улсын нэр хурааж байхад чинь түдгэлзэнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ. Очоод тэр хүн юу гэж хэлэх юм бэ. Ийм юм бодогдож байна, ийм шүүмжлэл хэлье гэж. Монгол улс, БНМАУ, Бүгд Найрамдах Монгол Улс гэсэн 3 санал дээр хүртэл дунд нь 30, 40 хүн түдгэлзээд байх юм, нэргүй болгох гээд. Ийм туйлбаргүй байр суурь битгий бариарай. Дараа, дараагийн энэ улсын нэрээр санал авах дээр нэрээр нь аваарай гэж улсууд хэлээд тэр цахим тоолуур дээр нэрээрээ гарч байгаа биз. Үнэхээр тийм улсын нэр дээр түдгэлзсэн хүн байх юм бол улсынхаа нэрийг арччихаад очсон тэр депутат харин сонгогчдоодоо юу хэлэх вэ. Энэ бол харин, одоо ёстой харин сонин, монин дээр тавьж болох ийм асуудал байхдаа гэж энийг хэлж болж байна.



3.

Өөр нэг зүйл бол энэ санал бол ерөнхийдөө 3 жигүүрт хуваагдлаа. Саналаа ер нь хураахад болж байх шиг байна. Энэний өмнө нэлээн маргаантай асуудлыг шийдэхдээ эвсэл холбоодууд нэг завсарлага аваад асуудалд эргэж хандсан нь нэлээд оновчтой болов уу гэж үзэж байна. Тийм учраас санал нэлээн төвлөрөөд ирдээ. Энэний өмнө санал авахдаа мөн депутатуудын бүлгүүд түр завсарлага аваад эргээд саналаа өгвөл яасан юм бэ гэсэн нэг ийм зүйл байна.

Санал төвлөрч байна. 25 хүн үг хэллээ. Одоо санал хураалтанд бэлтгэвэл ямар вэ.

Санал хураалтанд бэлдэхэд би нэг ганцхан үг хэлье. Санал хураалттай холбогдуулж.

Хурлын даргаа. Горимын ганцхан санал байна. Горимын санал.

Уртнасан: Уучлаарай депутатууд бидэн дотор байгаа эмэгтэйчүүдээ хүндэтгэж дараалалгүй яриульч гэсэн. Энхтуяа депутатыг 7 дугаар микрофон дээр урьж байна. Энхтуяа депутатын саналыг сонсоё.

Депутатууд суудалдаа сууж санал хураалтанд бэлтгэнэ үү.

Юуны өмнө намайг дугаарынхаа өмнүүр оруулж, тэгээд бас үг хэлэх зөвшөөрөл өгсөн та нөхдөд их баярлалаа.

Би богино ухаантай бүсгүй хүн буруу ярьчихаж, буруу бодсон байж магадгүй. Хэрэв тийм бол та бүхэн миний алдаагийг минь засна биз. Зүгээр яахав энэ Монгол улс, БНМУ, БНМАУ гэж энэ гурван нэрийн алийг ч хэлсэн онцын ялгаагүй юм байна л даа. Бид нар энэ дээр гурав хуваагдаад цөм болох талаас нь зөвшөөрч байхыг бодоход гурвуулаа л ялгаагүй юм байна. Нэгэнт гурвуулаа ялгаагүй юм шиг харагдаж байгаа нөхцөлд хамгийн ашигтай хувилбарыг нь сонгож авбал яасан юм бэ гэж бодож байна. Тэгэхлээр юуны өмнө ямар ч гэмгүй гэдэг юмуу, ямар ч харшлах шалтгаангүй байгаа энэ БНМАУ гэсэн таван үсгийг оролцоод яахав дээ гэсэн нэг ийм бодол төрж байна. Өнөөдөр манай хууль хулгайч, дээрэмчнээ айлгаж чадахгүй, харин хулгайч, дээрэмчнээсээ ард иргэд маань айгаад

төр ч төртэй, хууль шиг хуультай болох юмсан гэж бодож хүлээж сууж байгаа энэ нөхцөлд бид хамгийн гол чухал юман дээрээ нухацтай хэлэлцээд, онц шаардлагагүй байгаа ийм зүйлсээ санал нэгтэй өнгөрөөгөөд, заавал солих шаардлагагүй юмаа хэвээр нь үлдээвэл яасан юм бэ гэж бодож байна. Ер нь гэмий нь хяргаагүй байж үсийг нь хяргаад яахав, сэтгэлийг нь хурцлаагүй байж, биеийг нь хурцлаад яахав гэдэг үг байдаг. Төрнээс гадна бас өнгө зүсээ тордох гэж эхлээд гүйх юм бол үхэх болгон нь муурийн сүүлээр тоглосонтой ижилхэн болно ч гэдэг үг байдаг. Ер нь ингэж өнгө зүсээ эхлээд тордоод ардчилал хийсэн, өөрчлөн байгуулалт хийчихсэн юм шиг ийм байдал, ийм хуурамч баг хичнээн өмсөөд ч бидний ядуу зүдүү өнөөдрийн энэ байдал бол хэвээрээ үлдэнэ. Би энэ хэт хувьсгалч нөхдөөс бол айж болгоомжилж байна. Ардын хувьсгал яахав эхлээд зөв л байсан байх, нэг нийгмийг нөгөөгөөр сольсоныхоо хувьд дэвшил болсон. Ардын хувьсгалын нэр хүндийг хэт хувьсгалчид нь арчаад хаячихсан. Түүн шиг ардчилал маань хэдийгээр зөв болсон ч гэсэн бас хэт хувьсгалч нөхдүүд ардчиллын нэр хүндийг арчичихвий гэж айж байна. Намуудын хоорондын тулалдааны талбар болгож Их Хурлыг маань одоо үймүүлж байгаад бас их эмзэглэж байна. Нууцыг байхгүй болгоно гэж байгааг би зөвшөөрөхгүй байна. Нууцгүй байх юм бол угаасаа төр гэж юу байхав. Бид сайн мэдэж байгаа. Өнгөрсөн жил Коммунист намыг илчилж Содном гуайг гэмт хэрэгтэн болгох гээд л Монгол улсыг өрөнд оруулсан гэж жаал шуугисан. Тэгээд л хоорондоо бие биенийхээ дундаас дайсан илрүүлэх гээд бид нарыг хэрэлдээд эхлэхэд нэг л өдөр зөвлөлтийн хэвлэлд өрний тоо гарчихсан шүү дээ. Төрнийг хэн ч бодсон юм бүү мэд. Тиймэрхүү маягаар бие биенийгээ устгахаа боливол яасан юм бэ. Шуудайд хийсэн үхрийн эвэр шиг байхаа боливол яасан юм бэ. Энэ өөрчлөх шаардлагагүй юмыг өөрчилж хөрөнгө мөнгө үрэхээ боливол яасан юм бэ. Минхэнэ өөрчлөн байгуулалтаа хийхийн оронд ингэж ард түмнээ хуурах хэрэггүй юм бишүү гэсэн ийм л санал хэлэх гэсэн юм.

#### Уртнасан:

Цөөхийн саналыг таслая гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

26 хүн үг хэлсэн байна. Эрхэм депутат аа.

Та бүгдийг суудалдаа сууж санал хураалтанд оролцохыг урьж байна.

Цөөнхийн саналыг таслая гэсэн томъёоллоор санал хураалт явууллаа.

Уучлаарай микрофоны дарааллаар явсаар байтал ийм боллоо. 26 хүн үг хэллээ.

Танхимаас: Бид дэгээ л сайн баримаар байна.Хэн хүнгүй.

Нийт депутатуудын 340 нь буюу 91 хувь нь санал таслая гэсэн санал ирүүлээ.29 хүн буюу 8 хувь нь татгалзаж, 5 хүн түдгэлзлээ.374 хүн санал хураалтанд оролцсон байна.

Цөөнхийг хүндэтгэж цөөнхийн саналыг сонслоо.

Одоо бидэнд хоёр хувилбар байна.Та бүгдийг... Уучлаарай. Хажуугийн санал 2 хувилбар байна.Сая үг хэлсэн хүмүүсээс гурван хүн шалгаруулах санал хураалт явуулъя.Монгол улс гэдэг нэрийг оруулаад гурвуулангий нь шалгаруулаад дараа нь үлдсэн хоёр дээр нь дахин санал хураалт явуулаад шийдвэл шударга болноо гэсэн.Энэ саналыг бид маргалдахгүйн тулд энэ томъёоллоор үлдээж байна.Дахин анхааруулъя.Бид БНМУ, БНМАУ, Монгол улс гэсэн гурван томъёолол дээр санал хураана.Депутатууд та бүгдийг төөрөхгүй байхын тулд нэг л өөрийнхөө тогтсон нэр дээр саналаа өгөхийг хичээнгүйлэн гуйж байна.Тэгэхгүй бол будлианд орно.

Уучлаарай.Томъёоллоо хэлье.Одоо БНМУ гэсэн томъёоллоор санал хураалт явуулж байна.

Та бид томъёоллоо оруулахдаа эхлээд БНМУ, БНМАУ гэдгээр санал хураалт явуулаад 2-уулаа цөөнх болсон шүү.Үүнийг дахин анхааруулъя.

Сая саналын дунд гурван депутат шалгаруулах санал хураалт явуулъя.Өчигдрийн Болатын зарчмыг баримтлая гэсэн надад бичгээр ч ирсэн байна, амаар ч зарим депутатууд хэллээ.Үүнийг бид анхааран үзээд шалгаруулах санал хураалт явуулъя.Эрхэм депутатуудаа.Тайван байна уу.

Уучлаарай.Томьёоллоо дахин халж байна.Уучлаарай.Тэгвэл дахин санал хураалт явуулъя.

Шалгаруулах санал хураалт явуулъя гэдэг томьёоллоор санал хурааж байна.Шалгаруулах санал хураалт явуулъя.

Цөөнх болоод саналаа хэлж болно.

За уучлаарай.Бага Хурлын эрхэм гишүүд татгалзаж байна. Тэгэхдээ бид бас танхимын уур амьсгалыг мэдрэх ёстой байх. 392 депутат санал хураалгасны 333 нь буюу 85 хувь нь БНМУ гэдэг дээр санал өглөө.

Соронзон хальстай тулгаж нийлсэн

*В.Ошун*

ЭНХТҮЯА

Бичээч В.Ошун

Ж.Уртнасан -Шалгаруулах санал хураалт явуулъя гэсэн, уучлаарай.Шалгаруулах санал хураалт явуулъя гэдэг дээр өгч байна.

Хуулийг оруулж байгаа Бага Хурлын даргын үгийг сонсох нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Р.Гончигдорж /Улсын Бага Хурлын дарга, 56 дугаар тойргийн депутат/ -Горимын санал хэлье.Монголынхоо бидний мэддэг юмаар ярихад буруу морь уралдуулах гэж байна.Шалгаруулна гэдэг маань уралдуулна гэсэн үг мөн биз.Мөн.Хоёрыг нь сойлго уяагий нь тааруулчихлаа.Саяын ярьсан улсууд хоёр дээрээ л ярьсан шүү дээ.Монгол улс гэдэг тэр бэлчээр дээрээ явж байна.Тэгээд л уралдуулах гэж байна.Тэгээд л уралдуулбал уралдуулсугай, уралдуулахгүй бол өөрсдөө мэдсүгэй.Ийм л зүйл.

Улсын Бага Хурлаас энэний тухай юу гэж оруулсан тухай ерөөсөө албан ёсных нь юмыг нарийвчилж сонсоогүй байгаа.Яриулалгүйгээр яаж байна шүү дээ.Өөр ярих юм алга.Баярлалаа.

Ж.Уртнасан -За санал хураалтад бэлтгэхийг депутатуудаас хүсч байна.Санал хураалтад бэлтгэнэ үү.Эрхэм депутатуудаа, уучлаарай санал хураалтад бэлтгэнэ үү.

Уучлаарай хуралдааны цагийг сунгах уу үгүй юу гэдэг дээр бид нэг цаг сунгая гэсэн.Явж байна.Ер нь асуудлыг шийдтэл хуралдааны цагийг сунгуулмаар байна.Хуралдааны цагийг сунгая гэсэн санал оруулж байна.Асуудлыг шийдтэл хуралдааны цагийг сунгая.Асуудал шийдтэл буюу санал хураалт дуустал.

Уучлаарай депутатуудаа, бид Бага Хурлын гишүүдийг хүндэтгэх ёстой.Энэ хуулийг оруулж байгаа жинхэнэ субъект нь мөн.Энэ утгаараа бид Монгол улс гэдэг энэ хууль дээр бичиж орж ирсэн эх төслийнхөө талаар бид бас үг сонсохгүйгээр ингэнэ гэдэг

учир дутагдалтай болж байх шиг байна. Бага Хурлын дарга Гончигдорж гуайг Монгол улс гэдэг нэрийн талаар тайлбар өгөхийг хүсч байна.

За баярлалаа. Тэгвэл гуравдугаар микрофон.

К. Сайраан /85 дугаар тойргийн депутат/ -Та сая горимын хэд хэдэн зөрчил гаргалаа. Тэрнийг би сануулах гэсэн юм. Нэгдүгээрт энэний өмнө уг хэлсэн 25 хүн түрүүчийн санал хураалтаар цөөнх болсны хувьд, цөөнхийн хувьд саналаа хэлсэн. Гэтэл тэр цөөнхийг саналаа хэлээд тэрний дараа санал хураалгах хуучин тэр хэвээрээ хураалгах ёстой байсан. Гэтэл та шал ондоо юмаар гурван зүйлийг уралдуулна гээд хураалгачихлаа. Хэрэв **ийм** нөхцөлд хүрэх юм бол Монгол улс гэдэг нэрийг хамгаалаад уг хэлэх хүмүүс ээндөө байна. Тэр 25-аас үлдсэн бүх хүмүүс тэрний талаар уг хэлэх хүмүүс ээндөө байна. Тэрнийг хэлүүлэх ёстой. Тэгж байж тэр шалгаруулах уу үгүй юу гэдгийг нь дараа нь хэлэх ёстой байсан.

Тийм учраас би шалгаруулах саналыг нь эсэргүүцэж байгаа юм. Энэ талаар дахиад санал хураалгахыг шаардаж байна.

Ц. Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Би зүгээр хүндэт депутатуудад хандахад бүгд шударга байвал яадаг юм бэ? Хэрэв шалгаруулах гэж байгаа бол бүгдийг нь сонсоод, монгол улс гэдэг дээр ямар үндэслэл байгаа юм, Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг дээр ямар үндэслэл байгаа юм, Бүгд Найрамдах Монгол улс гэдэг дээр ямар үндэслэл байгаа юм бэ гэдгийг бүгдийг сонсох ёстой. Миний байр суурь бол эхнээсээ ямар байсан бэ гэхээр Монгол улс гэдэг энэ нэрэнд байгаа энэ зүүлтийг авах уу, Монгол улс гэдэг дээрээ тогтох уу гэдэг энэ асуудлаар өргөн санал шүүмжлэл явуулах ёстой л гэж би бодож байна. Энэн дээр бид нар бүгдээрээ санал бодлоо илэрхийлье гэж хүсэж байгаа тэр депутат нь илэрхийлэх хэрэгтэй. Тэгээд сая нэг талд нь илэрхийлж байсан улсууд илэрхийлсээр байгаад, уг нь бол бид нар чинь тооны хязгаар тогтоож байсан шүү дээ,

## 3.

7 юм уу 5 хүн илэрхийлээд хэрэв цөөнх гэж үзэж байсан бол тэгээд суугаад ярих байсан. Гэтэл 24-25 хүн ярьсан. Энэн дээр ямар нэгэн цөөнх биш, ердөөсөө энэн дээр санал бодлоо үргэлжлүүлж ярьж байна гэдэг энэ утгаар би ярих гэсэн юм.

Дараачийн нэг зүйл нь, бидний хурал явахгүй байгаа юм энэ асуудал дахин босож ирэх байх гэж би бодож байна. Бидний хурал явахгүй байгаа нэг юм завсарлагаар депутатуудтай ярихад депутатууд зөвшөөрч байгаа, юу вэ гэхээр хуулийг оруулж байгаа субъект, хуулийг баталдаг тэр объект хоёр нь хоёулаа их хутгалдчихаад байгаа. Бага Хурлын дарга жишээлбэл сая босож ирээд ард гэдэг үгийг хасахын учир утга, Бүгд Найрамдах гэдгийг хасахын учир утгыг хуулийн экспертүүдээс, мэргэжлийн хүмүүсээс, тэр Бага Хурлын зарим гишүүдээс нэр цохож ингэж хэлүүлээд, энийгээ Үндсэн төслөө хамгаалаад та бүхэн депутатууд бидэнд бүгдэд нь батлах эрх байгаа учраас бид батлах шийдвэрээ бид гаргана, та бүхэн хамгаалах ёстой, энэ хоёроо бид нар уг нь хоёр талд нь ингэж харж явах юм бол юм их тодорхой болно. Энийгээ одооноос эхлэж хиймээр байгаа юм. Бага Хурал дээр ч гэсэн ингэж ярьдаг, нөгөө жор бариагүй ламаас зовлон үзсэн чавганц дээр гэж, нэг бүтэн жил гаруй тэр хуулийг яаж хэлэлцэх вэ гэсэн энэ тэр гэсэн энэ зовлонг үнэхээр үзсэн. Нэг хэсэг нь хамгаалж, нэг хэсэг нь тэр шийдвэр гаргадаг хэсэг нь тэрнийгээ сонсож, тэр хамгаалж байгаа хүмүүсийн эсрэг өөрсдийнхөө бодол саналыг хэлж байж тэр хүмүүс нь шийдвэр гарахгүйгээр, ингээд энэ хоёр хоёулаа хоорондоо хутгалдчихаар ердөөсөө болдоггүй юм байна билээ. Энэн дээр анхаарч үзвэл яасан юм бэ гэж ингэж бодож байна.

Дараачийн нэг зүйл бол одоогийн Монгол улс гэдэг нэрэн дээр би өөрөө яагаад байгаа юм бэ гээд ингээд тайлбарлах юм бол их урт удаан зүйл тайлбарлах болж байна. Нэгэн зүйлийг л эсэргүүцэж байгаа юм. Энэ уралдуулж санал хураалгана гэдгээ больё. Одоо Монгол улс гэдэг дээр тайлбар өгөх тэр депутатууд тайлбарлаж байна гэж үзвэл би ингээд энийгээ үргэлжлүүлж ярьж болж байна. Одоо цагаа аваад.

За баярлалаа. Тэгвэл ярья. Энэ Монгол улс гэдгийг ярихад ямар нэгэн хэвлэл мэдээллээр битгий явуул энэ тэр гэж хэлэхгүй. Энд надад ердөөсөө нуух юм алгаа. Монгол улс гэдэг энэ нэрийг монголчууд манай эриний өмнөх 209 оноос эхлэж хэрэглэж эхэлж хэрэглэж ирсэн юм билээ. Одоо яг энэ жил 1991 онд 2100 жилийнх нь энэ их нэрийг авсан 2100 жилийнх нь ой. Энэ ийм л юм тохиож байгаа. Энэний хооронд 1924 оноос хойш 2100 жилийн дотор 67 жил нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэртэй явж ирсэн. Ер нь бол би бас нэгэн зүйлийг дахин хэлэхэд улсын нэрийг солих тухай юм уу, өөрчлөх тухай асуудал байхгүй, Монгол улс гэдэг нэр байж байгаа. Харин тэнд аваачиж зүүсэн Бүгд Найрамдах, Ард гэсэн энэ зүүлтүүдийг авах уу үгүй юу гэдэг асуудал байгаа. Депутатууд улсынхаа нэрийг өөрчлөх үү яахав, солих уу гэсэн энэ асуудал яриад байгаа нь нэг л боломжгүй юм уу даа гэсэн ийм ойлгомж надад төрж байгаа.

Дараачийн асуудал бол Бүгд Найрамдах гэдгийг нэгэнт Үндсэн хуулиндаа бид нар эхнийх нь нэгдүгээр заалтан дээр Монгол улс бүгд найрамдах улс гэдгээ, тусгаар тогтносон бүрэн <sup>бүгд найрамдах</sup> эрхт улс гэдгээ тунхагласан учраас Бүгд Найрамдах гэдгээ авъя гэсэн нэг ийм юм байгаа.

Дараачийн нэг зүйл нь энэ бол төрийн засаглалын хэлбэр. Үндсэн хуулин дотроо зааж өгч болох юм гэсэн нэг ийм юм хэлбэ. Зүгээр энэ Монгол улсын нэрийг авах тухай асуудлыг депутатууд нэлээн олон депутат ярихдаа улс төрийн асуудалтай хутгасан, монгол улсын аюулгүй байдалтай хутгаж ярьсан, хятад ингэх гээд байгаа, хятад тийм бодлого явуулж байсан гэж бид 30-40 жилийн өмнө гадна империализм, фашизм нөгөө дайнаар хөөцөлддөг хэнээтнүүд, нөгөө империалистууд, одоо нөгөө талын улсууд гэж өөрөө өөрсдийгөө хаалгаж, өөрөө өөрсдөө түгжигдмэл энэ байдалд байсан, энэ нэг байдлаар яримааргүй байна. Тэр үед харилцаж байсан харьцаа, тэр үед байсан харьцаа өнөөдөр өөрчлөгдсөн.

Бид өөрсдөө хятад ингэх гээд байна гэж ярьж байгаагаараа



тусгаар тогтнол энд тэнд аюул болчих вий гэж ярьж байгаагаараа өөрсдөө тусгаар тогтнолдоо зохиомлоор аюул учруулж байгаа гэдгийг анхаарах ёстой гэж ингэж бодож байна. Өөрсдөө тусгаар тогтнолдоо бид нар энэ яриагаараа аюул учруулж байгаа шүү.

Дараачийн зүйл бол их олон юм ярьж гэж бодож байсан. Ард гэдэг үгэн дээр яагаад ингээд байгаа юм бэ гэхээр Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн энэ нэрийг уншаад, хүн хэлмэгдүүлж байсан, барьж байсан гэдэг дээр энэ нэр хэлмэгдүүлж байсан уу үгүй юу гэдэг асуудлыг зарим депутатууд тавьж байсан. Яагаад энэ ардыг хасах юм бэ гэсэн, энэ нэрийг оруулсан бэ гэхээр ард гэдэг ядуу хүн байх ёстой. Ард гэдэг бол ардууд босч, баячууд тэр феодал ангийг устгаад, тэгээд тэдний хөрөнгийг аваад, тэгш хувааж аваад, тэгээд нэг сайхан жаргах ёстой гээд үзсэн байгаа юм л даа. Тэгээд үзсээр байгаад бид ийм болчихлоо. Зүгээр энд 1960 оны Үндсэн хууль байна. 1960 оны Үндсэн хууль дээр бол уг нь энэ манай 1960 оны Үндсэн хууль чинь бол коммунизмыг бүрэн төгс байгуулаад, төрийн үүрэг халагдаад, төр байхгүй болоод, төр нь коммунист эвлэлээр солигдоход энэ Үндсэн хууль халагдана гэж төгсгөлд нь бичсэн байдаг юмаа. Ийм л үзэл санаагаар хийсэн. Яг энэ ард гэдэг үг энэн дотроо сууж өгсөн учраас энийг хасъя гэсэн нэг ийм юм байгаа юм.

Дараачийн юм бол бид нар хийх ёстой юмаа тухайн цаг хугацаанд нь хиймээр байна. Цаг хугацаа болоогүй гэсэн юм ярьдаг. Ер нь хоёр жилийн өмнө энэ ардчилал ч гэдэг юм уу, энэ бүх юм монголчууд өөрсдөө санаачлаад ингээд гарч ирж байхад болоогүй байна, монголд таарахгүй гэж ярьсаар байгаад өнөөдөр, тэнд яригдаж байсан бүх зүйл өнөөдөр монголд өөрт нь биелэл олоод, өнөөдөр бид нар үүгээр нүүрээ тахлаад Америк, энд тэнд энүүгээр л нүүрээ тахлаж явж байгаа л даа. Ардчилалтай ингэж хөгжиж байгаа ийм улс орон Азид анх удаа энийг хийсэн улс орон гэдгээрээ бид нар нүүрээ тахлаж явж байгаа шүү. Тэр үед энийг хүлээн зөвшөөрч авч байсан хүмүүс

их л бага байна.

Тэгэхээр өнөөдөр энэ нэрийг өөрчлөөд тэр нэрэндээ зүүсэн тэр нэг зүүлтүүдийг бид нар авмаар байна. Дараачийн нэг зүйл бол Амар, Гэндэн, Бодоо, Данзан тэр бүх улсуудыг хороохдоо бид нар японы тагнуул, төрийн эсэргүү, янз бүрийн нэрээр хороож байсан, одоо бид нар тэр хүмүүсийг цагаатгахдаа японы тагнуул биш байсан юм байна, тэр зүүлтээ авсан, эсэргүү биш байсан юм байна, энэ чинь манай төрийн хүмүүс байсан юм байна. Төрийн эүтгэлтнүүд, монголын төлөө явж байсан улсууд байсан юм байна гэж, тэр нэрийг нь авч цагаатгасан. Нэг үгээр хэлбэл монгол улс гэсэн энэ нэрээ цагаатгая. Тэр Бүгд Найрамдах Ард гэсэн хоёр үгийг нь авч цагаатгая гэсэн ийм санал байгаа юм.

Дараачийн нэг зүйл, малчин ардууд ойлгохгүй гээд байна. Би их гайхаж байна. Та бүхний сонгосон тойрогт монгол улсын энэ нэрийг тэр зүүлтүүдийг нь авахын төлөө байгаа хүмүүс маш олон байгаа шүү. Яваад очиход малчин ард өөдөөс чинь асуувал яах вэ? Та тэр монгол улс гэдэг нэрнээс тэр зүүлтүүдийг яагаад авсангүй вэ? Дарга минь надаас дордоо юу даа гэвэл та бас л хэлэхэд нэлээн хэцүү л болох байхаа. Энэнээс өөрөөр ч асуух улсууд олон бий гэж ингэж бодож байна. Тэнд зөвхөн та бүхнийг 100 хувь сонгосон тийм улсууд хүлээгээд байж байгаа биш байхаа гэж би бодож байна.

Очоод энэ асуудлыг тайлбарлахад манай ардууд, манай малчид, малчид ялангуяа ойлгох ухаантай шүү. Малчид их тэсвэртэй байдаг, янз бүрийн улс төрийн тэмцэлд оролцдоггүй гээд байгаа. Энэн дээр тэд өөрсдөө өмчтэй учраас, өөрсдөд нь юм байгаа учраас тэгдэггүй юм шүү. Тэд өмчийн эзэн байгаа учраас. Харин тэрнийг нь, янз бүрийн юм бий, энэ бол өөр ярианы сэдэв байх гэж ингэж бодож байна.

Дараачийн нэг асуудал бол энэ ард, бүгд найрамдах гэдэг үгийг хасах тухай... эа ингээд хонх дуугарлаа. Их л олон юм яримаар байна. Үнэхээр чухал асуудал. Дахиж босно.

Гурван минут, хоёр минут гэж байгаа байхаа.

Ж.Уртнасан -Цөөнхийн санал сонсож байна.Шалгаруулах гэж санал хураалт явуулсныг эсэргүүцэж байгаа цөөнх. Уг нь хураалтынхаа хувьд, санал хураалтын хувьд биш хажуугийн санал гол санал гэдэг дээр.

Ц.Товуусүрэн /Улсын Бага Хурлын гишүүн/ --Үндсэн хуулийн бүлэг, зүйл, заалт болгон өөрөө шинжлэх ухааны бие даасан ойлголт болох учраас тийм ч амархан өөрчлөгддөггүй зүйл байдаг байх.Өнөөдөр бид нар Үндсэн хуулиа өөрчлөх ийм эрин үед тулж иржээ.Үндсэн хуулиар хуучныгаа халах болсон гол шалтгаануудын нэг нь манай улсын мөн чанар өөрчлөгдсөн явдал гэж би хувьдаа дүгнэж байгаа.1960 оны Үндсэн хуулиар Монгол улсын гол зорилго бол эх орондоо социализмыг төгөлдөр байгуулж, улмаар коммунизмыг байгуулах явдал мөн гэж заасан.Тэгвэл бид энэ шинэ Үндсэн хуулийнхаа төсөлд иргэний ардчилсан нийгмийг байгуулах тухай асуудлыг тавьж байгаа.Энэ бол зарчмын асуудал байх гэж бодож байна.

Монгол улс олон улсын тавцан дээр Монгол улс гэсэн энэ нэрээрээ танигдаж байдаг.Ирээдүйд ч танигдах ёстой.Тэгвэл бид 1924 оны Үндсэн хуулиар Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж нэрлэснээр олон улсын тавцанд бараг танигдахаа байсан. Монголиан пиблик репаблик гэж бичсэнээр энэ хаанахын Монгол вэ гэж асуудаг.Оросын монгол уу, хятадын монгол уу, Чингисийн монгол уу гэж.Энэнээс аваад үзэх юм бол өнөөдөр монгол улсынхаа жинхэнэ уугуул нэрийг л үлдээе, элдэв зүүлт чимгийг нь хасъя гэсэн энэ саналыг би дэмжиж байгаа хүн.

Энэн дээр янз бүрийн асуудал яригдаж байна л даа.Монгол улс гээд нэрлэчихээр бөхөө цоллож болохгүй гээд депутатууд ярьж байна.Би бол бөх цоллох асуудал бол уран сайхны асуудал гэж бодож байгаа юм.Өнөөдөр хэрэв монгол улсынхаа нэрийг яг хэлдэг бол яагаад бүрэн эрхт бүгд найрамдах монгол ард улсын гэж хэлдэг юм, улсын нэрэнд нь бүрэн эрхт

гэж байхгүй. Тэгвэл бид Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн гээд хэлчихсэн. Тэгвэл энэ бөх цоллоход нэг их саад болохгүй гэж бодож байна.

Гадаад оронд хүлээн авахгүй, хятадад зөвшөөрөхгүй гэх мэтчилэнгээр ингэж ярьж байна. Энэ бол энэ асуудлыг ингэж ярьж байгаагаараа харин хойд урд хоёр том хөршдөө ямар нэгэн байдлаар одоо тийм хардалт сэрдэлтийн юм үүсгэчих вий гэсэн ийм бодол байна.

Депутатууд төрийн түшээ нар монгол улсын тусгаар тогтнол гэдэг нэр томъёоны дор энэ асуудлыг их хөндөж тавьж байх шиг байна. Тусгаар тогтнол яах аргагүй ярих ёстой асуудал. Тэгэхдээ тусгаар тогтнол гэсэн нэрийн дор ямар нэгэн байдлаар хоёр хөршөө хардах явдал бол энэ тусгаар тогтнолыг бэхжүүлэхгүй, харин ч тусгаар тогтнолыг алдагдуулахад нэмэр болчихвий гэж тэмдэглэж байна.

Үүнээс гадна депутат Болат, депутат Бадам, депутат Насан-Очир нар энэ монгол улсын нэрийг сольсноор монгол улс дааж давахгүй эдийн засгийн дарамтад учирна гэсэн ийм сөрөг мэдээлэл хийж байгааг би хувьдаа зөвшөөрөхгүй байна. Яагаад гэвэл Улсын Бага Хурлын удирдлагаас надад үүрэг даалгавар өгч, тодорхой ажлын хэсгийг ахлуулж, энэн дээр ажилласны хувьд, би өнөөдөр ажилласныхаа төлөө буруутан болох гэж байх шиг байна. Би бол энэн дээр төрийн хууль тогтоох дээд байгууллагын дэргэд би буруутан болохыг хүсэхгүй байна. Ер нь аливаа юмыг хариуцлагатай ярих ёстой. Бид өнөөдөр хөдөлмөрчдөө, ард түмнээ, бид өнөөдөр тухайн тойргийнхоо сонгогчдыг буруу мэдээллээр төөрөгдүүлэх явдал бол харин ёстой төрийн түшээ хүний хувьд байж болохгүй асуудал гэж бодож байна.

Бид өнөөдөр тооцоог хийхдээ монгол улсын эдийн засаг ядуу байна, ийм учраас байгаа юмнуудаа боломжийнх нь хэрээр ашиглах ийм шийдвэрийг гаргая гэж үзэж байгаа. Ийм шийдвэрийг гаргах

эрх нь монгол улсын хууль тогтоох байгууллагад бүрнээ байгаа гэж би үзэж байгаа.

Бид өнөөдөр тамга, тэмдгийг сольё гэж асуудал тавьсан. Солихгүй байж болно. Солихгүй байхаар шийдвэр хийж болно. Ер нь эцэлдэг, хэрэглэдэг, элэгддэг зүйлийг элэгдээд дуустал нь хэрэглэх шийдвэр гаргахад яагаад болохгүй гэх вэ? Нөхөр Болат II200 байгууллагын тамга, тэмдгийг хийхэд 100 сая төгрөг гарна гэж байна. Үнэхээр хийсвэр аваад үзэх юм бол тийм юм гарах байх. Тэгэхдээ өнөөдөр хөдөө аж ахуйн нэгдлийг аваад үзэхэд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тийм аймгийн тийм сумын тийм нэгдэл гэж тамган дээрээ бичдэггүй. Тэгвэл тийм тамгыг солих шаардлага байгаа юм уу гэсэн асуудал ч гарч ирнэ. Энэ бүх юмнуудыг, ер нь төсвөөс хэдэн төгрөг гарах вэ? Тамган дээр төрийн сүлд байна уу үгүй юу. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж бичих үү үгүй юу гэдэг асуудлаас энэ асуудал ургаж гарна гэж бодож байгаа юм.

Энэ ер нь цаг цаг гээд ингээд хавчаад байх шиг байна. Би 5 минут ярилаа. Энэ ярьж байгаа зүйлийг эсэргүүцэж байгаа хүч нь их байгаа учраас би энэн дээр ингэж нэмж ярихыг больё. Хэрэв энэ асуудлаар шаардлагатай гэж үзвэл би хэвлэл мэдээллээр мэдэгдэл хийнэ.

Соронзон хальстай тулгаж

нийлсэн

*Д. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

258 дугаар тойргийн депутат Ш.Гунгаадорж:

Хурлын эрхэм даргаа, эрхэм депутатууд аа, би нэг зүйлийг юуны өмнө тэмдэглэж хэлэхийг хүсч байна.Өнөөдөр монгол орон өөрчлөлт шинэчлэлийн замд ардчиллын замд, зах зээлд орох энэ чиглэл рүү, эргэлт буцалтгүй орсоньг бид нэгэнт хүлээн зөвшөөрч байгаа юм бол энэ байр сууринаас өнөөдөр депутат бид нар хандаж ярих ёстой байхаа гэж бодож байна.

Ингээд би Монгол улс гэдэг энэ унаган нэрийг байлгах ийм хүсэлтэй хүний нэг.Үүнийгээ тойруулж хоёр, гурван зүйл хэлэх бодолтой байна.

Өнөөдөр улсын нэрийг юу гэж нэрлэснээс болж улс орны тусгаар тогтнолд аюул занал учруулах тухай яриад байгаа нь нэг л ойлгогдохгүй байна.Үүний тайлбар ч баталсан тайлбар өнөөдрийг хүртэл би гарч чадахгүй байна гэж бодож байна. Улс орны тусгаар тогтнолын төлөө зүрх нь цохилж, судас нь лугшиж байдаггүй, тийм монгол байхгүй гэж бодож байна.Өнөөдөр энд сууж байгаа 427 депутат ч мөн ийм байх, би ч мөн үүний төлөө зүрх цохилж байдаг хүний нэгээ.

Монгол улс гэж нэрлэхээр улс орны тусгаар тогтнол алдагдана гэдэг бол ойлгогдохгүй байна гэдгээ дахин хэлье.Ер нь улс орны тусгаар тогтнолын тухай асуудлыг улс орон хуулинд, төрийн хуулинд юугий нь ил зарлах ёстой юм бэ? юугий нь төрийн хар хайрцаганд байх юм бэ гэдэг бодлого бол байх ёстой байхаа. Өнөөдөр бид нэрээ шохоорхож ярьж, маргалцсаар байгаад тэр төрийн хар хайрцаганд байх ёстой юмаа илчилж гаргаж тавиад байгаа юм биш бизээ.Үүнээс болоод харин манайд хоёр талаас хохирол орох аюул байх юм биш байгаа.

Өнөөдөр монгол улс гээд зарлачихвал маргааш Хятад довтолж орж ирнэ гэдэг бол ойлгогдохгүй байна.

Өнөөдөр манай орны тусгаар тогтнол, хятад эзлэн түрэмгийлэх бодлогоор энэ арга, ажлыг явуулах уу? эсвэл эдийн засгийн аргаар явуулах уу гэдгийг ч гэсэн өнөөдөр бид өнөөдрийн бий болсон нөхцөл байдлаас дүгнэлт хийж, асуудалд хандах ёстой байгаа гэж бодож байна.

Ийм учраас би монгол улсыг Монгол гэдэг нэрээр нэрлэхэд тусгаар тогтнол, аюул занал учрах, учир шалтгаан байхгүй юмаа. Тийм учраас Монгол гэдэг нэрээр нь байлгая гэсэн ийм саналтай байгаа юм.

Бүгд найрамдах Монгол улс гэдэг санал гарч байна. Энэ бол үндсэндээ Үндсэн хуулиар, энэ шинэ үндсэн хуулиар зөвшөөрч хөөд байгаа, нэгдүгээр хуудсан дээр Монгол улс бол бүрэн эрхт тусгаар тогтносон бүгд найрамдах улс мөн гээд биччихсэн байгаа.

Өнөөдөр бид Бүгд найрамдах монгол улс гээд зарлах юм бол түрүүн хурлын дарга ярьж байсан, би үүнтэй санал нэг байгаа. Өнөөдөр Буриад улс, Бүгд найрамдах Буриад улс гэж зарлалаа, Тува улс Бүгд найрамдах Тува улс гэж зарлалаа, бид тэгээд түүнийгээ зэрэгцүүлж аваачаад, бас энэ холбооны энэ жижиг улсуудтай зэрэгцүүлж нэрээ тавих уу? энэ дээр бас эрхэм депутатууд ухаалаг бодох байгаа гэж бодож байна.

Харин энд Монгол улс гэдэг нэр нь байж байвал үүнээсээ ялгагдах онцлог нь байх байгаа. Тийм учраас би Монгол улс гэдэг санал дээр, Үндсэн хуулийн төсөлд анх боловсруулж эхлэхээс энэ санал дээр би байсан, одоо ч би энэ саналдасаа ухармааргүй байна.

Хоёрдугаар зүйл бол, энэ бүх асуудлыг өнөөдөр бид эдийн засгийн хүндрэлтэй холбож ярьж байна. Энэ зүйтэй. Энэ хүмүүсийг эмзэглүүлж байгаа гол асуудал. Тэгэхдээ эрдэм депутатуудаас хүсэхэд бүх зүйлийг зоосны нүхээр хармааргүй байна. Зарим зүйл дээр учир начиртай, энд хандмаар байна. Энд хийсвэр сэтгэлгээгээр

янг бүрийн тоонд наана, цаана нь хууртагдаж бас хандмааргүй байна гэдгийг хэлмээр байна.

Эцэст нь хурлын даргад хандаж хурлын удирдлагад хэлэхэд энэ дэгийг их сайн барья. Дэг барихгүй байсаар өдий хүрлээ. Хурлын орлогч дарга нарын үүрэг, хариуцлагыг өндөржүүлмээр байна. Та дөрвийг бид сонгохдоо, наашаа сайхан хараад сууж байх улс гэж сонгоогүй ээ, яг ахдаа хэн хэдэн минут ярьж байна, аль микрофон дээр хэн хичнээн удаа гарав гэдгийг хүртэл бүртгээд энэ дэгийнхээ дагуу явуулмаар байна.

Эцэст нь эрхэм хүндэт Ерөнхийлөгчид хүсэхэд, Ерөнхийлөгч таны үйл ажиллагаа энэ дээр бас идэвхтэй баймаар байна. Та бол манай монгол улсын монголын ард түмний ааваа. Монголын ард түмний бэлгэ тэмдэг ээ. Эв нэгдлийн бэлгэ тэмдэг ээ. Тийм учраас та бол 2 сая хүнийг ч эвлэлдүүлэх, үүрэгтэй, энэд байгаа 427 хүнийг ч эвлэлдүүлэх үүрэгтэй, энэ үүргээсээ Үндсэн хуулиар заасан эрх, үүргийнхээ дагуу та бас жаахан идэвхтэй ажилламаар байна гэдгийг хүсэх байна, танд.

Ийм зүйл байна, баярлалаа.

Депутат /нэр, тойргоо хэлээгүй/

Би энэ нэрийн талаар санал оруулах гээгүй. Энэ хэлэлцэж байгаа, дэгээ барихгүй байгаа талаар өөрийн бодлыг хэлэх гээд байна.

Юу вэ гэхээр энэ Үндсэн хуулийн төсөл маань Их Хуралдаа өргөн баригдсан төсөл. Тэгэхээр энэ бүлэг, зүйл болгон дээр хэлэлцэхэд, энэ субъектив зүйл зүйл кмаа гэж хэлээд тэнд нь ярилцахгүйгээр өөр санал юу байна вэ гээд хажуугийн санал гаргаад, хажуугийн саналыг аваад, ингээд түүнийг үзэхээр зэрэг гуравны хоёр хүрэхгүй нь гээд, тооны аргаар хасагдаад байх нь ээ. Энэ ийм арганд болж байна уу? Өчигдрийн хувьд бид нар цааз гэдэг нэр дээр уралдуулаад санал авсан, өнөөдөр болохоор энд Үндсэн хуульд субъектив нэр болоод үлдлээ. Одоо монгол улс гэж.



Тэгэхээр миний саналаар юу вэ гэхээр энэ Үндсэн хууль маань энд депутатын хэмжээнд яригдаж байгаа юм бол эхлээд нэр маань, Монгол улс гэдэг нэр маань болох нь уу, үгүй юу гэдгийг саналыг хураалгачихаад, дараа нь болохгүй, зайлшгүй санал гаргавал, түүн дээрээ санал аваад явж байвал яасан юм бэ?

Түүнээс зүйл, анги болгон дээр санал авахад, тэнд санал 100 хувь авч чадахгүй, 60-70 хувь хүрэхгүй ч юм үлдэх нь байна. Ганцхан ингэж тооны аргаар ингэж байгаа болхиосой гэдэг санал хэлэх гэсэн юм.

148 дугаар тойргийн депутат Д.Баттулга:

Би энэ дээр ерөнхий санал шүүмжлэл хэлэхгүй. Цөөнх болох ч үгүй. Яагаад гэвэл өнөөдөр одоо энэ дээр яг дэг зөрчигдөж байна. Би санал шүүмжлэлээ л хэлэх гэсэн юм. Шалгаруулах санал хураалт явуулна гэхээр л Монгол улс гэдэг санал цөөнх болсон юм шиг, цөөнхийн санал гээд баахан яриад уналаа.

Энэ монгол улс бол одоохондоо олонхийн санал байгаа. Мөрдөж байгаа дэгээр. Тийм учраас би энэ дээр еерийнхөө саналыг хэлэхгүй, цөөнх болсон тохиолдолд хэлнэ. Гарцхүү би хажуугийн санал хураалтан дээр ямар санал хэлэх гэж байна вэ гэхээр магадгүй ингээд шалгаруулах гээд хэдэн хувиар, 60 гаруй хувиар ингээд шийдчихлээ. Тэгсэн тохиолдолд, гурвуулангийн нь зэрэг морь уралдуулж байгаа юм шиг ингэж санал хурааж болохгүй.

Шалгаруулах санал хураалтыг яаж явуулах вэ гэхээр эхлээд 2 хэсэг болгох хэрэгтэй байна. Нэгдүгээрт нь, БНМАУ гэсэн нэрийг өөрчлөх үү? өөрчлөхгүй юу? гэж. Өөрчилнэ гэсэн гэсэн тохиолдолд нөгөө хоёр нь үлдэнэ. Монгол улс, Бүгд найрамдах Монгол улс гэсэн. Өөрчлөхгүй гэсэн тохиолдолд БНМАУ гэдэг нь үлдэнэ. Яагаад би үүнийг хэлж байна вэ гэхээр монгол улс гэдэг дээр би бол зогсож байгаа юм. Тэгэхдээ энд зарим депутатуудын Монгол улс гэдэг санал явахгүй байгааг би БН Монгол улс дээр нь саналаа өгнө гэсэн тийм саналтай

депутатууд байгаа учраас би үүнийг хэлж байгаа юм.

Тийм учраас гурвуулан дээр нь өгчихөөр нөгөө еөрчилнэ гэсэн саналтай хүмүүсийн санал нь хоёр хуваагдчихна. Ингэж болохгүй. Ингэж саналыг хувааж болохгүй. Тийм учраас группчилж, шалгаруулж санал хураалтыг одоо би, хэрвээ тэгээд яасан юм бол, саналаараа, нэгэнт хураасан саналаа бид хэрэгжүүлэх ёстой. Нэгэнт хураасан саналаа бид хэрэгжүүлэх ёстой. Нэгэнт хуралдаж байгаа бол хэрэгжүүлэх ёстой. Тийм учраас салбар, салбараасаа хоёр групп болгоод тэгээд хоёр группээ еер хоёр хуваагаад ингээд санал хураавал илүү боцтой болно. Тэгсэн цагт хэрвээ Монгол улс цөөнх болбол тэр хэлэлцүүлгийг үргэлжлүүлбэ. Ингээд байвал эх захгүй юм явах байхаа гэсэн ийм горимын саналтай байна.

113 дугаар тойргийн депутат Ж. Гуррагчаа:

Тэгэхээр улс орны маань нэрийн асуудал яригдаж байгаа учраас би энэ дээр уг хэлэхгүй байж чадахгүй байна.

Үнэхээр бид ойлгож байна. БНМАУ гэдэг нэр бол миний л лав ухаан орсон цагаасаа, хамгийн хайрлаж хүндэтгэж явсан ийм нэрээ. Өөрийнхөө өчүүхэн ололт амжилт, сайн сайхан бүхнээ энэ нэртэй холбож, энэ нэр дээр хийж ирсэн.

Тэгэхээр би ингэж ойлгож байгаа. Хэрэв хүнтэй зүйдлүүлээд улс орныг маань үзэх юм бол монгол улс гэдэг миний нэрээ. БН ард улс гэдэг нь түүний овог нь юм байгаа гэж ойлгож байна. Бид овогтой, нэртэй ийм улс байсан. Бага Хурлын гишүүн нөхөр Тобуусүрэн хэлж байна. Биднийг хаанахных монгол вэ гэж? ялгаж чаддаггүй гэж. Энэ үнэхээр тиймээ. Биднийг овогтойгоо нэртэйгээ байхад хятадын Монгол уу? Оросын Монгол уу гэж асуудаг. Бид овоггүй болох юм бол ер нь хэнийхийг нь ч бүр ч ойлгохгүй болж болов уу гэж би ингэж бодож, дотор сэтгэлдээ эмзэглэж байна.

Тэгэхээр би ерөөсөө бодохдоо энэ дээр олон төрлийн тайлбарууд гарч байна, олон янзын аргумент бас гарч байна. Ер нь БНМАУ гэдэг энэ нэрийг солиогүй байхад өнөөдөр бол нэг ч мөнгөний зардал гарахгүй. Солсон байхад саяар ч байна уу? хэдээр ч байна уу? мянгаар ч байна уу? тодорхой хэмжээний зардал заавал гарна.

Улс орны маань эдийн засгийн байдал өнөөдөр ямар байна вэ? Нэг мөнгө ч нэгдэхгүй, нэг төгрөг төгрөгдөхгүй ийм үе байгаа. Ийм үед бид заавал мөнгө хөрөнгө зарцуулж, үүнийг солихын төлөө яриад байхын хэрэг байна уу? гэж ингэж бодож байна. Тийм учраас би БНМАУ гэсэн энэ нэр дээр өөрийнхөө саналыг үргэлж өгнө. Таблон дээр эцсийн ганц санал үлдсэн байхад битгий гайхаарай. Мүний л өгсөн санал байх байх.

85 дугаар тойргийн депутат Сайран:

Би хоёр дахиа хэлж байна. Хэтэрхий будилж байна. Юуны өмнө горимын талаар тохирч авъя. Энэ чинь одоо юу болж байна вэ? БНМАУ-ын төлөө ч хүн яриад байх юм, тэр нэрийн төлөө хүн ч яриад байх юм бэ? Монгол улс гэдэг нэрийн төлөө ч хүн яриад байх юм бэ? Бид эхлээд горимоо ярьдаг шүү дээ. Би горимын санал тавьсан. Яагаад энэ биелэгдэхгүй байгаа юм бэ?


Нэгдүгээрт, ийм зүйл тохирмоор байна. Та эхлээд цагаа товлоё гэсэн. Тэр гурван асуултыг цагаа сунгаж гэсэн, одоо цагаа сунгах хэрэгтэй, хэрэв энэ асуудлыг хэлэлцэх юм бол?

Ж. Уртнасан: Цагаа сунгасан.

Сайран: Хоёрдугаарт, хэрвээ бид хэлэлцэхэд Монгол улс гэдэг нэрийг хэлэлцэхэд хүрэх юм бол юуны өмнө Бага Хурлын тайлбарыг сонсмоор байна. Тэр асуудал оруулж ирсэн субъектын тайлбарыг хичнээн хүн, ямар хэмжээнд ярих юм бэ? Яриг, түүнийг сонсмоор байна.

Гуравдугаарт, хэрвээ ингэж хэлэлцүүлэгт орох юм бол, цөвнх ч бай, олонхийн ч бай, түрүүний 25 хүн уг хэлсэнтэй адилхан, мөн адилхан үүнийг хамгаалсан хүн, 25-аас доошгүй хүнийг уг хэлүүлмээр байна. Ингэж байж дараа нь тэр шалгаруулах юмыг ямар уралдаан байх юм бэ? түүнийгээ зохион байгуулмаар байна. Би үүнийг л эргээд тохирч авмаар байна. Хэрвээ энэ үгээр үргэлжлүүлэх юм бол би Монгол улсын төлөө яагаад саналаа өгөх гэж байгаа тайлбараа хэлмээр байна. Эхлээд үүнийг сонсмоор байна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭНГЭГ

1991.XI.19.  
Кассет № 2  
20.31-20.46

Ж.Уртнасан -Уучлаарай, Сайран депутат үгээ хэлж гүйцэв үү?

К.Сайраан -Би эхлээд хариу сонсож байна, хэрэв шаардлагатай байвал үргэлжлүүлнэ.

Ж.Уртнасан -Сайраан депутат та үгээ хэлж дуусав уу?

К.Сайраан -Би Монгол улсын тухай хэлэх үгээ эхлээгүй байна. Би горимын талаар санал хэлчихээд танаас хариу хүлээж байна. Горимын санал явж байх дунд нь өөр зүйл яваад байна шүү дээ даргаа!

Д.Баттулга/148-р тойргийн депутат/ -Их Хурлын даргаа, би горимын санал тавьсан. Монгол улс одоохондоо олонх байгаа. Монгол улс цөөнх болсон тохиолдолд энэ хүмүүс үгээ хэлье. Тэнд хүмүүс саналаа өгчихсөн, тэр саналаа хэрэгжүүлээ чээ, үүнийг ямар замаар хэрэгжүүлэхийг би хэлсэн. Түүнээс бид одоо сөрөг болсон юм шиг яриад байгаа нь надад их сонин байна.

Ж.Уртнасан -Зөв, таны зөв, дахин үүнийг сануулахгүй бол болохгүй байна. Бид уралдуулах, шалгаруулах санал хураалт явуулна, явуулахгүй гээд цөөнх болсон хүмүүс ярьж байгаа болохоос биш, Монгол улс гэдэг дээр цөөнх болсон хүмүүс ярьж байна гэж ойлгохгүй байгаа шүү депутатууд аа! Үүнийг ойлгож байгаа байх гэж бодож байна.

К.Сайраан -Тэгвэл одоо завсарлая.

Ж.Уртнасан -Хэрвээ ярьж эхлэвэл дахин шалгаруулах санал хураалт зөв гэдгийг та зөвшөөрсөн шүү дээ.

Уучлаарай, дахин санал хураалт явуулъя. Энэ нь шалгаруулах санал хураалт явуулна, явуулахгүй гэдэг дээр бид саад хураалт явуулмаар байна. Ингэж шийднэ.

К.Сайраан -Эхлээд шалгаруулах саналын зарчмаа хэлээч.

Ж.Уртнасан -Би тийм томъёоллоор санал хураалт явуулсан шүү дээ.

К.Сайраан -Түрүүний Баттулгын хэлснээр явж байгна шалгаруулах санал уу. Та түүнийг тодруулахгүй юу?

Ж.Уртнасан -Хоёрдугаар микрофон та тайлбар тавих уу? Горимын санал уу?

Т.Очирхүү /17-р тойргийн депутат/ -Горимын санал хэлбэ. Би Баттулгын саналаар санал авахыг зүйтэй гэж бодож байна. Гэхдээ Баттулга ингэж хэллээ шүү дээ. БНМАУ гэсэн улсынхаа нэрийг өөрчлөх асуудлыг ярьж байна. Үүнээс бидний хурал эхлэх ёстой байсан л даа. Тэхээр үүнийг өөрчлөх үү, үгүй юу гэвэл, хэрэв өөрчлөнө гэвэл БНМАУ, Монгол улс гэсэн хоёр нэр үлдэнэ гэж байна. Тэхээр тэр нь зүйтэй юм, хажуугийн санал дээр болох байх. Гэхдээ БНМАУ, БНМУ гэсэн хоёр вариант дээр ярьчихаад, Монгол улс гэснийг яриагүй байж байгаад өөрчлөх үү, үгүй юу гэсэн саналыг асууж болохгүй. Одоо саналаа үргэлжлүүлээд, Монгол улс гэсэн саналын төлөө байгаа хүмүүсийг яриулчихаад, дараа нь Баттулгын горимын саналаар хурлаа үргэлжлүүлэх ёстой. Хэрэв тэгэхгүй бол өөрчлөхгүй гэгчихвэл Баттулгынхаар өөрчлөхгүй болчихно шүү дээ. Дараа нь цөөнхийн санал гэнэ. Тэр нь мөн эхлээд хэлэхгүй бол болохгүй. Санал хураахын өмнө ижил тэгш эрхтэй хэлэхгүй бол болохгүй юм.

Одоо хэлүүлээгүй нь цөөнх болчихоод байна, тэр хүмүүс чинь. Адилхан хэлүүлж байж энэ гурвыг тэгж санал хураах ёстой. Түүн дээр санал хэлүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Монгол улс гэдэг дээр хэлэх хүмүүс саналаа хэлээ чээ гэдгийг хүсэх ёстой. Дараа нь Баттулгын саналаар явах нь зүйтэй. Хэрэв тэгэхгүй бол ийм зүйл гардаг юм. Олонхийн санал дээр өгчихөөд, сүүлд нь цөөнхөөр юм уу, нэг хэсэг нь яриад, үндэслээд ирэхлээр нөгөө хүн нь өөрөө эргэлзэх байдалд орохгүй н тулд дүүрсэн хэрэг, дүнхийсэн толгой өгснөөрөө л дуусгая гэдэг шүү дээ. Тэхээр

3.

гурван зүйл дээр хураах гэж байгаа бол адилхан хэлүүлж, ижил эрх өгчихөөд, дараа нь ижил нөхцөлийг нь хангаж байж, санал хураах ёстой. Энэ нь хэвийн зүйл юм.

Ж.Уртнасан -Хуулийг оруулж байгааг сонсоё, сонсом болно. Горимын хувьд, зарчмын хувьд санал хураалт явуулах эсэхээ шийдмээр байна.

Д.Ламжав /39-р тойргийн депутат/ -Түрүүний санал хураалт нь юу бэ гэхээр эхлэхдээ цөөнхийг хүндэтгэнэ гэсэн санаагаар эхлэсэн шүү дээ. Тэхээр түүндээ үнэнч байх ёстой. Хэжүүгаас өөр зүйл ороод ирж болохгүй. Билээ нь одоо БНМАУ гэдгийн төлөө санал авах ёстой юм. Түрүүний санал хураалт, ярьж байсан зүйл дээ үнэнч байхын тулд. Хэрэв тэгэхгүй бол өөр, өөр зүйл рүү орчихоод байна. Тэхээр Ардын Их Хурлын орлогч дарга нараа, та нар даргад их туслаж байх шаардлагатай. Олон хүн бужигнаад, тэнд хэн ч очоод суухад хүнд шүү, санаж байхад хэцүү, үүргээ хуваарилаж байх хэрэгтэй.

Ж.Уртнасан -Уучлаарай, та өөрийн томъёолол, горимын саналаа хэлэхгүй юу?

Д.Ламжав -Түрүүнд цөөнхийг сонсоё гэсэн утгаар ярьж байсан учраас БНМАУ гэсэн нэрийг үүгээр байлгана гэж, угаасаа Монгол юм болохоор Монгол гэж дугарчихаад болж өгөхгүй юм л даа. Улсын нэр тийм байна гэдэг дээрээ санал хураах ёстой.

Д.Энэбиш/25-р тойргийн депутат/ -Миний ярьж байгааг хэвлэл, мэдээллээр нийтлэхгүй байхыг хүсч байна. Ер нь нэг хүн хэлсэн байдаг. Үг хэлэх үед дуугуй байх, дуугай байх үед дэмий ярих шиг том алдаа байдаггүй юм гэж байсан. Энэ үед би үг хэлье гээд эрхээ хасуулчих шахлаа.

Би Бага Хурлын нөхдүүдийг яриулах тал дээр байгаа юм. Гол нь би түүнийгээ юу гэж тайлбарлаж гэж байна вэ гэвэл Ж.Бейкер манайд ирээд хэлж байсан. Та нар хоёр гүрэнтэйгээ учраа олоо гэж хэлсэн. Би үүнийг юу гэж хэлээд байгаа юм бэ

гэхээр энэ хоёр нүрэн хэрвээ Монгол улс гэж нэрлэвээс Монгол үндэстэн байдаг том нуртгалийн дотоод хэрэгт хамраах асуудал болно шүү. Үүнийг би юугаар тайлбарлаад байгаа юм бэ гэвэл манай нөхдүүд мэдэж байгаа шүү дээ. Зөвлөлтийн Засгийн газрын комиссын хэлэлцээр, өчнөөн уулзалтанд ороод, Монгол та нар том болж байна гэж байгаа шүү дээ. Юм өгөхгүй гээд түүнээс болоод. Одоо хүнсний бүх зүйлээ хаалаа, мөн одоо шатахууныг хаах нь, энэ бодлогын цаана юм яваад байгаа гэдгийг бүгд ойлгох хэрэгтэй шүү дээ.

Хятад нь манайхыг үргэлж өөрийн нэг муж гэж үзэж байгаа, зураг нь ч тийм байгаа, заадаг хичээл нь ч тийм байгаа, мөн явуулдаг бодлого нь ч тийм байгаа юм. Сүүлийн үед Өвөрмонголын асуудал, мөн Хятадын Элчин сайдын яамны гадаа оюутнууд суусан, юу гэж дээд зиндааны хүмүүс ярьж байна. Манайх шиг өөрийн дотоод улс төрийн асуудлыг дэлхийд амаа цууртал цацдаг орон Монголоос өөр байхгүй. Тэгж хэлэхэд болно.

Хотын гудамжинд яриад явж байна шүү дээ. Дэд ерөнхийлөгч Гончигдорж БНХАУ-ын дарга Ян Шань Кунтай уулзахад, Ян Шань Кун дарга танайд би яг өөрийн улс шиг бодоод очино, нэг их бэлдэж бариад хэрэггүй гэхэд их сайн байна даа тэгж очивол гэж ярьсан. Манай Дэд Ерөнхийлөгч тэгж хэлээгүй байх, би түүнд итгэхгүй. Тэхээр улс, орон дотор ийм яриа явж байна.

✓ Дэлхийд газар нутгийг дахин хуваах бодлого Япон, Хятад хоёр оронд явж байгаа. Дэлхийн хот байгуулалтын мэргэжилтнүүд нэг км кв-тад хаана, ямар улсад хэн амьдарвал бололцоотой байна гэдгийг судлаад үзэхэд хамгийн түрхүнд Япон, Хятад хоёр улс байгаа юм. Тэнд Цагаачлалын хууль гараад хүн тэнд очихгүй.

Нөхөд минь би ингэж бодож байна л даа. Бага Хурлаас энэ томъёоллыг, Монгол улс гэж нэрлэвээс Монгол үндэстэнтэй БНХАУ-ын дотоод хэрэгт орсон гэж үзэхгүй үндэслэл бий юу гэдгийг заавал томъёолох хэрэгтэй. Түүнээс бусад зүйл дээр ард гэж байхан, ардын уламжлал гээд олон зүйлийг яриад байвал болно.



## 5.

Олон улсын хурал, зөвлөлдгөөнд олон удаа орж байхад өчүүхэн юман дээр том гүрэн, том шийдвэр аваад, олон дэмжигчидтэй явчихдаг шүү. Үүнийхээ учрыг сайн олох хэрэгтэй. Тийм учраас би БНМАУ-ыг өөрчлөхгүй гэдэгтээ биш, бид харин хааныхн Монгол гэдгээ тодруулаад, БНМАУ гэж хэлдэгт бид хаана ч гэсэн тодорхой байдаг. Бусад томьёоллуудыг би хүлээн зөвшөөрнө, би тэр томьёоллуудыг зөв гэж бодоод явж байгаа.

Хэзээ нэгэн цагт, ардчилал хөгжөөд, дэлхий дахинаар хэрэв түгвэл урд хөршид задралын процесс явагдана. Хэрэв коммунист дэглэм үргэлж ийм байхгүй бол явна. Энэ үед бид яах ёстой вэ гэдгээ өнөөдөр ярих ёстой. Түүнээс биш хэдэн хун гараад, булагнаж бүгэж байгаад хуулиа энэ нь зөв, бид нар яллаа гэдэгтээ биш юм.

Монгол улсын хувь заяа нь бид нараар тогтохгүй. Өнөөдөр бид хуулиа батлаж байна. Ажил хийж байна, алба хашиж байна, дараа нь алга болно, үхэж үрэгдэнэ, Дөч, тавин жилийн дараа энд байхгүй хүмүүсүүдийн үед Монгол улс ямар байх вэ гэдгийг бүрд бодож үзэх хэрэгтэй юм.

Хоёрдугаар аргумент бол хөрөнгө, мөнгө 8,3 сая юу ч биш гэж ярьж байна. Тийм биш юм. Монгол улсын төсвийн алдагдал өнөөдөр 2 миллиард гарчихаад, 12 сараас хойш 1 сард зарим байгууллага цалингаа тавьж чадахгүй.

Хүнсний барааны улсын нөөц өнөөдөр дуусаж байгаа шүү нөхөд минь. 12-р сарын юмыг өгөх байх, 1-р сараас улсын хүнсний нөөц байхгүй. Ийм болчихоод байхад энд том зан гаргаад өөр зүйл яриад байх юм.

Хөдөөний ард түмэн зөв юм хэлж байна шүү дээ. Тэнд идэж, уух юм алга байна шүү дээ. Өмсөж, зүүх юм алга байна. Хүүхдүүд нь гуталгүй гүйж байна шүү дээ. Тэгж байгаа ард түмнийхээ үгийг сонсдоггүй ямар төр байдаг юм бэ?

## 6.

Хэрвээ ийм асуудлыг ингэж ярих юм бол бид бүр өөр ярина. Өөрөөр ярихдаа МАХН-ын удирдлага хэрэв үүнийг ойлгохгүй бол бид намаасаа гарч байж ярина. Монгол хүний зүрх энэ улсын төлөө цохиж байгаа бол ярьдаг цаг бол яг өнөөдөр юм. Бид Монгол улсынхаа төлөө гэвэл бид зөвшилд орох ёстой. Хэрэв гадны хүчийг дэмжиж байгаа хүн байвал энэ зөвшилд орохгүй. Ийм баталгаа гаргаж байж ярина шүү. Тийм учраас энэ нэрийн хувьд нэрээр нь авах хэрэгтэй. Хэзээ нэгэн цагт түүх гэрчилнэ.

Манай улсын тусгаар тогтнол гэж ямар юм ярих вэ гэдгийг тэр үед бид байх ч юм уу, байхгүй ч юмуу, хойч үе биднийг шүүнэ.

Ж. Уртнасан —Уучлаарай, та томъёоллоо хэлэхгүй юу? Нэрээр авах ёстой гэдэг нь таныхаар яаж томъёолох ёстой вэ?

Л. Энэбиш —Монгол улс гэвэл Монгол үндэстэн байдаг энэ хоёр том гүрний дотоод хэрэгт хөндсөн асуудал болох уу, үгүй юу гэсэн тайлбарыг Бага Хурлаас аваад, дараа нь хүмүүсүүдэдээ ойлгуулж байгаад санал хураах хэрэгтэй.

Э. Бат-Үүл —Депутатуудаа, өнөөдөр бидний хувьд уршиг нь их хэцүү байж болох олон асуудлыг маш их цэдиггүй ярилаа: л даа. БНМАУ гэдэг нэрийг батлах гэж байгаа нь энэ гээд Хятадын эсрэг, Зөвлөлтийн эсрэг юм ярьчихлаа шүү дээ. Хэрэв Зөвлөлтийн Парламент ингэж байвал бид юу бодож суух байсан юм бэ? Энэ нь угаасаа хаалттай хийх тухай асуудал биш юм. Яагаад тусгаар тогтносон улс гэдгээ ойлгохгүй өнөөдөр гэнэт Хятад, Зөвлөлтийн асуудлыг яриад байгаа нь гайхмаар байна шүү дээ.

Та нар өөрсдөө бодоод үз л дээ.

Ж. Уртнасан —Депутатууд аа! нэгнмэхээ үгийг тайван сонсож зурмаар байна. Бидэнд ардчилал, дэг дутаж байна шүү.

Э. Бат-Үүл —Бид ямар нэгэн зүйлийг зөв гэж нотлох гэж нотолгоо эрж хайхдаа ийм бүдүүлэг алхам хийхдээ хүрнэ гэдэг нь юу гэсэн үг вэ гэсэн асуудал байна шүү дээ. Дахин ингэж бол-

7.

гоомжгүйгээр яримааргүй байна шүү дээ.Өөрсдөө тусгаар тогтнолоо баллаж, сүйдэх юм ярьцгааж байна шүү дээ.

Би хурлын даргад хандаж асуудлыг тавих гэсэн юм. Уртнасан даргаа, энэ нь сүүлдээ улс хоорондын харилцааны асуудалтай холбогдсон улс төрийн эвгүй зүйл гаргаж байгаа явдлыг анхаараа чээ. Сүүлд нь тэгж ярьсан хүмүүс хариуцлагийг нь хүлээжгүй, би тухийг байн мэдэж байла. Сүүлд хоёр сая хүн үүн дээр хариуцлага хүлээнэ.

К.Зардыхан -Саяны уриалсан хүмүүсийн тэр урианы тухай ярих гэж байна. Би улсын тухай, нэрийн тухай ярихгүй. Би улс төрийн уриаг ярина.

Ж.Уртнасан -Депутат Бат-Үүлээ саналаа хэлээд дуусахгүй юу?

Э.Бат-Үүл -Би саналаа хэлээд дуусая. Би депутатуудад хандаж нэг ийм асуудал хэлэх гэсэн юм. Ямар нэгэн асуудлыг зөв, энэ нь ийм юм гэдгийг нотлох гэж байгаа нь энэ гэж улс төрийн уршигтай тийм зүйл битгий хийгээсэй. Үүн дээр хурлын дарга анхаараа чээ.

Тусгаар тогтносон улс өөрийнхээ нэрийг сонгох асуудал ярьж байгаа юм. Жишээ нь Румын ч юм уу,Польш ч юмуу өнөөдөр нэрээ өөрчлөхөд Польш үндэстэн Зөвлөлтөд байдаг уу, гэвэл байдаг шүү дээ. Молдавд байдаг үү гэвэл байдаг шүү дээ. Энэ нэр нь тэдний дотоод хэрэгт орсон гэж Энэбиш даргын ярьж байгаа шиг тийм тэнэг юмыг зохиомлоор бий болгож хэзээ,хэн ч яриагүй. Гэтэл бид үүнийг улс төр болгож байхдаа яадаг юм бэ? Улс хоорондын харилцааны асуудал болгож байхдаа яддаг юм бэ? Ийм бүдүүлэг алхам хийнэ гэдэг нь дэндэж байна шүү дээ.

Соронзон хальстай тулгаж нийлсэн

Ц.БАЯРМАА

Бичээч С.ТУУЛ

Ж.Уртнасан:-Горимын санал сонсч байгаа гэж ойлгож байгаа шүү.

Ардын Их Хурлын 326 дугаар тойргийн депутат Ж.Гомбожав :  
—Одоо бид өнөөдөр хоёр цаг сунгаж хуралдлаа. Амарцгааяа. Орон нутгийн бүлгүүдийнхээ хурлыг хийе. Тэрэн дээр саналаа тохирмоор байна. Амарна гэдгийгээ бол би одоо тусдаа салж бүлгүүдийн хурал хийхийгээ ярьж байна.

Ардын Их Хурлын 427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж :  
Горимын санал байна. Хэрвээ байдал хүнд байна, тэнд хүн өлсч байна энэ тэр гэж ярьж байгаа. Хэрвээ энэнийг ойлгож байгаа бол одоо хоёр, гурван цагаар сунгаад хуралдсан ч болно. Яагаад бид энд ирчихээд, тэр зочид буудалд байрлаж байж, тэнд бэлэн км идээд байж байгаа мөртлөөсөө бүх монгол, бүх дэлхий наашаагаа харж байгаа, монголын хувьд бол наашаагаа харж байгаа. Энэ тохиолдолд яагаад дахиад хоёр цаг сунгаж болдоггүй км бэ? Дахиад яагаад хоёр цаг сунгаж ярьж болдоггүй км бэ энэ асуудлыг. Бид өнөөдөр тэр боолын боолын сэтгэлгээгээрээ бид өнөөдрийн нэрэнд байгаа тэр зүүлтээ авч хаях км бол гадна, дотнын улс орны цотоод хэрэгт оролцсон явцал болох гэж байна гэж гаднын юмыг яах гэж ингэж турхирч байцаг км бэ? Энэ дээрээ ярилцъя л даа. Нэрэн дээрээ ярилцъя. Дахиад сунгая.

Дахиж сунгах ёстой. Бага Хурал хоёр гурван цаг хүртэл хуралддаг км аа. Энэний чинь төлөө, нэг уг, энэний чинь төлөө хуралддаг байсан. Энэний төлөө бид нар ярьдаг байсан, энэний төлөө бид нар хараалгадаг байсан, энэний төлөө бид нар та нараар өнөөдөр хараалгаж байгаа. Яагаад ярьж болдоггүй км бэ?

Ардын Их Хурлын I дүгээр тойргийн депутат С.Баяр:-Тэгэхлээр би энэ хэлэлцэж байгаа, ярилцаж байгаа сэдвээр саналаа

хэлэхийг одоохондоо хүсэхгүй байна. Хэлэх санал бол надад бий. Би энэ асуудлыг хэлэлцэхдээ бид нэг мордохын хэзгэй болчихвуу даа л гэж санагдаад байгаа юм. Бидний баталсан дүрэм журам, дэг бий л дээ. Тэгэхлээр аливаа асуудлыг оруулж ирж байгаа субъектийг бид эрж хайгаад мөн үү, биш үү гээд байгаа. Яахын аргагүй мөн. Улсын Бага Хурал энэ төслийг оруулсан. Төслийг оруулахдаа чухам яагаад ийм томъёолол, ийм үг оруулав аа гэдэг үндэслэлийг нь эхлээд сонсох ёстой байх гэж санагдаж байна. Энэнийг бол хийсэнгүй. Ингээд олон янзын санал хэллээ. Түрүүний морь уралдуулахтай төсөөлүүлж ярьсан л даа. Үнэхээр тэгж болохгүй л дээ дарга аа, горимын хувьд бол. Хоёр морины уяа сойлт нь бэлэн болчихоод давхихад бэлэн байна, нөгөөдөх нь бэлчээрээс нь авчраад ерөөсөө уясан юм байхгүй уралдуулахаар шалгаруулах уралдаан биш юм л даа. Тэгэхлээр миний горимын санал юу вэ гэхлээр эхлээд Улсын Бага Хурлаас, одоо зүгээр танхим хүлээж авах эсэхийг мэдэхгүй байна. Аливаа асуудлыг оруулахдаа эхлээд тайлбарыг нь оруулмаар байгаа юм. Хэдэн хүн шийдсэн юм чинь бас нэг тодорхой үндэслэлтэй байж байгаад шийд тавина шүү дээ. Тайлбарыг нь хэлүүлээд, сүүлд нь өөрчлөх үү эсэх үү гэдэг дээр горимын санал хураагаад ингээд өөрчилнө гэх юм бол чухам ямар хувилбараар өөрчлөх вэ? өөрчлөхгүй юм гэх юм бол цөөнх, олонхио болоод ярьдаг дүрэм журам бий шүү дээ. Бид бол тэгсэнгүй л дээ өнөөдөр.

Тэгэхлээр одоо өнөөдөр бид ямар ч байсан энэ асуудлыг дуустал нь хуралдах ёстой байх аа гэж бодож байна. Тэгвэл бид цаашдаа хуралд суух, сонгогчидтойгоо эргэж уулзах ёс суртахууны эрхээ гэх юм уу даа олж авах юм. Энэ ордон манай тойргийн нутаг дэвсгэр дээр байдаг юм л даа. Өглөө, орой сонгогчидтойгоо уулзах боломж, бололцоо бусад тойргийг бодвол надад арай илүү юм. Үнэхээр одоо өнөө орой гараад явахад би зүгээр сонгогчид таарах эсэхийг мэдэхгүй байна, улсынхаа нэр, энэ бидний хэлэлцэж байгаа төслийн хавтаснаас цаашаа явсангүйдээ гэж хэлэхэд нүүр улайж байна. Өнөөдөр ямар ч байсан энэ асуудлаа дуусгах хэрэгтэй байна. Дуусгахын тулд бид бол

## 3.

бие биеэ тэвчээртэй сонсох, өрөөсөө гаднын орж ирж байгаа шинэ нотолгоо баталгааг хүлээж авах тийм чацвараа сэргээмээр байна. Энэ бол уриалгын чанартай юм. Горимын чанартай саналаа хэлсэн. Баярлалаа.

Ардын Их Хурлын 288 дугаар тойргийн депутат  
С. Баярцогт:

—Өнөөдөр дуустлаа хуралдъя гэдэг дээр санал хураалгах гээд түрүүн Ламжав гуай гаргасан, Зориг гаргасан, одоо ингээд гишүүд гаргаад байна. Энэ дээр санал хураах нь зүйтэй юм.

Ж. Уртнасан:—Асууцлыг шийдвэрлэлтээ ярьж гэж бид тогтсон шүү дээ.

Ардын Их Хурлын 14 дүгээр тойргийн депутат С. Лхагвасүрэн:—Би өөрийнхөө бодож байгаа юмыг хэлмээр байна л даа. Би өөрөө үйлдвэр худалдааны хүн байгаа юм. Аж ахуйн ажил хийдэг. Монгол улс маань өнөөдөр яаж байна гэхлээр өөрчлөлт шинэчлэлт хийчихсэн, улс төрийн өөрчлөлтөөсөө урд, хойд хоёр хөршөөсөө тэртээ тэргүй бид түрүүлчихсэн байгаа. Эдийн засгийнхаа шинэчлэлийг мөн адилхан хийж эхэлж байна. Тэгэхлээр яаж байна гэхлээр үнэхээрийн Энэбиш дарга сая хэлж л байна л даа. Бид нэр сольсноос хоёр улсын хэрэгт хөндлөнгөөс оролцож байна гэж байх шиг байна. Би бол бодохдоо энэнийг үгүй байхаа гэж бодож байна. Үнэхээрийн миний хувьд бол юу гэж бодож байна гэхлээр Монгол улс гэдэг чинь өнөөдөр тэртээ тэргүй та бүхэн мэдэж байгаа. Миний ярьж байгааг тэртээ тэргүй радио, телевизээр гаргахгүй байхыг хүсч байна. Тэртээ тэргүй энэ чинь Өвөр монгол, Буриад монгол гээд байж байна. Бужигнадаг юм бол аль хэдийнэ бужигачихсан гэж дотроо би бодож байгаа. Тэгэхлээр бид үнэхээрийн өөрчлөлт шинэчлэлт хийе гэж байгаа юм бол нэгмөсөн хийхгүй бол хоёрын хооронд дутуу алсан могой шиг ийм юм хийчихлээр чинь болохгүй байна.

Би та нарт ганц хоёрхон зүйлийг хэлж өгье гэж бодож байна. Дэлхийн 2 дугаар дайны үед Швейцар улс яагаад дайнд бага өртөгдсөн юм бэ? Өнөөдөр Кувейтийн асуудал яригдсан шүү дээ. Асууцлыг та нар бүгд мэдэж байгаа. Яагаад Кувейтийг Ирак эзлэн

түрэмгийлээд ороод ирэхлээр дэлхийн дайн болох гэж байна. Энэ чинь яаж байна гэхлээр тэр улсын тусгаар тогтнол бол зөвхөн тэр Кувейтийн үндэстний асуудал байгаагүй, Швейцарын асуудал ганцхан Швейцарын асуудал байгаагүй. Ийм учраас яаж байна гэхлээр монголын тусгаар тогтнолын асуудлыг үнэхээрийн ингэж ярьж гэж бодож байгаа юм бол тодорхой хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт манайд бол зайлшгүй шаардлагатай. Бид чинь асар их хэмжээний газар нутагтай байж байна. Мөнгө хөрөнгө байхгүй байж байна. Цөөхөн хүн амтай байж байна. Тийм учраас би юу гэж бодож байна гэхлээр тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт нэгдүгээрт хэрэгтэй. Энэ хөрөнгө оруулалт хийхийн тулд аль болохлоор бид хоёр том гүрнээсээ давуулж өндөр хөгжилтэй Америк ч байдаг юм уу Японоос оруулах нь зайлшгүй гэж би цотроо боддог юм. Гэтэл өнөөдөр энэ Америк, Японы нөхдүүд манайхыг юу гэж үзэж байна гэхлээр Монгол улс бол аргагүй өөрчлөлт шинэчлэлтийн замаар явж байгаа улс орон мөн гэдгийг тэртээ тэргүй хүлээн зөвшөөрч байна. Гэхлээ энэ зам дээрээ тууштай зогсч чадаж байна уу үгүй юу гэдгийг өнөөдөр тэр улсууд харж байна.

Монголыг бол өнөөдөр тэр нөхдүүд ажиглагчийн байр суурин дээрээс харж байгаа шүү дээ дэлхийн улс орнууд. Ингээд бол би юу гэж хэлэх гээд байна гэхлээр монголыг бол ердөөсөө энэ чинь ардчилал, шинэчлэлийн замд тууштай орчихсон орон гэж үзээгүй, монголыг өнөөдөр өнгөн дээрээ бол тэтгэж байгаа боловч цаанаа бол энэ одоо социалист орнуудад хэрэглэдэг, монголчууд бол гуравдагч ертөнцийн орон гэдэг үзэл одоо болтол хэвээрээ байгаа гэдгийг нэгдүгээрт бүгд ойлгох хэрэгтэй. Гэтэл гаднын хөрөнгө ингэж орж ирэхгүй байсаар байтал өнөөдөр та нар эдийн засгийн байцлыг харах хэрэгтэй шүү дээ. 47 хамтын үйлдвэр, энэ тэр ингээд байгуулагдсан чинь тэрний 50, 60 хувь нь Монгол-Гонконгийнх, Монгол-Америкийнх, Монгол-Сингапурын хамтарсан пүүсүүд байгуулагдлаа гэсэн чинь Монгол, Гонконгод суудаг хятад, Америкт суудаг хятад, дандаа цаагуур нь нийлээд хятадын цагаачид орж ирж байна. Эцсийн эцэст

бид үйлчилгээнийхээ салбарыг ингээд гаднын юм оруулж ирэл-  
 гүйгээр, доогуур нь тэртээ тэргүй бид чинь үйлчилгээ маань  
 60 гаруй хувийг алдах ийм вариантанд байна аа. Тэгэхлээр би  
 Японы үйлдвэр худалдааны том саятантай уулзаж ярилцаж байсан л  
 даа. Танайх яагаад ингээд юу яахгүй байна аа. Манайд хөрөнгө  
 оруулж хамтарсан үйлдвэр барья гэхэд тэр хүн тэгж байсан.  
 Хамаа байхгүй, чи тодорхой хэмжээний, би яах вэ асууцлаасаа  
 хальж байж болно, та бүхэн уучлаарай, хамтын үйлдвэрт  
 гэрээ контракт зураад эцсийн мөнгөн вариантанд гарын үсэг  
 зурах гэсэн чинь чиний улсаасаа түрээслээд авсан газар чинь  
 хаана байна.

Чиний газар дээр би үйлдвэр барихгүй юм бол Монгол улсын  
 одоо тэр эзэнгүй газар дээр барьж хэзээ нэгэн цагт тэр  
 юунд орохгүй, ердөөсөө орохгүй нэгдүгээрт гээд ийм асуудлуу-  
 дыг гадаадын бүх үйлдвэр худалдааны нөхдүүд энэнийг хэлж  
 байгаа. Газрыг ч баталгаатай болгох хэрэгтэй. Бид улсынхаа  
 нэрэн дотроос ард гэдэг үгийг үнэндээ авч хаях хэрэгтэй.  
 Ард гэдэг үгнээс чинь гадаадынхан яаж байна гэхлээр, энэ  
 бол коммунистууд гэдэг ойлголт тэртээ тэргүй энэн дотор  
 байж байна, БНМАУ гэдэг чинь ерөөсөө социализм дэлгэрсэн  
 орнуудын хэв загвараасаа үнэхээрийн татгалзъя гэвэл татгалз-  
 сан шиг татгалзах хэрэгтэй. Татгалзахгүй гэх юм бол хоёрын  
 хооронд ийм юм хийгээд хэрэггүй л гэж би бодож байна.

Ардын Их Хурлын 257 дугаар тойргийн депутат  
 Ч.Цэрэндагва:— Тэгэхлээр би энэ хурлыг явуулж байгаа журмын  
 талаар шүүмжлэлийн чанартай хэцэн үг хэлье гэж бодож байна.  
 Хэрвээ бид цаашдаа иймэрхүү горим журмаар хурлыг удирдаж  
 явуулбал асуудлыг шийдэж нэгдсэн тохиролцоонд хүрэх арга  
 алга байна. Жишээ хэлье. Бид анх тохиролцоод Бага Хурлаас  
 оруулж ирсэн улсын нэрийг үлдээгээд хажуугийн саналууд  
 дээр ярилцъя гэж тохирсон. Монгол улс, БНМАУ, БНМУ гэсэн  
 хажуугийн саналууд дээр ярилцъя гээд энэ дээр саналыг нь  
 хэлсэн. Хоёр цаг хэртээ энэ улсууд хажуугийн саналын талаар



## 6.

ярьчихаад яг санал хураадаг дээр болохлоор эргээд өшөө журам гараад ирж байна. Тэгээд одоо журам гаргачихаад тэрийгээ ярьчихаад бас яг одоо санал хураагаад ярьдаг дээр болохлоор бас өргөн шүүмжлэл уруу орчихож байна.

Ингээд тэгвэл монгол улс гэдэг нь тайлбараа хэлье гэж ярьж эхэлдэг, бас хажуунаас нь бусад нь яриад эхэлдэг, тэгээд ингээд нэгэнт тогтсон горимынхоо саналын эцсийн шийдвэрийг үеэж байж дараагийнхаа асуудал уруу орно гэхээс биш ингээд замаас нь хаяад хажуунаас орж ирсэн горимын саналуудыг авч хэлэлцээд тэрийг түрүүчийнх гээд хаячихаад дараагийнх уруугаа яваад байх юм бол бид яаж асуудал тохиролцоонд хүрэх юм бэ? Тийм учраас хэрвээ түрүүчийнхээрээ үлдээд Бага Хурлын төслийг Монгол улс гэдгээ орхиод хажуугийн саналуудаа хэлэлцсэн саналаа ахиж хураагаад цөөнх болбол одоо Монгол улс гэдэг санал дээр эогсож байгаа улсууд нь тайлбараа хэлэх нэг журам уруугаа ормоор байна.

Эсвэл ерөөсөө түрүүчийнхийгээ хаячихаад зөвхөн монгол улсаа дахиж сонооё гэж байгаа бол дан ганц Монгол улс гэдэг талынхаа санал дээр байгаа улсууд үндэслэлээ бүрэн хэмжээгээр гаргаж хэлүүлмээр байна. Тэгэхгүйгээр энэ чинь эавсраас нь юм орж ирээд болохгүй байна шүү дээ. Энэнийгээ нэгдэж тогтож байж энэ асуудлаа ярьж шийдэж, тэгж бид ойлгож энэ хуралдаанд оролцооор байна, эцсийн эцэст би алинд нь оролцохоо мэдэхээ байлаа. Энэнийгээ нэг журамлавал яасан юм бэ? Гишүүд ч гэсэн анхаарахад юу байна гэхлээр түрүүчийнхээ тогтсон горимын саналын хүрээнд тэрийгээ шийдэж байхад хажуунаас нь шинэ горимын санал гаргаж түрүүчийнхээ шийдсэн кмаа үгүйсгэж болмооргүй байна. Гардаг юм бол тэр саналыгаа хэрэгжүүлэхэд л горимын санал гарна уу гэхээс биш үгүйсгэж болохгүй гэж би бодож байна. Тийм учраас би хоёр саналаа хэллээ. Түрүүчийн санал бол хүчинтэй байсан. Монгол улс гэдэг Бага Хурлын саналыг хэвээр нь үндсэн санал гэж үзээд хажуугийн санал дээр ярилцана гээд саналаа сонссон. Одоо саналаа хураалгамаар байна. Хураалгаад хэрэв Монгол улс гэсэн нь цөөнх болбол маргаашаас эхлээд Монгол улсаа хамгаалах улсууд

К.Зардыхан /4 дүгээр тойргийн депутат/ -Би түрүүн Монгол улс гэдэг нэрийн асуудлаар өөрийнхөө санал бодлыг хэлэх санаатай түрүүн нэг боссон.Гэтэл ярьж байгаа асуудал өөр болоод явчихлаа.Би энийг чухам юу ярилцаж байгаагаа нэг их тийм тодорхой төсөөлөхөө байчихлаа.Ийм учраас би монгол улсын нэрийн талаар хэлэх зүйлийг эрхэм депутат Цэрэндагвын хэлснээр хойш нь тавиад хоёр гурван зүйлийг хэлье гэж бодож байна, нэгэнт босож ирсэн учраас энийг хэлэхээс аргагүй байна.

Бид нар 8 хоног хуралдаж байна, бараг 9 дэх хоногтоо хуралдаж байх шиг байна.Хуралдаж байх явц дунд тодорхой, томоохон хэсгийн бодол санаа юун дээр тулж ирэвээ гэвэл үндсэн 7 зүйл дээр тулж ирлээ.

Нэгдүгээрт хуулийн нэрийг өөрчилж болохгүй, улсын нэрийг өөрчилж болохгүй, газрыг өмчлүүлж болохгүй, парламент хоёр танхимтай байна, орон нутгийн засаг захиргааг хөндөж болохгүй, ~~сүлд, тугийг хөндөж болохгүй.~~ Үндсэн хуулийн шүүх хэрэггүй гэсэн ийм л ойлголтууд байна. Ийм байдлаар асуудлыг авч үзэх юм бол шинэ Үндсэн хууль хэрэггүй.Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль энэнд бүрэн хариулна.Энэ бүх юманд.Яг та нөхдийн, зарим нөхдийн хэлж байгаагаар яг байж байгаа.

Бид шинэ тогтолцоонд шилжиж байна.Шинэ үндсэн хууль баталъя гэж байгаа бол асуудлыг өөрөөр ярих ёстой.Энэ 7 зүйл дээрээ хатуу тогтог гэж МАХН-ын төв хорооны тэргүүлэгчдээс та бүхний гарт тараасан бичгээрээ явъя гэж байгаа бол шинэ Үндсэн хууль ярих хэрэггүй, магадгүй бидний дараахь үе ч байдаг юм уу, хэдэн жилийн дараа энэ ардчилал жаахан гүнзгийрсний дараа ярих шаардлага гарч магадгүй.Ийм учраас асуудлыг бүрэн бие дааж шийдэх ёстой депутатууд цугларч, энд төрийн хэрэг ярьж байгаа бол депутатууд депутат гэсэн байр суурин дээрээ байж бид яривал энэ улс оронд тустай зүйл болох болов

## 6.

ярьчихаад яг санал хураадаг дээр болохлоор эргээд өшөө журам гараад ирж байна. Тэгээд одоо журам гаргачихаад тэрийгээ ярьчихаад бас яг одоо санал хураагаад ярьдаг дээр болохлоор бас өргөн шүүмжлэл уруу орчихож байна.

Ингээд тэгвэл монгол улс гэдэг нь тайлбараа хэлбэ гэж ярьж эхэлдэг, бас хажуунаас нь бусад нь яриад эхэлдэг, тэгээд ингээд нэгэнт тогтсон горимынхоо саналын эцсийн шийдвэрийг үзэж байж дараагийнхаа асуудал уруу орно гэхээс биш ингээд замаас нь хаяад хажуунаас орж ирсэн горимын саналуудыг авч хэлэлцээд тэрийг түрүүчийнх гээд хаячихаад дараагийнх уруугаа яваад байх юм бол бид яаж асуудал тохиролцоонд хүрэх юм бэ? Тийм учраас хэрвээ түрүүчийнхээрээ үлдээд Бага Хурлын төслийг Монгол улс гэдгээ орхиод хажуугийн саналуудаа хэлэлцсэн саналаа ахиж хураагаад цөөнх болбол одоо Монгол улс гэдэг санал дээр зогсож байгаа улсууд нь тайлбараа хэлэх нэг журам уруугаа ормоор байна.


Эсвэл ерөөсөө түрүүчийнхийгээ хаячихаад зөвхөн монгол улсаа дахиж сонооё гэж байгаа бол дан ганц Монгол улс гэдэг талынхаа санал дээр байгаа улсууд үндэслэлээ бүрэн хэмжээгээр гаргаж хэлүүлмээр байна. Тэгэхгүйгээр энэ чинь завсраас нь юм орж ирээд болохгүй байна шүү дээ. Энэнийгээ нэгдэж тогтож байж энэ асуудлаа ярьж шийдэж, тэгж бид ойлгож энэ хуралцаант оролцоомор байна, эцсийн эцэст би алинд нь оролцохоо мэдэхээ байлаа. Энэнийгээ нэг журамлавал яасан юм бэ? Гишүүд ч гэсэн анхаарахад юу байна гэхлээр түрүүчийнхээ тогтсон горимын саналын хүрээнд тэрийгээ шийдэж байхад хажуунаас нь шинэ горимын санал гаргаж түрүүчийнхээ шийдсэн юмаа үгүйсгэж болмооргүй байна. Гардаг юм бол тэр саналыгаа хэрэгжүүлэхэд л горимын санал гарна уу гэхээс биш үгүйсгэж болохгүй гэж би бодож байна. Тийм учраас би хоёр саналаа хэллээ. Түрүүчийн санал бол хүчинтэй байсан. Монгол улс гэдэг Бага Хурлын саналыг хэвээр нь үндсэн санал гэж үзээд хажуугийн санал дээр ярилцана гээд саналаа сонссон. Одоо саналаа хураалгамаар байна. Хураалгаад хэрэв Монгол улс гэсэн нь цөөнх болбол маргаашаас эхлээд Монгол улсаа хамгаалах улсууд

7.

нь тайлбарлаж хэлмээр байна. Ийм л саналтай байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР



Бичээч Л. Хорлоо

уу гэж бодож байна.

Намайг хамгийн сүүлд энэ асуудлыг хэлэхэд хүргэсэн нэг шалтгаан бол үндсэндээ сонсогдохгүй байсан нэг үг сонслоо. Сая тэр надад бол их эмзэг сонсогдож байна. Бодвол ганцхан би биш, эарим хүмүүст эмзэг сонссон бололтой. Тийм учраас би нэг их ташаараагүй болов уу гэж ингэж бодогдож байна. Өнөөдөр хөдөлмөрчид өлсөж байна, бараг дөрвөн хөллөж байна, юу ч байхгүй боллоо. Бараг тамхи гуйж татаж байна гэх мэтчилэнгийн зүйл яриад, эцэст нь юунд хүргэв гэхээр МАХН хөдөлбөл хөдөл, хөдлөх цаг чинь болсон шүү, хөдлөхгүй бол чамаас гараад бид хөдөлмөө шүү гэдэг тодорхой хүчин энэн дээр үгээ хэллээ. Энэ бол маш том асуудал гэж би бодож байна. Энэ бол нэг хүний санал биш гэж бодож байна.

Өнөөдөр монгол орон ардчилал руу шилжих үү, ардчиллаас ухрах уу гэдэг ийм зааг дээр тулж ирчихээд байгаа. Энэ зааг дээр хоёр зүйл дээр мордчихоод байгаа, тодорхой хүчин бол. Нэгдүгээрт эдийн засгийн бэрхшээл дээр мордчихоод байна, хоёрдугаарт хөдөлмөрчдийн сэтгэл санаа нэлээн яриад, хөдөлмөрчдийн сэтгэл санааг нэлээн үймүүлээд, тэр яг тэрэн дээрээ мордчихоод байна. Энэ хоёр дээрээ мордоод давхих гэж байна. Энэн дээр хуучин Үндсэн хуулиа хэвээр хэрэглэж магадгүй гэдэг байдал бол ажиглагдаж байна. Хэрэв ийм байдлаар асуудалд хандах юм бол бид ирээдүйн өмнө, энэ монгол орны өмнө, монголын түүхийн өмнө нүгэл хийнэ. Депутатуудад ухаан байна. Депутатуудын ухааныг битгий хавчиж боогооч. Өөр өөрийнхөө ухаан санаагаар ажиллаж, монгол улсыг энэ үндсэн, ардчилсан маягийн байдаг юм уу Үндсэн хуультай болгож, ингээд бид үүргээ гүйцэтгэвэл яасан юм бэ? Тэгээд дараагийн үе бол биднийг шүүх байх. Энэ шүүхийн өмнө буруутан нь хэн бэ гэдэг хариуцлагыг бие биенээсээ эрээд хэрэггүй. Түүх өөрөө олж авна энийг.

Өнөөдрийн тэр гэмтэн, тэр гэмгүй гэдгээр шүүхгүй, тэрнийг Түүх өөрөө шүүж авна. Энэн дээр жаахан бодол санаа гаргаж ажиллах юм биш үү гэж би хэлмээр байна.

## 3.

Ү.Аварзэд /390 дүгээр тойргийн депутат/ -Би олон юм хэлэхгүй. Нэг тодорхой санал хэлье. Бид ерөөсөө зөрөлдсөөр байгаад ~~цэгцэрхэж~~ маргалдсаар байгаад, үзэл санаагаар зөрсөөр байгаад ер нь аятай тохиролцоонд хүрч чадахаа байлаа. Нэг ёсондоо цөмөөрөө тархи нь эргэчих шиг боллоо ер нь. Ингэхээр биднийг сонгох байтугай, биднийг төрүүлсэн ард түмэн бий. Тэгэхээр Зардыхан даргын ярьж байгаачлан бид Үндсэн хууль хэрэггүй гэж үзэхгүй байна. Хэрэгтэй заавал батлах ёстой.

Тэгэхдээ би ер нь нэг ийм юм хэлэх гэж байна. Энэ улсын нэр өөрчлөх, тэр газрын тухай асуудал, орон нутгийн засаг захиргааны асуудал ер нь ийм гол гурван юм байна. Зүгээр энэ туг, сүлд зэргийн юмыг ямар ч байсан бид тохирч болох байх. Иймэрхүү юмаар бүх сонгогчдынхоо санал хураалтыг явуулъя. Ерөөсөө ийм байдлаар хуралдаж байсан дор бол бид маргааш нөгөөдөөс цөмөөрөө тойрог тойрог руугаа нисэцгээгээд 10 хоног завсарлаад тэгээд тэр санал хураалт явуулаад хүрч ирээд хуралдвал дээр юм биш үү. Энэ чинь одоо ерөөсөө нийт сонгогчид, ард түмний зөвшөөрөлгүйгээр ерөөсөө нэг иймэрхүү улсын нэр, газрын асуудал, энэ орон нутгийн засаг захиргааны асуудлыг өөрчлөх эрх чухамдаа бид эдэлж болмооргүй санагдаж байна. Ийм л зүйл байна.

Ж.Норовсамбуу /303 дугаар тойргийн депутат/ -Бид Ардын Их Хурлын II хуралдаанаар манай хууль тогтоох дээд байгууллагаас сонгосон Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Монгол улс байж болох талаас нь боловсруулсан хувилбар хуулийн төслийг Ерөнхийлөгчийн тайлбар илтгэлтэйгээр сонсож байна. Энэ сонсооньхоо үндсэн дээр бид депутатууд шүүн тунгааж ярилцаад Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг тогтолцоог байлгах уу үгүй юу гэдгийг бүх депутатуудаар санал авч, энэнийхээ үндсэн дээр цөөнх олонхи болж үндсэн саналаа өрнүүлэх ёстой байсан гэж би хувьдаа бодож байна.

Депутат, Бага Хурлын орлогч дарга Зардыхан сая ярихдаа нам улс төржүүлэх асуудлыг хүндрүүлэх үүднээс нь битгий хан-

даачээ гэж бас зөвлөж хүсмээр байна. Бидэнд өгсөн лавлагаа бол хэд хэдэн парламентын намын лавлагаа бий шүү. Бид янз бүрийнхээ санал бодлыг уралдуулж байгаа шүү. Монгол ардын хувьсгалт намаас өгсөн лавлагаа бол бүх намын санаа бодлыг бичсэн байгаа шүү. Энэ одоо еөрт чинь байгаа байх гэж бодох юм, өнөөдөртөө. Тэгвэл бүх намынх байгаа шүү Зардыхан депутатаа.

Гуравдугаарт, бид улс төрийн зүтгэлтний хувьд, төрийн төлөөлөгчийн хувьд өнөөдөр улсаа төлөөлж үг хэлж байгаа. Тийм эрх хэмжээтэй улс. Биднээс гарч байгаа үг бол орон бүртээ хариуцлага авч байх ёстой. Ийм учраас бид нарыг төрийн төлөөлөгчид, улс төрийн зүтгэлтнүүд үг хэлж байна гэдгийг жигд ойлгож, энэ асуудалд хариуцлагатай хандах ёстой юм.

Бид асуудлаас асуудал руу шилжихдээ хурдатгах үүднээс биш, гарцыг нь бодох ёстой, механизмаа бодох ёстой. Ийм учраас миний горимын нэг санал бол Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн энэ санал дээр санал хураагаад завсарлах санал оруулж байна.

/Танхимаас/ --Нэг санал  
байна. Энэ Элбэгдоржийн саналыг дэмжмээр байна. Одоо энэ асуудал, комиссын дарга байж байна, Ерөнхийлөгч, Гончигдорж дарга байна, энэ хоёр хүнийг тэнд суулгаж байгаад жинхэнэ энэ хуулийн төслийг эзэн нь болж, субъект нь болж хэлэлцүүлмээр байна.

Тэгэхээр Элбэгдоржийн тавьсан асуудлыг бид дэмжихгүй бол болохгүй. Энийг л одоо авч хэлэлцмээр байна.

О.Очиржав /187 дугаар тойргийн депутат/ --Эрхэм депутат  
утатуудаа. Бид өнөөдөр монгол улсын Их цаазыг хэлэлцэж байгаа энэ завшаантай үйл явдалд оролцож байгаа ийм хувь тавилантай хүмүүс л дээ. Тэгэхдээ бид бас улс орон маань яаж амьсгалж, яаж ажиллаж байгааг бид харгалзахгүй байж болохгүй. Өнөөдрийн байдлаар гэхээр эдийн засгийн бэрхшээл тулгарч байна. Цас орж, цаг уурын байдал бас хүндрэх нь. Ер нь энэ цаг уурын

болон энэ эдийн засгийн бэрхшээлийг Үндсэн хуулийн хэлэлцүүлэгтэй холбох гэсэн тийм оролдлого байна уу даа гэж ингэж бид яримааргүй байна. Өнөөдрийнхөө бид бэрхшээл зовлон, энэ бухимдлаар магадгүй 20-30 жил үйлчлэх ийм Үндсэн хуулиа ийм үүднээсээ бид хэлэлцмээргүй байна. Тэгэхдээ энд уур амьсгалыг хараад байхад МАХН сая Зардыхан гуайн хэлдгээр тэр л дээ нэг лавлагаа тараасан. Тэр бол лавлагаа гэхэд тэр бол даалгавар маягийн тийм юм байгаа. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг тэр нэрийг үлдээнэ шүү гэсэн тийм маягтай. Тэнд Монголын ардчилсан намын байр суурь гэж гаргасан байгаа. Тэнд бол Монголын ардчилсан нам Үндсэн хуулийн талаар ямар байр суурь гаргасан бэ гэдгийг та бүхэнд хэлье. Энэ Үндсэн хуулийг Их цаазын төслийг зарчмын хувьд дэмжиж байна гэсэн тийм л байр суурь гаргасан. Тодорхой асуудлаар МоАН-ын байр суурь гараагүй.

Янахав би тэр асуудлыг лавлан хариуцаж байсны хувьд нэг илтгэл оруулсан. Тэр илтгэлийг хэлэлцээд гарсан зарчмын дүгнэлт нь тэр төслийг үндсэнд нь дэмжиж байна. Түүнээс улсын нэр тийм байна, хуулийн нэр тийм байна гэсэн тодорхой тийм байр суурийг бид гаргаагүй. Депутатуудынхаа гар хөлийг, сэтгэн бодох энэ чадварыг бид хааж бооё гэж бодоогүй. МАХН хэрэв Их цаазын төслийн талаар тодорхой байр суурьтай байсан бол бүх депутатуудад тарааж болох байсан. Тэгсэн эндээс юу гарч байна вэ гэхээр өөрийнхөө гишүүдэд тараагаад та нар энийг ерөөсөө ингээд барина шүү гээд, эндээс бас нэг үл ойлгогдох байдал үүсч байгаа юм.

Өнөөдөр Ерөнхийлөгчийн оролцоотойгоор бүлгүүдийн хуралдаан дээр МоАН-ын бүлэг ямар санал тавьсан бэ гэхээр ээрэг ер нь хурлын үйл ажиллагааг идэвхжүүлье, энд улс орны хувь заяаны төлөө хувийн хариуцлага хүлээх ёстой хүмүүс байна. Тухайлбал, БНМАУ-ын төрийн тэргүүн Ерөнхийлөгч байна, Дэд ерөнхийлөгч байна, энэ хоёр хүний оролцоо үнэхээр харагдахгүй байна. Магадгүй хардалт тулгалтын үүднээсээ тэд нар биеэ бариад суугаад байна. Энэ хоёрын оролцоог Их цаазыг хэлэлцэхдээ идэвхжүүлмээр байна. Бид Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдаанаар ямар



ямар нэг Засгийн газрын тайлан юм уу, өөр эс бус асуудал хэлэлцэж байгаа биш, Үндсэн хууль, Их цаазын төслийг хэлэлцэж байгаа болохоор энэ хоёр хүний хариуцлагыг идэвхжүүлбэ. Ер нь хурлын дарга нар бол хурлаа удирдана. Хурлын дарга хэвээрээ байна. Гэхдээ Их цаазын төслийг хэлэлцүүлэх ажлыг Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хоёр хөтөлж явуулаачээ. Хурлыг даргалах үүднээсээ энэ таван хүн даргална. Энэ хэлэлцүүлгийг хөтөлж явуулах, өөрсдөө тэр хоёр удаа Бага Хурлаар хэлэлцсэн, комиссын даргын хувьд энэ хүмүүс энэ хэлэлцүүлгийг хөтөлж, уур амьсгалыг бас ойлгож ингэж явбал яасан юм бэ гэдэг ийм санал тавьсан.

Нөгөө талаар бид Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд оруулсан Их цаазын төсөл бод бидний хэлэлцэж байгаа үндсэн баримт бичиг. Үүнийг үгүйсгээд надад нэг ийм хувилбар байна. Тэнд нэг ийм хувилбар байна гээд ингэж үгүйсгэмээргүй байна. Бид хэлэлцэх асуудал дээрээ тогтсон шүү дээ. Их цаазын төслийг хэлэлцэнэ. Түүний чинь баримт бичгийг хэн боловсруулсан юм бэ? Гол баримт бичиг маань Улсын Бага Хурлаас өргөн барьсан ийм төсөл байгаа. Дэгийн асуудал дээр бид бас өдөр дэгээ барья гэдэг санал тавьсан л даа. Энэ асуудал нэлээн яригдсан. Өөр нэг зүйл бол ард түмний зөвшөөрөлгүйгээр бүх юмыг өөрчлөхгүй, өөрчлөххийн эсрэг байгаа хүмүүс байна. Тэгэхдээ бид нар бас Ардын Их Хурал гэдэг маань юу билээ? Үндсэн хуулиндаа бол Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага. Бүрэн эрхэд маань бид нар бол Ардын Их Хурал бол Монгол улсын Үндсэн хуулийг шинэчилнэ гэсэн байгаа. Энэ эрхээсээ бид татгалзаж, элдэв бусын юм руу ингэж чихэж, цаг үеийн байдлаар ингэж тогломооргүй санагдаад байх юм.

Б. Чимид /396 дугаар тойргийн депутат/ -Энэ нэг ийм юм болоод байна даргаа. Монголоороо хэлэлцэнэ гэсэн нэг ойлголт байнаа. Монголоороо хэлэлцье, гадаадынх ямар хамаатай юм гээд ийм юм яриад байна. Тэгэхээр аливаа орны төрийн дээд байгууллага хууль тогтоодог, дэлхийд 700 жил мөрдсөн заншлын журам байна. Бид бусад улс гүрнийг ажиглаж сурах ёстой. Бид 8 өдөр яагаад ганц ч юм баталж чадаагүй вэ гэвэл эхнээсээ технологийн гажуудал гаргасан. Бид НҮБ-ын хурал шиг, намын их хурал шиг

өргөн шүүмжлэл гэж ойлгогдохгүй юм явуулсан. Одоо тэр өргөн шүүмжлэл дуусаагүй байна. Хууль хэлэлцдэг дэгээр явъя гэдэгт бүх депутат одоо захирагдмаар санагдах юм. Нэгдүгээрт энэ байна.

Хоёрдугаарт янз бүрийн тараад явъя гэдэг санал гаргаад байна. Тийм биш. Бид ерөөсөө хуулиа батлахын төлөө ажиллах ёстой байх. Ард нийтийн саналыг хэдэн асуудлаар хураая гэж байна. Тэгэх юм бол энэ Үндсэн хууль батлах ажил лав хагас жилээр хойшилно. Тодорхой асуудлаар санал хураалт буюу 1945 онд явуулсан **плебистит** гэдгийг явуулна гэвэл эхлээд **плебиститийн** хууль гаргах хэрэгтэй. Хуулийн төсөл бидэнд байхгүй. Тэр чинь яг сонгууль шиг явдаг зүйлээ. Нэг хоёр хүн очоод, хэдэн хүн цуглуулаад хураадаг зүйл биш. Бүр хуулиар явдаг зүйл. Зүгээр тав хоногт багтааж явуулдаг бидний арга бий. Тэр бол энэ ард нийтийн санал хураалт бишээ. Энэнээс болоод бид алдаж байсан. Ерөөсөө хэсэг хүний санал авчихдаг. Тэгээд олонхи нь байна гээд хооронд нь харьцуулаад тулгаад байдаг. Энэнээс болоод бодлого дээр алддаг юм их байна.

Хэрэв жинхэнэ ард нийтийн санал хураая гэж байгаа бол энэ бол намуудын талаар санал хураасны яг тийм адил байх ёстой. Бид чинь бидний монгол улсад хурааж байгаа санал хураалт чинь хүчин төгөлдөр үү, үгүй юу гэж дэлхийн улсууд хардаг юмаа. Бид ганцаараа саран дээр оршоогүй байна. Тийм учраас тэр асуудлыг ерөөсөө хойш тавих хэрэгтэй. Хэрэв тэгж үзвэл Их Хурлын энэ хуралдааныг дуусгавар болгох хэрэгтэй. Тэгж байж, хууль гаргаж байж санал хураана. Энэ бол хагалан бутраах гэсэн үйл ажиллагаа биш. Ерөөсөө цаад ажлын жам нь тэр юм. Зүгээр тойрог тойрог дээрээ депутатууд яваад санал асуугаад, тэрийгээ манай тойрог ингэж байна, тэр тойрог ингэж байна гээд яриад байна гэвэл тойргийн чинь сонгогчид мөн 4-5 саналтай байгаа. Улсын 10-аад нэр байна. 10-аад нэрийн жагсаалт байна. Энд. Бид голлож байгаа хоёр дахь нэрээр оруулсан. Нэгэнт хэлэлцүүлсэн учраас. Тэгэхээр ийм юман дээр ингэж маргалдаад баймааргүй байх юм.

За өөр нэг зүйл бол бид бусдын замаар явах нь ээ.Зарим одоо социализмаас гарч зах зээлд орж байгаа орон Үндсэн хуулийн төсөл боловсруулчихаад парламентаараа хэлэлцэх гээд чадахаа байгаад парламент нь тараад сонгууль явуулж байна. Ийм байна шүү.

Монгол улсын Их Хурлын хуралдаан дээр бусад улсын дотоод амьдралын асуудал, бусад улсын гадаад бодлогыг авч хэлэлцмээргүй байна.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН

*Ш.Зурмаа*

БҮРМЭЭ

Бичээч Уранчимэг

1991.XI.19.

Кассет № IY<sub>5</sub>

21.16-21.24

144 дүгээр тойргийн депутат Ц.Доохууз:

-Элэнц хуланцын замаар орчихлоо бололтой.Түрүүчийн санал хурааснаас би ингэж ойлгосон.Монгол улсын төлөө гэдэг нэрэн дээр 68 хувийн санал авсан, олонх болсон. Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг дээр 55 хувийн санал авсан.Бүгд Найрамдах Монгол Улс гэдэг дээр 40 хувийн санал авсан.Ингээд Монгол гэдэг нь олонх болоод нөгөө хоёр нь хажуугийн бага санал боллоо.Тэгээд энэний талаар улсууд ярих болсон.25 хүн ярьсан.Тэгээд тасалсан.Тэгэхээр миний ойлгож байгаагаар бол нэгэнт 25 хүн ярьчихлаа.Өөрийнхөө бүгд Найрамдах Монгол Ард Улс юмуу, Бүгд Найрамдах Монгол Улс гэдгийг баталж ийм байх нь зүйтэй юм гэдгийг ярьцгаа-лаа,25 депутат.Тэгэхээр энэ 25 депутатын саналыг зүйтэй, зүйгүй юу гэж дахиж гар өргөх ёстой болж байна.Өргөх ёстой гэж би ингэж санаж байна.Өргөлөө, хэрвээ олонх болбол 68 хувиараа санал олонх болсон байгаа.Тэр цөөнх бол тэр цөөнхийн саналыг дахиад ярих хэрэгтэй болно, хамгаа-лах хэрэгтэй болно.

Ингэхээр миний ойлгож байгаагаар одоо тэр Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн 55 хувийн саналыг дахиж нэг гар өргүүлмээр байна.Нөгөө Бүгд Найрамдах Монгол Улс гэсэн 40 хувийн саналыг бас нэг гар өргүүлээд тэгээд олонх болж чадах уу, үгүй юу гэдгийг шийдээд бид тарах хэрэгтэй байна.Маргааш Монгол Улс гэсэн 68 хувийн санал авч байсан улсууд цөөнх болсон бол маргааш өөрийгөө хамгаалаад яриг, бид сонсьё.Ингээд асуудлыг шийдвэл яасан юм бэ? Энд олонхийн саналыг сонсож эхэллээ, цөөн-хийг сонсож эхэллээ.Хоорондоо маргалаа, дахиад дэгийн тухай асуудал ярилаа.Энэ чинь хязгаар хэмжээ ерөөсөө байхгүй болсон байна шүү дээ.Бидэнд чинь цаг хэрэгтэй байна, хоол ундаа идэх хэрэгтэй байна, амрах хэрэгтэй байна.Ийм балиар заваан юман дотор хутгалдаж байхаа болимоор байна.Үгүй бол, цөмөөрөө депутатуудаа үнэмлэхээ хураагаад тарцгаах хэрэгтэй байна.Ийм л саналтай байна.

Ш. Уртнасан: -Уучлаарай, эрхэм депутатууд аа, бид энэ горимоос гармаар байна. Дэгийн алдаа гаргасанд уучлалт гуйж байна. Тэгэхээр бидэнд хоёр санал хураалт явуулчихвал асуудлыг өнөөдөр бид шийдэж болмоор юм шиг байна. Бид парламентын шугамыг Чимид гуай зөв ярьж байна. Олон улсын парламентын дэг журмыг барилгүй яахав. Горимын хоёр санал хураалт явуулбал бид өнөөдөр асуудлыг нэлээд цэгцэлж болмоор байна.

Нэгдүгээрт, улсын нэрийг өөрчилнө. Улсын нэрийг өөрчилнө гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уучлаарай, сонсож байна уу, тэгээд учраа бид ярилцъя. Улсын нэрийг өөрчилнө гэсэн санал хураалт явуулна. Эсвэл хоёр дахь хувилбар маань бид нарын хажуугийн санал гэж үзэж байгаа Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж нэг санал хураалт хураагаад Бүгд Найрамдах Улс гэдэг санал хураавал энэ асуудал шийдэгдэнэ.

БНМАУ гэдэг дээр санал хураалт явуулахад энэ хэрэв дийлэнх олонх болчихвол улсын нэр өөрчлөгдөхгүй гэсэн энэ томъёолол гараад ирнэ. Энэ хоёр дээр санал хураалт явуулъя. БНМАУ нэгдүгээр хувилбар, 2 дугаар хувилбар БНМУ. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Эхлээд БНМАУ гэдгийг зөвшөөрөөд олонх нь болчих юм бол өөрчлөхгүй гэсэн утга гараад ирнэ. Хажуугийн хоёр санал дээр санал хураалт явуулна гэдэг зарчмын хувьд зөв байх гэж би бодож байна. БНМАУ гэж нэг санал хураалт явуулъя. БНМУ гэсэн томъёоллоор нэг санал хураалт явуулъя. Ингээд өнөөдрийнхөө хуралдааныг бид энэ хоёр санал хураалтаар цэглэх нь зүйтэй байх. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Эхлээд БНМАУ гэсэн санал хураалт явуулна. Эхний томъёолол БНМАУ.

Хажуугийн хоёр санал орж ирсэн уучлаарай, депутатууд аа. Хажуугийн хоёр санал бол манай үндсэн санал хуулийн төсөл

дээр Монгол улс гэж байгаа.Энийг та бүхэн сайн мэдэж байгаа. Энэ тухай бид өнөөдөр хөндөхөө болилоо.Хажуугийн хоёр санал бол БНМАУ, БНМУ гэж орж ирсэн.БНМАУ гэдэг дээр санал хураалт явуулахад 280 буюу 71 хувь нь зөвшөөрч байна.100 хүн буюу 25 хувь нь татгалзаж, 16 буюу 4 хувь нь түдгэлзсэн байна.

Хоёр дахь санал, хоёр дахь хувилбараар бид санал хураалт явуулъя, энэ зарчмын юм.БНМУ.Энэ хоёр дахь хувилбарыг үзэх нь зүйтэй л дээ.Уучлаарай, депутатууд аа, санал хураалтад бэлтгэнэ үү.Улсын нэр Бүгд Найрамдах Монгол Улс.

Уучлаарай, депутатууд аа, өнөөдрийн хуралдаанаа завсарлая.МАХН-ын бүлэг, МАХН-ын гишүүдийг эндээ үлдэхийг зарласан байна.

Ардчилсан эвслийн бүлэг "А" танхимд цуглаарай.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

**БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ 1991 ОНЫ  
II ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ 12 ЦАГТ АРДЫН ИХ  
ХУРДЫН II ХУРАЛДААНД ОРОЛЦОЖ БАЙГАА ДЕПУ-  
ТАТУУДЫН БҮЛГИЙН АХЛАГЧ НАРТАЙ ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТАНХИМД УУДСАН ЯРИАНЫ  
ТЭМДЭГЛЭЛ**

**П.Очирбат** Бид санал хуваагдаж 2 тийн яваад байгааг ажигла-  
лаа. Тэгэхээр санал нэгдэх ямар боломж байгааг бид ярьж дундах  
санал дээр тогтох депутатуудаас танихнуулбал ямар вэ?

"Үндсэн хууль" нэр дээр нэлээд санал гараад байна. Дангаар нь  
үүнийг шийдэх болмооргүй шиг байна. Тэгэхээр Чимидийн хэлдгээр  
Монгол улсын Үндсэн хууль гэдэг дээр тогтвол ямар вэ? Үүнээс  
өөр ямар хувилбар байна? Дан ганц нэр томъёогоор зүтгүүлээд  
ажилт олохгүй нь. Мөн улсын нэр дээр их яриа болно. Иймд хамтад  
нь яриад шийдвэл ямар вэ?

**Р.Барсболд /УБ/** Чимид гуайн санал бол ерөнхийлөгчийн хэлснээр  
дундах, гэв чиглэлийг барьсан нэр санал бин үү. Бидний 2 гол  
асуудлыг шийдэх байна. Үүгээрээ болмоор гэх үзэх байна. Бид бүлгээ-  
рээ ярьж, энэ дигжлэлийг баримтлах нь зүйтэй гэж үзсэн. Их засаг,  
Их цааз дээр удаан маргмааргүй. Энэ саналыг бүлэг дэмжинэ.

**Баньд /Эннеговь/** Үр бүтээж багатай хураалдаа. Энэ байдал үр-  
галжлэх төлөвтэй байна. Хурлыг үр бүтээлтэй болгоход анхаармаар ч  
ям байна. Хурлын дарга дэргээ чанд баръя. Танхимын уур амьсгалд  
хөтлөгдөж байна нүү. Санал нүүмжлэлийг тухай бүр нь тасалж баймаар  
байна. Депутатууд байдлыг хүндрүүж байна. Иймд нутаг дэвсгэрийн  
бүлгээс депутатуудтайгаа ажигламаар байна. Олон дахин хэрэгтэй,  
хэрэггүй зүйл ярьж байгаа депутат байна. Тэдэндээ ярьж зөвлөж  
баймаар байна. Эмнээ нь: Сэлэнгэ, Дорнод, Улаанбаатарынхан нийлж  
яримаар байна. Монгол улс, Үндсэн хуулийн асуудлыг хамтад нь аваад  
нөлөөлж чадвал энэ асуудлыг дэмжиж болох асуудал.

**Хумлаанбаяр /Дорнод/** Саяин санал, Ерөнхийлөгчийн саналтай  
нийлж байгаа явдалд би баярлаж байна. Гэтэл дараа нь сүхдний  
асуудал гарч, энэ нь эвдэгдэнэ. Иймд төрийн байгуулалтын асуудлыг  
халаацгааж эхэлнээр байна. Хурлын орлогч дарга нар даргадаа тусалъя.

Гончиг /Төв/ Нэхдийн ярьсныг дамжих байна.Бүнгүүдийг сайн шигшнэ.Туг далбаа 2 дээр үдээс хойш зохион байгуулалттай баймаар байна.Аль чиглэл дээр энэ бүнгийнхэн санаа өгч байгааг судлах хэрэгтэй байна.Үдээс хойшхи хураа дээр шууд улсын нэрээ хэжэлцүүмье.Хурлын дарга үдээс хойш шууд санаа хурааа.Үндсэн хууль гэснийг танхим хүлээн авах саналтай байна.Улсын нэрийг одоо ярьж дургүйг нь хүргээд хэрэггүй.Иймд хуулийн нэрээ шийдүүлчихээд богино хугацаанд 2 асуудлаа шийдэх боломж байна.

Бямбаноров /Сэлэнгэ/ Нэг зүйлийг Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч бодмоор байна.Энэ хууль маань нилжилтийн үеийнх үү гэдгийг ойлгомоор байна.Энэ өөрчлөлтийг давж туулах эдийн засгийн бололцоо байна уу.Зөвшилцөх арга замд хүрэхээс аргагүй.Орлогч дарга нар уг хэлж байгаа хүнийг анхаарч сануулах байл.

Н.Насан-Очир /Чойр/ -Ерөнхийлөгч,Барсболдын саналыг зөвшөөрч байна.Улсын Бага Хурлаас оруулж буй төсөл учраас Улсын Бага Хурлаас гол гол шалтгааныг хэлж өгч баймаар байна.Олон хүний цаг ноёргоо хассан, хийсэн бүтээлийг хүндэтгэх хэрэгтэй.Удирдлагын талаар хэлсэн үгээ би татаж авч болно.Хурлын дарга ярьсан шүүмжлэлийг анхаараач, цаг барих хэрэгтэй байна.Зарим депутат 8 удаа II минут уг хэлсэн.Цөөнхийн санал ярих үед тэдний 10 хувийг уг хэлүүлэх болохгүй ну.Депутат бид аль нэг зөрөлдөөнтэй хувилбараас нэг дээр нь тогтсон байх ёстой.Сонгосон хувилбараа нэг адил тайлбарлах,хамгаалах ёстой.

Ийдээ /Увс/ Хурлын дарга танхимдаа битгий хөтлөгдөөч.Олон улсын парламентын тогтсон журам гэх ярьж байна.Тогтсон дэгээ л барья.Зарчмын асуудал нь энэ гэдгээ тогтоож явъя.Надад тэгэх ажиглагдах байна.Элдэв хэлбэрээр хурлыг сунжруулах гэсэн хүч байх шиг.Энэ миний хардлага ч байх болно.Иймд хурлын дарга зохицуулж баймаар байна.Буруу ярьж байгааг залруулж баймаар байна.Энэ үндсэн хуульд өөрчлөх юм бий.Үндсэн хуулийн нэрийг Үндсэн хууль гэх нь ч юу юм бол.Заавал үндсэн хуулиар зүтгүүлдээд баймгүй.Их засгийн хууль гэвал санаа авчхна гэх бодож байна.Үүний дараа улсынхаа нэрийг ярьж.Монгол улсын Үндсэн хууль гэдгийг хүлээж авахгүй.Иймд Их засгийн хууль гэдгээр санаа хураалгаа.Депутатууд соёлтой ярмаар байна.



Бат-Эрдэнэ /Нэгдэлчин, хоршоологчийн депутатын бүлгийн ажлагч/

Манай бүлэг харьцангуй тогтвортой саналтай байгаа. Хууль, улсын нэр, сүлд дамбааг цогцоор нь авч үзэх шийдэх хэрэгтэй байна. Салангад авч үзэхэд шийдэгдэхгүй байна. Хурлын даргаас тодорхой томъёолох оруулж ирж баймаар байна. Ямар нэг бүлэгт харьяалагдаж байгаа хүмүүс бүлгийнхээ саналд харьяаагдаж байгаа.

О. Дамбаагвар /УБ/ Та нар байдлыг ажигласан байх. 3 удаа санал хураахад Үндсэн хуульд олонх нь өгсөн. Би үзэл бодолдоо туунтай зогсоно. Улсынхаа нэрийг тогтоож байх хуулийнхаа нэрийг тогтмоор байна. Хурлын удирдлага их хүлээлтэй байгаа. Харин 3 удаа үг хэлсэн хүнд хяналт тавих ёстой. МАХН-ий бүлэг Үндсэн хуульд баттай зогсож байснаа буулт хийж байгаа нь Дам-Индонгийн хийсэн амхам буулт гэх үзэх байна. Хөдөөний депутатыг доромжилсан ба харин хуулийг сайн хэлэлцэж байгаа гэж бодож байна. Ингэж хэлэлцэж байна үр дүнд хүрэх ёстой. Хурлыг түргэн дуусгаад ирж гэж биднийг явуулаагүй. Манай бүлэг БНМАУ, Үндсэн хууль гэснээс хэрхэвч ухрахгүй. Сүлдийг өөрчлөх гавал зохицох болно. Тугийг өөрчлөхөд санал зөрөхгүй.

Ц. Бэлд /УБ/ Би горимын чанартай асуудал хэлжээ. Зөвшөөрөл өгсөн микрофоноос бусдыг ажиллуулахгүй байх. Цөөнх болсон хүнийг тодорхой хувиар төслөж байна. Эгнээ болгон мэдээлэл хийхээ больё. Цагаан утсаар Уртнасан өөрөө л ярьж байна. Наанаас нь утасдахыг больё. Хажуугийн санал олонхи болохгүй бол төсөл хэвээр үлдэнэ гэх хатуу тогтоё! "Монгол улсын Үндсэн хууль" гэдэгт тогтоё.

Эхбаатар /МоАН/ Бид минэ бүгд найрамдах улс байгуулах гэх байгааг бүлгийн ажлагч нар депутатдаа ойлгуулаач. Минэ төрийн тогтолцоо руугаа бид орж чадаагүй байна. Компромисийг зөвшөөрч байна.

Дантуу /Товь-Алтай/ Ард түмнээс асар их санал авчихаад Үндсэн хуульд тусгаагүйгээс ийм байдалд орж байна. Бид яагаад ч урт настай хууль хийж чадахгүй. Ард түмний дийлэнх олонхийн саналыг тусгахгүйгээр төр засаг тогтох болохгүй. Туг, сүлд, улсын ба хуулийн нэр хоорондоо нэгт уялдаатай. Монгол улс гэх авснаар бүх монголын хууль гэх ойлгогдох болно. Улсын нэрээ үдээс хойш ярь. 3 вариант дээр санал авъя.

Улсын нэр өөрчлөгдвөл бусад нь өөрчлөгдөнө. Орой болгон 20-21 цагийн хооронд бүлгүүдийн ажлагч нар санаагаа нэгтгэж, дараа нь бүлэгтээ ярьж байвал ямар вэ? Хурлын дундуур өөр ямар нэг асуудал оруулахыг больё.

Монгол улс гэх нэрлэхэд нэг ойлголтыг тодруулмаар байна. 1. Ингэж нэрлэхэд ЗХУ, хятадаас манай талаар барих бодлогод өөрчлөгдөх үү? 2. ЗХУ, хятадад байгаа монгол иргэдэд нөлөөлөх үү гэдгийг тодруулъя. Ард түмний дотроос гарсан олонхийн санааг заавал больё.

Очиржав /МоАН/ Ардын Их Хурлын II хуралдааны явц бидний сэтгэлд хүрэхгүй байна. Олон чухал асуудал байна. Иймд бид Монгол улсын үндсэн хууль байж болох юм гэж тогтсон. Өнөөдөр ЗХУ манайд өгөх баяжинээ тасалжээ. Засгийн газрын эсрэг ажил хаях хороо байгуулагджээ. Ардын Их Хурлын хуралдааныг дарга нь удирдаг. Харин Их цаазын хэлэлцүүлгийг Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч удирдах. Ардын Их Хурал хэлэлцэж буй үндсэн баримт бичгийнхээ үүднээс хандаач. Депутатууд өнөөдрийн бэрхшээл, бухимдлын үүднээс Үндсэн хуульдаа битгий хандаач.

Р.Хатамбаатар /УБХ/ Бид Барсболдын хэлсэн санаатай нэгдэнэ. Зөвшилд хүрэхийн төлөө ажиллана. Хуулийг хэлэлцүүлэгчийг тавьж төгмөөр байна. Нэгэнт батлагдсан Дэгдээ тайлбар хийе. Энд депутатын хэсэг ажиллуулъя.

Орлогч дарга нар хуралд оролцооор байна. Хардлага, сөрдлэгийг багасгамаар байна. Тухайлбал Дамбалбар депутат үүнийгээ болгооч гэж энд хэлэх гэсэн юм.

Дэл-Эндон Монгол улсын Үндсэн хууль гэснээр хоёр гурван асуудлыг шийдэх боломжтой. Зөвшилцөхөд бэлэн байна. БНМАУ-ын Үндсэн хууль, Монгол улсын Үндсэн хууль, Монгол Ард улсын Үндсэн хууль гэх мэт хувилбартай оруулбал ямар вэ? Ингэж яриад болохгүй бол Үндсэн хуулидаа орж дуусгаад эцэст нь нэрээ бодъё. Энэ хуулийг заавал батлах ёстой. Энэ хуульгүйгээр бид урагнаа ч явахгүй, хойшоо ч явахгүй.

Д.Дашням /МУАН/ Ерөнхийлөгчийн санаа үр дүнд хүрнэ гэж бодож байна. Бүх ямаа цааш ахуулъя гэж байгаа үед энэ санааг манай намын бүлэг дэмжиж байна.

Энэ нэр дээр ойртож байгаа бол үүн дээрээ ярья. Ерөнхийлөгчийн саналыг хүлээж авна.

Хамсран /МАХН/ Заалын уур амьсгалаар бол хуулийнхаа нэрнээс ажлаад шийдмээр байна. Үндсэн хууль гэхэд бол болмооргүй байна. "Их хууль", "Үндсэн хууль" дээр ярих. Улсын нэр, сүлд хоёрт өөрчлөхөд эдийн засгийн хувьд даажгүй юу.

Мнэмхэн /Баян-Өлгий/ Улсын нэр, Үндсэн хуулийн нэрийг давхар оруулъя. "Монгол улсын Үндсэн хууль"-ийг оруулъя.

Мөнхдорж /БХЯ/ "Монгол улсын их хууль" гэсэн хувилбар дээр ярьсан. Сүлдийг өөрчлөө. Төсөлд орж ирсэн сүлд бол АНУ-ын БХЯ-ны сүлд тэр хэзээр байгаа. "Монгол улсын Үндсэн хууль" гэвэл болмоор байна.

К.Сайраан -19 хүн үг хэлснээс 15 нь Ерөнхийлөгчийн саналыг дэмжив. Одоо саналаа тасалбал ямар вэ. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчөөр хуралдааныг даргалуулбал ямар вэ? 4 гол намын удирдагчид саналыг дэмжлээ. Ямар бүлгүүд байгааг депутатуудад тодорхой хэлж өгье.

Б.Чимид -Олон янзын саналаас нэгдсэн санал хүрэх 2 арга бий. 1/хүч хэрэглэдэг, 2/харилцан буулт хийх.

Манай улсын мөн чанарын өөрчлөлттэй холбогдуулаж би хувийн саналаа гаргасан. Улсын нэр зайлшгүй өөрчлөгдөх нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрсэн юм. 1924 оны Үндсэн хуулиар бол ард гэдэг нэрийг гаргах, феодал, лам гэх ялгасан. Одоогийн хуульд ашигчин анги, хоршоолдосон ард, сэхээтэн гэх заасан. Иймд үүнийг өөрчлөх ёстой. Дэлхийн олон улс нэрээ өөрчилсөн. Дэлхийн улстай хэвээр нэртэй очвол ангийн бодлого хэвээр байна гэсэн өйлгөлтөд хүрнэ. Монгол улс гэснээр гол төв гэсэн утга орж байгаа. Гэхдээ их монгол гэх нэрлээгүй гэдгийг анхааръя. Сүлд, бэлгэ тэмдгийн асуудал нэрнээс бий, мөн чанараас хамаардаг, заавал сүлдэнд нэр бичих шаардлагатай.

Ц.Төмөрбаатар /Өвөрхангай/ Групп гаргах тодорхой хувилбарууд өгөөч ээ. Улсын нэр, сүлдийг өөрчлөх гэсэн шалтгааныг тайлбарласан зүйл өгье.

Ахагласуран /Нөхцөл/ Бид ороод дэгэндээ тодогтол хийе.

П.Очирбат Бид одоо үдээс хойш хурлаа эхлэхэд завсарлахдаа ярьсан зүйлээсээ яриагаа эхэлье. Зөвлөлдсөө, нийм саналтай ирж байна гэдгээ хэлье. Ерөнхий санал болгох нийм хувилбар байж болох байна гэдгээ тогтоод санал хураалгавал ямар вэ? "Монгол улсын үндсэн хууль" гэдэг нэр дээр яривал ямар вэ гэх ихэнх нь үзэх байна.

Ерөнхийлөгчийн хувьд хурлын эрх дарх руу орж болохгүй гэх үзэх байна. Даргалах нь зохисгүй. Харин бид нидэр дээр хуулийнхаа талаар ярьж тайлбарлах үүрэгтэй орж болж байна.


Иманд бас хүлээцтэй хандахыг депутатууддаа хэлж ярьж өгөөч.

Үндсэн хуулийг заавал баталж байж салах ёстой. Энэ бол та бидний эрхам чухам үүрэг мөн. Энд мэдээж хэрэг засах янзалх юм бий байх.

Ярихцага 13.30-д дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн

Н.ДУВСАНХАВ



Р.ТҮНЖИН